

ИХ ХААДЫН САНАА

ТАВАН ХААДЫН ЦАДИГ



БАЯРТОГТОХЫН БАТРЭГЗЭДМАА (REGZED)

Их хаадын санаа
Зохиолч: Б.Батрэгзэдмаа

ISBN: 978-99962-0-840-9

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Эрхэм төрт ёсны хүмүүн Түмэндэмбэрэлийн Батдорж таньд мөхөс бичгийн хүн би бээр туйлын ихээр талархаж буйгаа юуны өмнө илэрхийлье!


Их Монголын Эзэнт Гүрний их хаадын цадиг түүхийг чадан ядан бичих алба надад яагаад ч юм оноогджээ гэж өөрийн онгодтой цагийг нэрлэж зүрхлээд, Мөнх тэнгэрийн хүчинд эргэлзээгүй итгэн дэлхийг засаглаж явсан Монгол их хаадын суу ухаан, сүр хүч алдар гавьяаг хийморио хэмээн сүсэглэн монголын үр хойч тэнгэрлэг яваасай гэхдээ зохиол бүтээлээ дэлгэрүүлэхээр барьж явахдаа таньтай таарав. Бүтээлийн заяаг тэтгэх хүмүүнийг тэнгэр явуулжээ гэж бодохыг хүсэв. Яагаад тийн сэтгэж болохгүй гэж..!

Монголчууд төрөлхийн итгэл, их билиг билгүүнтэй ард түмэн гэдгийг би сайтар ойлгосон. Тийм дээ ч гэгээн хүмүүн таныг хаадын дээд хүчит хийморь үйлсийг тань харж явна гэж итгэж байна!

Таньд дахин талархая!

Зохиолч Б.Батрэгзэдмаа

Их хаадын санаа



Чингис хаан

Өгөөдэй хаан

Гүюг хаан

Мөнх хаан

Хубилай хаан

Их Монголын Эзэнт Гүрний Их Хаадын цадиг оршвой.



Их монголын

Эзэнт гүрний

Их хаадын

Цадиг

Таван их хаадын таван бүлэгт сэтгэхүйн - эгээрэлт жүжиг

Таван их хаадын ордноор саатсан минь хэмээх өмнөтгөл үг

Юуны өмнө Б.Батрэгзэдмаагийн бүтээлч чанар их хөдөлмөрт баярлаж байгаагаа өмнөтгөлийн эхэнд дуу алдан баярлаж байна.

Биднээс их холдсон он цагт болсон үйл явдал гэдэг түүхэн тэмдэглэл, судар бичиг, үлгэр домог, малтлагын олдвор зэргээс баримттай буюу эргэлзээтэйгээр баригдах агал тэр үеийн хаадын санаа, сэтгэл сэтгэлгээ, сэтгэхүйд хийсэн эрэл гэдэг өтгөс миний хувьд дааж давшгүй санагдана.

Зүрхэлж зүтгэхэд хэцүү энэ давааг Б.Батрэгзэдмаа зохиолч давчихсан “овоог ” нь тойроод чулуу нэмэж явах юм...

Монголын уран зохиолын ирэх цаг, ирээдүй хоёрт үл эргэлзэхийн нэгэн шалтгыг Б.Батрэгзэдмаагийн бүтээлээс харлаа.

Энийг л чухам баяр бахархал гэж хэлмээр байна. Саяхан даа! Гэхдээ нилээд хэдэн он жил улиран оджээ. “Ногтрууны өндөг” шиг жижигхэн бор охин байсан сан. Энэ дайны ном туурвих хүн ирлээ!.. гэж тэр үед бодож байсангүй! Авьяастай хүүхэд гэсэн л бүдэг бадагхан итгэл үнэмшил байлаа... Намайг “багш минь” гэдэг хүүхдүүд “том ” болжээ. Би эднийхээ эхлэл, өрнөл хоёрын бахыг амсах хувьтай хүн ажээ...

Их хөдөлмөрлөсөн хүнд би нэг их баярладаггүй. Харин их бодсон, их ухаан, их эрэл шинэчлэлд баярладаг. Хөдөлмөрлөхүй гэдгийг хүн бүхэн чадна. Гэхдээ авьяас ухаан заяагаагүй бол жирийн л хүн байна. Хүний үнэ гэдэг алин ч байсан өндөр байдаг.

Чингис хааны санаа, Өгэдэй хааны санаа, Гүюг хааны санаа, Мөнх хааны санаа, Хувилай хааны санаа гэх эмгэнэлт- эгээрэлт” сэтгэхүйн таван хэлхээ жүжиг Б.Батрэгзэдмаа бичжээ.

Энэ жүжгүүд хоорондоо үйл явдлаар холбогдохоосоо илүүтэй төр сэтгэлгээ- төв санаа бодол, уламжлалт төрт ёсоор холбогдож байгаа нь олзуурхууштай. Б.Батрэгзэдмаа чи – Хөлгөн их бүтээл туурвилаа... Энэ бүтээлийг хэн хэрхэн үнэлэх нь уншигчдын эрх боловч, тэдэн рүү зоригтой нэвтрэхийг оролдох нь “ уран бүтээлч хүний оюуны түрэмхийлэл” ажаам. Хүлээн зөвшөөрөхөөс аргагүй зүйл гэж байдаг... Чамд чиний бүтээлд оюунлаг хэн бүхэн, жирийн уншигчид ч тэр бахдан баярлах болно. Урьд өмнө ийм хөлгөн жүжгийг хэн ч бичээгүй! Батрэгзэдмаа хуучин танил атлаа “шинэ” юм байна. “Байя! гэвэл шилдэг нь бай!” гэсэн үгээр өмнөтгөл үгээ дуусгая!

Чиний бүтээлийн хүлэг морины хөл чанга, ар дахь морьдын тоос хол байна. Уяа чинь бүү

цөмөртүгэй!

Монгол улсын төрийн шагналт Ардын уран зохиолч

Соёлын гавьяат зүтгэлтэн Бавуугийн Лхавгасүрэн

Оршил утга:

Мөнх хөх тэнгэр буюу дээд оршихуйн оюун санаанаас хүн төрөлхтнийг аврах гэгээрлийн хутаг шидийг (дээд оюун санааны дэлхий дэх төлөөлөл бүхий гэгээнтэн буюу гэгээрэгчидийн оюун ухааны ай сав цутгалангууд болон хамаарагдах Будда-Бурхан багш Шагжимуни Бодь мөрийн зэрэг, Христос - Есүс Библи, Лал - Мухамед Коран судрууд лугаа адил) хүн төрөлхтний өвөг, дээд гаралт монголчуудад буулгасан ариун ном нь Мөнх хөх тэнгэр - Чингис “Алтан Дээд Гэриэ” бөгөөд дэлхийг тохинуулан хүн төрөлхтөнг нэгэн хаант улсад нэгтгэн засаглах оюун ухаан, үзэл санааны Алтан Дээд Аялгуу чинхүү мөн ажээ.

Мөнх хөх тэнгэрийн хүчний эрхшээл дор шүтэн орших нүүдэлчин цөөнх монголчуудад нэг дэлхийд нэг үндэстэн хэмээх агуу санаа, агуу оюун, агуу хүч нэгдэн буусан бүхий тэр цагт эл үндэстэн Алтан Дээдийн Гэриэ ариун номыг өлгийдөн авах хишиг хүртэн дээд оюун санааны иш үзлийг бадраах Их Эзэн Чингис хааныг төрүүлэн, нүүдэлчин ард түмэн дэлхийг эрхэндээ хурааж Эзэнт Гүрэнг байгуулсан няцаагдашгүй үнэн түүхтэй.

Хүн төрөлхтөн анхны гарвал үндэс рүүгээ нэгдэн эв эетэй аж төрөх, дэлхий нэг улс гүрэнд хураагдан нэг төр цогцлогдох, засаглал нэг жолоонд захирагдсаар хүн төрөлхтөнг мөнх оршихуйн гэгээрэл рүү дээдэс доордос үгүй нийтээр зоригдон хүрэх нууцыг агуулсан Хөх Монголыг нүүдлийн соёлоор бадраах хутагтай Их засгийн “Алтан дээд гэриэ” ариун ном нь дэлхийг Монголын Эзэнт Гүрэнд төвшитгөх дээдийн оюун санаа ажгуу.

Гэнэт эл Ариун ном нууцаа нууцалж, Мөнх хөх тэнгэрийн зарлигаар Монголын Хөх нохойн овогтоныхон 15 үеэр аман дамжлагаар нууцлан өртөөлөн авчирсан ба өчигдөрхөн байсан сүүлчийн амьд хүн-ном Журнайн Нүрзэд хэмээх хүмүүн бололтой. Монголчууд бидний энэ цагт Хөх нохой овогтны сүүлчийн өртөөлөгчийн хичээл зүтгэлээр нэг хүн зохиож хэрхэвч гартахгүй эртний өвөг хэлээр цээжлэгдсэн ер бусын бичиглэл орчин цагийн хэлний тайлалаар цагаан цааснаа буун ил илчлэгдлээ.

Монгол орон, монголчуудыг гадаадынхан олон зуун жил төсөөлөл, таамаглал, судлал, шинжилэлдээ ер бусын нууцлагдмал, аймшигтай, гайхамшигтай, агуу тайлагдашгүй эгэл биш сүр хүч суу билигт цог зальт хэмээн өгүүлцгээж өнөөгийн энэ ертөнцийг үндэслэсэн гэдгийг хүлээн зөвшөөрч тэр нууц нь харин юу болохыг мөн л хайсаар байх бөлгөө.

Мөнх хөх тэнгэрийн таалалаар Монголчууд бидэнд “Алтан Дээд Гэриэ” ариун ном нууцаа гэнэтхэн дэлгэв ээ. “Алтан Дээд Гэриэ”-ний нууцыг тайлахаар эрдэмтэн судлаачид мэрийн эхлэв ээ.

...Тэнгэрийн цаг эхэлжээ. Сэрэх, сэхээрэх, итгэх нь хэн буй. Түүнд тусыг мөн хичээнэм...

Монголын Эзэнт Гүрний түүхийг энэ л шалтагаар өчүүхэн бичгийн хүн би бээр Алтан Дээд Гэриэг мөрлөх монголын их хаадыг “Их Хаадын санаа” нэг нэг бүлэгтэй ес есөн үзэгдэлт таван жүжгийн зохиол бүтээлээр зориглон хөндөх болов. Мөнх хөх тэнгэр - мөнхийн дээд оюун санаанд сүслэн мөргөнөм.

Чингис хааны санаа тэргүүн жүжиг жүжгийн явдал

- Тэргүүн жүжгийн эхлэл титэм

1. Тэнгэрийн ташуур газарт буув
2. Их хаан тэнгэрийн хэлийг тайлав
3. Алтан гавлын нууцыг нууцлав
4. Дээд судрыг гурамсан алтан бүсээр бүслэв
5. Шөнийн тэнгэрт таван од найрсав
6. Их эзэн хаан тэнгэрт морилов
7. Хангинах тэрэгний замыг дуу нулимс зурав
8. Толуй хан, хаан эцгийн сүнсэнд өршөөл эрж мөргөв
9. Өгэдэй Далай их хаанд өргөмжлөгдөв

-Тэргүүн жүжгийн төгсгөл ба дэд жүжгийн эхлэл титэм

Өгэдэй хааны санаа дэд жүжиг жүжгийн явдал

- Дэд жүжгийн эхлэл титэм

1. Толуй Их хаан ах Өгэдэй өмнөөс тэнгэрт гарав
2. Толуйн хатан Сорхагтанг Өгэдэй хаан гуйв
3. Их хатан Дөргэнэ,Фатимагаар мэргэлүүлэв
4. Сорхагтан хатан мөнх тэнгэрт мөргөл үйлдэв
5. Их хаан Өгэдэй ханхүү Гүюгийг шийтгэв
6. Их хаан Өгэдэйн зүүдийг зайран тайлав
7. Их хаан Өгэдэй мөнх хөх тэнгэрт одов
8. Төрийн хайрцаг онгойн Алтан дээд Гэриэ алдагдсаныг мэдэв
9. Их хатан Дөргэнэ ханхүү Гүюгийг их хаанд өргөв

- Дэд жүжгийн төгсгөл ба гутгаар жүжгийн эхлэл титэм

Гүюг хааны санаа гутгаар жүжиг жүжгийн явдал

- Гутгаар жүжгийн эхлэл титэм

1. Их Хатан Дөргэнэ харанхуйн хатан хаанаар тодров
2. Их хатан эх Дөргэнэ Ханхүү Гүюгийг мэдэв
3. Их хаан Гүюг Хар хүчний шидтэн Фатимаг даран хөнөөв
4. Их хатан Дөргэнэ хабсу хасу бөгж үмхэв
5. Их хаан Гүюг дэлхийг нэгжиж, төв төрийг эмхлэв
6. Их хаан Сорхагтон бэхээ хатныг зүүдэнд нь гуйв
7. Их хаан Гүюгтэй хан дүү нар тэрсэлдэн. Хаан тэнгэрт халив
8. Сорхагтан Бэхэ хатан хөвүүдийн хамт эх нутагтаа эргэж ирэв
9. Тэнгэрийн зарлигаар Мөнх хаан ширээнд суув.

- Гутгаар жүжгийн төгсгөл ба дөтгөөр жүжгийн эхлэл титэм

Мөнх хааны санаа Дөтдүгээр жүжиг жүжгийн явдал

- Дөтдүгээр жүжгийн эхлэл титэм

1. Их хаан Мөнхөд Өгэдэй, Цагаадайн хан хөвүүд нум сум зэхэв
2. Их хатан Огул Хаймиш энгэр юугаа дэлдэв
3. Их хатан эх Сорхагтан амьд хүн ном бүтээв
4. Гүрэн батжиж, алтан сан хөмрөг нээгдэв
5. Хатан эх Сорхагтан бэхэ бөө сэцэн тэнгэрт морилов
6. Их хаан Мөнх Монгол дээвэрт дэлхийн бүх шашинг хэлэлцэв
7. Их хаан Мөнх, мөнх хөх тэнгэр болов
8. Их хааны сэнтийд тэнгэрийн тэмдэг үзэгдэв
9. Тэнгэрт өрсөлдөн хоёр хаан Хубилай, Аригбөх тодров

Дөтдүгээр жүжгийн төгсгөл ба тавдугаар жүжгийн эхлэл титэм

Хубилай хааны санаа Тавдугаар жүжиг жүжгийн явдал

- Тавдугаар жүжгийн эхлэл титэм

1. Тэнгэрт хоёр нар мандах мэт газарт хоёр хаан тодров
2. Арслан барсын ноцолдоонд хөрс хөрвөв
3. Маргад эрдэнийн хаант улс хагарав
4. Их хаан Хубилайд, дүү Ариг бөх хаан ирэв
5. Их хаан Аригбөх тэнгэрт гарав
6. Монгол ноёд тал нутгаа эрхэмлэн одов
7. Цагаан дэлт чононы сүнс тал нутгийг эзэгнэв
8. Дэлхийг мэдсэн Их хаан Хубилай дээд тэнгэрт мориллов
9. Алтан Дээд гэриэт Хөх нохойнхон Алтайн ууланд нууцлагдав

Тавдугаар жүжгийн жаргаах төгсгөл титэм

Чингис Хааны санаа

Хааны гавал Их засгийн алтан хуулийн аяга болтугай.

Чингис хаан

Тэргүүн жүжигт тодрох дүрүүд:

Их Монгол Эзэнт Гүрний Их Эзэн хаан Чингис

Их Монгол Эзэнт Гүрний Төрийн Их хатан Бөртэ Үжин

Их Монгол Эзэнт Гүрний Төрийн хатад Хулан, Есүй, Есүгэн

Их Монгол Эзэнт Гүрний их хааны дүү төр түшигч Отчигон ноён

Их Монгол Эзэнт Гүрний их хааны отгон охин, гүнж Алалтун бэхэ

Их Монгол Эзэнт Гүрний Их эзэн хааны хөвүүн төр түшигч хан Цагаадай

Их Монгол Эзэнт Гүрний Их эзэн хааны хөвүүн төр түшигч хан Өгэдэй

Их Монгол Эзэнт Гүрний Их эзэн хааны хөвүүн төр түшигч хан Толуй

Их Монгол Эзэнт Гүрний Их хуралдайн дарга Сорхогтан бэхи хатан

Их Монгол Эзэнт Гүрний Өгэдэйн ханы хатан Дөргэнэ

Их Монгол Улсын хаан Толуйн бага хатан Мүхэй

Жүжгийн тодрох ба илрэх дүрүүдийн хамжаа туслах дүрүүд:

Их хааны ач Хубилай, Их цэргийн жанжин Зэв, Сүбэгэдэй, Төрийн зөвлөх Елюй Цуй Цай, Зайран, ордны Өлзийдэй ноён, Аригун ноён, Нахиадын арш Чан чун Бумба, Лалын лам Хажу Рахим, бусад түшмэлүүд хишигтэн цэргүүд, хэвгүүл, аягач шивэгчид, жүжигчин бүжигчин.

Жүжигт илрэх сөрөг дүрүүд:

Хорезм улсын их хатан эх Турхани, Мухаммедийн эхнэр хүүхдүүд Хорасаны Түсс хотоос олзлогдож ирсэн шивэгчин, хар шидтэн Фатима ба бусад...

Тэргүүн жүжгийн эхлэл титэм

Тайз: Өндөрлөгт хааны сэнтий байна. Их эзэн хаан Чингис өндөрт байна. Лалын лам Хажу Рахим доор бохирон суусан байна.

Их эзэн хаан Чингис:

- (Эзэнт Гүрний их хэнгэрэгийг дэлдэн дэгдэхэд Хаан баруун гараа дээш өргөнө) Мөнх тэнгэрийн хүчин дор, Их Монгол Гүрний эзэн хаан Чингис миний зарлигийг сонсохтун!

Дээд тэнгэрээс заяат Хөх нуруут бид ертөнцөд дэг журам тогтоохын тулд төрсөн. Мөнх Хөх Тэнгэрийн хүчин бээр Тэнгэрийн дор Нэгэн Эзэнт Гүрэн эзэгнэж нэгэн Хаант төр захирч гагц Их Монгол Эзэнт Гүрний ясу зарлиг, хуулийг дэлхийд мөрдүүлэн тулгах эрхийг хөх нуруут иргүн улс бидэнд өгсөн билээ. Хөх нуруутнууд бид хүмүүнийг өөд татаж хөх тэнгэрт хүргэх ясу зарлигтай. Их төрийн алтан аргамжаа, энхийг тулгах зарлигийн элчийг этгээдийн Сартуул орны мунхаг хан ноёд үл хэрэгсэж, улмаар ману төрийн алтан аргамжааг таслаж, элчийг маань алан хороож, дэд элчдийн сахал санчигийг хусаж басамжлан доромжилж ману худалдааны тайван замыг нээгч жирийн дөрвөн зуун тавин иргүнийг хядаж, таван зуун тэмээ ачаа барааг нь дээрэмдсэн жигшүүрт ялт хэргийг үйлдэв. Мөнх тэнгэрийн хүчин дор их суу залийн ивээл дор ертөнцийг засах Их засаглахуйн Алтан дээд үнэний аялгууг мөрлөн өргөх Их Монгол Гүрний эзэн хаан миний зарлигийг хэн үл бишрэх тэр хүмүүн, улс алдах үхэх ясу ёсоор шунал хүсэл, жаргал цэнгэл хэтийдсэн, шударгуу үнэн, ивээл хайр доройтсон хаан хэмээгч тэрсүүд Мухаммедад өсийг өшилж, хяслыг хясаж тийн тэрсээчдийн цөсөнд тэнгэрийн хууль цаазыг тулгахтун. Их Монголын Эзэнт төрийн Их хуралдай дор засагласнаар эдүгээ намрын тэргүүн сарнаа их цэрэг дайчин хүлэг морьтонгууд минь дайлаар их аянд морьдох боллоо! Мөнх тэнгэрийн суу хүчин ману үйлсийг мэдтүгэй!

Далдаас:

- Их хэнгэрэгээ дэлд! (Хэнгэрэгний дэлдээн, цэргүүдийн уухайн дуу түрнэ.)

Лал лам Хажу Рахим:

- (Хажу Рахим лал сүсэгтэний ёсоор хоёр гараа дээш өргөн аврал эрнэ.) Аллах тэнгэр минь. Үнэн мөргөлч, хэсүүлч бадарчин Багдадын Хажу Рахим би байна. Дорно зүгээс аймшиг өндийжээ. Газар тэнгэрийн савслагаас бачит шулмас элбисийн түрэн гаргасан аюулт Яжуж Мажуж мэт хэн ч орой дээр зүрхлэн гарах тэнхээгүй Тэнгэр уулын давааг аймшигт хүлэгтэнгүүд даван гарч ирээд түймэр мэт нааш довтлон айсуй. Тэдний зүс эрлэг мэт бөгөөд үзмэгц айдас хүрэм, сахалгүй уруул оочиндоо цөөхөн үстэй, нүд бүхэн жартайн гялалзсан, түргэн хурц харцаараа зөвхөн үхэл зарлана. Тэдний дуу тэнгэрийн нүргээн адил хүнгэнэн, газар тэнгэрийн шуургыг босгон эргэлдэх хуй савслага салхинаа гялтагнах сэлэм нь аадрын цахилгаан мэт гяласхийн үзэгдэнэ. Хүлэгтэнгүүдийн бие махбодь нь чийрэг хүдэр, сонсохноо тэд урт насалдаг. Тэднийг устгахаас нааш ертөнц амрахгүй. Орчлонг донсолгон доргиогч тэдний хосгүй зальт хаан ял асуун нааш иржээ. Аллах тэнгэр минь, нүгэл хилэнцэт биднийгээ өршөө. Нөмрөн ирэх аюулаас биднийгээ авар! Хорезм шах Мухамед та бол дэлхий дээр Аллахын дараа орох дээд эрхийг барих эзэн мөн. “Заяаны судар”-т хамгийг чадагчийн заасан насны хэмжээ урьдаас мэдэхүйеэ бэрх. Ялагдашгүй шах чи байлдан ялан дийлж, хэзээ нэгэн цагт одох сүнс чинь жаргалангийн орон руу саадгүй очиж, энд төр барих хатуу гар чинь үл нугарч, төр самууран унахын болзошгүйд Аллах тэнгэр бүү хүргүүлсүгэй. Ертөнцийн цог жавхлан, шашны сахиулсан, исламын юлд хааны сүр хүч Мухамед та минь үүрд төр барьж урт удаан жаргах болтугай. Аллах минь!

Нэгдүгээр үзэгдэл.

1. Тэнгэрийн ташуур газарт буув

Тайз: Сырьдарьяа мөрний эрэг. Их хаан Чингисийн аян дайны их өргөө гэр. Их хаан Чингис, Их хааны хатан Хулан хатан өргөөний хойморын сэнтийд морилох ба Төр түшигч хан Толуй, Сорхагтан хатны хамт мөн Төрийн зөвлөх Елюй Цуйцай, Зайран, ордны Өлзий ноён, Нахиадын арш Чан чун Бумба болон хэвгүүлүүд ордны албат аягач шивэгчид байна.

Их хаан эзэн Чингис:

- Өлзийдэй ноён та, ялалтын ялгуун аялгуунаас дуудаач. Өргөөнд хурсан олон, мэргүн Бумба тэргүүтэй миний зочдын чихийг аялгуугаар мялаахтун.

Өлзийдэй ноён:

- Жа, хаантаан. Их Монголын их цэрэг Сартуулын энэ орноо ирээд Эрчис голын эрэг дээрхи дайны эхлэлийг дуудсу би. (Зогсоц) Өвлийн тэсгим хүйтэнд газрын өндөр уулсын эцгийн магнай мөнх цасаар гялбалзана. Хөх нуруутны хааны эрэлхэг Зүч, Сүбээдэй жанжингууд эрмэг хүлэгтэнгүүдтэйгээ газрын өндөр Тэнгэр нэрт уулыг давж гарахаар шийджээ. Хүлэгтэнгүүд дагтаршсан зузаан цас мөсний дээр дөнгөж сая орсон цаснаас уулын эзэд сүрэг ирвэсний мөр олов гэнэ. Тэнгэр таалж зам заав хэмээн баясалдаж ирвисийн мөрөөр орон их Тэнгэр уулын зүрх рүү мацав. Нум сум агссан хүлэгт эрчүүд ирвисний мөрийг хөөн цас мөсний дунд цавчим хавцалыг өгсөн өгссөөр нэгэнтээ эцэг уулын магнайд ирэхүйд уулын дээд оройд сүрэг ирвэс үзэгдэв гэнэ. Уулсын зэрлэг сүр хүчтэнгүүд хүлэгтэнгүүдийг холоос ажиг байснаа алгуур дөхөн ирэх нь сүртэй. Сүргийн манлай эрэгчин хоёр алдын биеэрээ оцойн суугаад хүлэгтэнгүүдийг тайвнийн ажжээ. Сүргийн эмэгчин шинэхэн цасыг шинэшилснээ зөөлөн алхлан ойртсоор алхамын газар тулан ирээд мэндэлжээ. Хүлэгтэнгүүд маань хамгийн өндөрт байх аюул нь аюул бус болж, араатан араатаны зангаа гээдгийг үзэв гэнэ. Мөнх тэнгэр уулын эзэд ирвисийн ухаант, омогт харцаар хүлэгтэнгүүдэд санаагаа тийн өгөв. Уулсын эзэд амар амгалангаа хөөн хавцал өөд оджээ.

Их хаан эзэн Чингис:

- Мөн. Тэр бол тэнгэрийн оюун санаа өөрөө мөн.

Өлзийдэй ноён:

- Хааны хүчирхэг хүлэгтэнгүүд Тэнгэр уулыг давж Ферганы хөндийд орж ирэхэд Ала-Ад-Дин Мухаммед шах цочирдон айв. Зэв, Сүбээгэйдэй жанжингууд Хорезмын шахын цэрэгтэй Эрчис голын эрэг дээр тулалдан гурван түмэн цэргийг нь хохироон дайсныхаа хүчийг шалган турши снаа цацсан одны уран арга хэрэглэн гэнэт алга болов.

Их эзэн хаан Чингис:

-Их хаан би дайчин хүлэг морьтонгуудынхаа ялалтын ялгуун аялгуунд бүрнээ бүүвэйлэгдэв.

Илдний ишийг сайн барихгүй бол хурц ирийг нь барихад хүрнэ. (Чан Чун Бумба руу харна)

Чан Чун Бумба:

-Их эзэн Чингис хаан таны үг нүцгэн үнэнг илчлэв. Хаан таны урилгаар өчүүхэн арш би алс холын урт аяныг туулан ирэхдээ таны байгуулсан ялалтын уртаас урт улаан зам мөрөөр аялан явлаа. (Их хаанаас яльгүй эмээв) Гайхалтай нь та нарын үг санаа миний туулсан замын эцэст олсон олз минь боллоо. Ялалтын дагуух урт удаан аяны төгсгөл минь ийм гайхалтай ухаанаас эхлэлтэй зам мөр байсныг танив. Шудрага үнэн ямагт хурц үзүүрт илд мэт биеэтэй ажээ. Гэхдээ.. (Дуугүй болно)

Их эзэн хаан Чингис:

-Мэргүн Бумба, та эмээлгүйгээр өчихтүн!

Чан Чун Бумба:

- Бурхан ертөнцөд шудрага үнэний ийм хурц илд илгээсэн бол хайр энэрлийн бамбай мөн түүний адлийг илгээсэн байж таараа. Тэрхүү бамбайн ард дахь ирээдүй цагийг өтөл Чан Чун Бумба арш би биеэр үзэх хувь дутуу ажээ.

Их эзэн хаан Чингис:

- Ертөнцийг хөндлөн туулсан хаан миний аян дайны замд чихийг минь үргэлж дэлссэн мэргүн Чан Чун Бумба таны ухаан билгийн гүнийг би тааварлан асуувал хүмүүний хойчийн ирээдүйн тухай асуув уу? Мэргүн Бумба, ертөнцийн хойшдийн ирээдүй харин таныхаар юу болон үзэгдэнэ вэ?

Чан Чун Бумба:

- Бурхан миний энэ төрлийн цагт хөрст дэлхий нуруугаа хэрхэн шилгээхийг үзүүлэв. Нурсан хот балгад, үнсэн товрог болсон газар нутаг, үхээрийн элээ шувуу найрсан энэ үед хотол чуулсан дэлгэр цагийг үтэр түргэн ирүүлэх болтугай.

Их эзэн хаан Чингис:

- Ерөөл бат сайн оршиг!

Хааны хатан Хулан:

- Ерөөл бат сайн оршиг!

Өргөөнд байгсад цугаар:

-Ерөөл бат сайн оршиг!

Чан Чун Бумба:

- Үзэхнээ таны албат ард олон ухаан хайж үг сонсох туйлын хүслэнтэй ажээ. Үйл үйлийн дээд оюун ухааны үг санааг чих тавин сонсох нь нэн сайхан.

Их эзэн хаан Чингис:

- Миний ард түмэн үлгэр сургаал сонсож өсдөг. Мэргүн ардын үгээр бойжих тэнгэрийн хутагтай улс.

Чан Чун Бумба:

- Аан.., тийм байх нь... Тэнгэрийн хутаг тэрхүү судар номыг тань сөхөхийн туйлын хүслэн үсэг мөрийн явдалтан өчүүхэн надад байна. (Хааны харцыг гайхан) Аймшиггүй үгийг минь хэлтрүүлж хайрла.

Их хаан эзэн Чингис:

- Хэзээнээс ману ард мэргүн ухааныг гавалдаа тээдэг. Үг санаа бүрэлдэн бүтсэнг үр удамдаа өгүүлэн хүргэж, үр удам үргэлжлүүлж цааш дэлгэрүүлээд үр хүүхдүүддээ үглэн хүргэнэ.

Чан Чун Бумба:

- Мөөн, Мөн сонин. Ухаанаас ухаанд шууд уламжлах...

Их хаан эзэн Чингис:

- (Их хаан толгой дохино) Тийм.

Чан Чун Бумба:

- Танай улсын ухаанаар бойжихын тулд та нарын дунд төрж өсөх ёстой болох нь ээ...

Их хаан эзэн Чингис:

-Мэргүн арц, тийм ээ, тэгээд бүр тал нутагт.

Чан Чун Бумба:

- Хүлгийн нуруун дээр үү?

Их хаан эзэн Чингис:

- Тэр ч бас мөн...

Чан Чун Бумба:

-Эгэл бус улс. (Толгой сэгсрэнэ) Гайхаад баршгүй нь. Судар ном бүтээдэггүй гэсэн үг үү?

Их хаан эзэн Чингис:

- Хаан төрийн судар номоос илүү уураг тархинд итгэх ёс бий. Хааны үг зарлигийн бичигт хүрэх эрхтэй байхын тулд гагц алтан ургийн дотор төрсөн байх ёстой.

Чан Чун Бумба:

-Танай ард түмний гайхамшигт нууц тал нутаг, хүлэг морь, тархи дотроо ажээ. Суу ухаан нь дэлгээтэй сударт буй гэхээсээ уураг тархинд ажээ. Хүмүүнийг засаглахуй ухааны судар хаан таны гавалд гагнаастай. Мунхагууд бид хөөрхий. Өвлөн үлдэх хойчийн буян заяа их байх болтугай!

Их хаан эзэн Чингис:

- Юун уйт үг хэлэв. (Бодолхийлнэ) Таны адил суу зальт хүмүүн ч сунгах насгүй. Хүлэгтэн хөх нуруут бидний явдал хөрстийн цээжээр дүүрэв. Мэргүн арш, бүү харамс. Тохинуулах засаглахуйн ухааныг тод бичигт буулгах болно.

Чан Чун Бумба:

- Эй, аз зол... хөөрхий хүмүүн төрөлхтөний аз зол. (Хааны өмнө ирж мөргөнө.)

Өлзийдэй ноён:

- Хаантан минь Тэрсүүдийн хаан Мухаммед шахын эх олзны их хатан Турхани, Мухаммедын эмс хүүхнүүд өргөөний өмнө ирлээ.

Их эзэн хаан Чингис:

- (Оруул хэмээх мэт толгой дохино)

(Өлзийдэй ноён алга ташина. Гаднаас олзны хатан эх Турхани түүний эмс хүүхнүүд мөн зарц Фатима орж ирцгээнэ. Их хатан эх заасан зүгт үл суун зогсов. Бусад сөгдөв. Хатныг дагасан шивэгчдийн нэг Фатима хэмээх зарц эм жинтүү авч их хатны өмнө яаран ирж тавив. Тэр мөн доош сөгдөв. Их хатан үл сөгдөнө.)

Их хааны цэрэг:

- (Их хатанд ширүүнээр тушаана) Сөгд! (Турхани хатан үл сөгдөнө) Их хааны эрхэнд хураагдсан хөгшин эм чи сөгд! (Сэлмээ атгана. Хөгшин хатан дуртай дургүй жинтүү дээр өвдөглөн сөгдөв)

Олзны хатан эх Турхан:

- Монгол хаан чи их хотыг минь нурамлав. Одоо чи хөгшин хатан намайг яах хүсэлтэй байна вэ?

Их хаан эзэн Чингис:

- Дэлхийн бүх эмсийн эзэн гэж өөрийгөө өргөмжилсөн хөгшин хатны эрх мэдэл Хорезмын ихэс ноёдын голомт залгах хөвүүдийг хан хэрэмд тэжээх нэрээр хорин, засаглах хүслээ гүйцээдэг нь юутай өрөвдөм бэ? Харгис хатан чамаас чиний ноёдууд хорин нэгэн хөвгүүнийхээ амийг нэхэв. Тэд хаа байна вэ?

Их хааны цэрэг:

- Хариул! (Сүрдтэл хэлнэ)

Олзны хатан эх Турхани:

-Тэд миний албатууд.

Сорхагтан хатан:

-Хөгшин хатны гараас цус ханхалж байна.

Хан Толуй:

- Хорезмын хорин нэгэн язгуурт хөвгүүдийг хатан эх хөлөөс нь чулуу дүүжилж усанд живүүлж хөнөөсөн байна.

Олзны хатан эх Турхани:

-Бүдүүлэг малчны хаан чи намайг илдээрээ эсгэ. Үхэх минь.

Их хааны цэрэг:

- Их хааныг юу гэв чи! (Сэлмэндээ ишийг барина)

Их хаан эзэн Чингис:

-Чиний улс миний гүрэнд багтаж шудрага үнэнээр сэрэхийг хатан эх чи харах болно. Хар хатанг хатавчинд суулга. Харах бүрдээ бүгд цугаар эд баялагийн арчаагүй хямдхан мэдлийг мэдрэх санааны сануулга болог.

Олзны их хатан Турхани:

- Чиний эмсээс малын үнэр ханхалж байна. Малчны хаан чиний төр мөхнө.

Их хааны хатан Хулан:

- Аймшигтай. (Дуу алдана)

Хан Толуй:

- Хар хэлт хөгшин хатанг өргөөнөөс гаргаж хатгаж сүлбэн үхүүл!

(Их хаан хориглон гараа дээш өргөөд буулгана. Хааны цэрэг сугалсан сэлмээ буцаана)

Их хаан эзэн Чингис:

-Хатавчины хатанг хаясан ясаар хоолло. Шадар ноёд, хатдад Мухаммед хааны эмс, шивэгчидийг хуваан өгөхтүн.

Олзны хатан эх Турхани:

-Боолын заяа хатан надад зохихгүй. Одоохон ал. Алаад өгөөч! (Цээжээ балбан уйлна. Хатантай хамт орж ирсэн эмс, шивэгчид өргөөнөөс явах болно. Хөгшин хатан Турхани зарц Фатимагийн гараас барина. Цэргүүд хатанг түүнээс тусгаарлах гэнэ)

Олзны хатны шивэгчин:

-(Хатны жинтүүг газраас аван түүнд өгнө) Өршөөгөөрэй. Их хатан эх минь.

Олзны их хатан эх Турхани:

- Намайг битгий орхиоч... Фатима аа...уйлагнан Би чиний их хатан эх байна. (Чанга дуугарна. Гэвч энэ захирамж энд хэрэггүйг мэдэрнэ. Уйлагнана) Хамгийн хатан эх чинь үхмээр байна. (Цэргүүд тэднийг салган хөгшин хатанг хатавчинд суулгана. Өргөөнөөс эмс, шивэгчид явна. Хатавчинд суусан хатны өмнө аягач яс чулуудна)

(Далдаас, Их цэргийн бүрээ урамдан дуугарах дуу дуурсана)

Их хаан эзэн Чингис:

- (Илтэд баясна) Тэд минь ирлээ.

Элч :

- (Өргөөнд орж ирнэ) Цагаадай Өгэдэй, Зэв Сүбэгэйдэй тэргүүтэй их цэргүүд Крым, Судак, Денепр, Азовын тэнгис тулж, Каспийн тэнгис Арал тэнгисийн нутгийг эзлэн Сырьдарьяа мөрний эрэг дээрхи Их Монголын эзэн Чингис хааны их цэргийн хүрээнд орж ирлээ.

Их хаан эзэн Чингис:

- Хан хөвүүд минь, Дайчин баатар эрс минь ялалт өвөртлөн айсуй. Толуй хан хөвүүн минь дайчин хүлэгтэн цэргүүдээ тосон автугай! (Толуй хан хааны өмнө ирж ёслоод явна)

(Бүрэнхийлэл... Гэрэл тодроно) (Гаднаас Цагаадай, Өгэдэй , Зэв. Сүбэгэйдэй нар өргөөнд орж ирээд хааны өмнө зэрэг ёсолно. Толуй тэдний ард мөн ёсолно.)

Хан Цагаадай:

- Их хаан аав минь амар амгалан морилож байна уу?

Их хаан эзэн Чингис:

- Хан хөвүүн Цагаадай чи өвөг эцэгтэйгээ эгээ адилхан үзэгдэж байна.

Хан Өгэдэй:

-Их хаан аав минь аян дайны замдаа амгалан морилно уу?

Их хаан эзэн Чингис:

-Амгалаан амгалан. Өгэдэй хөвүүн чиний ухаан билиг арга мэхийг сонссоон. Эцгийн бийд уулыг давж усыг гатлах гэдэг энэ дээ. Үзвээс нүднээс чинь баяр хөөр гэрэлтэж, үгнээсээ түрүүлээд нүд чинь ярьж эхэлнэ. Баатар жанжин Зэв, Сүбэгэйдэй нарын минь аян дайны олз омог их тэнгис далайг өвөртөлжээ. Бахархах сэтгэл минь цээж дүүргэв.

Жанжин Зэв:

-Их хаан эзэн таны зарлигаар Хорезмын тэрсүүдийн хаан Мухаммед шахын мөрийг мөшгин явсаар Каспийн тэнгисийн нэгэн бяцхан арал дээр очлоо. Зугтсан хааны эцсийн нүүдэл тэр ажгуу. Аймшигтай нь энэ аралд өмөн өвчинд баригдан хот улсаасаа хөөгдсөн эрэмдэг зэрэмдэг хүмүүс орогнох бөгөөд тамыг санагдуулам аймшигт зүс царайтай тэдгээр хүмүүс тэрсүүдийн хаан Мухаммедыг зарцлан сөгтгөжээ. Хорезмын хаан үхлээ өөрөө олсон байх ба түүний сүүлчийн үхэл жигтэй ба сэжиглэм. Тамын зовлонт эрэмдэгчүүдээр шахын цогцосыг олуулж танив. Хааны тамгат бөгж энэ байна.

Их хаан эзэн Чингис:

-Аригун ноён, Бөгжийг эхэд нь өг. Хатавчны хатан таниг! (Зэв жанжины гараас даавуунд боолттой бөгжийг Аригун ноён авч хатавчны хатаны дэргэд ирэн түүнд хаан хүүгийнх нь бөгжийг үзүүлнэ. Их хатан эх Турхани бөгжийг хараад айн цочино)

Олзны хатан эх Турхани:

-Мухаммед хаан, миний хүү чи үхжээ. (Нүүрээ дарснаа Хаан руу харна) Миний хүү хаан чамайг алж чадаагүй ч миний сүнс чамайг амрахгүй дээ.

Их эзэн хаан Чингис:

- Их өргөөний хатавчнаас хөгшин хар хатанг хөө! Олзны хатанг тал нутагт малчны гэрийн хаяанд суулгаж хөгшин хатнаар унгас ноос савуулахгүйн!

Өлзийдэй ноён:

-Их өргөөнөөс үтэр түргэн чирч гарга! (Хар хатанг хэвтүүлүүд чирч гулдрал авч явна...)

Хан Толуй:

-Тэнгэрийн уур хилэн Мухаммедыг аймшигт там руу илгээж хатуу цээрлэлийг өөрөө хүртээжээ. Энхийн элч, Их Монголын алтан аргамжааг таслан, улсын итгэлийг эвдэн худалдаачдыг маань хороосон Инальчук тэргүүтэй башир сэтгэлтэнгүүд бүгд шийтгэгдэн хохиров. Хорезмын Бухар, Отрар, Нишапур, Ургенч, Хороасан болон бусд улс, олон хот бүгд Их Монгол гүрний мэдэлд шилжлээ. Хүлэгт дайчин Бала, Дөрбэй нарын цэргүүд Желал-Ад-Динийг нэхсээр Энэтхэгт цөмрөн Мультаг, Пенджаб, Лахор, Пешавар зэрэг хотуудыг их улсын ясу хуулийн өмнө буулган тулалдана.

Их хаан эзэн Чингис:

-Их Монгол улсын ясу цаазыг энд үүрд мөрдүүлтүгэй. Их засгийн алтан аялгуугаар эзэлсэн орныг хураан засаглаж, хүмүүнийг өөд татан хөх тэнгэрт дөхүүлэх хутаг мөнх орштугай! (Хааны царай хувирч. Догшин болно) Их Монголын голомтонд төрийн хэргийг засаглах миний дүү Отчигон ноён, Алагтун бэхэ нараас элч ирэв. Тангудын хаан Алтан улстай холбоолж их гүрний эсрэг ар худрагаар маань нууцаар холбоолно. Их хаан би Их Хуралдай зарлан хуралдуулж, шинэ улсыг хэрхэн засах, мөн сэм сүлбэлдэх улсыг хэрхэн шийтгэхийг хэлэлцэх их цэргээ дуудан цуглуулав. Их төрийн дайны төмөр жолоог хаан би эргүүлэн татаж эх нутгийн зүг цугаар эргэх боллоо. Хан хөвүүд, хүлэгт баатрууд минь зорьсон хэрэг сэтгэлчлэн бүтэв. Аян дайны алжаал юугаа Сырьдарьяа мөрний эрэгт тайлахгүйн! Их найр цэнгэл үүсгэтүгэй!

(Их хаан эзний өмнө бүгд мэхийн ёслоно)

Хоёрдугаар үзэгдэл.

2. Их хаан тэнгэрийн хэлийг тайлав

Тайз: Төрийн хатан Хулангийн өргөө. Хатан Хулангийн бие ихэд доройтсон байх ба хатан өргөөний өргөн орон дээр ирвисийн эрээн хөнжилд хэвгэнэ. Есүй хатан, Есүйгэн хатан, Сорхагтан хатан, Дөргэнэ хатан, Мүхэй хатан нар болон өргөөний бараа бологч эмсүүд, эм тан баригч, дом үйлдээч, аягач шивэгчид зэрэг дан эмэгтэйчүүд байна. Өргөөнд Их хаан орж ирнэ. Түүнийг Өлзийдэй ноён дагаж орж ирнэ. Хулан хатан өргөн орноос өндийнө. Хатад бэрүүд болон өргөөнд байгсад бүгд хаанд ёсолно.

Хатан Есүгэн:

- Ариун угаалга үйлдлээ. ,

Хатан Есүй:

- Тэнгэрт мөргөл үйлдэхийг хүссэн.

Хатан Хулан:

-(Хулан хатан орноосоо өндийнө) Хаантан минь.

Их хаан эзэн Чингис:

- Хулан хатан минь

Хатан Хулан:

- Цаг тулжээ. Мөнх хөх тэнгэрт мөргөөд одох хүч надад хүрэлцэнэ. Сүүлчийн хүслийг минь хаан та биелүүлнэ үү?

Их хаан эзэн Чингис:

-Хатан минь хүслээрээ болтугай.

(Их хаан сэнтийдээ сууна. Хулан хатны тэргүүнд бортогон малгайг хатад зүүж өгнө. Ёслолын булган дахийг нөмөргөнө. Хулан хатан тэнгэрт мөргөнө.)

Хулан хатан:

- Мөнх тэнгэр минь. Хатан хүнд гурван эр заяагдмал ажээ. Анхны эр алтан төр, ариун нэр, авсан эр ажгуу. Алтан төрдөө мөргөө. Алдар нэрийг өгсөн эзэн хаанд мөргөө. Ариун биеийг хайрласан хаан эрдээ мөргөө. (Хаанд гурвантаа мөргөнө. Өндийнө. Хаан руу харна) Их хаан таны хатан явсан минь миний энэ насны дээдийн зол заяа болов.

Их хаан эзэн Чингис:

-Хамаг монголыг нэгтгэхээр хар нүдээ үл цавчин, хатуу илдийг үл тавин, тэнгэрийн эрхэнд талын салхинд ид халуун биеээ эс эвхэн явлаа. Тэр цагт мэргэдийн иргүн улс тэнгэрийн сүр хүчний дор бөхийхөд Дайр Үсүний гэрэлт охин Хулан чи, хаан миний хилэнг хайлуулахаар өмнө минь яг ингээд ирж билээ. Урд минь үзэгдсэн чиний үзэмж гоо, үгний цэцэн цэнгэг хаан миний бие сэтгэлийг тэр цагаас бүрэн эзэмдэж чадсан билээ. Санаанд энэ бүхэн тод байна.

Хатан Хулан:

-Энэ ертөнцийн эзэн, миний хаан эр минь. Эрх хонгор насны бэрх цагийг та дуудлаа. Тэгэхэд би таны өмнө өст сэтгэлээ нууж ядан өмнө чинь чичрэн ирээд харцны чинь гүн, хад чулууг ч хүлхэх чадалтайг үзсэн билээ. Харин дараа нь хаан та торгон хөнжлийг минь эзэгнэх мөчид Мэргэдийн өст охин би эм заяагаа шүтэж их хаанд үүрд үнэнч явахаа зүрхэндээ шивнэсэн билээ. Өмөгт хатан заяаны хувь хагас ажээ. Аз минь өчүүхэн настай аж. Аз жаргалыг таньд би гүйцээн өгч амжсангүй. Өршөөгөөрэй хаан эр минь.

(Хатад түүний дэргэд ирнэ)

Их хаан эзэн Чингис:

-Язгуурын халуун зүрхт Хулан хатан минь, хазайхад минь түшиг, хальтрахад минь дах болсон хатад минь, хаан хүнд л заяах хатан эрдэнүүд минь. Ертөнцийг хураан ер бусыг байгуулах хүч чадлын ундаргууд минь, Тэнгэрээс ирсэн ухааны тэмдэг нь та нар минь Хурц сэлэмний мөр дагаж урссан цус, хаан миний өргөн зам мөр угаас ийм гэрэлт сэтгэлийн төлөө, угаас ийм үнэн зан, шударгуу ариун нандины төлөө байдгийг хатдын минь хурц ухаан, чин сэтгэл хаан миний хилэнгийн дараах цээжний шаналангаас авардаг. Хөрстийн хаан би ухаан билгийнхээ үнэн мөнөнийг хатад охидынхоо харамсах эс харамсах сэтгэлээр дэнсэлдэг. Оюун ухаан зүрх сэтгэлийн их дэнсний хэм болсон хатан Хулан минь

Хулан хатан:

-Хаан минь, хатан биений минь үнхэлцэг зүрхэн доторхи үхлийн хөндүүр айдас арилчихлаа.

Их хаан эзэн Чингис:

- Чамайг алдана гэдэг төрөлхтөний заяа уртаасаа хасагдахын харамсал. Төрсөн хаан бие эмтрэхийн нэг уй гуниг. (Нүүрээ дарна) Хулан хатан минь дээ.

Хулан хатан:

- Их хаан эр минь, Хатад минь, их төрийн агуу өргөөний алтан баганыг түшилцэж, алтан бүслүүрийг таталцах ухааныг Бөртэ Үжин их хатнаас сурсан билээ л би. Есүй минь, их өргөөний үүдийг сөхөх элгэмсэг ур дүйт ухааныг хатан таниас авсан билээ л би. Есүгэн минь, эм хүмүүний авьяас билгийн нууцыг таниар заалгасан билээ л би. Сорхагтан бэхэ бэр

минь, их тэнгэрийн зөн билгийг чамаас таньсан билээ л би. Мүхэ бэр дүү минь, эрдэм номын ухааныг чамтай таалцах дуртай билээ л би. (Биеийн тамир муудна)

Мүхэ хатан:

- Хулан хатан эгч минь.

Хулан хатан:

- Мүхэ дүү минь миний бие сайн байна. Баясал надаар дүүрээд би хээр тал руугаа ч давхиж хүрч чадахаар байна.

Есүй:

- Хайрт халуун Хулан хатан минь сувдан нулимсийг чинь арчиж өгье.

Хулан хатан:

- (Нулимсаа арчиад) Их төрийн хатад минь та нартаа мөргөө. (Хулан хатан, хатад мөргөнө. Хатад бас түүнд мөргөнө)

Есүй хатан:

-Хүсэх хүслээ хэлээч. Хатан дүү минь.

Хулан хатан:

- Хайртай хүлэг морийг минь эх нутагт минь сул тавиарай. (Хулан хатан ганхана)

Есүй хатан:

-Тэр чамд тэнгэрийн унаа болно.

Их хаан эзэн Чингис:

- Хүслээр чинь болгоё. Хатан чинийхээ хайрт шарга хүлгийн зоог амрааж, гэгэлгэн хээрийг ч нь амгаланд тавья.

Хулан хатан:

- Сэтгэл минь ханалаа. (Гэнэт бие нь сулрана. Хатад түүнийг түшин авна.)

Сорхагтан хатан:

- Хаантан минь бөө бэгийн цаг алдуурч байна.

(Өргөөний эмс шивэгчид Хулан хатанг өргөн орон дээр хэвгүүлнэ. Хатад ирвэсэн хөнжлийг нөмөргөнө. Тэд гуниг уйтгар дунд сууна. Хатад гэнэт мэгшин уйлна.)

Сорхагтан хатан:

- Их хаан минь, Хөөрхий Хулан хатан хөх тэнгэр лүү халин одлоо.

Их хаан эзэн Чингис:

- Их Монголын эзэнт төрийн их хаан миний зарлиг.

Аригун ноён:

-Жа., Хаантан.

Их хаан эзэн Чингис:

-Алтан өргөөний гадаа хүрээлэн буй хан хөвүүд жанжин баатрууд, миний хүлэгт дайчин хөх нуруутангуудад их эмгэнэл гашуунийг зарла. Их Монголын их төрийн Хулан хатан түүнийг их хатны зэрэгт онголсугай.

(Бүрэнхийлэл. Хатан Хуланг баатар эрс өргөн авч явна. Хатад эмсүүд дагалдана. Их хааны дэргэд Өлзийдэй ноён мөн зайран ирнэ) (Гэрэл тодроно) .

Их хаан эзэн Чингис:

-Миний хатад, бэрүүд, охид бүгд өнгө жавхаатай, гал мэт гэрэлтэй, Тэднийхээ уруулыг балаар амтлан, биеийг нь алтан хувцасаар чимж, хурдан морь унуулж, хурын цэнгэг ус уулгаж, малыг нь өвстэй нугад бэлчээж, зам харгуй, бэлчээр талыг нь хогийн өргөст цэцэгсээс цэвэрлэх нь хаан эр, хаан эцэг хэмээх туйлын нэр минь билээ. Хаана би осолдож алдав. Харагч бөө зайран минь хэлээч! Үнэрээ агаарт дөнгөж задалсан тэргүүлэгч цэцэг шиг гоо эрх хатан минь яагаад ийм эрт анхилуунаараа, яагаад ийм үзэмж төгөлдөр атал үхэлд булаагдан одох нь энэ вэ?

Зайран:

-Хамгийн хаан минь, хэлэхэд бэрх таахад хатуу хар хэл хатны аминд хүрэв. Гай түйтгэрийг атган барьж чадсангүй, хар хүчнээс сүнсийг хамгаалан тэмцэлдэв. Бөө бэгийн увьдас чадлын хүчээр хатны сүүлчийн тэнхлийг тэжээн сүнсийг агуулан дарж, мөнх тэнгэрт арай ядан даатгав.

Их хаан эзэн Чингис:

- Ивий тэр минь.

Зайран:

-Тэнгэрийн хүчийг дуудан хэнгэргээ нүдэхэд хэрэх хүч амины минь сүвэгчээр зүрхийг минь атгахаар завдав. Хачин ёр тэр, хар зүгийн хүч мөнөөс мөн.

Их хаан эзэн Чингис:

- Мөнх тэнгэр минь. (зогсоц) Хаанаас боссонг тааж мэдэв үү?

Зайран:

- Мэдэх гэхээр бэрхийн бэрхийг амсав.

Их хаан эзэн Чингис:

- Муу ёр хатны минь аминд хүрэв. Өвчний оёг үндэс үл олдож эдгээх тан эмийн шид эс бүтэн харсаар хар нүдэн дээр минь өвдөн үхэв. Хаан надад тэр гэхийн тэмдэггүй хүйдэс мэдрэгдээд удав.

Зайран:

- Муугаас муу, хараас хар, ёроос ёр түүний хар хүч их.

Их хаан эзэн Чингис:

- Харин урьд шөнийн үүр үнэгэн цагаар хар зүгийн сүг дүрс албин шинж урвуу дүрээр зүүдэнд орж гарч зүдрээв. Нэг бол үзэсгэлэнтэй эм, нэг бол цусан улаан эвэрт туранхай үнээ болон мөөрнө. Элдэв дүрийн нэг эм зүст хааны амь хөнөөхөд бэрх юм гэж уйлан уйлав. Төдөлгүй сүг сүүдэр хөхгүй шуламд хувиран тэнгэрийн хаан чамайг эс дийлэвч хаан төрийг чинь булаана хэмээн төмөр хуурайдах мэт инээв. Аймшигт хүч агаарт хувисаад алга болов.

Зайран:

-Урьд өмнө тулж үзээгүй муу зүгийн аймшигт хүч хаан төрд халдах ёрын хүчээ шидэв. Цаашдаа хэрхэх буйг хэлж мэдэхгүй нь хаан минь ямартай ч зүүдийг тань төлгө тавьж тайлъя.

Их хаан эзэн Чингис:

- Өлзийдэй ноён, өргөөг есөн хүрээнд хүрээлж хатуу хориг тавихтүн! (Өлзийдэй ноён хаанд ёслоод гарна. Далдад хэвгүүлүүдийн хөлийн чимээ үүснэ)

Зайран:

- (Чулуу татна) Их эзэн минь татсан чулууны хэлийг тайлвал хаан эзэн минь, таныг алтан биед халдаж үл чадах ба алтан аялгууг таньд гартахгүй хэллээ. (Хирдсхийн цочино) Ай аюумшиг. Хасар дүү тань, Хатан Хулан тань хар өлөгт өртжээ. Хаан ширээг өвлөх тэнгэрийн заяатай голомтны хан хөвүүн хийгээд үрийн үрийн заяаг харлуулах ёрын тэмдэг элгэн улаан чулуу ган ганц үлдэв. Үтэр түргэн гай түйтгэрээс өрсөх хэрэгтэй гэж чулуу шивнэнэ. Бас тэгээд ..

Их хаан эзэн Чингис:

- Мөн байна. Цааш нь бүү тайл. Төлгийн чулуу зүүдний замаар орж явсаар тэнгэрийн хэлийг өгүүлэх болно. Тэнгэр надад авралын зам зүүднээ нээсэн. Ад ёр сонсоно. Цааш бүү тайл. Үзчихнэ хураахгүн.

Зайран:

-Жа хаан минь. (Зайран төлгийн чулууг далдын хүчнээс айн яаран хураана)

Их хаан эзэн Чингис:

- Тал нутагтаа хүрэх замд уй гашуу дайрав. Төрийн зайран чи хаан миний зүүдний тайлалыг хавт цээжиндээ хав дарж хадгалахгүн! Хэзээ ч энэ зүүдийг үл тайлахгүн!

Зайран:

- Жа хаан эзэн минь, Хавт цээжиндээ үүрд дарсу.

(Бүрэнхийлэл) (Хулан хатанг их хатны зэрэгт хүндэтгэн алтан шарилыг зална. Эмгэнэл харуусалын дуу дуурсана) (Харанхуйлал)

Гуравдугаар үзэгдэл.

3. Алтан гавлын нууцыг нууцлав.

Тайз: Хааны гэр өргөө. Их хаан эзэн Чингис, болон Есүй, Есүгэн хатан, Чан Чун Бумба, Илюй Цуй Цай, Хааны ач Хубилай болон бусад бараа бологч нар байна. Их хаан эзэн

Чингис:

-Ертөнц дахинаа ихэсийн жаргал цэнгэл хэтийдсэн тул мөнх тэнгэр буруу үзжээ. Хаан миний бие ар газар төрсөн тул тугал, хургын хамт өсөж, хүчир бэрхшээлийн дунд бойжин, идэж уух, өмсч эдлэх нь дөхөм борогжуун бөгөөд хүсэл тачаалд үл шунах ажгуу. Ард иргүний үр хөвгүүдээр үзэж, цэрэг байлдагчидад ах дүү мэт ханддаг. Эелдэг, энэрэхүй өгөөмөр харъяатыг боловсруулахуйд биеэр манлайлж, хатгалдан байлдахуйд үхэхийг үл сэтгэмүй, тийнхүү их үйлс бүтээж, таван өнгө дөрвөн харийг нэгэн жолоогоор шударгатгав.

Чан Чун Бумба:

- Их эзэн хаан, Дөрвөн зүгт байлдан дайлж, махбодын гашуун ба барсын зовлон хийгээд өлсөх даарах, гачигдах мохох, басамжлагдах, доромжлогдох, гүжирдлэгдэх, зэрэг зуун зүйлийн мянган ангийн зовлон туулж, мах цусны мөрөн далайд умбаж, мянган удаагийн үхлээс гэтэлж, түмэн зэрэг мөхөхөөс мултарч нар мандахын орноос нар унахын орон лугаа шудрага үнэнийг тулгажээ. Хүлэгт Богд гэгээн таны эл бүгд тэнгэрийн санаа болой.

Их хаан эзэн Чингис:

-Чан Чун Бумба аршийг тэнгэрээс түрүүлсэн мөнх хүн хэмээн хэлэлцдэг бөлгөө. Өөрөө нэрлэсэн буюу? Бусдаас дуудсан буюу?

Чан Чун Бумба:

-Хөдхи Бумба өөрөө нэрлэсэн бус өөр хүмүүсийн дуудлага бөлгөө. Амь насыг хамгаалах ёсон буйгаас бус ашид мөнхрөх бие үгүй болой.

Их хаан эзэн Чингис:

- Тийм... Ертөнцийн чуу үнэн өөрөө тэр мөн.

Чан Чун Бумба:

-Гурван мянган ял үйлдсэн ч ачлалыг өгөгч хүсэлтэн бол мөнх амьдралыг хойтод олно. Ачлалгүй бол мянган шидийг олсон ч зовлонт орныг эс гэтэлгэнэ. Хаан та эрдэм сүрээ бадруулан ачлалгүй явагсдыг сөгтгөнө. Ачгүй бачтанг тэнгэр ерөөс цээрлүүлдэг болой.

Их хаан эзэн Чингис:

-Хутагт аршийн үг хаан миний санаанд чив хэмээн нийлэв. Дээд тэнгэр хутагт аршаар эдгээрийг хаан надад хэлүүлсэн бөлгөө. Та нар марташгүй цээжлэн автугай. Хутагт аршийн гурван удаа өгүүлсэн урт наслахуй ёс нь миний сэтгэлд гүн суугдав. Хятад хүн хутагт аршийг хүндлэх нь үлгэрлэвээс та нар тэнгэрийг бишрэх лугаа адил болой. Өдгөө би тэнгэрий мөнх хүний өгүүлэн буйд улам итгэх болов. Арш өргөөнд удаж ядрав. Ахин зоог бариваас ямар?

Чан Чун Арш:

-Хөдөх бумба болвоос бясалгагч хүн тул гагцхүү нам гүм сэлүүнд дуртай. Нутгийн зүг зам салах цаг ирсэн тул биеийг хичээе. (Арш босно.)

Их хаан эзэн Чингис:

- Та тааваараа болтугай. Есүгэн хатан аршийг өргөө юунд хүргэтүгэй. (Есүгэн хатан Чан Чун Бумба дээр хүрэлцэн ирнэ. Чан Чун Бумба хаанд мэхийгээд явна) (Өлзийдэй ноён өргөөнд орж ирнэ)

Өлзийдэй ноён:

- Хан хөвүүд айсуй.

Их хаан эзэн Чингис:

-Би хөвүүдтэй тусгайлан уулзана. (Есүй хатан, Өлзийдэй ноён, Илюй Цуй Цай, болон бусад бараа бологч нар хаанд ёслоно) Хубилай, ач хөвгүүн түр үлд. (Хубилай ач хөвүүн үлдэнэ. Бусад явна. Хаан Өлзийдэй рүү явж болно хэмээн дохино. Өлзийдэй хамгийн сүүлд ёслоод явна. Хубилай хааны өмнө ирж сөгдөн сууна) Зөөлөн дүртэй хөвүүн минь... Сүргийн эзэн адууны хүч юунд оршдог вэ?

Хааны ач Хубилай:

-Азрага бол тэнгэрийн хүлэг.

Их хаан Чингис:

- Үр төл нь мөн тэнгэрийнх. Хамгийн хаан байхын нууц нь юу гэж би чамд хэлсэн бэ?

Хааны ач Хубилай:

-Мөнх тэнгэрээс заяагдах.

Их хаан эзэн Чингис:

-(Инээнэ) Тиймээ... Тэгвэл хөвүүн чи тэнгэрийн бус зүйлийг нэрлэ дээ.

Хааны ач Хубилай:

-(Бодолхийлнэ) Уул ус, жигүүртэн шувуу, цэцэг навч хүмүүний бие тэнгэрийн шимийг хүртэнэ. (Дуу нь бүдгэрснээ гэнэт цовоо дуугаар) Боулхай, булхай муу сэтгэл.

Их хаан эзэн Чингис:

- (Илтэд баярлана) Мөн дөө... Чиний хүлэгт, бас чамд боулхай булхай сэтгэл бий юу?

Хааны ач Хубилай:

- Байхгүй. Учир нь бид мөнх тэнгэрээс заяагдмал.

Их хаан эзэн Чингис:

-Тиймээ бид бусдаас юугаараа ялгаатай вэ гэвээс тэнгэр газрын шимээр бүтсэн мөнх тэнгэрийн сэтгэл. Бидний сэтгэл мөнх тэнгэрийн алтан аялгуу.

Хааны ач Хубилай:

- Хамгийн хааны нууц бол бидний сэтгэлийн алтан аялгуу.

Их хаан эзэн Чингис:

- Бидний гэв үү. (Баясана) Мөн. (Хурцаар хөвүүнийг харна) Хөх тэнгэрийн далд дахь мөнхийн хүчийг чагнаж яв. (Өөрийнхөө цээж рүү зааж) Тэр цээжинд эгшиглэдэг юм. Миний үр үндэс бүхэн хааны заяатай гэхдээ мөнх тэнгэр нэгийг нь нэрлэнэ. Учир юу гэвээс энэ ертөнцийг нэгэн гайхамшигт гэрэлт нар гэрэлтүүлдэг шиг нэг агуу хаан захирах ёстой. Чи миний үгийг санаж яв. (Хуруугаараа Хубилай руу чичлээд) Чи бол хамгийн хх.. (Үгээ залгин царайн хувирч гүн бодолд орно.)

Хааны ач Хубилай:

-Их хаан өвөө минь таны сэтгэлийг юу зовооно вэ?

Их хаан Чингис:

- Энэ зовлонг чи ч бас амсана. Гэхдээ одоо биш. Охин хүүхэд шиг зөөлөн гадаад дүр чинь надаас ялгаатай ч чиний доторхи надтай адилхан хатуу чанга гэдгийг би чамаас харав. Хувь тавиланг чинь нэр чинь бас заажээ. Яв даа.

Хааны ач Хубилай:

- Жа. (Хубилай өргөөнөөс явна)

Их хаан эзэн Чингис:

-Азрага байдсаа хасаж хөөнө. Чоно бэлтрэгэнийхээ хоолойг тас хазна. Бүргэд өндгөө үүрнээсээ түлхэнэ. Амьтны араншин, удам угсаагаа авч гарахын үлгэр, амьд үлдэхийн чанар.

Удмын төлөөх урьтаж угтсан зөн. Байгал ертөнц бүгдийг бичиглэнэ. Унших ухаан л хүмүүнийх ажгуу. (Шийдмэг байна)

(Гаднаас Хан Өгэдэй, Хан Толуй орж ирнэ. Их хаан эцгийнхээ өмнө ирж ёсолно)

Өгэдэй хан:

- Их хаан аавын үтэр түргэн ир хэмээн дуудснаар яаран довтолгож хүрч ирлээ.

Их хаан эзэн Чингис:

- Уг нь би хан хөвүүдээ бүгдийг их өргөөндөө дуудсан юм. Зүчи минь эс ирэв. Өвчтэй хэмээн элч илгээн хэлүүлэв. Ав хомрогын үеэр мөн шалтаг өгөн эс ирэв. (Цагаадай руу хяламхийнэ. Цагаадай хаан эцгээсээ нүүр буруулна) Цагаадай чи сонсохтүн! Бусдын зүрхний энэлэнг өөрийн бие дээрээ буулган мэдэрч мэдэж яв. Баяр хөөрийг ч мөн адил. Ялалт ялагдалыг ч түүн шиг хүрт!

Цагаадай хан:

- Жа... Хаан аав минь.

Их хаан эзэн Чингис:

- Хамгийн хайртай хан хөвүүн минь, их гэр бүлийн дотор шургагч муу хүмүүний хэлний зэр зэвсэгт зүрхээ хатгуулав. Хайрт хөвүүнээ би гуниг шаналангийн мөрд орохыг харна.

Цагаадай хан:

- Би их бурууг үйлдэв.

Их хаан эзэн Чингис:

-Хайран хан хөвүүн минь. Сайхан эхийн чинь надад өгсөн хамгийн их баяр ууган хөвүүн тэр минь. Нэгэн эхийн хэвлийд бүгд та нар бүрэлдсэн. Эхийн ачийг мөнхөд саналтай. Хан ахыгаа мэргэдийн зулбасага хэмээн хочлон дайрч бид бүгдийг мэдэх болоогүй гэж хэлснийхээ төлөө чи их гэрийг эзэн байх заяа хүртэх үү? Хэнхдэг дотор чинь үг бий бол хэл надад!

Цагаадай хан:

-Хаан аав минь хэлэх үг надад алгаа. Эрх надад бас үгүй.

Их хаан эзэн Чингис:

- Этгээдийн санаа тархинд чинь хэн сүвлэсэн түүнийг шийтгэхтүн! Үүнээс хойш муудалцан тэмцэгч хоёр этгээдийн нэгийг хэн дэмжвээс тэр этгээдийг цаазлахтүн! Урт удаан наст их гэр бүлд шургах зүүний үзүүр хэзээ ч бүү оруул!

Хан хөвүүд цугаар:

-Зарлигийг тогтоов.

Их хаан эзэн Чингис:

- Шудрага үнэн мөнхийн илд гэдгийг цээжилж явтугай. Бусдыг удирдах хамгийн анхны алхам өөрийгөө хянах нь зэрлэг арсланг номхруулахаас амаргүй зүйл бөгөөд хүч тэнхээтэй бөхийг дийлэхээс ч хэцүү зүйл болох уур уцаараа дарж жолоодоход оршино. Мөн баяр хөөрөө дарж эс чадвал бусдыг удирдаж үл чадна. Өөрсдийгөө бусдаас хүчирхэг, илүү ухаантай гэж хэзээ ч бүү бод, уул өндөр боловч оройд нь ан амьтан гардаг. Тэгэхээр тэд уулнаас өндөр байгаа хэрэг. Халуун сүүт Бөртэ эхийн хэвлийн нууц тэнгэрийнх. Хаан би ч үүнийг эс шүүнэ. Үүрд энэ нууц руу үл халдтугай. Ууган хан хөвүүн Зүчи та нарын ах миний хөвүүн гэдэгт итгэж явсугай.

Хан хөвүүд цугаар:

- Жа. Хаан аав минь.

Их хаан Чингис:

- Мөнх тэнгэр минь, хан хөвүүдийн сэжгийн цогийг бүр мөсөн унтраа! (Хан хөвүүдээ харснаа холыг бодолхийлнэ)

(Зогсоц) Мөнх тэнгэрийн ивээл дор хамаг улсыг нэгтгэх заяатай Монголын Эзэнт Гүрний их хаан, хүлэг моринтонгууд тэнгэрийн тааллыг дагаж аян дайнд мордоод их үйлс бүтээн хамаг улсыг хураан цуглуулав. Миний улс өмнө, умар, өрнө, дорно хаа хаашаа бүр нэгэн жил явах өргөн уудам нутаг орон бүхий их улсыг анх цогцлогдов. Ертөнцийг төвшитгөх үүргийг гүйцэтгэхгэхүй дор мөхөс миний амь нас даанч богино мэт амой. Үүнийг гүйцэтгэх нь та нар болно. Та нар дайснаа дарж өнө удаан зол жаргалтай амьдрахын төлөө ганц сэтгэл ганц тэргүүнтэй явах учиртай. Их хаан эцэг чинь өнөөдөр нэгэн их хэргийг шийдэх болов. (Зогсоц) Их Монгол Гүрний их хаан би (Өгэдэй рүү заана) Өгэдэй хан хөвүүн чамайг миний үхсэний хойно их монгол гүрний эзэн, хамгийн хаанд суутугай хэмээн нэрэллээ. (Зогсоц) (Хан хөвүүд цугаар гайхцгаана) Хэн үүнийг эс зөвшөөрнө. Одоо үгээ хэлтүгэй.

Өгэдэй хан:

- Их хаан аав минь. Зүрхлэн асуух үг Өгэдэй надад байна. Сийгэн тэр жил Тоул алтайн эзэн Тоулчу мэргүнийд зочилохдоо хаан эцэг та их улсын хаан болох эрдэмд мэргэшүүлэхээр хан хөвүүдийн дундаас отгон дүү хан Толуйг сонгон авч явсан. Туг сүлдийг барих нь гал голомтны эзэн Толуй отгон хан дүү хэмээн Өгэдэй би санасаар ирсэн билээ. Яагаад гал голомт залгах отгон дүүг хожмийн хаан суудалд заасангүйв?

Цагаадай хан:

- Хаан аав минь, Гурван үнэнд тэгш хаан төрүүлнэ хэмээн заагдсан Толуй басхүү Толуйн их

хатан Сорхагтан бэхэ Их хуралдайн даргач билээ. Бага хатан Мүхэ засагч хатнаар бэлтгэгдэн өргөмжлөгдсөн. Их улсын туг сүлдийг өргөн авах нь Толуй хан дүүгийн бүл билээ. Хаан аавын гэнэтийн санаа юун учиртай буй?

Толуй хан:

- Их гүрний эзэн их хаан аав минь, Их хуралдайд Толуй би хөрөнгө хөрвөж зоос мөнгөнд хувирахыг илтэд эсэргүүцсэн билээ. Хан Толуй би зоосны санааг мөхөөхийн тулд мунхаглалын хэцүүгээс гэгээрлээр зассан хаан аав таныг эл санааг дэмжихэд мунхаглалын шинэ үр тарив хэмээсэн билээ. Хойдыг таних билэгт ухаан надад дугав уу?

Их хаан эзэн Чингис:

-Нэгэнт олсон мэдлийг анд хүнд болгож чадаагүй болбоос нээрэт их засгийг хорлогч тэр мөн. Толуй хан хөвүүний хажир үнэнг зөвшөөрсөн би. (Зогсоц) Хатан хэвлийд бүрэлдэх алтан үр, хааны гавалд бүтэх ухааны үр тэнгэрийн явдал бөгөөд бүрэлдэн бүтэхүйн нууцаар агаар нэгэн мөн. Сүнсний аялгуу хэрхэн бүтэх нь тэнгэрийнх. Ухаан санаанд бүрэлдсэн санааны эл явдлыг тайлбарлан хэлэхэд бэрхтэй. Их итгэлийг би та нараас хүснэ.

Цагаадай хан:

-Тэнгэрээс заяат хаан аавд итгэх нь зайлшгүй.

Өгэдэй хан:

- Жа... гэхдээ хаан аавын оюунд тэнгэрээс юу ирэв?

Их хаан эзэн Чингис:

- Бидний ирээдүйг тэнгэр мэднэ. Тэнгэрийн ивээлээр болсон мөрийг минь бүү мөшгөгтүн. Бөртэ хатан эхийн хэвлийд үр та нар хэрхэн бүрэлдэх нууцыг таах гэж үл зүтгэхтэй адил, хаан миний гавалд энэ санаа хэрхэн бүтсэнг үл эр! Хар хүчний гэм зэм төрийг төнхөнө.

Хан хөвүүд бүгд цугаар:

- Хаан аав минь.

Их хаан эзэн Чингис:

- Бэрх хэцүү нүүрлэхийг би мэдэрч байна. Их итгэлийг та нараас гуйя.

Хан Толуй:

- Хан Толуй би хаан аавын их итгэлийг өвөрлөв.

Хан Цагаадай:

- Хан Цагаадай би их итгэлийг эдлэхийг хүснэ.

Хан Өгэдэй:

- Их Монголын эзэнт гүрний алтан төрийн жолоог хан Өгэдэй надад атгуулах их хувийг зааж, тэнгэрээс заяасан хаан эцгийн орыг эзлэх эрхээр намайг өргөсөнд хаан аавдаа ихэд баясав.

Их хаан эзэн Чингис:

- Зүч, Цагаадай, Өгэдэй, Толуй хан хөвүүд та нар хаан эцгийн зүрхэнд эв эе хичээн нэг гал болвоос төрөлхтөн амар жаргана. Зүч хөвүүн минь хэдий дэргэд байхгүй боловч миний гэрээсийг үл зөрчин самуурал гаргахгүй байх аа. Намайг үхсэний хойно Өгэдэйг өргөмжилөн хаан суулгатугай. Толуй хан хөвүүн чи хаан ахынхаа дэргэд ямагт байж мартсныг сануулж, унтсныг сэрээж яв. Хаан би хэзээд чамайг дэргэдээ авч, билэг ухааныг бусдаас сөөм илүү юүлсэн. Миний өвлүүлсэн эрдмийн тэрхүү өвөөр хаан ахыгаа хэзээд үл дутаа! Амла!

Хан Толуй:

- Хаан ах Өгэдэйн мартсныг сануулж, унтсныг сэрээж явахаа хаан аавдаа амлав. Амласан энэ амлалт хэрэв алдарвал сүнс минь тэнгэрт эс хүрэг.

Их хаан Чингис:

-Ай хан хөвүүн минь. (Нулимс дусаана) Толуй хан хөвүүн минь аргагүй би чамайг хааны ухаанд бойжуулан өсгөжээ. Бие, хэл, сэтгэл чинь их итгэлээр үтэр түргэн дүүрэхийг би үзлээ. Өгэдэй чи харж автугай! Хааны зэрэгт та ах дүү улс цугаар ирсэн юм шүү. Хувилгаан хөвүүд минь. (Нулимсаа арчина)

Хан Өгэдэй:

-Хаан аавд мөргөө. Чингис цоо ухаан Өгэдэй надад төрөх болтугай!

Их хаан эзэн Чингис:

- Болтугай! (Их хаан алга ташина. Гаднаас Өлзийдэй ноён орж ирнэ) Их өргөөнд төр гэрийн ихэс дээдэс, хатад ноёдыг урьсугай. Дуулгах үг бүрнээ бүтэв.

(Харанхуйлал.)

Дөрөвдүгээр үзэгдэл.

3. Дээд судрыг гурамсан алтан бүсээр бүслэв.

Тайз: Эх нутаг. Гал голомтны алтан өргөө. Их хаан эзэн Чингис, их хатан Бөртэ үжин, хан хөвүүд, хатад ихэс дээдэс харийн хэлийн ван ноёд болон хааны албатууд зэрэг дэвээрээ өргөөнд морилно.

(Өргөөнд морин хуур эгшиглэж, уртын дуу уянгалан найр цэнгэл дэлгэрнэ.)

Отчигон ноён:

- Их Монголын эзэн Богд Чингис хаан их цэргүүдээ манлайлан түмэн бээрийн чанд дах сартуулын орноо дайлаар одоод олон улс хотыг Их гүрний мэдэлд хураан ялалт өвөртлөн ирсэн ба Туул голын Хар түнэ дахь ордондоо морилох намрын эл цагнаа дээд үйлийн хуггийг олноо зарлах болов оо.

Их хатан Бөртэ Үжин:

- Алтай Хангай уулстай хар задын орон газар есөн мөрөнд цаг уур орон зай бүтэж, дэлхийн усны эхэнд байгалын хүчин дор хүмүнү үржив. Өтүгэ, мон, Моныг голлох, Монгол бүхий дөрвөн нэүрэт өвгөдийн маань амжилт бол их засгийн ухамсар билээ. Дөрвөн нэүрэт их засгийн мэдвэл зохихуй Алтан дээд үнэний аялгууг миний отгон хан хөвүүн Төр түшигт Толуй, хатан бэр Их хуралдайн даргач Сорхагтан бэхэ нар их хаан эзэнд өргөтүгэй.

Толуй хан:

- Их Монгол улсын эзэн хаан Чингис ану зарлигласнаар их хааны билиг сургаалыг тосон буулгаж, өнийн өвгөд мэргүнийн иш ухааныг хураан Бөртэ Үжин их төрийн их хатан эх тэргүүтэн Хан Толуй, Хатан Сорхогтан бэхэ бид Мөнх тэнгэрийн ясу зарлиг Их засахуйн Алтан дээд гэриэг сударлан бүтээж их хаанаа өргөх цаг болов.

Сорхагтан хатан:

- Өэлүн эхийн зөнд гэгээрч, өвгөдийн шавь болж, Есүхэй баатрын их хүслийн зүйтэн Тэмүүжин та билээ. Айл бүлийн хамтын хариуцлагыг улсын харилцаа болгож, арван түгээмэл хэмийг уялгын онолоор цэгцэлж Алтайн уулсын ар, өвөр хоёрт их засаг байгуулж, далайгаас далай хүртэл төвшин сайхныг тогтоож, далан гурван суут мэдвэл зохихуйг амжилт болгож, Моныг голлогч улсуудыг Монгол улс болгосон. Мянга есөн зуун дөчин гурван мэргэшлийг Мон амин чанар болгож Монгол ухамсрыг нээсэн Чин, чу, хажир гурван үнэнд гис байдлаар таарсан. Дөрвөн нэүрэт ухамсраар зуун найман хэм олсон Монгол зөнд нэн гүн гэгээрсэн Их хаан та билээ. Тэнгэр язгуурийн “Алтан дээд гэриэ”-г өлгийдөн баринтаглав. (Их хаанд хан Толуй, хатан Сорхагтан нар ширэн бортого гурван алтан бүст судрыг өргөнө. Хаан судрыг хүндэтгэн авна)

Их хаан эзэн Чингис:

- Мянган ам нэгдсэн тархитай байхын түмэн наст үлгэр миний газар өнөөдөр байгалийн бус бодит хүчин боллоо. Мөнх тэнгэрийн хүчин гэж Их засгийг миний хураасан улс нийтээр хэлтүгэй. Хамгийн хаан нь юу бодохоос үл хамаараад хамаг Монгол улс минь хамтын тархин дор төвшин сайхны төлөө халуун элгэн гэриэтэй байтугай. Их монгол улсын Чингис хаан би тэнгэрийн зарлигийг өргөв. (Дээш өргөнө) Ертөнцийн хүмүнү бүхэн наран дор төрөөд хуулин дор захирагдана. Мөнх тэнгэрийн хүчийг, хаанаар түрүү болгосон хамтын ноёрхолоор хэрэгжүүлж, түмэн он боловч үл буруудах их засгийн Алтан дээд гэриэ ийн оршвой.

Их хатан эх Бөртэ Үжин:

-Хурай! Хурай! Хурай!

Их хаан эзэн Чингис болон бүгд цугаар:

- Хурай! Хурай! Хурай!

Их хаан эзэн Чингис:

- Их Монголыг төрөөр бадраах хутагтай Нэүрэт засгийн алтан дээд үнэний аялгуу тэнгэр ертөнцийн аврагч билээ. Агуу Их Монгол улс минь, миний алтан ургийн үр ач нар минь их төрийг жолоодох үндэс засаг ба билгийн Алтан дээд гэриэг дээдлэн биширтүгэй! Хэн эс бишрэнэ тэр алдах үхэх! Хэн хаан тэр мөн бөхийхтүн! Эс бөхийвөөс тэнгэр нэргэгтүн! Толгойтон бүхний дээр гагц ясу хууль, ясу хуулийн дээр мөнх тэнгэр оршино. Мөнх тэнгэрийн алтан аялгууг миний хойчийн хаад, улс түмэн мөнхөд мөрлөн өргөтүгэй! (Хан Өгэдэй хааны өмнө ирнэ. Алтан дээд аялгуут бортогт мөргөөд хүндэтгэн авна)

Өгэдэй хан:

- Дота ухаан тэнгэр билээ. Бай ур дүй хан боловсролын тэнгэр билээ. Бата хур ерэн цэврийн тэнгэр билээ. Батачу цэцэн билиг амьдрахуйн тэнгэр билээ. Өгэлүн Хаубул хан олзын тэнгэр билээ. Өбэгүн Бай ур дүйтэн баатар зөнгийн тэнгэр билээ. Иэчихэ эх баатар засгийн тэнгэр билээ. Долоон дээд тэнгэрийн найм дахь болох Чингис тэнгэр билээ (Алтан гэрэгэнд өргөөд) Уялгын онолоор агуулагдах ахуйн тэнгэр болтугай. Моны онолоор суралцах хүслийн тэнгэр болтугай. Гэрийн онолоор байгуулагдаж улсын тэнгэр болтугай. Гурван үнэнд ургаж үүслийн тэнгэр болтугай. Гурван үнэнээр шалгарч оршихуйн тэнгэр болтугай. Дэлхий улсууд Монгол тархитай байхын дээд тэнгэр Алтан дээд аялгуу мөнх орштугай! Хурай! Хурай! Хурай!

Бүгд цугаар:

- Хурай! Хурай! Хурай! (Өгэдэй магнайгаа сударт гурвантаа хүргээд Отчигон ноёнд өгнө. Отчигон ноён дээдэд хүндэтгэн зална)

Их хаан Чингис:

-Өлзийдэй ноён зарлигийг болгоохтүн!

Өлзийдэй ноён:

- (Хуйлаастай зарлигийг дэлгэн өндөр дуу хоолойгоор зарлан дуудна) Их Монголын их эзэн Чингис хааны зарлиг бүгдээр сонстугай! Орчлон ертөнцийн амин чанарыг онож үйлдэхүйн сүр онолын дээд хур болсон их засахуйн Алтан дээд гэрэгэг алтан бүслүүрт өргөөнд төр залгах ёсны нэрт, Өгэдэй хан тэргүүтэй ерэн таван түмэн улсын зуун ноён залсугай. Алтан өргөөний өндөр газраа улсаа өмөөрөн босоо оршихуйн есөн ухааны есөн цагаан тугаар билэгдэж Толуй ханг сахиулд тогтоосугай. Оюуны санг билэгдэж найман цагаан өргөөг дэргэд нь барьж онолын их багш нарын ууган оюунтан Сорхангтан хатанг харуулд тавьсугай! Алтан дээд гэрэгэний сургаалыг Хан Толуй, Хатан Сорхагтан бэхэ хариуцан жилийн эхэн адаг бүр ихсээс энгийн иргүн ардад сонсготугай! Их Монгол улсын төр ёсны дээдийг өргөн залах эл өдрөө өтгөс настан бүрд хишиг түгээсүгэй! Нэг хувьд хишигт нэг лан мөнгө, нэгэн бөс, арван суулга амуу, жаран настанд хоёр хувь, наян настанд гурван хувь, ерэн настанд дөрвөн хувь, зуун настанд таван хувь, зуугаас дээш настанд хааны сангийн алтан хувь олгосугай! Улсын ард олон энэ өдрийг найр цэнгэлээр жаргаасугай! (зарлигийг хуйлна)

Отчигон ноён:

- Их хааны охин өмнийн орноо эзлэн суух төр захирагч гүнж Алалтун бэхэ их хаан эцгийнхээ агуу ялалтанд найр цэнгэлийг нэмэхээр яруу аялгуутай ирэв ээ.

Алалтун бэхэ гүнж:

- Их өргөөний ихэс дээдэс минь ээ миний захирах газар орон дуу хуурт нэн дуртай. Их хаан аав, их хатан ээж минь таалан болгоо.Өөрийн биеэр биелэн бүжсү би. (Алга ташина. Өргөөний захад байх хөгжимчид аялгуу үүсгэнэ. Олон гоё ганган бүсгүйчүүд гарч ирнэ. Алалтун бэхэ тэдний дунд голлон биелэнэ. Их хаан, их хатан тэргүүт бүгд даган баясана)

Их хаан эзэн Чингис:

- Хайрт охин Алалтун бэхэ минь цэнгэлийн дээдээр аавынхаа сэтгэлийг баясгалаа. Охин үр минь нялх балчиртаа эрхлэн нааддаг алиа хонгор үеэ дурсуулан сайхан цагийг эргүүлэн авчирч эцэг эхийгээ чи дахин баярлууллаа. Өтгөн гэр бүл минь, үнэр сайхан охин минь зол жаргал минь, хайрт эцгээ өршөөгөөрэй. Халуун залуу нас дөнгөж гэрэлтэхэд харь улсын дунд суулгаж хаан биеийг минь төлөөлтүгэй хэмээн охин чамайгаа одуулсан билээ. Ухаант цэцэн охид минь бүгд цугаар хураасан улсыг минь захиран сууж хүчийг өгөхийн ихээр өгч төрийг бататгана. Хатад охид минь та нар минь үгүйгээр би хэн билээ. Хэзээ ертөнц амар амгаланд хувьсаж хэзээ халуун ам бүлээрээ жарган суух болдоо та нар минь.

Алалтун бэхэ гүнж:

-Хаан аав минь бүү гунигла ялалт бүхэн бидэнд тэр цагийг ойртуулан авчирч байна.

Их хаан эзэн Чингис:

-Тэр түмэн үнэн. Алалтун бэхэ охин минь өөрийн захиран суух орон нутагт үймэн боссон

тэрсүүдийг хуяг дуулга өмсөн хурц сэлэм барин хүлгийн эздийг захиран дотоодын самууныг даржээ чи. Дайчин чин зоригт алдрыг чинь магтъя! Төрийн зөвлөх Елюй Цуй Цай та улсын бичигт миний охин Алалтун бэхийн алдрыг тоочин бичиглэтүгэй. (Илюй Цуй Цай хаанд ёслоод суудалдаа сууна) Охин үр минь чи хөвүүнээс үл дутна. Хаан аав нь чамд гоёл зүүлт бэлэглэх учиртай сан гэвч би чамд Хорезмийг мохоосон илдээ өгье! (Өлзийдэй ноён хаанд хааны сэлмийг өгнө) Энэ илд миний охиныг дайсны үймээн самууны аюулаас үүрд сахин хамгаалах болтугай! (Алалтун гүнж хааны гараас сэлэм тосон авна)

Алалтун бэхэ:

- Хаан аав хатан ээж минь урт удаан энх мөнх жарган суутугай !

Өргөөнд байгсад:

- Ерөөл бат сайн орших болтугай! (Алалтун бэхэ хаан аав хатан ээждээ гурвантаа мөргөн ёслоод өөрийн суудалд сууна. Бүжигч эмс мөн мөргөж ёслоод гарна)

Отчигон ноён:

-Их Монгол улсад алба өргөн ёслох Гуулин улсын Гао-Цзи тэргүүтэй ихэс дээдэс хаанд бараалхан өргөөнд морилохгүн! (Гао-Цзи тэргүүтэй ноёд гуулин улсын эд баялаг барьсан албат эмс өргөөнд орж ирнэ.)

Гао-Цзи ноён:

- Их хааны түмэн амгаланг эрье! Монголын жанжин Жала, Хабжин нар манай Гуулин улсын зүг энхийн зарт илч илгээж бидний хоёр улс үүрд ах дүү байж, түмэн үе үр сад маань энэ өдрийг бүү мартаг хэмээн гэрээ хийж найрсаг харилцаа тогтоов. Их хааны агуу улстай манай Гуулин улс ах дүү бололцон найрамдсаныг билэгшээн хаан таны яруу ялалтыг магтан сайшааж бидний эзэн хайр хүндэтгэллээ илэрхийлж буйг таалан болгооно уу! (Албат эмсүүд хаанд бэлэг сэлт барина)

Их хаан эзэн Чингис:

-(Их хаан баясан толгой дохино) Гуулин улсын иргэдийг найрсаг түмэн хэмээн хаан би машид талархав. Их улсын өмгөөлөлд үүрд орштугай! Өлзийдэй ноён, Их төрийн өргөөнд Гуулин улсын ноёд дээдэст суудал олгосугай! (Өлзийдэй ноён Гуулин улсын ихэс дээдэст суудал олгоно)

Отчигон ноён:

- (Үүд рүү харснаа) Тангудын орны дэргэдээс Мухулай жанжины хөвүүн Бору элч илгээжээ. (Хаан толгой дохино.Элч гаднаас орж ирнэ.Хаанд ёслоно. Хаан Отчигон ноён руу харна.) Төрийн их өргөөнд хурсан ихэс дээдэс хатад ноёд, гийчин зочдыг найр цэнгэлийн их өргөөнд урьж байна.

(Бүрэнхийлэл) (Гэрэл тодроно. Их эзэн хаан Чингис, хааны гэр бүл, хан хөвүүд жанждийн

хамт зогсоно. Их хаан гараа дээш өргөнө)

Их хаан Чингис:

-Миний дайчин цэргүүдээ! Та нар бол их улсын гол иргүн юм. Хад чулуу мэт хатуу юм. Хотын хан хэрэм шигээр намайг хамгаалж хулс мэт нягт зогссон миний цэргүүдээ. Та нар бүгдээр хаан миний хэлэхийг сонсохгүн! Тангуд улс, Их Монгол улстай найрамдъя хэмээн гэрээлэхэд энхийн хүчийг соёрхсон билээ. Гэтэл эл улс Алтан улстай эвсэн биднээс урвасан. Тангудууд эв эе итгэлцэл хэмээх юу болохыг хэрхэвч үл танина. Тангудын этгээд санааг бүр мөсөн мөхөөсү. Их Гүрний цэргүүдээ! Нударгын хуруу мэт бүлгэмдэн амьдарч дайран орох үедээ дүүлэх элээ мэт байгтун! Тоглож наадах үедээ жигүүртэй эрвээхэй шиг цэнгэж бүжиглэхтүн! Байлдааны үед болжморт буух харцага мэт орохтүн! Бидний шудрагуу үнэн эсэхийг мөнх тэнгэр мэдтүгэй!

Хаан цэргүүд цугаар:

-Уухай! Уухай! Уухай!

(Дайн тулааны хэнгэрэг дэлдэнэ. Бүрээ татна)

(Харанхуйлал)

Тавдугаар үзэгдэл.

5. Хаанд хулангийн дайрлагаар тэнгэрийн дохио ирэв

Тайз: Их хааны өргөө. Их хаан эзэн өргөн гоёмсог оронд том булган хөнжилөөр хучуулан өндөр дэр налан хэвтэнэ. Есүй хатан, Өгэдэй хан, Толуй хан, жанжин Сүбээдэй, Толун черби, Елюй Цуй Цай, Өлзийдэй ноён нар байна.

Есүй хатан:

- Их хаан минь, өршөөн соёрх! Хаан та минь, үгийг минь ав. Эрдэнэт бие тань бүхнээс эрхэм билээ. Эх нутагтаа харьж илааршлыг олоод эргэн ирж дайтах нь чухаг. Таны минь бие төрсөн нутгийнхаа ус агаарт сайжралыг олно гэдэг бид итгэж байна.

Елюй Цуй Цай:

- Хаантан минь, Есүй хатны үг туйлаас зөв. Амар тайван эмний дээд нь билээ. Дайны замыг түр орхиж, эргэн харьцгаая. Үтэр түргэн харих тусмаа таны амар амгалан таньд маань эргэн ирж, сэтгэл ухаан тань ядрал зүдрэлээс ангижран сэргэнэ.

Их хаан эзэн Чингис:

- Ар бухад их ав хомрого хийж байх бүхийд тэнгэр намайг сүрэг хулангийн дайралгаар өөдөө одон явахын дохио илгээн дуужээ. Гэвч өшөөт дайсныг бүрнээ өвдөглөн дарж байж санаа минь шулуудана. Тийм чөлөө надад буй хэмээн найдана. Бид байлдана гэж ирээд гэдрэг буцвал дайсан баясна. Тангудууд биднийг зүрх шантран буцав гэж хөхөрнө. Хийморь минь янцгаан буйг би мэдэрч байна. Гэхдээ энэ дайн миний хамгийн чухаг дайн. Эртний өшөөт Тангуд өрцний өргөс болон явсаар ирлээ. Их гүрэн мөн хаан би этгээд хүчирхэг улсыг бүрнээ дуусгаж амар амгаланг ёсоор нь мэдрэх болно. Би үхэх болоогүй. Үүнийг үзэх болно.

Толуй хан:

- Бид буцахыг эс хүсэвч таны эдгэрлийг эрхэмлэнэ.

Өлзийдэй ноён:

- (Хаанд хандана) Хаантан минь Бору жанжины элч ирлээ.

Их хаан эзэн Чингис:

- (Өндийнө. Толгой дохино) Би машид яарч байна.

Хааны элч:

- (Өргөөнд орж ирэн хааны өмнө ёслоно) Бору жанжин дуу бариулав.

Их хаан эзэн Чингис:

- Өчтүгэй!

Их хааны элч:

-Тангуд биднийг элэглэн басамжлав. Монголчууд та нар байлдаж сураад байлдья хэмээвээс миний Алшаа нутагт тэрэм гэртэй, тэмээн ачаатай хүмүүс буй Алшаа өөд зорьж над ирэгтүн! Тэнд байлдья! Алт мөнгөн агуурс таваар хэрэгтэй болбоос Яргай, Эрижэү хотод ирэхтүн! хэмээн өдөөн хатгав.

Их хаан эзэн Чингис:

- Юу гэнээ? (Их хаан хилэнгэн өндийнө. Гэвч түүний бие зовиурлан хойш хэвтэнэ)

Есүй хатан:

- Хаантан минь.(Хааныг түшиж тулна) Та хэвт. Биеэ хайрла.

Их хаан эзэн Чингис:

- Ийм их үг хэлж байхад яаж буцаж болох вэ? Үхэвч тэр их үгийг зүгээр орхиж болохгүй.

Өгэдэй хан:

-Хаан аав минь, таны зарлигийг сонслоо. Үл буцаж урагш хандья. Хандсан зүгтээ шувт дайрч, хамаг Тангудыг мөхөөе!

Толуй хан:

- Хаан аав минь. Тангудыг мөхөөсү.

Сүбээдэй жанжин:

- Тангудыг мөхөөсү.

Их хаан эзэн Чингис:

- Зөв. Хан хөвүүд, өрлөг жанжингууд минь зөв. Алтан улсаас Амбугай хаан тэргүүтэй миний өвөг дээдсийн цусан өшийг авахын тулд урваач Тангудыг буулган дар!

Сүбээдэй жанжин:

-Боомт бүхий алтан улсын шилдэг цэрэг нь өмнөш өндөр уулаар халхалж, ардаа их мөрөнийг түшин байх тул түргэн эвдэхэд бэрх билээ. Сүн улс, Алтан улс хоёр эртнээс өстэй учир, хэрвээ Сүн улсаас зам гуйвал манд саадгүй өгнө.

Их хаан эзэн Чингис:

- (Өндийн босно.) Өрөөсөн нүдэт Өрлөг жанжин минь зөв Тэр үед Танчжоу, Дэнчжоугийн газраар цэрэг орж, дахин буцаж Алтан улсын өмнөд нийслэлийг байлдвал, Алтан улс шахамдахад эрхгүй боомтоос цэргээ татах болно. Хэдэн түмэн олон мянган цэрэг газрын холоос туслахаар одоход хүн морь нь цөхөж ядрах тул хэдийгээр хүрч очиж чадваас тэд байлдах чадваргүй. Тиймээс эвдэрхүйеэ хялбар билээ. Дайн тулаан өмнө маань үзэгдэнэ. Мөнх тэнгэр чи мэд! Маргаашийн мандахын улаан нарнаар их цэрэг Тангуд руу довтлон дайлахтун!

Өгэдэй хан:

- Хаан аав минь зарлигийг авлаа. Дайлсу.

Толуй хан:

- Зарлиг ясу ёсоор гүйцээе!

Сүбээдэй жанжин:

- Биеэ гамнаарай хаантан минь. Зарлигийг аван морьдлоо.

(Их хаанд Өгэдэй хан, Толуй хан, Сүбээдэй өрлөг жанжин, Толун черби нар ёслоно)

Их хаан эзэн Чингис:

- Хан хөвүүд, өрлөг жанжин минь ялалт өвөрлөн над дээр иртүгэй!

(Хааны өргөөг орхин гарцгаана. Өлзийдэй ноён алга ташина. Эм тан барьсан албатууд орж ирнэ)

(Бүрэнхийлэл) (Гэрэл тодроно) (Их хааны дэргэдээс албатууд явсан байх ба түүний дэргэд Есүй хатан, Илюй Цуй Цай, Өлзийдэй ноён байна)

Илюй Цуй Цай:

- Хаан та унтаж байна уу?

Их хаан эзэн Чингис:

- Би сэрүүн байна.

Илюй Цуй Цай:

-Муутуу цааснаа хураан буулгасан Монгол яруу шүлгийн шаднаас хаан таньд дуудъя! (Хаан толгой дохино. Илюй Цуй Цай муутуу цаасыг дэлгэнэ) Хөхөмдөг уулсыг сэлмээр зурахуйяа уул хагарах шиг болмуй. Хөх мөрнөө хүлгээн услахуйяа мөрөн ширгэхэд хүрчүхэй Зуун түмэн шилдэг цэрэг мөрний өмнөдөд буухуйяа Жадны үзүүр, зэвсгийн дээр хурмасын хур гэрэлтэн

буумуй.

Их хаан эзэн Чингис:

- Чихнээ нэн яруу сонсогдов. Цааш нь дуудаач!

Илюй Цуй Цай:

- Жа... Үелзэх мөрөнд завь ургашлахуйяа долгион догшин Өмний нутагт морьд довголохуйяа өвс модон чичирмуй Түнэр үүлс мянган газрыг эгшнээ харанхуйлан бүрхэхүйеэ Түүдэг гал түмэн уулнаа шөнийн гүнд гэрэлтмүй.

Их хаан Чингис:

- Тийм ээ. Тэнгэрийн санаа тэр мэт тогтох ажгуу.

(Бүрэнхийлэл) (Гэрэл тодроло)

Өлзийдэй ноён:

- Хаан эзэн минь, Сүбээдэй жанжины элч дайны талбараас довлон ирлээ.

Их хаан эзэн:

- (Хаан догдлоно) Элчийн мэдээг үтэр түргэн дуулга!

Сүбээдэй жанжны элч:

- (Сөгдөн ёсолно) Их хаан, Сүбээдэй жанжны зүүн гарын их цэргүүд Тангудын орноо нэвтрэн орж, Ганьжоу, Сучжоу хотыг эзлэн эрхэндээ авав. Өдгөө их цэрэг элс манхныг туулж, Хатан голын есөн оломд хүрч Инли хотыг эзлэн авахаар цааш тэмүүлэн хөдлөв.

Их хаан эзэн Чингис:

- Өрөөсөн нүдэн хүлэгт Сүбээдэй минь, ялалтын мэдээ нааш илгээлээ. Миний хүлэг баатрууд шонхрын нүдээр Тангудын орны дээгүүр нисэн явна. Дуулав уу? Өлзийдэй ноён, Илюй Цуй Цай минь хаан миний магнай тэнийв.

Өлзийдэй, Илюй Цуй Цай нар:

- Хаан минь таны адил сэтгэл тэнийв.

Их хаан эзэн Чингис:

- Хөвүүн, хүлэг морь хөвчирсэн сум мэт нисэн ирсэн байлгүй. Элчийг амраа!

Сүбээдэй жанжны элч:

- Их хаан эзэн минь түргэн илаарших болтугай.

Их хаан эзэн Чингис:

- Болтугай. Нас сунам бахдал өвөртөлж ирлээ. Аян замын алжаалаа тайлаад хариу эргэн иртүгэй. Өрлөг жанжин өөд хаан миний дууг аван одсугай.

Сүбээдэй жанжны элч:

- Жа.., их хаан эзэн минь. (Элч хаанд ёслоод өргөөнөөс гарна)

(Бүрэнхийлэл) (Гэрэл тодроно) (Хаанд зориулан Есүй хатан намуухан аялгууг бифа хөгжмөөр тоглоно)

Өлзийдэй ноён:

- Өгэдэй ханы баруун гарын их цэргээс элч харван ирлээ. (Элчийн чимээгээр Есүй хатан хөгжмөө тоглохоо орхино)

Хааны элч:

- (Их хааны өмнө ирж сөгдөөд ёслоно) Их хаан эзэн танаа Өгэдэй ханы баруун гарын их цэргүүд Түрэмгий балгасыг бүслэн байлдан тулалдана. Тангудын эзэн Ли Дэ ван үхэж, түүний орыг ач хөвүүн Ли Сянь гээч эзлэв. Залуу Ли Сянь тавин хүрээ цэрэг удирдан Түрэмгий балгасыг хамгаалахаар хөдөлснийг Хан Өгэдэй мэдээл хэмээн илгээв.

Их хаан эзэн Чингис:

- Миний элчийг дууд! Өгээдэй ханы элч амарч автугай! (Өгэдэйн элч ёслоод гарна. Хааны элч орж ирж ёслоно) Толуй ханы цэргүүд өөд яаран довтлон хүрсүгэй. Хаан би Толуй ханыг Тангудын туслах их цэргийг Түрэмгий балгасанд ирэхээс урьтан хүчийг таслан цуцаа. Бүх цэрэгт сумыг хоосон харваж үл болон хэмээн хатуу зарлиглав. Элч чи одтугай!

Хааны элч:

- Мөрдлоо. Хаан эзэн минь! (Ёслоод явна)

(Бүрэнхийлэл) (Гэрэл тодроно) (Хааны дэргэд зайран ирсэн байх бөгөөд бие зайлан хэнгэрэгээ дэлдэн бөөлнө)

Зайран:

- Мөнх тэнгэрийн заяагаар үүдэн Мөргөл шидлэгийн эрчээр ирсэн Ерэн есөн тэнгэр хайрхад минь ээ Урин залан дуудъя.

Угтан залан урин мөргөө.

Нартын орноор заларч хайрла Нарсан хэнгэргээ дэлдсүү

Аргатын орноор морилж хайрла.

Арьсан хэнгэргээ дэлдсүү Шоог. Шоог. Шоог. (Дээлийн энгэр дэх толио харна. Айн сүрдэнэ)
Өршөө хаан эзэн минь.

Их хаан эзэн Чингис:

- Айлтгүй өчсүгэй! Миний төр эдүгээ ба хойчийн ирээдүйд юу эс байвч би сонсоно.

Зайран:

- Таны төр зуун зууныг үзнэ. Гэхдээ хаан минь. Хаш чулуун улс тань хагаран бутарч, хурааж цуглуулсан ард тань хамаг зүгт тарж, өндөр дээд ноёрхол тань бууран доройтно. Мөнх тэнгэр өршөө! Гэвч алсын урт ирээдүй хойчид төр чинь сэргэж хаан таны Монгол улс мандана.

Их хаан эзэн Чингис:

- Боллоо. Би сонсохыг хүссэнээ олж сонсов. Тэнгэрийн толь мэргийн харыг далдлан нууж мэргийн цагааныг үргэлж үзүүлэх болтугай.

Зайран:

- Толийг би хорзонд дүрж, сүүнд угаая! Их хааны есөн хүсэл эдүгээ ба ирээдүйд биелэх болтугай хэмээн тэнгэрт гараа дэлгэн мөргөн гуйя!

Их хаан эзэн Чингис:

- Сонсцгоо. Бид дайсны дотор буй бөгөөд хэдийгээр дайсны цэрэг ялагдалд илт ойртсон ч Тангудын эзэн бууж өгсөн атал ирээгүй билээ. Тиймээс миний үхсэн чимээг хэрхэвч дайсанд мэдэгдэж үл болно. Тангудын хаан ирсэн хойно алтугай! Зарлигийг хан хөвүүд, өрлөг жанжингуудад хадгалан бич!

Есүй хатан:

-Хаан эр минь.

Их хаан эзэн Чингис:

- Есүй хатан минь бүү сандар, би үхэх арай болоогүй байна. Үе үе ухаан нойронд алдуурна.

Илюй Цуй Цай:

- Жа..., хаантан бичиг үйлдье!

(Харанхуйлал)

Зургаадугаар үзэгдэл.

6. Их хаан эзэн тэнгэрт морилов

Тайз: Их өргөө. Хаан эзэн ёс төгөлдөр цагаан дээл малгай өмсөн сэнтийдээ морилно. Есүй хатан, Өгэдэй хан, Толуй хан, Сүбээдэй жанжин, Толун черби, Илюй Цуй Цай, Өлзийдэй ноён хааны цэрэг албатууд байна.

Их хаан эзэн Чингис:

- Өнгөрсөн өвөл би Яньчжоуд буухад таван од баруун өмнө агаарт төвлөрч байсныг олж үзээд алан хядахыг больсугай гэж амласан бөлгөө. Гэвч яарах учраас тунхаглалыг мартав. Хөх тэнгэр таван од найрсах цагаар тангараг өгч үүнээ зарлиг бичиг болгохоо мартжээ. Өдгөө нийтэд мэдэгдсүгэй. Үүнийг дотоод, гадаадад зарлан тунхаглаж, дэлхий дахинаа хүн бүрт мэдүүлсүгэй.

Илюй Цуй Цай:

- Их Монголын хаан эзэн Чингис таны эл зарлигийг тань алтан үсгээр мөнхөлсү.

Их хаан эзэн Чингис:

- Мөн. Туйлын сайн хэрэг. (Зогсоц)Зөвхөн тэнгэрийн эрхэс орчдог бус тэнгэр өөрөө байнгын орчилд оршдог. Хөх тэнгэрийн агаар сэрүүн хүйтнээр намайг урина. (Есүй хатан аяархан уйлна.) Бүү уйл, түүний оронд дуул.

Сүбээдэй жанжин:

- (Өөдөө болон босоод) Өвгөн шувуу асууруун (гэж хэлээд нулимсаа тэвчин уртын дуугаар аялгуулан дуулна) Жаргалтайн дэлгэр зуныхаа сард Жигүүртэн шувуухай та минь Гадаад их далайн захаас Ганганан дэвсээр юундаа ирэв.

Өлзийдэй ноён:

- (Өндийн босч) Шувуу учируун (гэж хариу хэлээд) Эргэх дөрвөн цагийн улиралд Ээлтэй халуун зуны сард Эртний үйлийн салхинаар дэгдэж Өссөн тунгалаг нууртаан ирлээ.

Сүбээдэй жанжин:

- (Хариу барин) Өвгөн шувуунаас асуун асууруун (гэж хэлээд цааш нь аялгуулан дуулна.)

Санаж хүссэн нууртаа ирээд Садан амраг нөхөртөөн золгоод Сайхан цэнгэн сууж байтал Сарын эцсээр юундаа уйдав

Өлзийдэй ноён:

- Шонхор шувуун хариу ийн хэллээ. (хэмээгээд мөн аялгуулан дуулна)

Өндөр уулын оргил дээр Үүл цас будрахын үед Улиран ирэх хүйтэн улиралд Өвөлсөн дулаахан газартаан явна аа

Сүбээдэй жанжин:

- Өвгөн шувуунаас лавлан ийн асууруун (гэж хэлээд дуулна)

Өвөлжсөн дулаахан газартаа хариад Энх мэндээр сууж байхад Эргэж ирэх хаврын сардаа Эгэж буцан юундаа ирээв.

Өлзийдэй ноён:

- Шувуу ийн хариу асуувай. (хэмээгээд харилцаа дууг үргэлжлүүлнэ)

Зуур замын аянд явахдаа Задгай нууртаа тоглож байгаад Залуу сайхан идэр наснаасаа Шилжиж өтөлсөн нь юунаасаа вэ?

Сүбээдэй ноён:

- Өвгөн өөдөөс нь ийн өчивэй. (аялгуулан дуулна) Үйлийн үрийн үнэн худал Үүлэнд жиргэгч шувуухай та минь Өтлөх үхэхийн дөрвөн далайн нь Өөр бусад хэн ч ирнэ ээ Залуу сайхан үзэсгэлэн байгаад Залгаад цааш өтлөхийн жимээр Зэргэлээний үзэгдэл мэтээрЗамхран одох нь мөнх ёсон.

Их хаан эзэн Чингис:

- Миний улс таван өнгөтэй, дөрвөн гадаад газартай. Би та нарт дэлхийн хамгийн том гүрнийг үлдээв. Та нар энэ амар тайван гүрний эзэд. Тиймээс нэгэн хэлтэй нэгэн сэтгэлтэй байхтүн! Ертөнцөд хүчирхэг алдар минь үлдэнэ. Би ийм их алдар хүндийг эдлэсэн тул үхэвч харамсах зүйлгүй. Миний өрлөг жанжид, эрдэмтэн мэргүн цөм цугаар хан хөвгүүдийн минь түшиг болж элсэн цөлд ундаалж, уул хаданд ангахад нь цангааг нь тайлж, төөрөхөд нь замыг нь зааж өгөхийг хаан би хүснэ.

Сүбээдэй жанжин:

- Жа хаантан минь үүрд өмгөөлөн явахаа андгайлья!

Их хаан эзэн Чинис:

-Дуул өрлөг жанжин минь!

Сүбээдэй жанжин:

- (Хүнгэнэсэн хоолойгоор Эртний сайхан уртын дууг эхлэнэ.) Энэ сайхан оронд нь Эзэн Чингис хааныхаа Язгуур аац бүрдэв ээ Тэнгэр мэт заяатай Тэгш таван оюунтай Тэнүүн

уужим зарлигтай Тэнгэрийн минь үр сад билээ.

Их хаан эзэн Чингис:

- Миний Алтан аялгуу эгшиглэн бүрээдэв. Тэнгэр намайг дуудав. (Яльгүй өндийнэ) Миний сүг сүнс эх нутгаа эргээд мөнх хөх тэнгэрт буцах болтугай! (Хаан сэнтийгээ хойш налав. Хаан өөд болно. Есүй хатан амаа дарна. Хан хөвүүд болон өргөөнд байгсад бүгд цугаар их хаанд мөргөнө. Сүбээдэй дуулсаар байна)

Сүбээдэй жанжин:

- Олон одны дундаас Сарны гэрэл тодорхой Яндар мэт чимэгтэй Сүмбэр уулын оройгоос

Сүндэрлэн цацраад Сүр жавхлан дэлгэрээд Сүлд нь бадартугай Хамаг Монголын рашааныг

Ханахгүй шимсээр хүртээд Хаан эзэн Чингисийн өмнө Хамаг бүгдээр жаргая.(дуулж дуусаад)
)Мөнх тэнгэр минь!

(Сүбээдэй хамгийн сүүлд доош сууж хааны алтан шарилд гурвантаа мөргөнө.)

(Морин хуурын аялгуу эгшиглэнэ) (Харанхуйлал)

Долдугаар үзэгдэл.

7. Хангинах тэргэний харих замыг дуу нулимс зурав

Тайз: Тангудын орон. Өндөрлөг нэгэн толгод. Сүбээдэй, Толун черби тэргүүтэй Хааны шадар цэргүүд туг хиарыг мандуулан зогсоно. Тангудын хаан Ли Сянь болон эхнэр хүүхэд бараа бологчид тэдний өмнө ирнэ. Тэд дуу бүжиг үүсгэн том цартай сувднууд зэрэг бэлэг сэлтийг барин ирнэ.

Тангудын хааны албат:

-Тангудын хаан заларч явна. (Зарлана) Тангуд улсын хаан Ли Сянь Монголын их хаантай найрамдахаар өөрийн биеэр хүрэлцэн ирлээ.

Толун черби:

- Их хаан эзэн бие чилээрхсэн тул Тангудын та улсыг хүлээн авах боломжгүй.

Тангудын хааны албат:

- Их хаантай өөрийн биеэр уулзахыг манай хаан туйлаас хүсэмжилнэ. (Тангудын хаан албатынхаа чихэнд ямар нэгийг шивнэн удна)

Толун черби:

- (Догшиноор) Боулхай чи юунд албатынхаа чихэнд шивэгнэнэ вэ? Хоолой чинь хатсан хэрэг үү?

Тангудын хаан:

- (Аймсангуйгаар) Тангуд улсын их хаан би их хаан Чингистэй биечилэн уулзах хүсэлтэйг хаан эзэндээ дуулгана уу. Хааны бие илааршихаар эргэн ирж учиръя!

Толун черби:

-Их хаан эзэн та улсыг хүлээн авахыг үл хүснэ. Хэрэв хэнхдэгэндээ хэлэх үг тээн ирсэн бол бидэнд хэлсүгэй!

Тангудын хаан:

- Та хэддүгээр ноён бэ?

Толун черби:

-Юу гэнэ ээ. Муу боулхай.

Тангудын хаан:

-Өршөө жанжин нар минь. Хаанд ёслон мөргөж Тангудын орны бэлгийн дээдийг барихыг хичээнгүйлсэндээ таныг давж ёс алдлаа. Их хааны барааг үзэх минь дээд аз тул хаан миний хүслийг дамжуулж ёсоор болгож соёрх!

Сүбээдэй жанжин:

- Аз, Та улсад эрт заяасан боловч түүнийгээ үл мэдэн эдүгээг хүрч иржээ. Аз гуйн царайчлах чинь өрөвдөлтэй тул зөвхөн хааны цацарын зүг ёслон мөргөх эрх өгье!;

Тангудын хаан:

- Би..! (Дургүйлэх байдал илт илэрнэ)

Толун черби:

- Хааны алтан өргөөнд мөргөх хувь азыг голов уу чи!

Тангудын хаан:

- Үгүй ээ. Бид ёслон мөргөхдөө баяртай байна. (Тангудын хаан алсад дахь цацар, өргөөний зүг харан яаран доош өвдөглөж мөргөнө. Түүний дагаачид даруй дуурайн доодод суун мөргөнө. Тангудын хаан албат руугаа эргэн харахад албатууд түүний харцаар бэлэг сэлт том цартай сувдийг өргөөний зүг хандуулан тавина. Тангудын хаан өргөөн тийш хандан гурвантаа ёслон мөргөөд хариу эргэн Сүбээдэй жанжин өөд хандав) Хааны жанжинтай эв найрамдлын гэрээг хийх хүсэлтийг минь хүлээн авна уу?

Сүбээдэй жанжин:

- Сөгтөг!

Тангудын хааны албат:

- Манай хаан эв эеийг эрхэмлэн шударгуу гэрээ найрсан найрамдан хийхийг туйлаас хүсч байна.

Толун черби:

- Тангудын хаан чи сөгд! (Хааны цэргүүд ойртон ирэхүйд тэд яаран сөгдөнө.)

Тангудын хаан:

- (Сандрана.) Бидний Тангуд орны түмэн олон, та улстай энх тайваныг тогтоон цаашид улмаар Их Монголын эзэн хаан Чингисийн ясу ёсыг шүтэн дагаж үнэн итгэлт нэгэн улс нь явахаа илэрхийлж, дайн тулааныг зогсоохыг хичээнгүйлэн хүсэж их хаан эзэн Чингист үнэнч явахын баталгаа болгон нийслэл хотоо бэлэг болгон өргөн барихыг хүлээн авна уу?

Сүбээдэй жанжин:

- Тангуд боулхай нартай эхлээд эртнээс эдүгээ хүргэсэн булхай бүрийг дуудан дурдаж ял хэлэлцье. Тангуд та улс, анх дугаарт их хаан хамаг Монголыг нэгтгэн хаан ор суух бүхийд тэнгэрийн зарлигт эс итгэн хааны өөр зэвсэглэсэн Монголын Хэрэйд аймгийн вангийн хөвүүн нялх Сэнгүмийг урван зугтахад тангуд улс далдлан нууж өш ишилсэн. Урван тэслээчийг нэхэхэд эс өгөн дайнд дуудсан. Гэвч та улс дийлдэн эрхэнд ирсэн билээ. Дараа удаа та Тангудын ноёрхогч сэтгэл урвуулж алба татвар эс өгөв. Улсын хэмд ороод зарлиг эсэргүүцэхэд мөн бид цэрэглэх болсон. Дахин бөхийж та улс буун өгч сөгдсөн бус уу. Удаахад цэрэг элсүүлэхэд эрсээ эс ирүүлэн илтэд гэжсэн. Мөн л хүч босгон ирэхэд дагаар орж баруун гар чинь болж, Чагаа нэрт охиноо хаанд өргөсөн. Дөтгөөр удаад сартуул улсад улсын алтан аргамжаа тасдуулаад баруун гар болж дайтъя хэмээхэд танай Аша Хамбу Хүч эс хүрэхгүй бол хаан юунд болов гэж басамжилан доромжлоод гэдрэг суусан. Өдгөө энэ удаа Сартуулыг дайлаад их цэрэг их замыг туулах үед ар худрагаар Алтан улстай хуйвалдан нэгдсэн төдийгүй манай төрөлх орны Эзнэй голын зүгээс та улс уулгалан халдаж бидний их цэрэг хөдлөн энд бас ирэв. Үргэлж олон булхай бурууг та улс хийв. Үүнийг юу хэмээн өөрсдийгөө өмгөөлөх вэ? Хаан чи хэлтүгэй!

Тангудын хаан:

- Бидний түмэн буруу. Үйлдсэн нүглээ наминчилан өршөөлийг эрэн мөргөө! (Сандран мөргөнө. Албатууд хаанаа даган мөргөнө)

Сүбээдэй жанжин:

- Дайнд ямагт дийлдэх мөхөс атал дэмий цэрэг хүлгийг та улс зовоов. Одоо мөн л сөгдөн бууж улсын хотоо боулхайн хаан чи өмнө маань барив. Үгэндээ батгүй, итгэл мэдэхгүй, эв эе нийлэхгүй боулхай улс гэдгээ бүрнээ нотлов.

Тангудын хаан:

- Танай хаан туйлын дээд Чингис хаан ажээ. Их улс хүчирхэг бөгөөд хууль ёс үнэн шударгууд бид айн ичив. Үүнээс хойш манай Тангуд улс ямагт Их Монгол улсын хууль зарлигийг дээдлэн шүтэх болно.

Сүбээдэй жанжин:

- Мөнх тэнгэрийн ясу цаазыг хэн хоёр хөлт хохимой толгойтон тэр бишрэн дээдлэх хутагтай ясан толгойт хаан чи ухаж сая ойлгов уу?

Тангудын хаан:

- Бүрнээ танилаа. Мунхаг биднийг өршөө! Тангуд улсыг ард иргэдийн амийг хэлтрүүл! Мөнхөд та нараас сурч эвтэй явья.

Сүбээдэй жанжин:

-Өршөөл уучлал эс зохих төрөлхийн муу сэтгэлт та улсад урт удаан хорин жилийн сэхээрэн гэгээрэх боломж өгөв. Танай хаад бүгд эс авав. Тэрсүүдийн боулхай та нар мөнөөс мөн тул тэнгэрийн гэсгээлийг амсч үхэл чинь та нарыг сургах болтугай!

Тангудын хаан:

- (аймсангуй) Өршөө баатар жанжин минь!

Сүбээдэй жанжин:

- Тангудын хаан чиний нэрний утга юу гэнэ вэ?

Тангудын хаан:

- Бурхан. Миний нэрийн утга бурхан.

Сүбээдэй жанжин:

- (Доогтой инээнэ) Дээд нэрийг чи хаанаас зээлэн хүртэв. (Догшин ширүүнээр харж) Бурханы явдал хэрхэвч чиний энэ явдал бус. Дээдийн дээд утгыг доодын доод болгон хулгайлжээ.

Тангудын хаан:

- Би биш эцэг минь энэ нэрийг төрөхөд минь хайрласан билээ.

Сүбээдэй жанжин:

- Үтэр түргэн боулхай чи нэрээ өөрчилж өөрийнхөө муу явдалд тэнцсэн нэр өөртөө өгөхгүн!

Тангудын хаан:

-Ямар нэр?

Сүбээдэй жанжин:

- Тэнгэр бурханы алдар нэр авч үлдэн, боулхай чамд би тохирох нэр өгөв. Чамайг Муу нохой хэмээн нэрийдэв.

Тангудын хаан:

- Муу нохой.?

Сүбээдэй жанжин:

-Тийм чиний нэр энэ боллоо.

Тангудын хаан:

- Би хүсэхгүй байна. (Гутарна)

Сүбээдэй жанжин:

-Тангудын доорд боулхай хаан Муу нохой нэртэд мөнх тэнгэрийн шударгуу ёсны илдийг соёрхов. Хань бараа бологсодтой нь хамт цаазлахгун!

Тангудын хааны хатан:

- Өрөөсөн нүдтэй жанжин чамд охин үр бүхнээ өгье!

Толун черби:

- Цэргүүд цааз дор тэднийг аваач!

(Хааны цэргүүд тэднийг чирч гулдарна)

Тангудын хаан:

- Чингис агуу хаан тул биднийг өршөөх болно. Туйлын дээд Чингис хаан намайг сонсон өршөө. Өршөө хаантан минь!

Тангудын албат эмс хүүхдүүд:

- (Орилолдоно) Өршөө их хаан. Өршөөж хайрла. Чингис хаан. (Сүбээдэйн цэргүүд тэднийг хөөн тууж тайзны голд авчиран бүгдийг сөхрүүлнэ)

Толун черби:

- (Өндөр дуугаар) Бидний их улсын өөдөөс хорин жил тэрслэн тэмцэж урван шаравсан Тангудын боулхайн хаануудын сүүлчийн хаан, Муу нохой нэртийг мөн түүний үр удам үзүүр ёзоор бүгдийг хатад эмс хань бараа бологсодын хамт гэсгээн цээрлүүлэн цавчтугай. (Гараа дээш өргөөд) Цаазыг гүйцэтгэ! (Доош буулгана.)

(Хааны цэргүүд тангудын хаан болон ноёд эмс хүүхдүүдийг цаазална) (Бүрэнхийлэл) (Гэрэл тодроно) (Сүбээдэй, Толун черби тэргүүтэй цэргүүдийн хошуучлагч нар их гүрний босоо хар сүлд, шонхор шувууны дүрст тугийн дэргэд зогсоно)

Сүбээдэй жанжин:

- Тангуд улс мөхөв. Их Монгол Гүрний яруу алдрын дайчин хүчирхэг эзэд, Мөнх хөх тэнгэрийн хөх нуруутан хүлэг цэргүүд ээ! Тэнгэрээс заяат туйлын дээд хаан эзэн Чингисийн цэргүүдээ! Ахуй эх нутагтаа буцацгаая! Их цэргүүд их хаан эзний нууц зарлигийн ёсоор нутгийн зүг хандан хүлгийн жолоо юугаа эргүүлэхтүн! Төрөлх эх нутгийн зах руу дуу хуурыг агуулан явтугай! Алтан улсын заяаг дараа бид буцан ирж шийднэ. Тэнгэр тэр цагийг хэзээ хэмээхийг мэдэг!

(Хөөмийн дуу эхлэнэ.) (Бүрэнхийлэл.) (Гэрэл тодроно.)

Толун Черби:

- Их нутгийнхаа зах руу орж ирлээ. Их цэргүүд минь Их Гүрний дайны хар сүлдийг гудайлгахтун! Бид их хаан эзний алтан шарилийг тээн ирлээ. Хүний нутагт унагаагүй нулимсаа унага. Тэвчин явсан эмгэнэл гашуудалаа гадагш гаргаж болно.

(Цэргүүд дайны хар сүлд, цагаан шонхор бүхий туг дарцагуудаа гудайлгана)

Нэгэн өвгөн цэрэг:

- Мөнх тэнгэр минь! (Доош газар сууна) Ай, Хайран хаан эзэн минь. Хүү минь. (Гашуудан уйлна)

Гилүгэн баатар:

- (Гашуун гунигт дуугаар)Харцгай шувуу мэт халин одов уу та эзэн минь Хангирсах тэрэгний моо болон одов уу та эзэн минь Хатад хөвгүүд ээ үнэхээр гээв үү та эзэн минь Харалмай албат улсаа үнэхээр тэвчив үү та эзэн минь Жиргэх начин мэт завхан одов уу та эзэн минь Жигирэх ногоо мэт хийсэн одов уу та эзэн минь Жаран зургаан насан дээрээ есөн өнгө улстаа Жаргаланг үзүүлэн өөд болов уу та эзэн минь ?

Сүбээдэй жанжин:

- Хамгийн хаан халуун зүрхний анд нөхөр минь.

Гилүгэн баатар:

- Хөх мөнгөн тэнгэрээс заяагаар төрсөн Хүний арслан тэнгэрлэг богд эзэн минь ; Хүр их улс бүгдээ гээж орхиод Хүрэн зорчив та эзэн минь дээд төрөлдөө ;Төвөлдөн учирсан хатад чинь Төвшнөө байгуулсан төр чинь ; Төрлөн зохиосон засаг чинь

Түмэлэн зохиосон улс чинь тэнд бөлгөө. Унасан газар Дэлүүн болдог чинь Угаасан ус хатан мөрөн чинь Хэлэх бүгдийг хураасан алтан орд харш чинь Хэрлэнгийн хөдөө арлун суусан орон чинь тэнд бөлгөө. Бүтэхийн урьд учирсан Бөртэ цэцэн хатан чинь Бурхан халдун хан өлзий нутаг чинь тэнд бөлгөө. Хайрт амь чинь гарав Хас эрдэнэ мэт хүүрийг чинь авч ирлээ. Хатан Бөртгөлжинд чинь үзүүлье. Хамаг улст чинь авчирав.

(Алсад бүрээн дуу дуурсана)

Толун черби:

- Цэргүүдээ! Эх нутгаадаа түрүүлж морьдсон Өгээдэй Толуй хангууд маань цэргүүдтэйгээ их хааны алтан шарилыг залахаар угтан айсуй. Тэрэм тэргээ хөдөлгөцгөөе!

(Бүрэнхийлэл) (Тайзны өмнө цэргүүд гарч ирнэ. Тайзны алсад мөн цэргүүд гарч ирнэ. Тэд

доош суугаад тэнгэрт мөргөөд босно. Тайзны өмнөх цэргүүд алсад буй цэргүүд рүү нум сум онилон харвана. Тэдний дунд гагц Гилүгэн баатар ганцаар үл харвуулан үлдэнэ. Тайзны өмнөх цэргүүд тайзны гүн рүү эгнээгээрээ очно. Тэд нум сумаа газарт тавин доош суун тэнгэр мөргөөд босно. Тэднийг алсаас сум нисэлдэн ирж харвана. Гилүгэн ганцаар үлдэнэ.)

Гилүгэн баатар:

- (Ёслоно) Хасаг тэргэнд хүлгүүдийг хүлж, хаан эзний Хас эрдэнэ мэт хэсгэн язгуурыг Хан уулын өлгийд онголов. Хүслээр тэнгэрээс заяат хааны сүг сүнсийг дагах замыг сонгосон хөх нуруутан эрс хавт нууцыг аван халив. Тэнгэрийн мөнх хүүрийг мэдэх гагц нь Гилүгэн баатар би үлдэв. Нууцын нууцыг багтай цоожилтугай! Мөнх тэнгэрийн хаан эзэн юугаа зорьсу би. (Гилүгэн баатар хуяг дуулга хүндэтгэн тайлна) (Их хааны алтан ургийнхан тайзнаа гарч ирнэ. Толуй хан Гилүгэн баатрыг харвана)

(Харанхуйлал)

Наймдугаар үзэгдэл.

8. Хан өгэдэйд хааны сэнтий хүндэв

Тайз: Дөргэнэ хатны өргөө. Дөргэнэ хатан, Аригун ноён, өргөөний албатууд болон дууч аягач эмсүүд.

Аригун ноён:

- Их хааны зайран, хэнгэрэг даах чавхаагүй өтөл нас ирсэн тул төрийн албанаас чөлөө олгоно уу хэмээн гуйлаа.

Дөргэнэ хатан:

- Аригун ноён, өвгөн зайран ядруу дор буй бол улсын нэр бүхий төлөгч, зурхайч зайран удган бүгдийг хатан миний өргөөнд урь.

Аригун ноён:

- Жа хатан минь, (Зогсоц) Дөргэнэ хатан та өргөөндөө олзлогдсон эмс охидоос биеийн угаалга ус цасыг зөөх шивэгчин сонгон авах уу? (Дөргэнэ хатан ихэмсэгээр толгой дохино. Аригун ноён алга ташихад олзны эмс охид орж ирнэ)

Дөргэнэ хатан:

- Аригун ноён та өргөөг орхиж болно (Дөргэнэ хатан эмс охидыг ойрт хэмээн дохиод тэднийг шинжин ихэмсэгээр ажина. Эхний охиныг харснаа) Гар чинь эвдрээгүй тэгээд цагаан харагдана. Зүс чинь бас аятайхан юм байна. Би чамайг аягачаар өргөөндөө авав. (Бусдыг шинжин харснаа голох мэт дуугүй болно. Хорезмын шивэгчин Фатима хатан руу толгой өндийлгөн харснаа)

Фатима:

- Хатан таны хүж хорхойн шүлсээр нэхсэн торгон дээлний доорхи уян цагаан нуруун дээрх хар мэнгэ өвчилжээ.

Дөргэнэ хатан:

- (Цочисхийнэ) Хөх тэнгэр минь! (Зогсоц) Эм чи үзмэрч хэрэг үү? (Фатима нүүр бууруулан доош харав)

Фатима:

- Бага сага домын ухаан бий билээ.

Дөргэнэ хатан:

- Харваас чи тансаг орд харш, үзэм жимс, дарсны орноос иржээ дээ. Олзны эм чи миний өргөөнд үлд. (Өргөөний албатад хандан) Аягачинд гэр зааж өг. Бусдыг нь өөр тийш нь явуул. (Өргөөний албат эмсийг авч явна. Хатан хорезмын шивэгчин рүү хандан) Наашаа ойрт! (Фатима хатны дэргэд ирнэ) Хатан миний өөдөөс эм чи харахгүйн! (Олзны эм хатны өөдөөс харна.) Цэхэр нүдтэй юм гээч. Шивэгчин эм чи миний нуруун дээрхи мэнгэ өвчилсөнг хэлж чадав. Хэлж чадсан тул чамд итгэж хатан биед хүрэх эрх өгье. Миний өвчинг засаж чадвал би чамайг шагнаж их өргөөний шивэгчингээр тэжээе ! Хэрэв эс чадваас хар овоохой руу хөөгдөх заяа ч чамд эс олох бөгөөд хар толгойг чинь авах болно.

Фатима:

- (Шивэгчин Фатима толгойгоо өндийлгөнө) Жа...(Хатанд ёслоод) Хатан та орон дээрээ хэвтэж болох сон болов уу?

Дөргэнэ хатан:

- Чамд өөр юу хэрэгтэй вэ?

Фатима:

- Дом заслын мэс хэрэгтэй.

Дөргэнэ хатан:

- (Өргөөний шивэгчид рүү хандан) Заслын мэс түүнд өг! (Хатны шивэгчид том модон хайрцаг бүхий заслын хэрэгсэл авчиран хатны дэргэд доош сууна.)

Фатима:

- Өршөөгөөрэй! Хатан та домын үеэр хувцас болоод гоёл зүүсгэлгүй бол их сайн.

Албат хөвүүн:

- Чи хатнаас хэтэрхий ихийг шаардав. (Өрөөний албат сэлмэндээ гар хүрэн ойртон ирнэ)

Дөргэнэ хатан:

-Хүлээ. Түүнийхээр больё! (Өргөөний шивэгчид хатны дохиогоор ирж , хоёр нь өргөөний орны хөшгийг татахад албат эр хойш ухрана. Хатан түүнийг үлд хэмээн дохиод албат дороо зогсоно. Бусад шивэгчид хатны гоёмсог бортгон малгай дээлийг явдал дунд нь тайлна. Хатан нэмгэн дан торгон цагаан дээлтэйгээ ор руугаа явна. Хөшигний цаана гарч нимгэн тэрлэгээ тайлан оронд хэвтэнэ. Түүнийг нэгэн зарц эм булган хөнжилөөр хучина. Фатима хатны ор руу очно. Эмсүүд орны өмнөх хөшгийг татна) (Зогсоц) (Фатима хатны орны хөшигний цаанаас гарч ирнэ)

Фатима:

- (Цагаан торгон дээр багахан цус дуссан байна. Алчуурыг гар дээрээ бариад албат эр рүү бөхийгөөд) Хатны өвчилсөн мэнгийг авлаа. (Эмсийн нэг албатын харцаар Фатимаагаас алчуурыг аваад цааш эргэнэ. Нэгэн хайрцагт хийнэ) (Зогсоц)

Албат хөвүүн:

-(Хөшигт дөхнө) Хатан таны бие ямар байна? (Зогсоц)

(Чимээ үл өгсөнд албат хөвүүн сэлмээ сугалан Фатимагийн хүзүү рүү чиглүүлнэ. Эмсүүд айцгаана)

Фатима:

- Хатан нойрссон. Одоо удахгүй сэрднэ. (Албат шивэгчид рүү дохино. Шивэгчид хатны хэвтэж буй орны дэргэд ирж хөшгийг сөхөж цааш орно)

Шивэгчин:

-(Хөшгийг сөхөж нааш хандан) Хатан жигдхэн амьсгалаад унтаж байна. (Хатан сэрднэ) Хатантаан! (Шивэгчин доош сууна. Албат хөвүүн Фатимагийн хүзүүнээс сэлмээ авна) Таны бие зүгээр үү?

Дөргэнэ хатан:

- (Хатан өндийн босно) Би сая нойрмоглон унтлаа. Бие жаахан даарч байна. Дээлийг минь авчир! (Шивэгчид хатны дохиогоор хатны дээлийг авчиран өмсгөнө. Хатан гутлаа өмсөөд бүрэн үл хувцаслан хөшгийн цаанаас гарч ирнэ) Их унтсан юм шиг санагдаж байна.

Шивэгчин:

- Цай дэврэх хором төдий мөч өнгөрөв.

Дөргэнэ хатан:

- Тийм үү? (Шивэгчид толгой дохино. Хатан олзны эм рүү ирнэ) Гайхалтай. Амаржсаны дараах агшин хоромтой төстэй ч юм шиг, биш гэхнээ агаарт дүүлж нисмээр бие хөнгөрөв. (Албат хөвүүн рүү хандан) Бие сахигч хөвүүн сэлмээ хуйндаа хийж болно. (Албат хөвүүн сэлмээ хуйндаа хийнэ. Фатимад хандан) Хатан миний биенээс өргөс авсан боол эм чамайг хуй торгоор шагнав. Өнөөдрөөс эхлэн чи хатан миний өргөөнд үйлчил. Олзны эм чамайг би өргөөний шивэгчингээр авлаа.

Фатима:

- Хатны өгөөмөр хайр хишигт мөргөө!

Дөргэнэ хатан:

- (Хатан эхэмсэг сэргэлэн байна. Баяртай мишээн) Мөргөө мөргө! (Хатан алга ташина) Өргөөг орхицгоо.(Фатима руу зааснаа үлд гэж гараараа дохино. Өргөөнөөс албат зарц шивэгч бүгд явна.) Чамаар нэгэн зүйлийн учрыг таалгая.

Фатима:

- Жа хатантаан. Дорд боол би хичээе.

Дөргэнэ хатан:

- Гурван хоногийн өмнө билэггүй зүүдний хэл энд ирэв. Их хатан эх нааш зүүдээ хэлүүлэв үү? Эсвэл түүний хажууд буй бэр хатны санаа байв уу?

Фатима:

- Тэр зүүд мөн байна. Бэр хатан тань их хатан эхийн зүүдний хэлийг сонсгохоор зарагдан ирсэн байна.

Дөргэнэ хатан:

- Мөөн...

Фатима:

- Өршөөхтүн хатан та...

Дөргэнэ хатан:

-Юу болов. Хэл!

Фатима:

- Аюумшиг үзэгдэнэ. Тэр аюул амь насны барьцаа хаа сайгүй нэхнэ.

Дөргэнэ хатан:

- Тийм байх нь...(Зогсоц) (Ширүүн хүйтнээр) Тэр аюулаас зайлах арга байна уу?

Фатима:

- Их хааны сүнсэнд их тахилга тайллага үйлдвэл аюулаас зөрж өнгөрч мэднэ. Дөчин гоо эмэгтэй, зуун морьдоор цусан тахилга үйлдвэл язгууртан, хаан ширээ залгамжлагч ханы амьтай дүйнэ.

Дөргэнэ хатан:

- Хаан ширээ залгамжлагч хан гэв үү?

Фатима:

- Тийм ээ.

Дөргэнэ хатан:

-Аймшигтай.

Албат хөвүүн:

- (Өргөөнд орж ирж ёслоод) Хан Өгэдэй морилон ирж байна.

Дөргэнэ хатан:

- (Фатимад хандан) Үзээч шивэгчин чи ил далдын үзсэн харсан болоод хатан надаас сонссон бүхэн амнаасаа хэнд ч бүү алд. Алах байсан ч үл алд. Хэрэв алдвал хэрээс чинь хэтэрсэн цааз онооно. Амлаж өлмий үнс.

Фатима:

- Амлаж байна. (Хатны өлмийг үнсэнэ)

Дөргэнэ хатан:

- (Албат хөвүүнд хандаж) Хуй торго дээр нэмж нэг мөнгөн зоос өг. Яв. (Олзны шивэгчин хойш ухарсаар гарна)

(Өргөөнд Хан Өгэдэй орж ирнэ. Хатан түүнийг угтан ёслоно.)

Өгэдэй хан:

-Хатан минь царай зүс чинь юутай их гунигтай харагдана вэ? Чамд минь эм тангийн засал таарч тохирохгүй байна уу?

Дөргэнэ хатан:

- Бие илаарших шинжтэй. Гэхдээ хан эр минь, их хааны ор суудал эзэнгүй жилийн нас үзэв. Их хуралдайн тов гурван ч удаа зарлагдаад зарлагдсан өдөр ойртох бүрийд ямар нэгэн саад бэрхшээл гэнэт үүснэ. Эхний удаад их усан үеэр бууж хол ойрын зочид, ихэс дээдсийн хөл хоригдсон. Удаах нь хан эр таны минь бие чилээрхэн ханиалгах бөгшихөөр чөлөөгүй зовж хуралдайн товыг цуцалсан хойно төдөлгүй эдгэрсэн. Энэ удаа муу юм бүү тохиолдоосой хэмээн залбирах боловч хатан миний бие нэг л сайнгүй. Их хатан Бөртэ Үжин эхийн зүүд эвгүйрч хан Өгэдэй танаас товийн өдрийг хойшлуулаач гэж гуйлгалаа. Энэ бүхэн ямар нэгэн аюул айсууг хэлэх бус уу?

Хан Өгэдэй:

- Хатан минь тэгээд аргыг юу хэмээн хэлэхийг хүснэ вэ?

Дөргэнэ хатан:

- Их хааны сүнсийг аргадан их төрийн тахилга тайлга хийх хэрэгтэй байна. Төрийн энэ тахилга эртний хойлголох хатуу үйлээр үйлдвэл хааны сүнс амарч төрийн сэнтий зөөлрөн хаан эзэн тань юугаа угтана.

Хан Өгэдэй:

-Хаан эцэг минь эртний хатуу тахилгын үйлийг цээрлэдэг билээ.

Дөргэнэ хатан:

- Хан Өгэдэй та минь болгоож тунгаана уу? Их хаан эцэг тань ертөнцийн агуу их тэнгэрийн хүч билээ. Их тэнгэрийн хүчийг аргадах арга үүнээс өөр үгүй гэж хатан би бодно. Гуйя Өгэдэй хан эр минь. Төр их улсын төлөө хан эр минь энэ бүхний төлөө зүрхээ дэвсэн гуйя. (Уйлна)

Хан Өгэдэй:

- Бүү уйл. (Өгэдэй хан зовиурлан бодлогоширно) Их хатан эхээс асууя!

Дөргэнэ хатан:

- Их төрийн хэргийг эзэн хаанаас хойш та мэдэх захиастай заагдсан эрх хүч та өөрөө... их хатан эхийн хариу үг эс зөвшөөрөхөөс өөр үгүй. Их төрийн үйл одоо таных, хойшид мөн таных гэдгийг болгоохтун.

(Бүрэнхийлэл) (Гэрэл тодроно)

Тайз эргэнэ. Толуй ханы өргөө. Толуй хан, их хатан эх Бөртэ Үжин, Толуйн хатан Сорхагтан бэхэ, бага хатан Мүхэ нар өргөөний хоймрыг эзлэн сууна. Илюй Цуй Цай өргөөний баруун биед сууж бийр бэх нийлүүлнэ.

Их хатан эх Бөртэ Үжин:

- Анх, энх, мөнх хэмээх нь гурван үнэний онолын чанар болно. Анх хэмээх нь өнгөрсөн цаг ба энх хэмээх нь одоо цаг, мөнх хэмээх нь ирээдүй цаг заасан утга бөлгөө.

Илюй Цуй Цай:

- Тун гайхамшигтайгаар цэцэлжээ. Мөнх хэмээх гарцаагүй дээд утгат ирээдүй ажгуу. Та улсын тэнгэрийн ухаан төгөлдөр агаад шимтэх бүрийд цэнгэлийг эдлүүлнэ. Гурван үнэнд тэгш онол эгэл энгийн атал оночтой мэргэн нь мунхаг хүмүүнийг ч гэгээрүүлэх увьдасыг хураан утгыг гүйцээсэн юм байна.

Их хатан эх Бөртэ Үжин:

- Цэцэн ухаанд дурлагч мэргүн минь. Үнэн. Мөнх хэмээх дээд утгатаа хүмүүн бие анх энх цагийг үзээд мөнх ирээдүйг олох зүйтэй. Их төрийн ухаан билгүүн тэнгэр зүй болбоос, хүмүүнийг гэгээрүүлж хөх тэнгэрт хүргэмү хэмээх утга билээ. Эл билиг билгүүн их төрийн ясу хууль засагхуйгаар утга бүрнээ хүмүүн бүрд хүрч хүмүүн бүр мөнхийн хувь хүртэх учиртай.

Илюй Цуй Цай:

- (Толгой дохино) Төрийн ясу хууль аргын үйл.

Их хатан эх Бөртэ Үжин:

- Мөн. Мөн. Арга билгийн зохицлын үр хүмүүн бүрийг хөх тэнгэрт хүргэх учиртай.

Илюй Цуй Цай:

- Төрийн их хатан эх Бөртэ Үжин та минь, сая л би бүхнийг ухан ойлгов. Арга билгүүнийг оршоогч нь гурав дахь үнэн болж байна.

Сорхагтан бэхэ хатан:

- Илюй Цуй Цай та үнэн зөвийг олж хэллээ. Эцгийн сүүн эс эхийн улаан эс үрийг бүрэлдүүлэн бүтээнэ. Арга билгүүний эл зохицохуйд гурван үнэн тэгш оршино.

Толуй хан:

- Орон дээд гурван үнэн Алтан дээд гэриэнд боловсрохуй улсын үндэс нь зон ард иш нь айл ард цоморлиг нь ил ард бөлгөө. Ургамал цэцгийн босоо орших тэнгэр тэмүүлэх зам улсын өөдлөн дэвжих мөр болно. Тэнгэрт тэмүүлэн цэгц орших гэж үүнийг тэмдэглэн буулгаж болно.

Илюй Цуй Цай:

- Мөөн мөн. (Цааснаа бийр гүйлгэнэ)

Толуй хан:

-Ард түмэн болвоос ураг төрөл үүсэлтэй. Улс төр орчилтой. Засаг бадралтай билээ. Чин,чу, хажир энэ онол туйлын дээд үнэн бөгөөд үндэс иш цоморлиг, үүсэх орших шилжих, өнгөрсөн одоо ирээдүй, урт өргөн өндөр, тоос чийг хий, оршихуй, сүлжихүй, засахуй, үүсэхүй төрөхүй үхэхүй гурван гурвал эл бүгдээр газарт буй. Оломловоос огторгуйд нүүнэ.

Өлзийдэй ноён:

- (Өргөөнд орж ирэн ёслоод) Их хатан эх Бөртэ Үжин минь, Хан Толуй минь, их хааны буурч

агсан Үнгүр өвгүн уйлан хайлан ирэв.

Толуй хан:

- Өргөөнд оруулахгүйн!

Буурч Үнгүр:

- (Өргөөнд орж ирээд шууд сөхрөнө) Их хатан эх минь ээ... (Нүүрээ дээлийн ханцуйгаар шувтарна)

Их хатан эх Бөртэ үжин:

- Буурч Үнгүр та минь яав? Юу болов?

Буурч Үнгүр:

- Их хатан эх минь, Толуй хан минь, Сорхагтан бэхэ минь... Охиныг минь даанч яах нь энэ вэ? Гоо улаан хацарт тэр минь голын ганц амь минь шүү дээ.

Толуй хан:

- Үнгүр өвгүн минь таны охинд юу учрав?

Өлзийдэй ноён:

- Их хэрэг болжээ. Хан Өгэдэй их хааны сүнсийг тахих тахилга үйлдэхдээ гоо дөчин охидоор хойлгын ёс үйлджээ. Хааны буурч Үнгүрийн галын ганц охинг булаан хойлгын ёсонд зориулжээ.

Их хатан эх Бөртэ үжин:

- Мөнх тэнгэр минь!

Буурч Үнгүр:

- Их хаан минь энэ ёсыг халсан сан. Хааны зарлиг хаа одоо вэ?.. Одоо би охин үрийнхээ эхийг яаж уйлан хайлахыг тэсч дэргэд нь суух билээ? Их хааны минь цаг тэргүүлшгүй сайхан цаг байжээ. Мөнх хөх тэнгэрээс их хаанаа эргүүлэн дуудмаар байна. Хаан эзнээ үгүйлэх минь, үгүйлэх минь..(Уйлна)

Толуй хан:

- Хан ах минь, хэлэлцэлгүй ийм үйл хийхгүй. Учир юу вэ?

Сорхагтан бэхи хатан:

- Өгэдэй хан өрөөл бусдын ятгалагт оржээ. Зөнгийн мэлмий бүрэлзэв.

Их хатан эх Бөртэ Үжин:

- Ай, Хөх тэнгэр минь, Харамсавч багадам явдал. Хан хөвүүнд минь, хааны сэнтий хүнддэхийг мэдсэн. Хатуу үйлээр зөөллөхийг хүсчээ. Зүүдээ юунд түүнд хэлүүлэв дээ би. Айдас хүйдэст автсан хэрэг. Хаан эцэг нь түүнийг хэрхэхийг мэдэж хаан сэнтийд заасан хэрэг. Мэдэж туслах минь багадав. Үүнээс хойш бүхнийг хан хөвүүн Өгэдэй тэр өөрөө мэдэг. Төрийн хэргээс холдох минь. Нэгэнт хийсэн үйлийг яаж буцаалтай вэ дээ. Өвгөн буурч Үнгүр та минь, хаан эзнээс хойш юу эс ирэхийг мэдэх бэрх.

Толуй хан:

- (Хилэнтэйгээр) Байж болшгүй. Хан ах руу хүрч очин хаан эцгийн хөдлөшгүй ясу зарлигийг хаашаа хийсэнг хайн эрж асууя.

Их хатан эх Бөртэ Үжин:

- Болохгүй. Болохгүй. Ямар нэг аюул биднийг оролдоно. Нам гүм байтугай. Энэ бол эцгийг чинь удаан зовоосон тэр зовлонгийн хэсэг. Хэрхэвч бүү тэрс! Үүнээс муу юм үүдэж мэднэ. Хан Өгэдэй эцгийнхээ тэр зовлонгоор зовж буйг эхийн зөнгөөр би мэдэрч байна.

Толуй хан:

- Хаан эцгийг минь зовоосон ямар зовлон бэ хатан эх минь хэлээд өгөөч!

Их хатан эх Бөртэ Үжин:

- Мэдэхгүй. Хаан эцэг чинь өөрөөсөө хүртэл нуудаг тийм зовлон. Битүү тэр зовлонг хаан эрээсээ асуувч үл хэлнэ. Ахуй зүрхний тэр зовлонгоо хав дарж алтан гавалдаа нуугаад түлхүүрийг нь би залгисан гэж зүүдэнд минь уйлсан. Айх зовох, гэмшихээр ах чинь дүүрч байгаа би хан хөвүүнээ хэвлийдээ буй мэт яг одоо мэдрэн байна. Аядуу нам бай. (Зогсоц) Хан Өгэдэй тэр минь ухаан санааныхаа түмэн зовлонгоос дөнгөж сая хаан болж төрлөө. Үйлийн эзэн тэр боллоо. Заяаг нь тэнгэр гагц мэднэ. Огторгуйд оломлогдох орхигдох нь түүний хаан гавлын ухаан билгийн их бага үүнээс хойш мэдэх болов.

Буурч Үнгүр:

- Хөөрхий ихэс дээдэс минь, та нарын зовлон эгэл минийх мэт бус ажээ. Хаад дээдсийн зовлонг охин үр минь нимгэлэх учиртай бол асгаруулсан нулимс минь хоргүй хатаг!

Их хатан эх Бөртэ Үжин:

- Мөнх хөх тэнгэр, Бурхан халдун уулын зүг сүү өргөсү би. (Зогсоц) Төрийн их хатан эх тэргүүтэй улсын өргөө гэрийн хатад бүхэн, өрх гэрийн гэргий бүхэн, ханат гэрийн эхнэр бүхэн, хар овоодой авгай бүхэн өдөр бүрийг үл алгасан өглөөний наранд сүү өргөтүгэй! Өнөд үүнийг охин үрээс охин үрд , галаас галд, өрхөөс өрх тасрах бүрд өвлүүлэн заншиж явтугай. Хаан тэнгэрийн хатан наранд өргөх цагаан сүүний цацал ертөнцийг их түйтгэрэл зовлонгоос

халхлан сүйрэл сөнөлөөс хамгаалан түмэн оны турш хотол олныг аврах болтугай хэмээн залбирсугай! Төрийн их улсын эх хатан миний сүүлчийн зарлиг энэ болно. Гүрний өрх гал бүрт зарлигийг түгээ! Сорхагтан бэр чи алтан бүст хувин, мөнгөн цацлын халбага, сүү бэлдтүгэй!

(Бүрэнхийлэл) (Нар мандаж буйг тайз илэрхийлнэ) (Төрийн их хатан эх тэргүүтэй олон хатад наранд сүү өргөнө)

Далдаас Энэхэн замбуутивийн наран уртын дуу эгшиглэнэ.

Их хатан эх Бөртэ Үжин:

- Жаа (Цацал өргөхдөө)

Энэ сайхан замбуу тивийн наран Илхэн бүхий дэлхий дээгүүрээ Мөхөлгүй дэлгэрэн түгэн Мандан мандсаар байдаг билүү дэ та мину зээ Жаа Тэр лугаа адил Олон түмний минь өршөөл ;Үнэн сэтгэлтэй бүхнийг Ялгалгүй асгарсаар байдаг билүү дээ та мину зээ

Жаа Үүлэн чөлөөний нар мэт Өчүүхэн явах энэ насаа Үнэн мөнх доор барьж

Үггүй муухайгаар хууртдаг шүү дээ та мину зээ (гээд цацал өргөөд) Өршөө...өршөө...өршөө..!
(Наранд мөргөж залбирна. Хатад бүхэн цацал өргөн залбирна. Уртын дууны эхний бадаг дуугаараа эгшиглэнэ)

(Харанхуйлал)

Есдүгээр үзэгдэл.

9. Өгэдэй далай их хаанд өргөмжлөгдөв

(Тайзны хойморт хаан сэнтий байна. Өгэдэй ханыг Их хаан ширээнд өргөмжлөх ёслол эхлэнэ. Ихэс дээдэс хатад бүхэн хурсан байна. Хаан Өгэдэйг цагаан эсгий дээр цэргүүд өргөн авчирна. Цагаадай хан, Толуй хан, Отчигон ноён нар Өгэдэйг цагаан эсгийн дээрээс түшин их хааны сэнтийд суулгана. Их хатан Сорхагтан бэхэ түүний хажууд бага хатан Мүкэ зогсоно.)

Өлзийдэй ноён:

-Их хуралдай дор Их Монголын Эзэнт Гүрний Их эзэн Чингис хаан орыг их хааны алтан захиа гэрээсэнд заагдсанаар хааны гуравдугаар хөвүүн Өгэдэй хан авч, Их Монголын Эзэнт Гүрний Далай хаанаар өргөмжлөгдөн тодорлоо. Их Монголын Эзэнт Гүрний Далай Их хаанаар Өгэдэй өргөгдлөө.

(Төрийн их бага хэнгэрэгийг цэргүүд дэлдэн, их ба бага бүрээг татна)

Нийтээр бүгд:

-Хурай...! Хурай...! Хурай...!

Их хатан эх Бөртэ Үжин:

-Нэргэгч Чингис хааны Их Монгол улс цаг бусын үхэл өвчин үгүй, цагдах шорон байцаал үгүй, тамлах таван тахал үгүй, үхүүлэх дөрвөн булхай үгүй доройтуулах долоон хясал үгүй энэ буюу. Эв эеийн орон айлын засагтай ертөнц тэнгэрийн улс билээ. Үр тариа аривдан дэлгэрсэн үйл насан буян тэгш сайн. Энх эсэн амрын өсөг хур бялхсан эзлэгдсэн хүмүүний улс баяжиж, Их Чингисийг даган сурч, хүсэл болоод арганд шамдсан айдасгүй жаргалант амар түвшингийн нэгэн их аялгуут ертөнцийн их улс төгс бүтэх хутагтай. Дэлгэр төгс цагийг бүтээ хаан хөвүүн Өгэдэй чи. Их хааны тэнгэрээс нэүрэт засаг заларч үүслийн олзыг хойдод дарлан засаглатугай. Далай их хаан Өгэдэйн агуу их үйлс дэлгэрэн бүтэх болтугай! (Алтан аягатай сүү өргөнө)

Нийтээр бүгд:

-Ерөөл баг сайн орших болтугай.

Толуй хан:

- (Хайрцагтай тамга барин урагш гарна.) Эзэнт Гүрний туг тамга сахигч төр түшигч хан Толуй би бээр Их хаан Өгэдэйд Чингис хаан эцгийн алтан төрийн хабсу хасу тамгыг өргөв. (Хан Толуй Их хаан тамгыг хаанд өргөнө. Өгэдэй хаан ихэд дээдлэн хүндэтгэн авна.)

Нийтээр бүгд:

-Хурай...! Хурай...! Хурай...!

Сорхагтан бэхэ хатан:

- (Гуравсан алтан бүстэй судрыг дээр өргөн) Мөнх хөх тэнгэрийн хүчин дор бүтсэн засаглахуйн билиг билгүүн аргын ясу хууль, Их Монголын Эзэнт төрийн залгамж Алтан дээд гэриэ юуг Их хуралдайн даргач Сорхагтан бэхэ хатан би Далай их хаан Өгэдэй танд өргөсү. (Алтан бүст гэриэг Өгэдэй хаан дээдлэн авна)

Далай их хаан Өгэдэй:

- Мөнх хөх тэнгэрийн хүч Их монголыг төрөөр бадраах хутагтай нүүрит засгийн алтан дээд үнэний аялгуу Далай Их хаан Өгэдэй миний оройд дүүрч хааны алтан гавал болгох болтугай!

Нийтээр бүгд:

- Хурай...! Хурай...! Хурай...!

Далай их хаан Өгэдэй:

-(Эзэнт Гүрний их хэнгэргийг дэлдэнэ. Хаан баруун гараа дээш өргөнө) Мөнх тэнгэрийн хүчин дор, Эзэн Богд Чингис хааны суу дор Их Монголын Эзэнт Гүрний Далай их хаан Өгэдэй миний зарлигийг сонсохтүн! Мөнх Хөх Тэнгэрийн зараалаар дээд тэнгэрээс заяат төрсөн хөх нуруут бид тэнгэрийн дор Нэгэн Эзэнт Гүрэн, Нэгэн Хаант улсыг бүтээн Их Монголын ясу зарлиг, хуулийг дэлхийд мөрдүүлэн тулгах эрхтэнгүүд билээ. Манай гол ил зоригдоон эрс хөх нуруутын нүүдлийн ёс мөлсү дор мөр цагаан иргүнүүд уужим эв эе үүрдийн ав зарлан хуралдахуй нэгэн их улс тэнгэрт мэндэлж ертөнцөд хөгжих хутагтай. Их Монголыг төрөөр бадраах хутагтай Алтан дээд үнэний аялгуугаар чиглээд дөрөөлөн дэрлэгэн иргэнийг бадраах хутаг Төрийн найман цаха аялгуугаар ёсыг мөрдөн хөх толботууд нүүрүт засгаар бадармой. Их Монгол улсын босоо оршихуйн жаягт Алтан Дээд Гэриэг Мөнх тэнгэрийн хүчинтэй гэрээлэн Далай их хаан Өгэдэй би бээр мөрлөн өргөж Их засахуйн ясу зарлигийг бататгахаа андгайлав. Эзэнт гүрний улс иргүн бүгд нийтээр Алтан Дээд Гэриэнд мөргөн биширч ясу хуулийг мөрдөхийг их хаан би бээр зарлиглан тунхаглав. Дэлхий ертөнцийн хүмүүн төрөлхтнийг сэхээрүүлэхээр хөх нуруутнууд бид ариун чин шударгуу хууль цаазыг тогтоохоор мордох болно. Мөнх тэнгэрийн хүчин хааны суу мэдтүгэй. Уухай!

Нийт бүгдээр:

- Уухай...! Уухай...! Уухай...!

(Төрийн их бага хэнгэрэгийг цэргүүд дэлдэн , их ба бага бүрээг татна)

Тэргүүн жүжгийн тимэм төгсгөл

Чан Чун Бумба:

- Тэнгэрийн дор нэгэн гайхалтай улс төрсөн хэмээх нь үнэн ажээ. Аглаг буйдыг эрхэмлэн

даян сууж нэгэн насыг үзсэн бумба би өтөл насны сүүлд даян дэлхийг өөрийн биеэр хэрэн үзэх заяатай агаад энэхүү хувь заяаны зам минь ертөнцөд төрсөн нэгэн гайхамшигт хаантай биеэр учрах аз өглөгтэй ажээ. Мөнх тэнгэрээс язгуурт заяамал энэ хаан үнэхээр ертөнцөд дэг журамыг сэлмийн ирээр заах бошгот богд хутаг мөн. Чингис хааны улс мөн тэнгэрээс заяагдмал агаад энэ шинж нь нүднээ ил хөх нуруут хүлэгтэн тэд нэг нь нэгийгээ хүндэлж, хоорондоо эвтэй найрамдалтай хоол идшээ хуваалцан идэлцэнэ. Хоёр гурван хоног хоол идэхгүй явавч цатгалан мэт дуулж наадах зэргээр ер бачимдахгүй, халуун хүйтнийг сайнаар өнгөрүүлж чадна. Харилцан нэгэнд муу санах, хордох явдалгүй, чадах чинээгээрээ бие биедээ тусална.

Тэнгэрийн улс хөх нуруутан хүлэгтэнгүүдийн хүчээр дэлхий ертөнцөд тэрссэн хар муу зүгийн, хорт санааны уг үүрд тасран устаж, дарагдан үгүй болох болтугай. Их Монголын төрт улс чи газрын тоос тэнгэрт хадаж, тэнгэрийн тоос газар бууж байхад ч замаа бүү алдах болтугай!

(Их хэнгэрэгний дэлдээн, бүрээн их дуу дуурсав) (Хөшиг)

(Чингис хааны санаа тэргүүн жүжиг өндөрлөв)

Өгэдэй Хааны санаа

Хаан алдах эрхгүй

Хатан урвах эрхгүй

Харц цөхрөх эрхгүй

Дэд жүжигт тодрох дүрүүд:

Их Монгол Эзэнт Гүрний Эзэн Чингисийн хаан орыг залгамжлагч-Далай Их хаан Өгэдэй

Их Монгол Эзэнт Гүрний Эзэн Чингисийн гал голомт өвлөгч-Төр түшигч Хан Толуй

Их Монгол Эзэнт Гүрний Далай хаан Өгэдэйн Их хатан Дөргэнэ

Их Монгол Эзэнт Гүрний Их хуралдайн дарга Сорхогтан бэхи хатан

Их Монгол Эзэнт Гүрний хаан Өгэдэйн хүү, хаан ор залгамжлагч Гүюг

Их Монгол Эзэнт Гүрний хаан Өгэдэйн отгон дүү Алалтун бэхэ

Их Монгол Эзэнт Гүрний Төр түшигч Толуй, Сорхагтан хатны хан хөвүүд Мөнх, Хүлэг, Хубилай, Ариг бөх

Их Монгол Эзэнт Гүрний Төрийн тэргүүн яамны сайд Илюй Цуй Цай

Их Монгол Улсын Төр түшигч Толуйн бага хатан Мүкэй, хан хөвүүн Жөн Мон тоба

Жүжгийн тодрох ба илрэх дүрүүдийн хамжаа туслах дүрүүд:

Зайран, Жалайр аймгийн ноён Мэнгэсэр, Алчидай хүлэг баатар, ордны албат түшмэд Ойрад аймгийн Аригун ноён, Бенедикт сүмийн лам Матю Парис Ромын элч санваартан Плано Карпини, Року Эд Дин бусад түшмэлүүд хишигтэн цэргүүд, хэвтүүл, аягач шивэгчид салбадай, жүжигчин, бүжигчин.

Жүжигт илрэх сөрөг дүрүүд:

Хорасаны Түсс хотоос олзлогдож ирсэн шивэгчин, хар шидтэн Фатима Лалын худалдаачин нэрээр төрд шургалсан Абдулхман Абд-Ар-рахман Арабын хан хүү Алмат Исаман ба бусад...

Дэд жүжиг

Жүжгийн явдал

Нэг бүлэгт - Есөн үзэгдэлт

- Дэд жүжгийн эхлэл титэм

1. Толуй Их хаан ах Өгэдэйн өмнөөс тэнгэрт гарав
2. Толуйн хатан Сорхагтанг бэхэ бөө цэцэнг Өгэдэй хаан гуйв
3. Их хатан Дөргэнэ, Фатимагаар мэргэлүүлэв
4. Сорхагтан бэхэ хатан мөнх тэнгэрт мөргөл үйлдэв
5. Их хаан Өгэдэй ханхүү Гүюгийг шийтгэв
6. Их хаан Өгэдэйн зүүдийг зайран тайлав
7. Их хаан Өгэдэй мөнх хөх тэнгэрт одов
8. Төрийн хайрцаг онгойн Алтан Гэриэ алдагдсан мэдэв
9. Гүюг Их хаанд өргөгдөв

- Жүжгийн төгсгөл ба гутгаар жүжгийн эхлэл титэм

Дэд жүжгийн эхлэл титэм

Тайз: Өндөрлөгт хааны сэнтий байна. Их хаан Өгэдэй өндөрт байна. Санваартан Матью Парис доор бохирон суусан байна.

Их хаан Өгэдэй:

-(Эзэнт Гүрний их хэнгэргийг дэлдээнэ. Хаан баруун гараа дээш өргөнө) Мөнх тэнгэрийн хүчин дор, Эзэн Богд Чингис хааны суу дор Далай хаан Өгэдэй миний зарлигийг сонсохтун! Дээд тэнгэрээс заяат Хөх нуруут бид ертөнцөд дэг журам тогтоохын тулд төрсөн. Мөнх Хөх Тэнгэрийн хүчин бээр Тэнгэрийн дор Нэгэн Эзэнт Гүрэн эзэгнэж Нэгэн Хаант төр захирч гагц Их Монгол Эзэнт Гүрний ясу зарлиг, хуулийг дэлхийд мөрдүүлэн тулгах эрхийг хөх нуруут иргүн улс бидэнд өгсөн билээ. Их Богд Чингис хааны байгуулсан Их Монгол улс гүрэн ертөнцийн хүмүүн төрөлхтөн бүгд нийтээр хөл хөсөр, гар газар жарган суух энх цагийг Их Далай хаан миний энэ цаг дор хөх нуруут иргүнүүд бид гүйцээн үзэх болно. Их Монголын төрийн Их хуралдай дор засагласнаар Их цэрэг Умрыг эзлэх зүүн гарт Өмнөдийг эзлэх баруун гарт хуваагдан элдэв улс оронд тэнгэрийн хууль цаазыг тулгахтун. Эс итгэсэн улс хотыг үл өршөөн, их итгэлтэн улс хотыг өмөөрөн автугай. Монгол хүлэг морьдын туурай газар бүрийг тамгалж, тэнгэрт авирч далайд шумбан Дэлхийг Их Монголын Эзэнт гүрний мэдэлд хураан авчирахтун! Аз хийморьтой дайчин хүлэг морьтонгууд минь дайлаар их аянд морьдтугай! Тэнгэрийн хүчин хааны суу мэдтүгэй!

Матью Парис:

- (Санваартан дээш хоёр гараа өргөн аврал эрнэ. Сүмийн хонхыг дэлдэнэ.) Хэртфордшир

мужийн Бенедиктийн сүмийн санваартан Матью Парис би байна. Ромын Гэгээн Пап болон сүсэгтэн бүгд нийтээр сонсоцгоо. Аюумшигт үүл хуралдав. Дорноос аюул айсуй. Бидний үйлдсэн нүглийн гайгаар хаанах нь үл мэдэгдэх улс хүрч ирэв. Адгуусан төрөлт тэднийг хүн гэхээс амьтад гэвэл зохино. Бухын ширээр хувцас хийж өмссөн, гартаа махир сэлэм, нуруундаа нум сум агссан зэрлэг аймшигт хүмүүс царцаа шиг нөмрөн ирлээ. Тэдгээр үл мэдэх зэрлэг хүмүүс чийрэг өргөн цээжтэй, туранхай цонхигор царайтай, ёрдгор өндөр мөртэй, богино хамартай, урт хөмсөгний дор онигор хэрнээ догшин нүдтэй, ширүүн аймшигт дуутай, түгшсэн дүртэй... бүгд бага биетэй хурдан морьд унах бөгөөд тулалдах нь харагдаж үзэгдэхгүй. Арслан барсаас догшин хэрцгий тэд арван хүний дунд шарын арьсаар хийсэн завь авч явах бөгөөд ширүүн урсгалт гол, хамгийн том мөрнийг ч сааталгүй гатална. Идэх хоолоо ачаалж явахгүй тэд мориныхоо хүзүүний цусыг зогсоогоор нь шимж сорж хооллоно. Цусанд дуртай зэрлэг хүмүүс биднийг идэхээр ирж байна. Тэд баригдвал амь гуйхгүй, тэдэнд баригдвал өршөөлгүй. Тэд бүх дэлхийг эрхэндээ оруулахыг зорино. Бидний нүглийн сав дүүрч бурхан гэсгээн цээрлүүлэхээр дорноос зэрлэгүүдийг нааш илгээжээ. Ариун дарь эх Мариа минь биднийгээ авар. (наминчилангаа хэлэх нь) Эсвэл тэд тамаас алдагдсан тартариусууд...

Нэгдүгээр үзэгдэл

1. Толуй их хаан ах өгэдэйн өмнөөс тэнгэрт гарав.

Тайз: Монгол нутаг. Уулын оройн сэргийлэгч харуул зогсоно. (Их төрийн эвэр бүрээ хангинана) Тайз руу харсан үзэгчид Толуйн цэргүүд мэт тайз өөрөө эх нутаг мэт байх. Толуй хан толгойн цэрэг дайчин шилдэг эрсийн хамт зогсоно. Толуй хишигтэн магнай харуулын цэрэг тэднээс өмнө байна. (Толуйн магнай харуулын цэрэг Их цэргийн эвэр бүрээг үлээнэ)

Толуй ханы хишигтэн цэрэг:

-(Орой харуул руу хандана) Их Монгол улсын Далай хаан Өгэдэйн төр түшигч Хан Толуй жанжны их хишигтэн цэргүүд Төвдийн ууланд ялалт байгуулаад хаан эзэн рүүгээ явж байна. (эвэр бүрээг татна) Хааны хишигтэн харуулаас их цэргийг зогс гэсэн дохио ирүүллээ. Их төрийн туг хиар үзэгдлээ. Их хаан ирж байна.

Толуй хан:

- Дайчин хишигтэн цэргүүд ээ! Алтанхудагт амарч үдэлцгээе. Ахуй нутагтаа ороод ирлээ. Их хаан ах минь өөрөө угтахаар ирж явна. (Цэргүүдийн баярлах уухай)

Толуй ханы хишигтэн цэрэг:

-(Толуй ханд хандана) Уулын оройн сэргийлэх харуул галт дохиог унтрааж хар өвчин тахлын аюулын дохио үзүүллээ. (Тайзнаа уулын оройн сэргийлэх харуул аюулын хар хиар барина)

Толуй хан:

- Хар өвчин ёр тахлын аюулын дохио гэнээ. Эх нутаг, их улсад минь гай гамшиг тохиожээ дээ. (тайзнаа уулын оройн сэргийлэх харуул өвчин тахлын дохиог мөн Их төрийн туг хиарыг өргөнө)

Өрлөг дайчин:

-(Толуйн дэргэдэх) -Хачин юмаа. Хааны өөрийн туг хиар мөн байна.

Толуй ханы хишигтэн цэрэг:

- Хаан айсуй.

Толуй хан:

- Хаан ахын өөрийн туг хиар, хар муу өвчин ёр тахлын хиартай хамтдаа өргөгдөөд... Ойлгохгүй байна. Эзэнт улсад маань их гай нүүрлэжээ дээ. Их цэргүүд Хаан ахыг минь тосохоор хүрээл.

Толуй ханы хишигтэн цэрэг:

-(эвэр бүрээгээр түгшүүрийн дуу татна)

Толуйн өрлөг жанжин:

- (Толуйн дэргэдэх) Их Монгол улсын эзэн Далай Их хаан Өгэдэйг угтах их хүрээ үүсгэ.

Толуй ханы хишигтэн цэрэг:

-(эвэр бүрээ татна) Цэргүүд их хүрээ үүсгэ.

Толуйн хан:

- Харц сунгах үзүүрт Хаан ах алтан өргөө тэрэг, хүлэгт торгон цэргүүдтэйгээ л айсуй.

(Бүрэнхийлэл)

Тайзнаа: Толуй хан шилдэг дайчдынхаа хамт байна. Далай Их хаан Өгэдэй хаан бараа бологсдын хамт байна. Толуй ханы өрлөг дайчин эрс хааныг тойрон дотуур хүрээ болон зогсчээ.

Зайран:

- Их хааны алтан бие чилээрхэж, хар задын хүчинд баригдан ертөнц газарт тэсэхүй тэвчихүйн шаналанд өртлөө. Бэг Задын хүчинд хорыг арайхийн аргалан торгоож байна. Домын шившлэгийн хатуу хүчээр Их хааны биеэс хар хорлолыг хураан авч хороглон түр тогтоов. (төмөр бортогыг үзүүлнэ.)

Толуй хан:

- Хаан ах минь...

Их хаан Өгэдэй:

- Аминаас минь дөнгөж салгаад арайхийн ангижраад байна. Ар араасаа ирэх ялалтын цууг сонсоод баярлах бүрдээ амсгалаа уртаар авч амсхийн тайвширч байна.

Толуй хан:

-Их Монголын хүлэг морьтонгууд эзэрхэг хүчит хоёр гарт хуваагдан Эзэнт гүрний ноёрхолыг соёолон морины хурдаар цахилан эх дэлхийг нэгэн хаан ах танд хурааж байна. Хаан ах минь.

Их хаан Өгэдэй:

-Алтайн өндөр оргилын дээгүүр хаан ах чинь начин шонхорын хараагаар Төр түшигч Толуй чиний алдар гавьяаг цохлон харж арван зүгтээ зарлан алдаршуулахыг амин зүрхнээсээ хүсч

байлаа. Уг нь би чамайг хэрхэвч ингэж угтахгүй сэн.

Зайран:

-Өндөр дээдсийн алтан биеийг угаасан рашаан ус харлан эсээд агаарт дусал төдий ууршвал, газарт дусал төдий унавал хорлол хороо үл барна. Хаан биенээс юүлсэн зад бэгийн хүч удахгүй алдарна. Өдөр сараар бус цаг мөчөөр хэмжигдэж байна.

Толуй хан:

- Хаан ах минь хэрхэхийг минь хэл. Хар хорыг яахыг заагаад өг.

Их хаан Өгэдэй:

- Хэлэх үг тархиа нэгжээд ч алга. Надад.

Зайран:

-Хааны алтан бие рүү ассан хорлол амины золиог алтан ургаас нэхлээ. Авралыг хайн эрэн гуйхад авлага хүчрэхгүй хатуу нэхэлтэй байна. Ах хааны өмнөөс дүүгийн хүслээ. Толуйг Төр түшигч хан Толуйг. Айдас биднийг баглан хүлж авралын зүгийг Толуй хан дүү рүү заалаа. Мөнх тэнгэр минь хэрхэхийг хэлээд өгөөч. Хэн ч юу ч хэлж мэдэхгүй нь. Мөнх хөх тэнгэр минь өршөө!

Бүгд цугаар:

- (Өгэдэй, Толуй хоёроос бусад) Өршөө..! Өршөө..! Өршөө..!

Толуй хан:

- Намайг хаан ахын дэргэд байж мартсаныг сануулж, унтсаныг сэрээж яв гэсэн билээ. Одоо хаан ах таныг алдваас би хэний мартсаныг сануулж унтсаныг сэрээх билээ. Алд биеэ дотроо ад хорыг үхүүлэн дарж алтан амины хишгээ ахуй их төрдөө би өргөө.(Төмөр бортогыг авна)

Өрлөг жанжин:

- Ууж болохгүй. (Хэлсэн үгэндээ эмээнэ)

Өгэдэйн хааны жанжин:

-Дээдсийн дунд дэмийрэв. Даруй чиний хэлийг чинь огтолсу.(Өгэдэй хааны торгон цэргүүд түүн рүү хөдлөх гэнэ)

Их хаан Өгэдэй:

- Орхи. (Торгон цэргүүд эргээд байрандаа зогсоно) Үг байвал үгээ өчтүгэй.

Өрлөг жанжин:

- Тэвчсэнгүй би. Харамсах гуниг хоолойд бөглөрөн тээглээд хахахдаа үг унагачихав. Төр түшигч Хан Толуй эзгүйвэл, хамх цохих цүүцний зүүр мохох, алтан аялгуут хан хуурын эмхрээ мөнгөн чавхдасны нэг нь тасрах бус уу. Төр түшигч Толуй ханы уухай, тэнгэрийн чононы улилт, тэр уухайг түрэх хаан таны дайнч эрсийн харц нь сум, хацар нь нумарч харснаа хатуу зэвээр харвахаасаа өмнө номхруулдаг. Дайн тулааны тэнгэр, Энх амгалангийн тэнгэр хос хасбуг эрхэндээ хураасан Төр түшигч Толуй хан жанжины цэргүүд хацраа эсгэсэн шархнаас өөр үгүй.. Ай хайран хаан эзэн, ай хайран ч хан. (Үргэлжилсэн зогсоц)

Толуй хан:

- Үгийг минь цугаар сонсохгүн. Хаан аавын отгон хөвүүн Төр түшигч Толуй би тэр нэгэн цагт Хаан эцэгтээ чин сэтгэлээ өргөхөө амласан. Их Монгол улсын эзэн Богд Чингис хааны их төрийн туг тамгыг түшин, хаан орыг залган суух хэнийг хөвгүүдээсээ нэрлэнэ, би нэрлэсэн нэгний дэргэд халхавч болж халхлан, сэрэмжлүүлэгч болж сэрээн, уриалах дуунд уухай болж унах моринд ташуур болж, холын аянд хошуучлан, ойрын аянд оройлон зүдрэхийн цагт зүдрэлцэн, жаргалдахын цагт жаргалдан, золихын цагт золио болж, гэрийн нохой мэт үнэнч, гэнтү чоно мэт соргог, үргэлж үл хождон зүтгэж явна гэж андгайлсан билээ... Үгэндээ би хүрэх үнэн иржээ. (Төмөр бортогыг онгойлгох гэнэ)

Их хаан Өгэдэй:

- Толуй дүү минь. Болохгүй би өөрөө эргүүлээд хүртье. (Суудлаасаа өндийх гэнэ)

Зайран:

- Далай Их Хаан минь. Эзэнт Гүрний Их хаан минь. Хаан төрийн төмөр хүлгийг харайх явдал дунд, хатуу хазаарыг нь угз татах гэж үү? Бүдчин сөхрөх вий, бүтэн төр зүдэрнэ. Бүрэлдсэн бүлээн тараг шиг Эзэнт гүрний төр та үгүй бол эсэж шуугина их явдал үүснэ.

Толуй хан:

- Хаан ах минь. Мөнх хүчний зарлиг ниргэгч тэнгэрийн аянга аадар яг одоо хөрст дэлхийг тэр чигт нь дэвтээн хөшөө чулуу шиг орон улсын дээгүүр нижигнэн бууж ниргэн байна. Эх дэлхийг Эзэнт нэгэн гүрэнд нэгтгэн зангидаж байна. Ах хаан та Алтан жолоо юугий нь атгасан гараа суллаж хэрхэвч болохгүй.

Их хаан Өгэдэй:

-Хүрэн зүрхний оронд хүрэл зүрх хэрэгтэй байна надад дүү минь.

Толуй хан:

- Хаан ах минь ээ. Их хүслийн нуур мэт мөс чанар, гүн далай мэт сэрэхүй дор шаналахыг

тань харж байна. Их Монголын Эзэнт төрийн төлөө уутугай би. Хаан ах минь санаж явтугай. Ихсийн этгээд хүслээр гэмд хүрэгч шуналыг тасалж, өслөн хонзогновоос начин шонхор байлаа ч гэгийг дарж, дээдсээс заяат хөх Монгол иргүний ахуй юугаа өмөөрөн өвөртөлж нэүрит засгийн төрийн алтан бүслүүрийг чангатгахдаа хан дүүгийнхээ хэлэх хажир энэ үнэнг мөрлөн хадгалтугай. (Төмөр бортоготойг залгилаан бүгдийг ууна)

Их хаан Өгэдэй:

- Толуй дүү минь.

Толуй хан:

-Би хатнаа дахин нэг хармаар байна. Сорхагтан бэхэ минь би чамайг харж байна. Цагаан тэмээ унаад чанх өөдөөс минь ирж байна. Тэнгэр болон тамын хоорондох хүн нутагладаг газар.. юу гэнээ... Хөвүүд минь хаа байна... Зүүд лав биш. Надад хатан минь харагдлаа. (Өгэдэй хаан ах руугаа харна) Ах минь, дотор луу минь могой мэт гулсаад мөс мэт хүйтэн юмаа. (ганхана.)

Их хаан Өгэдэй:

- Түшиж ав. Дүүг минь та нар. (Өөрөө суудлаасаа өндийнө)

Толуй хан:

- Алтан худагт алд бие минь уналаа. Ах хааны өмнөөс аавын тэнгэрт би гарав.

(Толуйг жанжин дайчид түшиж авна. Толуй хан үхэдхийнэ. Өрлөг жанжин уйлна. Өгэдэй хаан гуниг харамсалд автана.) (Хөгжим Морин хуурын гуниглангуй аялгуу)

(Харанхуйлал)

Хоёрдугаар үзэгдэл.

2. Толуйн хатан сорхагтан бэхэ бөө цэцэнг өгэдэй хаан гуйв

Тайз: Толуй ханы хатан Сорхагтан бэхэ хатны өргөө. Өргөөнд Сорхагтан хатан, Их хаан Өгэдэй, ордны түшмэл бараа бологчдын хамт ирнэ. Энд харь орны Илюй Цуй Цай болон Арабын Абдулхман, Алмат Исаман нар байна.

Их хаан Өгэдэйн түшмэл:

- Төр түшигч Толуй ханы бэлэвсэн хатан Хэрэйдийн ван ханы дүү Жаха Хамбугийн хоёрдугаар охин Их Монгол улсын Төрийн мэргэн цэцэн хатан цолт Их хуралдайн дарга Сорхагтан бэхэ бөө сэцэн минь ээ. Их Монгол улсын хаан Өгэдэйн хишиг бэлэг. (Алга хавсран ташина. Ордны бараа бологч булган хөнжил бэлэг сэлт барин ойртон ирнэ)

Их хаан Өгэдэй:

- Сорхагтан бэхэ бөө сэцэн минь. Бэлэвсэрч үлдсэн гунигаа тайл. Битүү булган хөнжилд минь дулаац. Хан дүү Толуй, Хаан миний аминд оров. Амины алтан өртэй билээ би чамд. Ачлахыг би мэдэж, Бөөцийлөхийг би мэдье чамайг. Ах дүүгийн гэгээн бие тус тусдаа ч гэрэлтэх цусны уг нэг билээ. Салаалж ургах нэг модны салбар нийт бие билээ. Хаан миний хатдын нэг болж, дархан илүү эрхтэн болж, Бөө цэцэн бэхэ минь билиг төгс, оюун ухаанаараа Хаан Төрийн хангинах төмөрлөг биеийг нь хурайлж өг.

Сорхагтан бэхэ хатан:

- Өгэдэй хаан таныг хаан суудалд залахад Цагадай ах тань баруун гараас Толуй дүү тань зүүн гараас авга ах Отчигин таны бүсэлхийнээс түшиж хаан ширээнд залсан билээ. Тулгын гурван чулууны нэг туйвж уналаа. Богд Чингис Хаан эцгийнхээ гал голомтыг отгон хөвүүн Толуй өвлөсөн. Хан эр минь үхэв. Хан Толуйн халуун гал голомтыг түшиж би үлдэв. Хаан эзэнд хураагдах нь хатан биеийн заяа билээ. Гэвч Толуйн дөрвөн нялх хөвүүд голомтоо тойроод галыг нь ширтэн сууна. Их Монголын төрийн гал голомтыг манахаар эм биеэ хураан тэвчиж эрийнхээ бүсийг би бүслэв. Дорой дөрвөн хөвүүнээ додомдон өсгөж хан Толуйн зэрэгт хүргэж Дээдсийн голомтыг сахин мануулах өндөр итгэл, их зүтгэл өмнө байна. (Сорхагтан босно. Толуйн мөнгөн аралт ширэн бүсийг бүсэлсэн байна)

Их хаан Өгэдэй:

- Тийм ээ, Их үнэн. Ийм хатуу байх хэрэггүй.

Сорхагтан бэхэ хатан:

- Өршөөж хэлтрүүл бас намайг. Харьж буц даа Хаан.

Их хаан Өгэдэй:

- Биднийг үлдээ. (өргөөнд байгсад мэхийн ёслоод гарна) Ханьцашгүй хатан ухааныг чинь мэднэ. Чиний түмэн зөв. Эр биед эрээд олохгүй үнэнч эрдэнэ гэдэг энэ. Уян бэлхүүсэнд чинь хүнддэх бүсээ тайл. Ухаан чинь чамайг хүлчихлээ. Хайртай билээ би чамд. Хаан миний хатан бол гуйя. Чамд зориулж Хархорумд орд харш босгосон.

Сорхагтан бэхэ хатан:

- Харш орд уу? Хаан төр лүү уулын ус шиг цутгах алт эрдэнэс агуулах сав хүндэднэ надад. Хан Толуй дайлаар мордоод эргэн ирэхдээ амьгүй тэр алт эрдэнэсийг тэнд нь орхидог. Дайны олзонд ирэх жингийн цуваа нь үр ургамал, үндэс мөчир эм тан эрдэм ухаан байдаг билээ. Нүүдэлж чадахгүй орд өргөөнд, нисэж чадахгүй шувуу байх уу?

Их хаан Өгэдэй:

-Нүдний чинь буланд мөс байна. Хайлтал уйлаад өгөөч. Хагацалд гансарсан цээж чинь хатуурч чангарсан байна.

Сорхагтан бэхэ хатан:

-Тэнгэрийн зарлигаар суурмалыг нурааж, Нүүдэлт засгийн бэлийг тэлж бэлдэхдээ хан Толуй үл залхуурму. Тариаланд тамлагдсан газрыг адууны хөлөөр талхлаад дараа нь намайг дагуулан ирэхэд амарсан газар соёолохыг би үздэг. Хичнээн сайхан үйлс. Тэнгэрийн хуулиар хан хэрэм хамхран унаж, тэнгэрийн салхи газарт эрхээрээ хөллөөд... Багширсан буман сийрээд ирэхээ үзээд сэхээрч эхэлдэг.

Их хаан Өгэдэй:

- Ухаантай бөө цэцэн минь. Их үйлс өмнө минь байна. Бүү хатуурх. Зүсээ зөөллөөд зүг нэг хамтдаа харья.

Сорхагтан бэхэ хатан:

- Мөнх хөх тэнгэрийн хүч Чингис хаан эзний хүмүүн төрөлхтөнг төвшитгөх зарлигийг гүйцээн өгч тань Толуй билээ. Гэтэл Нүүдэлд хүндрэх засаг. Нүүж буухад төвөгтэй алт эрдэнэс их хөрөнгө.

Их хаан Өгэдэй:

- Мэдрэгдэм хүч шүү дээ.

Сорхагтан бэхэ хатан:

-Нүүдлийн засаг гэж юу болохыг хаан танд би эхний бөгөөд эцсийн удаа халдан сануулъя. Нүүдлийн засагт иргүн үгүй бол төр бадрахгүй. Нүүдэлчдийн ахуй үгүй бол нүүдлийн засаг амь үгүй. Ахуйгаа төрөөс салгаваас алдаа биш солиорол. Ахуй үгүй төр бол хаанаа даахгүй өөөднө.

Их хаан Өгэдэй:

- Дуугаа аяар гэм.

Сорхагтан бэхэ хатан:

- Алтан улсыг цөмлөх гэж Амбугай хаан зоос сэдсэн. Сартуул улсаас өс авахын тулд их хаан зоос цутгасан. Мунхагуудыг маллах гэж манай хаад зоос сэтгэсэн. Аялгууг нь атгаж авах гэж алтан өргөөт хаад зоос хийсэн. Иргүнийг төрөөр бадраах нүүдлийн засгийн их хаан их зоосоор өөрөө бадрахгүй. Газрын хэвлийг хүүлж гараа дүрж олсон олж алсдаа гамшиг, ойрдоо гутамшиг. Адуугаа зоосоор солиж агт болгон дөрөөлөх үү? Алтаар зоос цутгалаа ч ааруулын оронд үмхвэл үхнэ. Ингээр солигдсон зоос ботго гаргаж үржих үү?

Их хаан Өгэдэй:

- Бөө сэцэн минь.

Сорхагтан бэхэ хатан:

- Аргал янгир идэх заяагаар чоно ирвэс болсон. Гөрөөс буга идэх заяагаар арслан барс болсон бөгөөтөл туулай хөөгөөд цадах уу? Морин дэлэн дээрээс байгуулсан улсыг морин дэлэн дээрээс удирдах Нүүдлийн засаглал бус уу? Ахуйгаа зоосоор орлуулбал ахуйт төр хоосрох бус уу. Ардаасаа гуйхуй, дээрэмдэхүй, хулгайлахуй, хуурахуй, болох бус уу. Ниргэгч хаан Чингисийн Их Монгол улсад хятад мэтээр сууна гэвээс хөгшин хонь унаад агт цаламдах адил болно биш үү. Нүүдлийн засаглал суумал руу зүтгэх юун.

Их хаан Өгэдэй:

- Аядаж үз.

Сорхагтан бэхэ хатан:

- Алтан дээд гэрэгэ, үнэний аялгууг гэвээс нүүдлийн засаг ахуйт төр иргүнээ гутааж, ор суугч хаанаа даахгүй өөднө. Төрийн найман цах аялгууг гэвээс түвшин цагт ч хөх Монгол иргүн төрөөр гутаагдан өөдгүйд боолчлогдоно. Толуйгийн минь амийг авсан хажир онол хожим ялна. Толуйн хажир үнэнээс айхдаа ний гэмтэнгүүд түүнийг минь зааж хөнөөлгөлөө.

Их хаан Өгэдэй:

- Сорхагтан бэхэ!

Сорхагтан бэхэ хатан:

- Хавьташгүй хар хорыг, хүсэшгүй мууг их хаан хүсэв. Үзэшгүй мууг иргүн үзэв.Цөвүүн цагийг их хаан дуудав.

Их хаан Өгэдэй:

- Дуугаа тат! Эм барс чамайг бахирсан зулзагуудтай чинь базаж хаяж чадна. Би. Алтан ургийн амины өрөнд чамайг өршөөлөө. Хорслын хар нүдэт минь, хааны булган хөнжилд бүү хэл хатан голын наана цаана бид багтахгүй. Ийм бол их төрөөс зай бол. Хаан эцгийн голомтыг харин би хурааж авлаа. Үхэх хүртлээ хүртэхээ тасалж ав. Нангиасын орон Жендэн рүү үтэр түргэн явж суу. Цөлөх минь чамайг.

Сорхагтан бэхэ хатан:

- Завсрын улсын зүү тэвнэ тэр. Таныг мэхэлсэн.

Их хаан Өгэдэй:

- Ёрын хүчийг дарах задын тэмдэгт зүг дүүг минь заасан. Мэдэж ав. Итгэж яв.

(Өгэдэй хаан Сорхагтан хатны өргөөнөөс гарна)

Сорхагтан бэхэ хатан:

- Хар хүчний хаалга онгойсоон. Тэнгэр болон тамын хоорондох хүн нутагладаг энэ газар цөвүүн цагийн үр энд тэндгүй соёолов. Худаг, булаг хатаж, өвс үргүйдэж үнс болно. Хулганы нүх сахиж зүднэ. Бяруу сохорч нүүдэл зогсож худагт уягдана. Буруу зөв холилдож ертөнц тэнгэр холдлоо, булай булхайгаа танихгүй цөвүүн цаг нөмрөн ирлээ. Цаг огторгуй хөрсийг хэрүүл хараал эдэлж, цавчилдан өрлөлдөн алалдана. Онгон хайрханыг олиггүй хараал нөмөрч охид хөвүүд уйлалдан цурхилдан ирнэ. Харж байна би. Өндөр төр лүү шургалсан булхайнууд өвгөд эмгэдийг өвсний чийгээр ундаална. Харж байна. Цөвүүн цагийн ирэх нүүрийг харж байна. Төрийн хайрцаг...бүү үзэгд. ..Маргад эрдэнийн улс хагарч, бутрах... нүдээ хамхих минь ..., Ээ... Мөнх хөх тэнгэр минь...,Цөвүүн цагийг үүдийг хаах хаан эзэн хаа байна вэ? (хөгжим)

(Харанхуйлал)

Гуравдугаар үзэгдэл.

3. Их хатан дөргэнэ, фатимагаар мэргэлүүлэв

Тайз: Хархорум. Ордон өргөөний сэнтийд Өгэдэйн их хатан Дөргэнэ, Ордны зөвлөх Аригун ноён, Олзны шивэгчин Фатима нар байна.

Их хатан Дөргэнэ:

- Сонсож байна аа.

Аригун ноён:

- Их Монгол Улсын Их хатан Дөргэнэ таны Эзэнт Гүрэн Хойд туйлаас Инд мөрөн, Солонгосын хойгоос Кавказын нурууг даван асар уудам газар нутгийг эзэгнэж байна.

Их хатан Дөргэнэ:

- (үл хөдлөн) Тийм.

Аригун ноён:

- Их хатан та гүн далайн ёроолын сувдаа нуусан хясаа шиг нүдээ анин зүүрмэглэх мэт атал сэрүүнээр өдөржингөө сэнтийдээ үл хөдлөн суулаа. Таны таалал юу хүсэв? Түүнийг мэдвэл таалал дор тань өргөхсөн.

Их хатан Дөргэнэ:

- Хэрэггүй ээ.

Аригун ноён:

-Далай хааны бас Их хатан таны алдар дэлхийн улс түмэнд нар саран лугаа гэрэлтэн мандаж байна.

Их хатан Дөргэнэ:

- Ертөнцийн хамгийн том Эзэнт Гүрэн.

Аригун ноён:

- Их хатан та уйдаж байна уу? Хархорин хотынхоо Түмэн амгалант ордон доторхи Таван тансаг цэнгэлт нуурнаа алтан мөнгөн онгоцоор хөвж шувуу агнахыг сонирхох уу?

Их хатан Дөргэнэ:

- (ихэмсэг хэрнээ зөөлнөөр) Үгүй ээ.

Аригун ноён:

-Хятадын өнгөт ший, Персийн хүчит бөхчүүд, Византын ариа салбадай, давжаа морийг сармагчин унахыг үзэх үү, эсвэл заанууд бөмбөлөг дээр тэнцэхийг та таалж болгоох уу? Аль эсвэл ханьжиугийн уянгат ятгын эгшгийг сонсох уу?

Их хатан Дөргэнэ:

- Үгүй.

Аригун ноён:

-Алжааж ядарч байна уу?

Их хатан Дөргэнэ:

- Үгүй ээ.

Аригун ноён:

- Их хатан ... (зогсоц) Таныг би тайван амгаланд тань орхиё.

Их хатан Дөргэнэ:

- (хүйтнээр) Хүлээ...Хүлээ...

Аригун ноён:

-Жа.

Их хатан Дөргэнэ:

- (ихэмсгээр нэг янзаар) Сонсож байна.

Аригун ноён:

-Их хатан таны алтан сонор юуг таашаах сан бол (зогсоц) Азотын тэнгисийн эрэг дээрхи нэн шинэ ялалтын ялгуун аялгууг сонсох уу?

Их хатан Дөргэнэ:

- Аригун ноён ярь.

Аригун ноён:

- Азотын тэнгисийн эрэг.. Мөхөөгч Зэв Сүбээдэйн хүлэгт цэргүүд Славянчуудын зэр зэвсэгт өртөхөөргүй зайнд тэнгисийн усны нам гүмийг дуурайн зогсоно. Монгол морьдын хөл дээрээ тогтон ядан газар цавчлах доргилт, үе үехэн долгион ирэх тэнгисийн хөнгөн давалгаатай ижилсэнэ. Морьтонгууд тугны дохиогоор довтолгооноо чимээгүй эхэллээ. Яг л тэнгисийн түрэлт мэт. Морьдын төвөргөөнд газар чичрэхийг сэтгэл түгшин хүлээх славянчууд тэнгисийн шуургыг хүлцэх зовлонг эх газар шиг хүлээнэ. Хүлэг морьтонгууд гэнэт зогсов.Тэнгис зүгээс өндөрт өргөгдөн өндийх үхлийн давалгаа мэт төмөр сумнууд тэдний дээрээс нөмрөн буув. Дайсагнагч славянчууд үй олноороо гэсгээн цээрлүүлэгч хүлэгтэнгүүдийн суманд сүлбүүлэн газартай хадагдлаа. Гэнэт морьтонгууд тэнгисийн татралт мэт эргэн холдов. Догширсон тэнгэр хилэнгээ хураагаад амгаланд цэлийхэд түүний доорхи тэнгис тогтон дөлгөөнд хувирах мэт хүлэгтэнгүүд тэртээд холдон зогсов.

Их хатан Дөргэнэ:

- Тэгээд... цааш нь

Аригун ноён:

- Эзэнт гүрний хүлэгтэнгүүд тэрсүү хааныг үхэгсдээ хаяад зугтахад бугуйлаа шидэн бариад хаанаар нь морьдынхоо баасыг түүлгэж элэглэн шоолцгоов. (Хатан муухан инээмсэглэв) Энэ улс Эзэнт гүрний Их хаан Их хатны өмнө мөхөв.

Их хатан Дөргэнэ:

-(бадрангуйгаар) Тийм ээ. Дэлхийг мэдэн захирах Их хаан хатан... Дэлхийг эргүүлэх салхины үзүүрийг би гартаа чанга атгах ёстой. Салхи..(хилэнтэй болно) Салхины үзүүр ёзоорыг гартаа чанга атгах... (өндийн босож ирнэ) Тиймээ.. (биеэ арайхийн барина. Түгшүүрт автана. Уйтгартай зөөлнөөр) Нишапурт ч, Вавилонд ч, амьдралын дарс дусал дуслаар шүүрэн, амьдралын модны навч нэг нэгээрээ унасаар байв.. (царай нь аймшигтай болон гунигт автана)Хүлээ.. Хүлээ...

Аригун ноён:

- Юу билээ. Их хатантаан?

Их хатан Дөргэнэ:

- Үргэлжлүүл..

Аригун ноён:

- Аан, юу...

Их хатан Дөргэнэ:

-Сонсож байна.

Аригун ноён:

- Ялалтын аялгууг үргэлжүүлэн дуудах уу?

Их хатан Дөргэнэ:

-Зовлонт хормуудыг шүлэглэжээ дээ.

Аригун ноён:

- Тийм байна.

Их хатан Дөргэнэ:

-Фатима чи энд байна уу?

Фатима:

-Тийм ээ. Их хатан. Та юу хүсэх сэн бол?..

Их хатан Дөргэнэ:

-Аан.. (үргэлжилсэн зогсоц) Аригун ноён цааш нь...

Аригун ноён:

- Жа.. Ялалтын дараа өрлөг жанжин Зэв, Сүвээдэй нар цэргүүдээ дагуулан Хар тэнгисийн эрэгт хүрч тэнд хаврыг өнгөрүүлэв.

Их хатан Дөргэнэ:

-Энэ гунигт яруу шүлгийн эзэн хэн гэлээ.

Аригун ноён:

- Саяхан таны дуудсан тэр шүлгийн шад уу? Оюу эрдэнэ, яруу найраг, шаазан урлалын өлгий таны эзэмшил болсон Перс орны яруу шүлэгч Омар Хайям.

Их Хатан Дөргэнэ:

- Аригун ноён та миний дүрийг уран зурахуйгаар дүрслүүлье гэж орж ирээд ярианыхаа эхэнд хэлсэн билүү.

Аригун ноён:

- Тийм ээ. Дөргэнэ Их хатан минь. Ертөнцийн хаад хатад ариун дүрээ бүтээлгэдэг тэр ёсоор.

Их хатан Дөргэнэ:

- Бид тэдний ижил биш.

Аригун ноён:

-Өршөөнө үү! Их хатан минь.

Их хатан Дөргэнэ:

-Тэнгэрийн төрх нэг янзаар биш.

Аригун ноён:

- Тийм ээ. Өршөө.

Их хатан Дөргэнэ:

- Энэ бол их хориг. Аригун ноён та айн мэгдэх хэрэггүй. Харин Персийн тэр яруу үгт, хатан миний тухай юу гэж шүлэглэх бол.?

Аригун ноён:

- Төрөлх хотоо ид шидийн яруу үгсээрээ өлгийдсөн алдарт найрагч таны эзэмшилд орохоос өмнө ертөнцөөс хальсан.

Их хатан Дөргэнэ:

- Их төрийн шан хүртэж чадсангүй дээ.

Аригун ноён:

- Алдарт шүлгийг нь та болгоох уу?

Их хатан Дөргэнэ:

-Аанхан. (Толгой дохино) Дууд дууд..

Фатима:-

Их хатан хэл чимээ ирлээ.

Их хатан Дөргэнэ:

- (түгшүүрт автан эргэж харна) Аригун ноён одоо болно. Өргөөг түр орхи. Оруул. (Абдулхман өргөөнд орж ирнэ)

Их хатан Дөргэнэ:

- (Хүйтнээр) Яав? Юу болов? Тэд ирж байна уу?

Абдулхман:

-Үгүй ээ. Их хатан минь.

Их хатан Дөргэнэ:

- Юу үгүй гэж?

Абдулхман:

-Хатан цөлөгдсөн.

Их хатан Дөргэнэ:

- Худал донгосч байна уу чи. Үтэр түргэн бүгдийг хэл.

Абдулхман:

-Өгэдэй хаан өргөөнөөс гарч ирээд хурсан улс түмний зүг гараа өндөрт өргөөд ...

Их хатан Дөргэнэ:

- (ширүүнээр) Тэгээд?

Абдулхман:

-Зарлигласан. Эхлээд Их төрийн зүүн гарын Их цэргийг Сорхагтан бэхэ бөө цэцэн хатны мэдлээс хураан авлаа. Хаан дараа нь Их Монголын Эзэнт Гүрний Их төрийн түшээ Толуй ханы зүүн жигүүрийн улс орныг мөн Эзэн Чингис хааны уугуул нутаг Бурхан Халдун, Хэрлэн Онон мөрний сав газар эцгийнхээ гал голомтыг би өөртөө хадгалах болно. Зарлигтай минь тэрсэлсэн хатан Сорхагтан бэхэг хөвүүдийн хамт Нангиасын орон Жиндэд одтугай хэмээн нутаг заав.

Их хатан Дөргэнэ:

- Хатан нь болохгүй гэжээ. (бахтай зэвүүнээр инээнэ) Эзэнт гүрний хатан болохоос татгалзжээ. Төрийг минь засъя, тэргүүнийг минь захирлья гэж ирэх гэж байна уу гэсэн чинь харин эх чоно төрүүлсэн бэлтрэгүүдтэйгээ цөллөгджээ. Унхиагүй хатан эм юмаа. Хааны орд өргөөний босгыг минь давж орж ирээд надтай уралцах юм байх гэсэн хүчгүй амьтан хөөрхий далд орлоо....

Абдулхман:

- Сорхагтан бөө сэцэн хатанг хэн ч өмөөрөөгүй.

Их хатан Дөргэнэ:

- Өмөөрөөгүй гэнэ ээ. Толгойгоо авч үлдэх гэж тэр дээ. (доогтой инээнэ) Сонорт минь баяр авчирсан худалдаачин Абдулхман чамайг эзлэгдсэн хот улсуудаас гааль, гувчуур авах эрх соёрхоё.

Абдулхман:

- Эзэнт Гүрний Их хатан Дөргэнэ таны өлмийд сөгдье. Өндөр их хишиг тань мөргөө.. (сөгдөнө)

Их хатан Дөргэнэ:

- Явж болно. (Абдулхман гарч явна) Салхи эргэлээ.. Салхи эргэчихлээ... Салхины үзүүр ёзоорыг надтай булаалдах хүн үгүй боллоо. Ташуурыг нь би атгах болно. Салхи.. салхи.. салхи. Тэнгис Газрыг би уулын орой дээрээс харж байлаа. Харин одоо би тэнгэрийн нүдээр ширтэх болно. Хүссэнээр минь болох тэр.. Фатима өмнө минь хүрч ир..

Фатима:

- Их хатан Дөргэнэ таны царай буйлсны ягаан цэцэг үзэгдэж байна. Түрүүнд та өвлийн тэнгэр шиг дүнсийн цайрч байлаа. Харин одоо бол хаврын үүлгүй тэнгэр шиг үзэсгэлэнтэй байна.

Их хатан Дөргэнэ:

- Сайхан сонсогдож байна. Цээж минь цэлмээд тэр..Ахад чинь шан хүртээв. Харин Фатима чамд би чигчий хурууныхаа алтан хумсыг өгье. (Гоёмсог урт алтан хумсаа авч өгнө) Өрсөлдөгч минь нүүрээ буруулав. Хөлөө хүлүүлэв. Миний засаглалд шинэ улирал ирж байна. Цэл ногоон зун ... Эргэлзэж байлаа.

Фатима:

-Эхний удаад та минь итгэхгүй байсан. Айх хэрэггүй байсан шүү дээ.

Их хатан Дөргэнэ:

-Гайхамшигтай юмаа. Би ийм эрс өөрөөр эргэнэ гэж төсөөлсөнгүй. Би бүр гайхахдаа мэнэрч чичирсэн шүү. Миний Хан хүү Гүюгийг мэдэж байна уу чи? (гоёмсог өндөр дугуй араб хийцийн ширээн дээрх хөзрөөс нэгийг авна)

Фатима:

- Хан хүүгийн орой дээр азын од гэрэлтэж байна...

Их хатан Дөргэнэ:

- Тийм ээ тийм... (өөртэйгөө ярина) Ийм гайхалтай байх уу? Эрийнх нь үхэл эм барсын зүрхийг үхүүлчихэж..

Фатима:

- Хачин юмаа.. (ахиад нэг хөзөр авна.Цочирдон арайхийн хэлнэ) Аймшиг.. аюул..

Их хатан Дөргэнэ:

- (өөртэйгөө ярьсаар байна) Сорхагтанд алдрах Өгэдэй хааны дур хүслийг би мэднэ. Харснаа авч чадахгүй хаан бишсэн. Хүсэл дор нь үл захирагдах хэн буй. Хачирхалтай. Яг юу болов. (бодлоо үл гүйцээнэ) Үнэхээр их хүч Сорхагтанаас илүү их хүч надад байна... (Фатимаг үл харна) Фатима Миний ханхүү Гүюг ирж явна уу?

Фатима:

- (айдастай чигтээ хөзрөө алдана) Эрлэгийн элч шиг үзэгдэнэ.

Их хатан Дөргэнэ:

-(шид үзэхийн таслан баяр хөөртэйгөөр) Ялалтын дуу авчирч байна уу.

Фатима:

-(толгой дөнгөж дохин сулханаар) Тийм ээ.

Их хатан Дөргэнэ:

-Яв. Рашаан ус бэлтгэ. Цэцэгсийн үнэрт цэнгэмээр байна. Хүлээ... Ханхүүгийн амжилтын цаана нууцхан би өөрийнхөө энгүй их ялалтыг тэмдэглэх болно. (Фатима зэвхий царайласнаа нуун мэхийнэ) Баяр цэнгэлийн хивсийг дэлгэж, шунхан улаан дарсыг, яруу хөгжмийн эгшгээр сүлж элбэг хангалууны дээдээр ордонг би бялхуулах болно. (Фатима явна Их хатан Дөргэнэ баяр бахдалаа дарж ядан зогсоно. Гэнэт түгшин царайгаа хувиргана) Худлаа ..Сорхагтан бэхэ хатан тийм өчүүхэн амьтан биш. Тэр хэтэрхий их зоригтой байна. Хаан тэвчихээргүй хатуу зоригийг Сорхагтан гаргасан байна. Тийм учраас хатанг хол нясалжээ.

(Харанхуйлал)

Дөрөвдүгээр үзэгдэл.

4. Сорхагтан бэхэ хатан мөнх тэнгэрийн хүчинд мөргөл үйлдэв

Тайз: Уул усны онго тахилгат газар. (Хөгжим . Хөөмий) (Толуйн их хатан Сорхагтан бэхэ, Хан хөвгүүд Мөнх, Хүлэг, Хубилай, Ариг бөх Толуйн бага хатан Мүкэ, Мүкэй хөвүүн Жөн Мон Тоба нар Жендэд цөлөгдөхөөс өмнө нутгаа орхин гарахдаа Мөнх хөх тэнгэрт хандан андгай өргөх үйл)

Сорхагтан бэхэ хатан:

- Мөнх хөх тэнгэрийн хүчинд мөргөмү. Дээд тэнгэрийн язгуур Бөртэ чино, Гоо Марал мину алтан үрс биднийгээ аварч хайрла,

Бүгд цугаар:

-Аварч хайрла. (Бүгд цугаар мөргөнө)

Сорхагтан бэхэ хатан:

- Өтүгэ, Мугулюй, Манукул, Хөх Монгол улирлын газар болоод огторгуй үнэн бөө бүх ертөнцийн долоон дээд өвөг эцэг элэнцийнхээ сүр сүлдэнд сүнсэнд мөргөмү.

Бүгд цугаар:

- Долоон дээд өвөг эцэг элэнцийнхээ сүр сүлдэнд мөргөмү. (Бүгд цугаар мөргөнө)

Сорхагтан бэхэ хатан:

- Үүслийн гурван эрдэнээр бадарсан, хайрын хос дуулаас ургасан хөх нуруут дээд төрөлт үрс бүхэн яс цусны алтан бүсээр оломлогдсон билээ. Ерэн есөн тэнгэрт мэндэлж, арван хоёр их ертөнцөд бойжиж, агуу гурван үнэн, зуун найман билгүүнд мөнхрөөд Алтай, Хангай, Хар жодоотыг эзэгнэх хөх Монгол иргүнүүд Их Монголын босоо голч нь билээ. Мөнх хөх тэнгэртээ мөргөмү.

Бүгд цугаар:

-Мөнх хөх тэнгэртээ мөргөмү.(Бүгд цугаар мөргөнө)

Сорхагтан бэхэ хатан:

- Мөнх хөх тэнгэрийн хууль дор Хамаг Монгол улсыг нэгтгэх заяатай Монголын Эзэнт Гүрний Мохоон гэсгээгч Богд Эзэн Чингис хааны сүр сүлд сүнсийг дууднам.

Бүгд цугаар:

- Богд Эзэн Чингис хааны сүр сүлдэнд мөргөмү. (Бүгд цугаар мөргөнө)

Сорхагтан бэхэ хатан:

-Өргөн түнгэд өнчрөх өдөр үгээ өчин мэдүүлнэ би Хаан ахын харц дор халширч, Хатан эгчийн хүсэлт дор сөгдөж, жаргалдах цагт жаргалдан, золихын цагт золио болно гэж Хаан эцэгтээ андгайлсан үгэндээ хүрч, золио болсон Толуйн цогцсыг өргөн өртөөлөн байж, захиран явсан улаан бургадад задын дор онголсон билээ. Хөх огторгуй өлгийгөөс үнэнийг гуйхдаа Толуй ястай Сорхагтан цустай хөвгүүдээ би төрийн найман цах аялгууг мөрлөн, Тэнгэр ертөнцийн их улсын төрөөр бадраах хутагтай нүүдлийн их засгийн Алтан дээд үнэний аялгуугаар амлуулж Дэрлэн-Дөрөөлөн хаадыг төрүүлнэ би Хан Толуйн хажир үнэнээр суут Чингисийг төрүүлэн өртөөлөх төгс босоо голчийг илгээсүгэй.

Бүгд цугаар:

- Чингис суутыг төрүүлэн өртөөлөх төгс босоо голчийг илгээсүгэй. (Бүгд цугаар тэнгэрт хоёр гараа өргөнө)

Сорхагтан бэхэ хатан:

-Эргэж нүүх хорвоогийн үнэнд эхийн сэтгэлд баригдан хэлсү. Төгс сайн цагаан задат Толуй минь ээ.. Дэнсэнд баригдсан бэхэ би чинийхээ бүсийг бүсэлж зогсоод хэлсү. Хатад хөвүүд чинь өнчирч үлдэв. Хар ертөнцийн аюул ирэв. Халуун голомтоо алдаад харь суумалын ертөнцөд цөлөгдөх болов бид чинь. Цөвүүн цагийн хилэнгээс би чиний хөвгүүдийг төмөр цүүц мэт өндийх хаадыг бэлдэж төрүүлнэ. Миний хөвгүүд үл долгилох гүн далай мэт сэтгэхүйтэй,үл хождох наран мэт гавьяатай. Эс няцах аадар мэт зоригтой эргэн нүүх хорвоог алгандаа төвшитгөх болно. Хар хүчний хаалгыг хаан түгжих ёстой. Үүслийн гурван үнэнд мэргэн, Үнэний таван хүрдэнд тэгш, Долоон дээд эцэг элэнцийн зөнд гэгээрсэн, Найм дахь их Чингис эцгийн зөнд тодорч, Арван түгээмэлд нэвтэрхий, Ерэн есөн тэнгэрээр тэтгэгдэх Зуун найман төвшин сайханд төгөлдөр хаадыг бойжуулна. Би

Мүкей бага хатан:

- Сийгэн тэр жил Чингис хаан эзэн, хан Толуй, хатан Сорхагтан бэхээн хамт анхны амь үүссэн гэх домогт манай Алтай Тоулын орон Хасхах Ёл ууланд миний эцэг Тоулчу мэргэнийд морилон ирсэн билээ. Хишиг өндөр Эзэн хааны гэгээн тэр замаар Тоулчу мэргэний охин Мүкэй би туг сүлд барих Толуй ханы бага хатан Засагч хатнаар өргөгдөн ирсэн билээ. Өндөр заяат алтан ургыг үүрд түшиж явна би. Амалъя.Тэнгэрээс биднийгээ тэтгэхийг гуйя. Толуй хан эр минь. Тоул Алтайдаа мөргөө. Ачилж хайрла.

Бүгд нийтээр:

- Алтай Тоулдаа мөргөө.

Сорхагтан бэхэ хатан:

- Ачилж хайрла.

Бүгд цугаар:

-Ачилж хайрла.

Сорхагтан бэхэ хатан:

-Бадраагч их хаадыг Толуйн хажир үнэнтэй байлгах төмөр нүүрт үгээ би хэлсү. Төгс Үлэмж Хөг Бүтээгч, Төрөөр Иргүнийг Бадраах Хутагтай Нүүдэлт Засгийн Алтан Дээд Үнэний аялгуугаар Их Монгол улсын Эзэнт Гүрний Их хаадыг бэлдэхээ Мөнх хөх тэнгэрийн хууль огторгуйн хүчинд мөргөн байж андгайлъя. Өндөр хаадын төрийг ясаа тасартал, цусаа ширгэтэл өмөөрөн байж хан хөвүүдээ хаадын зэрэгт хүргэнэ би. Андгайн үг минь хөхний цагаан сүү, зүрхний улаан цусаар бүтэв. Андгайг минь автугай.

Мөнх хан:

- Мөнх Хөх Тэнгэрийн хууль дор мөргөө. Гэсгээн ниргэгч Тохинуулан тогтоогч, Гэгээн Тэнгэрт өөд татагч Мөнх Тэнгэрийн хүч Төр түшигч Хан Толуйн хөвүүн Мөнх надад хүчээ өгтүгэй.

Хубилай хан:

- Есөн дээд өвөг эцгийн ав эв овын мөлсү дор алтан гурвалд зуун найман билгүүний цомирлигийг Хан Толуйн хөвүүн Хувилай надад дэлгэтүгэй. Үзсү би.

Хүлэг хан:

-Цагаан задын эзэн Толуйн хөвүүн Хүлэг надад Алтан оосрыг билгээр харах, арван түгээмлийг түгээх, нэурит үнэнг нээж өгтүгэй. Үзсү би.

Ариг бөх хан:

- Хан аавын Ариг бөх надад Хабсу их ертөнцийг онож бойжиход хаадын онго шүтээн харж тэтгэтүгэй.. (Мөргөцгөөнө)

Сорхагтан бэхэ хатан:

-Агуу дээд мөнхийн оюун ухаан, Алтан Дээдийн Гэриэ алтан урагын залгамж хэлхээ хөвүүдийн минь амин голоор урсаж хайрла.

Бүгд цугаар:

- Алтан Дээдийн Аялгуу амин голоор минь Урс...Урс...Урс...Хурай... Хурай...Хурай...

Сорхагтан бэхэ хатан:

-Мянган сэрэхүй нэгэн оюунд гал болж, миний хөвүүд мэргэд гарахын нөр хичээлээр гүн болж, Сүнс болоод эзэн биеэ тайлан уухайлж, Сүлд болоод гавалт бүрээний уянга дор ертөнцийг хурайлж, тэсч магад гарахын чанга хүчийг эзэгнэж, Дэлхийн улсууд монгол тархитай байхын дээд Тэнгэр хэмээн зарлиглах болтугай. Хаад хөвүүд минь хөрстийг энхжүүлэн, хөх тэнгэрт хүнийг өөд татах хүчит олом болох болтугай.

Мөнх хан:

-Толуй ханы ууган хүү Мөнх би Хүлэг, Хубилай, Ариг бөх дүү нартайгаа Есөн эцгийн цагаан задын сүнсэнд залбирч Ерэн есөн тэнгэрт тэтгэгдэн Их Монгол Улсаа өмөөрөн босоо орших ухааны хураар тэжээгдэн Эх Дэлхийн Эзэнт Гүрний төлөө хүчээ өргөхөө андгайлан тангараглья.

(Хан хөвүүд андгай тангаргийн ёсыг үйлдэнэ)

Хан хөвүүд нийтээр:

- Андгайлав бид. Андгайлав.

Жөн Мон Тоба хан:

- Алтай Тоул, Хасхах Ёлын нохой овогт отгийн эзэн Тоулчу мэргэний ач би. Толуй хан аав Мүкей хатан ээжийн Жөн Мон Тоба би Хатан ээжүүдийг минь хан ах нарыг минь хайрлан өмөөрөхийг гуйж байна. Харь нутагт цөлөгдөх надад хатан ээжүүдээ өмгөөлөх эрэлхэг зориг хайрла. Харьж заавал эргэж ирэх халуун цагаан мөрийг одоо хайрла.

Сорхагтан хатан:

- Бурхан Халдун хаан аав алтан ууландаа мөргөө, Хэрлэн Онон хатан ээж ариун мөнгөн мөрөндөө мөргөө. Их Монгол Улсын гал голомтондоо мөргөө. Бөртэ хатан эх Толуй ханы гал голомт биднийгээ харж яваг. (Бүгд цугаар мөргөнө.Сорхагтан их хатан, Мүкэ бага хатан цацал өргөнө. Бага хөвүүн Мөн Тобэ нулимсаа арчина) (Хөөмий, Морин хуурын аялгуу)

(Харанхуйлал)

Тавдугаар үзэгдэл.

5. Их хаан өгэдэй ханхүү гүүгийг шийтгэв.

Тайз: Их хаан Өгэдэйн өргөө. Далай Их хаан Өгэдэй, Их хатан Дөргэнэ, Илюй Цуй Цай, Аригун ноён, хааны бараа бологчид, хишигтэн цэргүүд байна.

Их хаан Өгэдэй:

- Ул ар гүн жил Эзэн Чингис хаан айлдахдаа “Хамгийн хаан нь юу бодохоос үл хамааран Хамаг Монгол Улс минь Хамтын тархин дор Төвшин сайхны халуун элгэн гэриэтэй байх ёстой. Алтан Дээд Гэриэт засаг барихаар очсон засаглахуйн сайдууд төр болохдоо тэд засагтай, засаггүй байвч ард түмэн алжаалгүйн төлөө Их Монгол улс үндэстний үүсэлт Алтан Дээд гэриэтэй байх ёстой хэмээн зарлигласан билээ. Бидний зорилго өндөр үүрэх ачаа хүнд. Илюй Цуй Цай таны эрдэм билгийг миний эцэг Эзэн Чингис хаан ч магтан өдгөө та Тэнгэрийн улс бидэнд хүчээ өгч зүтгэж буй билээ. Өнөөдөр Их хаан би Их Монгол Улсын Төрийн тэргүүн яамны сайдаар Илюй Цуй Цай таныг өргөн томилов.

Илюй Цуй Цай:

- Өндөр төрийн албыг өвгөн би даах болов уу гэж эмээж байна. Их хаан таны зарлиг дор тань бөхийе.

Их хаан Өгэдэй:

-Мэргүн Илюй Цуй Цай минь цэцэн ухаан тань чин үнэнчийн голоор урсдаг билээ. Тэнгэрийн ухааныг шагшран бишрээд чин сүжиг дор биднээ зүтгэсээр ирлээ та. Өндөр хүндлэлийг гагц танд өргөнө. Төрийн сайд Илюй Цуй Цай та Толуй хажир хан, Сорхагтан бэхэ хатны үйл хэргийг хураан залгуулан авч явах боллоо.

Илюй Цуй Цай:

- Итгэлийн дээдээр та намайг шагнав. Мөхөс би хүчрэхгүй болов уу гэж айн сүрдэж байна. Итгэлийг тань хөсөрдүүлэх вий.Энэ биенд ахадсан ачааг та надад үүрэгдлээ.

Их хаан Өгэдэй:

- Их Монгол төрд итгэлийг хэдийнэ бөхөлсөн та их төрд бичгийн их үйлийг агуулах хүмүүн бол яах аргагүй та мөн.

Илюй Цуй Цай:

- Зарлигийг тань хичээнгүйлье.

Их хаан Өгэдэй:

- Ханхүү Гүюг, Хөлөг баатар Алчидайг өргөөнд оруул.

(Ханхүү Гүюг, Хүлэгбаатар Алчидай нар орж ирнэ.)

Гүюг:

- Хаан аав, Хатан ээжийн амар мэндийг эрье. (бөхийнө)

Алчидай баатар:

- Амар мэндийг эрье. (бөхийнө)

Их хаан Өгэдэй:

- Гүюг би чамтай дараа тооцоо бодно.

Их хатан Дөргэнэ:

- Хаан та, ханхүү Гүюгийг минь буруутгах ямар шалтгаан байна. Алсын газар аян дайнаас ялалт өвөртлөөд хөвгүүн минь ирж байна биш үү.

Их хаан Өгэдэй:

- Их хатан. Гэрийн хэргийг гэрт, хээрийн хэргийг хээрт төрийн хэргийг төрд шийдэх ясу зарлиг бий. (Гүюг босож өөрийн суудалд сууна) Алчидай хүлэг баатар минь Эзэнт гүрний их цэргийн Умард зүгийн аян дайны мэдээг өгүүлтүгэй. Би сонсох гэж яарч байна.

Алчидай баатар:

- Мөнх тэнгэрийн зарлиг дор Их Монголын Эзэнт гүрний хуулийг дэлхийд тулган мөрдүүлэх Далай Их Хаан Өгэдэйн таны ясу дор ертөнц дэлхийн өргөргийн зуун хэм, таван мянганаас хэтрүү бээр удам газар орныг Монгол морины хурдаар хүлэг морьтонгууд Эзэнт Гүрний эрхэнд буулган хураан авлаа. Умардыг хураах их аян дайны эрхт Бат ханаар удирдуулсан Өрлэг жанжин Сүбээдэй Хан хүү Гүюг, Хан Цагаадайн хан хөвүүд болон таны зарлигаар нэхэн ирсэн Толуй ханы Мөнх, Хубилай хан хөвүүн нарын зүүн гарын их цэргүүд Өрнөд Европыг эзэгнэв. Их цэрэг умардын их талд хуран буудаллаж Их Монголын Эзэнт Гүрний Далай Их хаан Өгэдэй таны сүрт их ялалтын ялгуун аялгууг их цэргүүд уухайн дор тунхаглав.

Их хаан Өгэдэй:

- Миний их цэргийн Агуу ялалтын аялгуу Эзэн хаан миний алтан биений нүх сүвээр минь урсан орж ирээд гавал болоод цээжний дотуур дүүрч сэтгэл зүрх минь Мөнх Хөх Тэнгэрийн Алтан дээдийн аялгуунд эзлэгдэн бүрнээ хөглөгдөн донсолж байна. (удаанаар үргэлжлэх зогсоц) Тэнгэрийн зарлигийг үнэмшээгүй Умардын олон улсуудыг хэрхэн мөхөөн сөгтгөн доройтуулав. Дуудан өгүүлтүгэй. Яруу улаан аялгууг хөлөглөн сууна би.

Алчидай баатар:

- Мажорын уудам ногоон хөндий морьтонгуудын өмнө цэлийнэ.. Их Монгол Эзэнт Гүрний хүлэг морьтонгууд огт таньж мэдэхгүй харь хүмүүс хэрхэн тулалдахыг үзэхээр ойртлоо. Төмөр морьд... Төмөр цэргүүд...Төмрөөр өөрсдийнхөө бас өндөр морьдынхоо нүднээс бусдыг харийнхан зэвсэглэжээ. Дайны ав овын бүрээ уудам хөндийд дуурсав. Бат ханы ташуурын зангаагаар туршуулын цөөн хүлэг морьтонгууд урагшлав. Төмөр хайрцаг мэт жагссан харийнхны зүг цөөвтөр сум нисгэж үзэв.

Их хаан Өгэдэйн:

-Үхлийн занга мөн дөө. Хаан эцгийн өрлөг жанжин өрөөсөн нүдэт өвгөн Сүбээдэй минь хаан эцгийг минь дайтах ухааныг ахин амилуулж байна..Цааш нь сонсох минь...

Алчидай баатар:

-Төмөр цэргүүд хүнд сумаар манай хөнгөн хөлт хүлэгтэнгүүдийн зүг харвацгаана. Манай хөнгөн хөлт морьтон эрс тэдний харвасан сумыг дагаж давхилдан доог тохуу хийн нааш цааш давхилдлаа. Төмөр морьтонгууд хааныхаа тушаалаар урагш довтлов. Хүлэг сайт манай цэргүүд айсан дүр үзүүлэн гэдрэг эргэн зугтахдаа харийнхны зэвсгийн тусгал хүрэхгүй газар аажуухан давхилдана. Зугталтанд мэхлэгдсэн төмөр цэргүүд эгнээгээ орхин араас элдэв. Монгол морьдын хөлд хүнд нүсэр төмөр морьтонгууд эцэж сульданд цувраад ирэх нь тэр.Батын их цэргүүдэд ан овын үргээлэг мэт довтлох дохиог үзүүлэв. Их цэрэг ан овын их уугчаа хашгичааг үүсгэн харь улсын цэргийг элдэн хөөж гүн намагт төмөр цэргүүдийг төмөр морьтой нь живүүлэв. Тэнгэрийн зарлигт тэрсэлсэн төмөр улс Далай Их хааны хүчийг үхэж мэдэцгээв.

Их хаан Өгэдэй:

- Тийм. Миний их цэрэг умардын зүрхэнд тулж очлоо. Түүнээс цааш газар үгүй. Далай тэнгис л зөвхөн бий. Умард зүг Эзэн Их Гүрэнд минь их цэрэг хүлэг морьд цахих хурдаар харайхын газар бүрнээ хураагдах төгөлдөр их цаг дөхөн айсуй. Алчидай хүлэг баатар минь тэгээд...

Алчидай баатар:

- Өргөн их өвст хөндийд хураад үр дүнгээ хэлэлцэж дуусаад ялалтын сүрлэг өргөн найр эхлэв.

Их хаан Өгэдэй:

- За мэдлээ. Хурсан бүхэн сонстугай. Өргөөг орхи. Гэрийн хэргийг гэрт шийдэх цаг ирэв. (Өргөөнд хурсан олонг өргөөг орхи хэмээн гараар дохив)Алчидай баатар үлд. (Их хатан Дөргэнэ, Ханхүү Гүюг, Алчидай баатар нар өргөөнд үлдэнэ.Гүюг ханхүү Хааны өмнө ирж сөгдөнө)

Их хаан Өгэдэй:

- Би чамайг харахаас ч ичиж үхэм.

Их хатан Дөргэнэ:

- Их хаан минь хатан миний сонороос холуур юу болов?

Их хаан Өгэдэй:

-(Хан хүү Гүюгт хандана) Өндөг шиг ялзарвал таарна. Тархийг чинь би хагалаад яг одоо асгана.

Их хатан Дөргэнэ:

- Хаан минь, хүүг минь өршөө. Ханхүү Гүюг минь яаж орхив оо чи минь.

Их хаан Өгэдэй:

- Хатан эхдээ ичгүүрээ үтэр түргэн хэл чи.

Гүюг хан:

- Өршөө хаан аав, хатан ээж минь.

Их хатан Дөргэнэ:

-Гүюг ханхүү минь, юу болсныг хатан ээждээ хэл.

Гүюг хан:

-Ялалт алдрын найран дээр Бат хан түрүүлэн өндийж ялалтын дарсыг өргөн хааны ач үрсийн дотор бүхнийг тэргүүлэн их хаан болох хүслээ үзүүлэв.

Их хаан Өгэдэй:

-Мунхаг булай минь. Би түүнд аян дайны эрхийг өгсөн Бат эхлээд ялалтын хундагыг өргөх ёстой.

Гүюг хан:

-Өгэдэй хаан аавын таны хөвүүн Гүюг надад Бат ханаас түрүүлэн их хаан болох эрх бий. Бат хан бол алтан ургийн бус мэргэдийн Зүчийн хүү.. Алтан ургийн хан хөвүүдийг тэр их найран дээр жижиглэн үзэв.

Их хаан Өгэдэй:

-Амаа тат. Хуйндаа хэвтээ сэлмээр хуйхыг чинь би харин хуулна.

Их хатан Дөргэнэ:

-(Сэнтийнээсээ босч хааны өмнө сөгдөнө) Өршөө хаан минь. Өсөж том болох өдий байна хүү чинь. Өршөөж үз.

Гүюг хан:

-Хаан аав минь өршөө.

Их хаан Өгэдэй:

-Амыг нь авч би асуугаагүй байхад аль хэдийн өөрийгөө хаанд өргөн явж байна. Хааны энгээр сагсуурч хавьтсан ойртсондоо хашгиран гуугчина гэнэ. Хар толгойг чинь цаазална.

Их хаан Дөргэнэ:

-Хаан минь, эр минь. Хан хүүгээ өршөөж хэлтрүүл.

Их хаан Өгэдэй:

-Хэрхэвч би хэтэрсэн энэ явдлыг хэлтрүүлэхгүй.

Их хатан Дөргэнэ:

-Хэрэв ангасан сэлэм чинь үсчиж байгаа бол алив би өмнөөс нь үхье. Намайг чавчаад өг. (Үргэлжилсэн зогсоц)

Их хаан Өгэдэй:

-Өөрөөсөө нуусан гунигийг минь өвтгөж битгий баз. Өвдөж байна. Үрээ өмөөрөхдөө эх амьтан өрийг минь урав.

Их хатан Дөргэнэ:

-Хаан та үрээ энэр.

Их хаан Өгдэй:

-Хан хүү чи эцэгтээ мөргө.

Гүюг хан:

-Хазгай үгээ засахаа амлая. (Гүюг мөргөнө.)

Их хаан Өгэдэй:

-(зөөлөрнө) Хатан эхдээ бас чи мөргө.

Гүюг ханхүү:

-Их хатан ээж минь өршөө. (Гүюг мөргөнө...Уйлна)

Их хаан Өгэдэй:

-(зөөлөн хэдий ч хатуугаар) Уруулын уранхайгаар уралцаж Их гэрийн дотор хэрүүл шуугиан тарилаа чи. Дайчдынхаа хийморийг унагалаа. Чамайг сүрхий болохоор харь улс бууж өгсөн гэж бодоо юу? Тэднийг чамаас айсан гэж санав уу? Ганц хоёр цэрэг олзолсноор чи өөрийгөө дайнд ялсан гэж санаж л дээ. Ганц ишиг ч чи олзлоогүй Мэд. Гэрээсээ анх гарч үзсэн чи, эр хүн шиг байж үз. Бүхнийг өөрийн хүчээр олж авсан юм шиг та нар санаж байна уу. Бусдыг адгуус шиг дордчилж, агсарна гэнэ ээ. Муу ёрын бодол тархи руу чинь шурган шүгэлжээ. Алчидай хөлөг сайн эр минь.

Алчидай баатар:

- Жа, Их хаантан минь.

Их хаан Өгэдэй:

-Цэргийн хэргийг цэрэг дотор шийдвэл зохино. Ханхүүтэй ханьсан турхиралцаж сахалтай эмгэнийг өсгийгөөр давгаж, өлмийгээр гэшгих юмсан гэж Бат ханыг доромжилсон булхай мунхгийг хүлж бариад аманд нь чулуу чихэж үхүүл. Мунхаг хөвгүүн Гүюгийг алсын аян дайнд эргүүлээд авч яв. Явахдаа буруу харуулан моринд нь мордуулж хөлийн нь хүлээд мянган бээрийг туулуул. Замдаа зангирсан мунхгаа залхааг. Ёрын муу бодол нь явдал дунд нь зайлагдан унаг.

Алчидай баатар:

-Зарлигийг ёсоор болгоё.

Их хатан Дөргэнэ:

- Хөөрхий, Ханхүү Гүюг минь...(ганихарна)

Их хаан Өгэдэй:

- Хүчийг би төрүүлсэн бол тэвчиж магад гарахыг хуулиар болог.. Хаан миний ууган ханхүү Гүюг чи хамаг олны хайр хүндэтгэл булаан явах байтал хайран нэрээ хугалав чи.. Хаан төрд үнэнч бүхний халуун голыг нь хөргөв чи. (сэнтийнээсээ өндийнө).Умардын Их цэрэгт мэдүүл. Бат хан болон хан хөвүүдийн сонорт Их хаан миний зарлигийг буулга. Өмнөд Сүн улсыг хураах Баруун гарын их цэргийн түрүүнд оройлон дайтах ханхүү Хүчүг би хан хөвүүдийн дотроос Хаан миний хаан орыг минь эзлэн суух хөвгүүн хэмээн хаан би заав.

Их хатан Дөргэнэ:

-(балмагдан сандарна) Хаантан минь (их хатан сэнтийнээсээ өндийн босно)

Алчидай баатар:

- Зарлигийг тань ёсоор болгоё.

Их хаан Өгэдэй:

- Хамаг хэрүүлийг хагалан цохих минь. (Гүюг рүү муухай харснаа Их хатнаас нүүр буруулан сэнтийндээ сууна.) (хөгжим.)

(Харанхуйлал.)

Зургаадугаар үзэгдэл

6.Их хаан өгэдэйн зүүдийг зайран тайлав.

Тайз: Хааны ордон суурин иргэншлийн дүр төрх илтэд орсон байна. Өгэдэй хаан, Их хатан Дөргэнэ, Илюй Цуй Цай, Аригун ноён, Року Эд Дин, Абдулхман, жүжигчин бүжигч, алия салбадай, шивэгчид байна.(Ордны бүжигчид бүжин, амаараа гал үлээх перс эрчүүд, мөнхүү оросын салбадай нар хаан хатныг цэнгүүлээд өргөөний доод биенд сууна. Року Эд Дин ноён хааны дохиогоор өмнө ирж сөгдөнө)

Их хаан Өгэдэй:

- Суумлын ертөнц Багдадын их үгт ноён Року Эд Дин чиний тэр их гэх ухааныг ухаж нэг мэтгэлцье.Ордныг гэгээрүүлэх соёл гэж цэцлэх утгыг чинь нэг сорьё.

Року Эд Дин:

-Агуу хаантан минь, Ухаан минь өчүүхэн билээ.

Их хаан Өгэдэй:

- Асуусанд минь өч. (Року ноён балмагдан илүү дор сөгдөнө) Сайрх тэр танай суумал засгийн амин чанар юу болох вэ? За чи хэл.

Року Эд Дин

- Сонгохуй. Санал хураана. Олон хүн итгэвэл сонгогдоно.

Их хаан Өгэдэй:

-(Том эвэр цомоор архи ууна. Ихэд согтуу байна) Зуун хүн санал өгтүгэй. Тавин нэгэн тэнэг булхай, Дөчин есөн цэцэн иргүн гэвээс хаан болохыг тэнэгүүд дэмжвээс суумлын засаг тэнэг булхайг хаанаар залаад хар толгой хага цохиулах бус уу.(Том эвэр цомтойг гүйцэт хөнтрөөд эвэр цомыг харна)Урьд шөнийн зүүдэнд ийм эвэр зүүдэлсэн юм байна. Духан дээрээ ганц улаан эвэртэй туранхай хар үнээ газар шижилж мөөрөв. Тэнгэрээс юун дохио ирэв ... Аригун ноён их зайранд зүүдийг минь тайл гэж айлтга... Айраг сөгнө..(Эвэр цомоос сэжиглэнгүй дэргэдээ байх Абдулхманы тоссон гарт алдаж өгнө Аригун ноён мөнгөн аягатай айраг барина. Хаан түүнээс ууснаа таатай болно) Року Эд Дин ноён танай суумал засгийн хөг бүтээх гэж юу вэ?

Року Эд Дин:

- Дээдсийн ордны яруу хөгжим бялхсан найр цэнгэл, элдэв эрдэнийн гялбаа, бүжин цэнгэх тогос мэт бүсгүй хүн, гоо эмс охид...Хөгжил цэнгэл хичнээн дүүрнэ. Хөг бүтэх тэр болно. Нижгэр их дуу хуур наадам бол нийтийн жаргал.

Их хаан Өгэдэй:

- Хөлгүй их цэнгэл жаргал дуусна. Хөрөнгө чинээ барагдана.

Року Эд Дин:

- Татварыг хатуу чанга мөрдүүлж, тариачин, будаачин, бүрийг хатуу тоолно. Хааны сангаас үр тариа өгнө. Хамгаалж бас өмгөөлнө. Газар бүрийг хэмжиж, гарах гарцаас ашиг ирж хөрөнгө зоорь нэмэгдэнэ.

Их хаан Өгэдэй:

-Татвараас айхдаа тариалангаас өндийхгүй харц боолын бас татвараар идээлж таргалах хаад ноёдын бие үхвээс хөрөнгө яахав?

Року Эд Дин :

- Хүү өвлөнө.

Их хаан Өгэдэй:

- Дайтах хүү дайнд үхвэл яах вэ?(Нүүрээ дараад мэгших мэт болсноо) Ай хайран хөвүүн Хүчү минь..

Аригун ноён:

-Сүн улсыг зүг бүрээс нь довтлох манай гурван замын их цэрэг ялалтыг удахгүй танд авчирна.

Их хаан Өгэдэй:

- Тэнгэрийн зарлигыг үл хэрэгсэж тэгээд миний хүүг онилж байна тэд. Буулгаж аваад хотод нь уйлах нүд ч бүү үлдээхгүн. (агсрангуй уурлана)

Року Эд Дин:

-(сандрахдаа) Би өв залгах хүүгээ дайнд явуулахгүй.

Их хаан Өгэдэй:

- Юу гэнэ ээ. Олон үгт чи хэл. Хэн гэргийгээ халхалж, хэн гэрээ өргөж, хэн эх нутгаа өмгөөлж, хэн хүлэг морио унах вэ? Тэгээд?

Року Эд Дин :

- Хаан ор залгах ханхүү ордонд эрдэм сурч дайнд үл мордоод төр гийгүүлэх ухаанд шамдана. Манай хан ноёд агь хөвгүүдийнхээ өмнөөс хөлсний эрчүүдийг дайнд явуулна.

Их хаан Өгэдэй:

- Суумал ертөнцийн зальтай булхай боольху мөн дөө Чи. Тэгвэл сүнсийг чинь хэн чиний өмнөөс тэнгэрт аваачих вэ? Хөлсний цэрэг үү? (зэвүүрхэн инээнэ) Мэд.. Тэнгэр зөвхөн шударга ариуныг таална. (Айргаа залгилна. Өмнөө тавина)

Року Эд Дин:

- Өршөө. Их Гүрний Эзэн хаан минь өршөө.

Их хаан Өгэдэй:

- Чамайг манай элэнц өвөг хижи гөрөөс гэдэг юм. Чи бол босоо хижи гөрөөс. Идэхийн тулд ижил төрлөө дээрэмдэх, хооллохын тулд хорлохыг зорих, булаацалдан идэж бусдыг үл бодохыг босоо гөрөөс гэж нэрлэнэ. Хүний төрөлд дөхөж яваа амьтан байна даа. Орж яваа хүний энэ төрөл чинь харин хижи гөрөөсний дээрдлийн үе. Мэд. Танай суумлын ертөнц одоо биш гэхнээ алс хойчдоо сүйрэн балрах заяатай. Суумлын төр гээч хүмүүний цуглуулга... Тэнгэрт авирах мөн ч хол байна даа. Алтан аялгуунд оосорлогдож агуу тэнгэрийг онож очих гэж юу болохыг чи мэдэхгүй. (сүрдүүлэнгүй) Мөнх Хөх тэнгэрийн зарлигаар хөх нуруут иргүн улс биднийг дэлхийн булхайг нэгжиж, ертөнцийг төвхөнүүлэн, хүнийг засаж, хүн төрөлхтөнг засагла гэж илгээсэн юм. Бидний нуруун дээрхи Мөн тобэ бодисын Хөх толбо бол тэнгэрийн оршигчийн тамга. Засаршгүй булхай боульхай нарыг даруй ниргэх зарлигтай.

Року Эд Дин:

-(Айна.Хахан гацна)өө.

Их хаан Өгэдэй:

- Нялцгай боолхой чи төвөнхөндөө хахах шахав.

Року Эд Дин:

- (Року ноён арайхийн амьсгаа авна) Хүний хаан, хөрстийн эзэн минь намайг өршөө!

Их хаан Өгэдэй:

- (Хаан хөхрөнө) Салбадай чи Року Эд Дин ноёд малгайгаа өмсүүл. (салбадай малгайгаа өмсүүлнэ) Чиний суумлын төрийн титэм бол энэ.(Хаан инээнэ. Хатан үл инээнэ) Аригун ноён, ордны жүжигчин бүжигч, салбайдай нар аягач шивэгчид бүгд Року Эд Дин ноёныг хүндтэй өргөж залаад хааны эрдэнэсийн сангийн орд дотор гурван өдөр шөнийг эдлүүлэн жаргаа. Суумлын тэр ертөнцөд хүнс бүү оруул. Абдулхман чи ч бас хүндтэй энэ ёслолд оролц. (Аригун ноён жүжигчин мөн алиа салбадай бүжиглэгч эмс нар луу дохино. Балмагдсан Року Эд Дин ноёнг дээр өргөнө)

Року Эд Дин:

-Энэ дэлхийг захирах эрхийг бурханаас таньд ноогдуулсан болохоор таны бүх үг үнэн.

(Өргүүлэн явна. Абдулхман хаанд ёслоод араас нь дагаж гарна. Орд өргөөнд Хаан, хатан, Илюй Цуй Цай нар үлдэнэ)

Их хатан Дөргэнэ:

-Хаан та Року ноёноор зугаацаж яанам. Уй гунигаар бусдыг элдэвлэв.

Их хаан Өгэдэй:

-Үнэн үгийг олж авч, үхлээрээ хохирохыг нь болиулах гэсэн хэрэг. Суумлын ертөнцийн мунхгийг хаан би тогтоож авья, хатан чи бас харж ав. Өөрсдийгөө элэглэх минь...

Их хатан Дөргэнэ:

-Хаан та их согтож хөлчүүрхэж байна.

Их хаан Өгэдэй:

- Өөрсдийгөө элэглэж байна би. Хатан чи харин яагаад харж чадахгүй байна. Эд баялаг, эрдэнэс хоолойны хаана тулаад эргээд хаашаа авч явдгийг нь үзэж байна би. Гүн ёроол руу... Хөлөө хэрэм дотор хорихоор хөгцөрдөг юм байна. Хөөрхий хатан минь өөрийгөө хараач. Хацрын цусан улаан цэцэг чинь хагдарчихаж... хагд өвс удахгүй царай руу чинь өгсөх нь...

Их хатан Дөргэнэ:

-Ертөнцийн түмэн өнгө гүрэн улсад минь хуран чуулав. Дэлхийн буман хүч гүрэн улсад минь цуглав. Их гүрэн ингэж дүүрэн бялхах учиртай.

Их хаан Өгэдэй:

-Их хатан минь үнээн үнэн. Элдвийн бүхэн ирлээ. Их гүрний сав далай тэнгис ёсоор их эргүүлгэндээ угаах цаг ирлээ. Үнэн хүнд нь үлдэж өгөр булайг болгоныг нулимж гаргах цаг ирлээ. Их худалд хүлүүлээд эмх цэгцгүй болсон ертөнцийн, оройн биш ёроол нь онгорхой юм гээч. Их далайн ус шиг бохироо цэвэрлэх цаг ирэв. Нүүдлийн засагт Эзэнт гүрний ай савыг ихэмсэг тэнгисийн хилэнгээр цэвэрлэхийг би их яарч байна. Суумлын ертөнцийн хэсгээс таслан нүүдлийн оршихуй ертөнцөдөө авчирч хар хотыг босгон хашигдаж хоригдохыг туршин хаан би биеэрээ үзлээ. Суумлын энэ хотыг Хархорин гэж нэрлээд хажуунаас нь харж туршиж үзлээ би. Илюй ЦуйЦай минь энэ суумлын ертөнц их том мөхлийн эзэн юм гээч. Дэлхийг зөөлөн зооглох ёрын шинжийг үзэв.

Илюй Цуй Цай:

-Их Монголын Эзэнт Гүрний нүүдлийн засаглал энэ дэлхий ертөнцийн аврал билээ. Морин дэл дээрээс удирдах засаг төрийн нүүдлийн хөдөлгөөн бол мөнхийн хөдөлгөөн. Төрөлхтөнг аврах нэгэн үндэс билээ.

Их хаан Өгэдэй:

- Морин дэл дээр эзэлсэн улс орныг мориноосоо буулгүй удирдаж болохгүй нь дээ гэж эргэлзэж байлаа, би. Их ухааныг хүсч байлаа. Эргэлзэж өөртэйгөө хэрэлдэж байлаа. Шилэх сайныг нь олов. Шинжгүй муугийн нь мэдэв.

Илюй Цуй Цай:

-Эзэн Богд Чингис Хаан минь чулуун хана хэрмийг үзэн яддаг байлаа. Цоо мэргэн хаан хорлолын шинжийн цочтол надад хэлж билээ.

Өгэдэй хаан:

- Аялгуут дээд үнэнээс гажваас хохирлыг нь даана гэх үгүй ажээ. Нэүрит засгаас нэг шинжийг нь хасваас нэрвэгдэх ажээ. Хорвоогийн нүүхүй мөнх хөдөлгүүр, бодисын жам нь чин үнэн байхад суухуйгаар зохицох гэх зүүдний тэнэгрэл мөн ажээ. Гурван оломлогчтой засаг байгуулаад гайхуулах нь Их Монголоос өөр хаана ч үгүй.

Илюй Цуй Цай:

- Хүчит цэрэг, алтны сангаар зогсох засаг хүчээр байлдаж хядаж сөгдүүлж чадах ч хүмүүний иргүн болгож хүчрэхгүй.

Их хаан Өгэдэй:

- Тэнгэрт хүргэх хөг бүтээгч аялгуут засаг Хөх Тэнгэрийн дор Нүүдлийн засаг Их Монголоос өөр хаана ч үгүй. Хүмүүнийг дууриаваас араатан ажгуу. Хүмүүнүүдэд хөх Монголыг дуурайх хөх бодис үгүй ажээ. Хорвоогийн хүмүүнийг иргүн болгох уу? Хуучин хэвээр нь хүн байлгах уу? Хамтдана гэж хүсвээс хоёр нар мандуулах гэсэнтэй адил худал үнэн холилдож хор найрагдму.. Суумлын төр орших гэх нь мөхлийн үндэс аж.

Илюй Цуй Цай:

-Их Чингис эзэн суухуйг устгамай гэж нэргээд Их Монголын аминг нүүхүй гэж чанарласан.

Их хаан Өгэдэй:

-Гарцаагүй үнэн. Ганц хөлт тийрэн улс алсдаа зогсож гал мэт хохиролд идэгдэн хямарна. Суумал засаг эцэстээ сүйрнэ. Нэүрит засаг соёолон морины хурдандаа чангаран тэнгэрт мэндэлж ертөнцөд бойжно. Алтан дээд үнэн аялгуугаар асрах ухаан чин үнэн. Сэтгэлийн төрхийг хоослогч хана хэрэм...

Илюй Цуй Цай:

-Их хаан минь энэ үнэн.

Их хаан Өгэдэй:

- Суумал ертөнцийг хурааж нүүдлийн замд оруулах дэмчийн аялгууг бид цааш зохионо. Хаан

би Хар Хорин хотыг Хавт сайн эрийн сум тавьсан газраас цааш ахиж үл тэлнэ. Хожмын хаад ч бас үүнийг дага. Их хаан Өгэдэй миний зарлигийг үйлд.

Илюй Цуй Цай:

- Ёсоор болгоё.

Их хаан Өгэдэй:

- Их хатан минь, Хар Хорины сан эд баялгийг харамгүй түгээ. Нүүдлийн засгийн ачааг хөнгөлөх минь.

Их хатан Дөргэнэ:

- Мансуурчээ та.

Их хаан Өгэдэй:

-Хатан минь чи давчуу байна.

Их хатан Дөргэнэ:

- Хаант төрийн сан хөмрөгийг задлах нь харин ухаангүй хэрэг.

Их хаан Өгэдэй:

- Хатан минь ийм түргэн хорлогдож байхад хөх иргүнүүд минь бүр хэцүүджээ. Эдэнд умбан, тансаглалд автсан бол эргэж түүнээс гарах хэцүүг харах минь энэ... Хатан минь, гайг гавлаасаа үтэр хөө..

Их хатан Дөргэнэ:

- Хаан та ихэд согтууран хөлчиж дээ. Ханхүү Хүчү дайнд үрэгдсэнээс хойш та уй гунигаа архи дарсаар аргадах болсоор удаж байна.

Их хаан Өгэдэй:

- Уусан бие халсан ч ухаан минь цоо байна

Их хатан Дөргэнэ:

- Хаан та хатадтайгаа босгосон хотоо тойроод нүүж сууж байна. Аян дайны нүүдэл ч алсад хөдөлнө бус уу. Бэлэгдлийн хотыг бүү оролд. Бэлэг нь бүүр зузаатгах нь хаан төрийн нүүр тодорч өнгө үзэмж гэрэлтэнэ.

Их хаан Өгэдэй:

-Хатан минь, гадаснаас уяатай ботго шиг хаан би Хархорин хотыг тойрон нүүж суув үзэв...

Уулс ч үүлс ч нүүдэг.. сүнс сүлд ч газар тэнгэрт нүүдэллэдэг. Ширхэг зоос газраас, дусал нулимс ч биеэс үл авах ертөнц бол бидний суух энэ ертөнц. Эзэнт гүрний их төрийн нүүдлийг үргэлжлүүлж их хаан би уяагаа эвхэх минь..

Их хатан Дөргэнэ:

- Өргөөндөө би мориллоо. Амрах минь.

(Хатан сэнтийнээсээ босоод явах гэтэл бөө зайран орж ирнэ. Их хатан зогсоно)

Их хаан Өгэдэй:

-Их хатан өргөөндөө морил. Ухааныг минь удаанаар тунгаа. Их жаргалаас ангижирч нойрноосоо сэр. (Их хатан Дөргэнэ явна)Сүн улс руу би өөрөө дайлаар мордоно.

(Хаан Илюй Цуй Цай өөд явж болно хэмээн толгой дохино. Илюй Цуй Цай сайд хаанд ёслоод явна.)

Зайран:

- Хаан эзэн минь. Хаан таны зүүдийг тайллаа. Өршөө хаан минь. Муу хар зүгийн илбэ шид. Их хаан минь харийн хатавчний хар хатан тэр мөнөөс зайлахгүй. Түүний илбэ жилбэ хаан тан руу минь нүүрлэсэнг сая мэдэв.

Их хаан Өгэдэй:

-Сартуулын хар хатан эх үү?

Зайран:

-Тиймээ.

Их хаан Өгэдэй:

- Тэр одоо хаана байна?

Зайран:

- Их хаан эцгийн тань зарлигаар малчин иргүний гэрийн хаяанд унгас ноос саван сууж байх учиртай. Хар зүгийн хачин хар эхийн муу ёр ханхүү Хүчүгийн өэжин биеийг үхүүлжээ. Хар шид, хараал дом, хар зад өндийжээ. Өндийж.. ханхүү рүү харваад хариу эргээд иржээ.

Их хаан Өгэдэй:

- Одоохон түүнийг газрын мухар, гуу жалганаас ч болтугай ол!

Зайран:

-Үхсэн байна.Тэр хар хаган үхэх үхэхдээ сүнсээ хан хүү рүү зүтгүүлжээ. (Энгэр дэх гуулин дугуй толио заана)

Их хаан Өгэдэй:

- Юу?

Зайран:

-Аймшигт хараалын хар хүчинд сүнс нь хураагджээ. Сүнсийг нь дуудахад үл ирнэ. Эгэл бус эзэн нь хаа нэгтэй тэнүүлчилнэ.

Их хаан Өгэдэй:

-Ханхүү Хүчүгээ би хаан суудал руу заалаа гэсэн чинь хар үхлийн эрлэгүүдэд заагаад өгчихлөө гэж үү.. Ай хайран хөвгүүн, ай хайран ханхүү..

Бөө зайран:

- Улаан ганц эвэрт үнээ гэх харь зүгийн хар ертөнцийн эм дүрт хар хүч мөн. Хаан таны зүүдээр нүглээ нууж барахгүй үзэгдэх атаа улаан азар харын сэжим тэмтрэгдэв. Барихад бярдугав. Алтан ургийг дуудан цуглуулж , ерөн есөн тэнгэрийг тахиж илбийн хар ертөнцийн ёр ёзоорыг таслах хэрэгтэй байна. Их төрд гай нөмрөх нь... ганц улаан эврээр газар сэжих нь тун ёр.

(Хаан цочирдон түгшив. Түгшүүрт хөгжим)

Их хаан Өгэдэй:

- Алтан өргөөг гурван хүрээнд хатуу хоригт мана. Тэр хар эмийн ясыг авчирч сайтар шалгаж таниад шатаахгүйн! (өргөөний хэвгүүл хишигтэн цэргүүд өргөөг хатуу хоригт авна)

(Бүрэнхийлэл) (Гэрэл тодорно)

Их хаан Өгэдэй:

- (Зайран зарлиг бичиглэнэ) Мөнх тэнгэрийн хуулиар цагаан зад бөө бэг хүчийн нууцын оршилд нар зөв эргэсэн хабсу хасу эргэн хамагдваас бадран мандана. Хар задын бөө бэг хүчийн нууцын нууцад нар буруу эргэн хамагдваас хабсу хасу хар их ертөцийг устгана. Ужиг өвчин дотрыг минь үе хүчтэй төнхөнө. Нэүрит төрийн хар хабсу хасуг үйлдэхийг чанарлаж хар хасу бөгжийг чанадлав. (Гараасаа бөгж авч Илюй Цуй Цай , Зайранг ээлжлэн харснаа зайранд өгнө)Хар хабсу хасыг би эс амжваас хаан орыг авах түүнд зарлиг тулган өгсүгэй. Их хаан чанарласныг чандлан тушаагтун. Зайлшгүй үйлийг зарлигийн дор бичиглэж нууцад хадгалтугай. Хаантай тэрсэлсэн харцага шонхор ч бай үхүүлтүгэй. Хаан эс үйлдвэл үхтүгэй. “Хаадын гавал Их засахуйн Алтан дээд гэриэний аяга байх болтугай. ”Эзэн Богд Чингис хаан эцгийн алтан гэрээсийг мөрлөтүгэй. Хаан эс мөрлөвөөс үхтүгэй. Далай хаан Өгэдэй. (Зайран зарлигийн бичгийг өгнө.Өгэдэй хаан төрийн хасбу тамгаар зарлигийг тамгална) Золиосонд

одсон түүний минь ууган сүүн эсэнд уяагдсан тэнгэрийн аялгуу, хөх бодист тэр үзэх болтугай! Нууцлахтун!

(Түгшүүрт хөгжим)

(харанхуйлал)

Долоодугаар үзэгдэл

7. Өгэдэй хаан мөнх хөх тэнгэрт одов

Тайз: Их хатан Дөргэний өргөө. Их хатан Дөргэнэ шивэгчин Фатима нар байна.

Их хатан Дөргэнэ:

-Ханхүү Гүюгээ хаан суудалд суулгах их хатан миний орь ганц хүслийн мандмал од гэнэт тэнгэрээс ховхрон харвах замдаа шатаж уналаа гэтэл Хүчү ханхүүг хүний өтгөн дотроос, хөрстийн өргөн дундаас олж биеийг нь дарж буулгачихлаа. Үгээр хэлэхэд багадам үгүүлшгүй хүч минь үгийг минь сонс оо. Алдарт авирах замыг нь зас. Алтан сэнтийд хүрэх замыг нь тос.

Фатима:

-Алтан Дээд гэриэнд хүрч нэг үзэх сэн.

Их хатан Дөргэнэ:

- Болохгүй. Эзэн хааны их төрийн хоригт харь хүн үл үзэх хатуу цааз дор Алтан дээд гэриэ бий... Үзэх ёстой нүд үзнэ. Үзэх ёсгүй нүд үзэхгүй.

Фатима:

- Үзвэл үнс, харвал хальс болох юм уу..

Их хатан Дөргэнэ:

-Амаа мэд. Тэнгэрийн гэсгээл чам руу ирнэ. Чимээгүй. Тэнгэр надаас тааллаа хураана. Өршөөл эр. Тэнгэр биднийг харж байна.

Фатима:

- Үргэлж харж байх уу?

Их хатан Дөргэнэ:

-Мунхаг эм. (Тэнгэрээс айн зөөлнөөр) Мөнх хөх тэнгэр үргэлж биднийг ажин харна. Хамаагүй үг үсэргэж хамаг огторгуйн эрхшээгчийг хилэгнүүлнэ. Хатан надаас хүчээ эргүүлж татна. Амаа хамх... чимээгүй бол... Эрхшээгч тэнгэр ямагт их төрийн их хатны миний талд байна. Агаарт хориг зөрчих тэрс үг бүү түгээ. Хөөрөөд хүрчихнэ. Сонсчихож мэднэ.

Фатима:

- Их хатан та хувцсандаа багасах нь.

Их хатан Дөргэнэ:

- Фатима чи чинь юу гэв ээ?

Фатима:

- Их Хатан та надад хүслээ шивнэхэд хангалттай.

Их хатан Дөргэнэ:

- Тэнгэр минь дуугаа тат. Үхэхийг хүсэв үү чи. Орой дээрхи ивээгч тэнгэрийг цочоон уурлуулах нь. Мунхаг боолыг өршөө.

Фатима:

- Их хатан та мөргөлийн тэнгэр ээ андуурч байна.

Их хатан Дөргэнэ:

-Ухайс даа. Их юм ярих нээ зарц боол эм чи. Сөгд өмнө минь. (Фатима үл хөдөднө.) Сөгдөхгүй гэнэ ээ. Зарлигийг минь тэрслэнэ гэнэ ээ. Одоохон сөгд. (Фатима үл хөдөлнө.)

Их хатан Дөргэнэ:

- Аан..! юу болж байна энэ чинь. Одоохон хөлд минь сөгдөхгүй бол чамайг цаазална.

Фатима:

-(үл хэрэгсэнэ)Дэмий дээ. Хатан минь.

Их хатан Дөргэнэ:

- Юу гэнэ ээ. Үгийг минь үл дагаж, өөдөөс минь үг хэлж зүрхэлнэ гэнэ ээ. Байж болшгүй. Сөгдөхгүй байна гэнэ ээ. Хөлийн хуруунаас чинь эхлүүлэн үе болгоноор чинь цавчиж сөгдүүлнэ би. Тасдаж хаяад чамаар нохой хооллоно.

Фатима:

- Хатан та үхэл рүү яарч байна уу?

Их хатан Дөргэнэ:

-Хатан руу харц харгалдана гэнэ. Үзээгүйгээ үзэх минь.

Фатима:

- Хэрэв намайг алвал хариу та үхнэ.

Их хатан Дөргэнэ:

-Задарсан боол гэнэт галзуурах эм.

Фатима:

- Өмнө минь хатан та сөгд!. (Их хатан өөрийнхөө нарийн сэлмийг авна. Фатима руу чиглүүлнэ.)

Их хатан Дөргэнэ:

-Би юу сонсчихов оо. Худал сонсоогүй байгаадаа.. (инээд алдана) Их тэнэгрэлийн дуу чих рүү оров.

Фатима:

- Үхэл минь нэг шүү дээ!

Их хатан Дөргэнэ:

-Юу вэ? Эзэнт Гүрний өндөр заяат их хатан дорд заяат эмтэй үхэл нэг гэв үү? Юу сонсох минь энэ вэ? Галзуурчихжээ энэ эм. Дор нь чавчих минь. (Хатан нарийн гоёмсог сэлмээ хуйнаас нь сугална)

Фатима:

- Хараа тань сохорч хүсэл тань унтарна.

Их хатан Дөргэнэ:

- Ха ха ха..бардаж байгаа юм байна чааваас. Чи бол миний дээрхи мөнх хөх тэнгэрийн зараал зарц. Мөнх хөх тэнгэр надад чамайг зар гэж явуулсан шороон түмний нэг.. ха ха... Их хатан миний дээш холыг тандан харах нүдний нэг л сормуус чи. Доош гишгэн тулах хөлний ул хогжруу төдий чи. Олзны олон дотроос татаад өргөөндөө хатан би чамайг өөдлүүлэн зарцлах гэж авчирсан болохоос хатан мөрөн дээр минь авирч ас гэсэнгүй. Их хатны үлдэгдэл чамд их олз байлаа. Ихэрхсэнээсээ чи үхэх нь энэ. (Хатан нарийн урт сэлмээ сүрдүүлэн өргөнө)

Фатима:

- Хүлээж байна.

Их хатан Дөргэнэ:

-Айхгүй байна. Эм чи бол ерийн нэг үзмэрч... Дэлхийн булан тохой бүрд байдаг л нэгэн.. Хатны зөнгийн мэлмийг тайлж хэлж тандан харахад дэмнэх өчүүхэн хүч чинь юу ч биш. Нясалж алж болох өлөн хуурс чи. Чамайг би үхүүлнэ. Туугдаж ирсэн боолуудын дотроос зарц шилэхэд нүдний чинь цагаа надад торсон. Үзэмжийг чинь биш өнгө нь зөрүү хоёр нүд чинь

өртсөн. Байз.. байз.. (сэлмээ чиглүүлэх гараа доо яльгүй буулгана)

Фатима:

- (найланхай дуу гаргана.) Тэгээд би цагаан хар нүднийхээ харыг нь аниад их хатан таны хүж хорхойн шүлсээр нэхсэн торгон дээлний доорхи уян цагаан нуруун дээрх хар мэнгэ өвчилснийг хэлсэн.

Их хатан Дөргэнэ:

-Хөх тэнгэр минь!

Фатима:

-Чш,чимээгүй. Тэнгэр сонсоно. Нуруу дагасан хөх толбо тань нэн бага.

Их хатан Дөргэнэ:

- Цэхэр зэтгэр!

Фатима:

- (тачигнатал инээнэ) Нэн бага хөх бодисноос болоод их хатан таны хоёр нүд хөх тэнгэрийнхээ холд хүрдэггүй. Их Хаан эзнээс эмээхдээ их хатан минь нуруундаа хөх бэр цэцгийн өнгө будгийг нууцаар шавшиж хөх толбоны өнгийг шингээдэг.

Их хатан:

- Чавчиж чамайг алах минь! (Фатимагийн зүгээс ирэх үл үзэгдэх хий хүчинд гар нь сэлмээ үл даан сульдана. Гайхна) Чамайг тасдаж би чадна. (Сэлэм нь хүндрэн бие нь сульдана) Чи муу ёр мөн үү? Муу ёр үхээр байна.

Фатима:

-Амь тань миний гарт. Хатан таны мэнгийг би авсан.

Их хатан Дөргэнэ:

- Илааршуулахаар чи ирээд би нойрссон.

Фатима:

-Их хатан та түр үхсэн.

Их хатан Дөргэнэ:

-Их даарч сэрсэн.

Фатима:

- Хаан их хатантайгаа энгэр зөрүүлэх бүрдээ хордоно.

Их хатан Дөргэнэ:

- Хаан өргөөнөөс минь гараад хоногийн дараа өвдөж эхэлдэг. Эм хүн болохоор би үүнийг түрүүлж мэдэрсэн. Эмзэглэж би энгэрээ энэ шалтгаас хумьсан. Ай бүү үзэгд... Их Хаан хатан бид хоёрын өврийн нууцыг үзжээ. Үгүй юм байна чи үүнийг хийсэн. Илбэ жатга ёр чи байна.

Фатима:

- Тийм ээ. Тийм. Тийм л учраас таны атаат хүсэл амилаад бодсон бүхэн чинь бодлоор чинь хүссэн бүхэн чинь хүслээрээ болж байна.

Их хатан Дөргэнэ:

- Хан хар, гүжир хар, хар чи мөн байна. Их хатан намайг илбэ жатгаар эзэмджээ.

Фатима:

- Их хатан тайвшир. Би бас бүх юм биш шүү. Хар хүчний бие хар юмандаа л шингэн үүрлэдэг.

Их хатан Дөргэнэ:

- (сэлмээ газар алдана) Мөнх хөх тэнгэр минь аварч хайрла.

Фатима:

- Атаа улаан, хар өс хатны биенд буглаатай. Эртний мэргэдийн өс цусанд чинь ирсэн. Өндөр төрөлтөнгүүдийн өмнө тэд буруутан нь байсан байна. Эд мал булаах дуранд автсан эртний Мэргэдүүдэд тохирох шийтгэл оноожээ. Уг гарлын чинь эх мэргэдүүд эсээ хордуулж өс шингээжээ дээ. Мэргэдүүд хүчээ сэлбэн өндийх бүрт сөгтгөдөг, мөнхөд дарагдах заяатай аж. Тэр аймгийг сүүлчийн удаад мөхөөн дарахад Мэргэдийн эзэн эр чинь чавчуулж, чамайг хаан өөрийн ханхүүд өгчээ. Эрээ чавчуулсан чи их гомдол тээсэн байна. Их хааныг Сорхагтанг үнэлэн магтахад үе дамжсан өсөнд атаа үүрлэсэн. Хаан хиргүй тунгалаг хатан бэхээгийн ухааныг сайшаан үнэлэхэд бачуурч галзуурч та Сорхагтан хатанг далд ороосой гэж зүхэв. Зүхэхдээ Их хатан та Эзэн хаан эрээ үхэж үз гэж хараасан. Хааны биед хараал шингэсэн. Эр эм биеийн эс бодис холилдон найралдсан бол биендээ бүхнээ өгөлцөж авалцана. Цус эсээр гүйгээд тархах нь амархан. Их хаанд халдах их хэцүү байлаа. Их хатан та их тус хүргэлээ, надад. Хааны өмнөөс Хан Толуйг золиулж, Ханхүү Хүчүг ч зүхэж та үхүүлсэн. Их хар атааг эзэмдэх амархан.

Их хатан Дөргэнэ:

- Үгүй ээ үгүй.

Фатима:

-Хүсэл чинь биелэхээр хөх тэнгэрийн хүч гэж итгэжээ. Мөргө надад. Аль хэдийн хатан чи эзэмдүүлсэн. Эд баялаг бол миний хүчийг гааруулдаг. Шунал намайг тэжээдэг. Өнөөдөр Их хатан та Их хаан эрээ үхээсэй гэж өргөөндөө морилж ирээд их хүчтэй бодсон.

Их хатан Дөргэнэ:

-Үгүй. Худлаа.

Фатима:

- Таны таалал тэр. Ертөнцийн орой дээр байх амаргүй дээ. Хүчтэй байх хэрэгтэй. Хан Толуйн хатан Сорхагтан бэхэ бөө сэцэн мэт ариун үнэн ойртоход нүд сохлом хурц гэрэлтэй дотор бие хөг аялгуугаар бүтэх, хамаг хүчийг сарниагаад хүрэхэд амаргүй. Их хааны дотоод гэрэл хүчтэй хүчтэй энэ хөрстийн ус шорооноос бүтсэн тэр биеийг сүйтгүүлэхгүй зовоох юм. Мөн ч хэцүү. Одоо надад ганцхан боломж хордуулсан архи л тусална.

Их хатан Дөргэнэ:

-Зайлаад өгөөч. Тонил хар муу ёр...

Фатима:

-Их хатан ухаар. Хамтдаа бид тонилох болно шүү дээ. Би чинь та, та чинь би. Их хатан бол та бас би.

Их хатан Дөргэнэ:

-Мөнх хөх тэнгэр минь.Аварч хайрла.

Фатима:

-Их хатан таныг харж чадахаа больсон. Харлаад халхлагдсан.

Их хатан Дөргэнэ:

- Үхье би. (Сэлмээ авах гэнэ)

Фатима:

-Сүнс чинь тэнэнэ. (Хатан сэлмээ авахаа болино) Тайвшир тайвшир. Бидний өмнө дэлхий ертөнц байна. Их хатан энэ ертөнцийг эзэгнэн жаргах боломж байна. Ийм боломж ахиж танд ирэхгүй. Хаана ч тэр (Их хатан цөхөрнө. Сэлмийг нь авна.Эргүүлж байранд нь тавина) Их хаан яагаад, их хатан таныг өргөөндөө морилсны дараа хатуу гурван хүрээ чангатган засаглаж өргөөгөө юунд өндөр хорионд хориглов.

Их хатан Дөргэнэ:

-Мэдэхгүй.

Фатима:

-Мэдэхгүй гэнэ ээ. Муу байна. Аврах гэхээр амаа үдэх юм.

Их хатан Дөргэнэ:

-Зайран их хааны зүүд тайлахаар ирсэн. Би өөрийг мэдэхгүй.

Фатима:

- За сайн байна. Би мэднэ. Миний зардас Сартуулын их хатан эх үхсэн. Тэр хөгшин хатан үхэх ёстой. Үхэлгүй бие хамгийн хатанд ч ирэх учиртай. Эрх мэдлийн тэр хатны эзэн нь би байна. Хар Салхины үзүүр ёзоор би байна. Алт мөнгө эрх хүчийг би түүнд хангалттай өгсөн. Харин чи одоо Ав даа. Хүсэл чинь биеллээ.

Их хатан Дөргэнэ:

- Хар хатан.. Тэр хатавчний хар хатны ясыг хаан шатаасан. Тэнг..ээ.. минь!

Фатима:

- Тэргүүн хааны зөн байлаа. Эрх мэдэлд үл цадах хүслэнгийн гадас улаан нүдний ичгүүрийг илчлэх учиртай хатавчны хар хатан. Ха хаа хаа...

Их хатан Дөргэнэ:

- Хар муу зүгийн хүч, хар салхийг би дуудсан гэж үү?

Фатима:

- Намайг тэгж нэрлэх хэрэг байна уу? Та хар би хар.

Их хатан Дөргэнэ:

-Үгүй би хүсэхгүй байна. Чамайг.

Фатима:

- Ханхүү Гүюгээ хаан болгох орь ганц хүсэл чинь тэнгэрт тулсан мөсөн царил намайг бүр зовоож байна. Биелэх болно. (царай нь эвгүй муу болно)

Их хатан Дөргэнэ:

-Надад тусал. Фатима. Намайг орхи. Би хүссэн бүхнийг чинь өгнө. Орд харш, алт эрдэнэс

бүхнийг өгнө.

Фатима:

- Надад тэр чинь хэрэггүй. Шуналаар нь би хооллодог. Эрх мэдэл чинь надад хэрэгтэй. Тэнгэр газрын завсрын тэнэмэл сүнс болох уу? Эсвэл хүчит харанхуйн хатан болох уу? Хар хатны үхлийн сүүлчийн хүч надад их хэрэгтэй байлаа. Үзэн ядах хашгираан нь хааны сэнтийд заагдсан хан хүүг бүрэлгэхэд хангалттай байлаа. Одоо зайлуул өрөвтөр өлсгөлөн сүнс болсон. Орох газаргүй зовлонт. Хөгшин хар хатан минь харанхуйн хар галав руу үйлээрээ од доо. Одоо надад ядуу хүчгүй сүнс чинь хэрэггүй. Яв. (Хий ярина) Явчихлаа. (Хий яриснаа Дөргэнэ хатан руу харна)

Их хатан Дөргэнэ:

- Би юу ч хүсэхгүй. Хатан суудал, хаан сэнтий алийг нь ч би хүсэхгүй байна.

Фатима:

- Хүсэл чинь аль хэдийн одсон.

Их хатан Дөргэнэ:

-Бүх бодол санаснаар хэтэрхий биелээд цочоож сандаргах, их хатан надад мөнх тэнгэр хүчээ өгч байна гэтэл би өөрөө тэнгэрийг хатгах царил болжээ. Тэнгэрт цав суулгажээ. Ээ хар толгой.

Фатима:

- Үхвэл тарчилал цаана чинь байна. (Их хатанг өндийлгөн босгоно) Өмнө чинь тансаг жаргалт амьдрал байна. Одоо энэ дэлхий ертөнцийг хувирган эдэлж байгаа аз жаргалаараа өөрчилж харанхуйн төлөө амьдран миний адил энэ ертөнцөд төрөх азыг харин би чамд өгч чадна. Хөгшин хатан намайг дорд үзснийхээ хувийг эдэллээ. Харин чи намайг хэзээ ч дорд үзэхгүй гэдгийг би мэдрэнэ. Их хүч чадалд чи итгэн дурлаж байна. Сайхан байгаа биз дээ . Одоо энэ бүхэн.. Харанхуйн хатан бол.Тансаг жаргалдаа умба. Чамд би хүчээ өгнө. (хатнаас илүү ихэмсэг байна) Цэнгэ. Жарга. Их хатан минь. Ирнэ ирнэ. Хүсэл бүхэн чинь өөрөө ирнэ. Харж байна би. Хатан чиний ихэмсэг царай чинь эргээд ирлээ. Эзэнт Гүрний Их хатан бол та.

(Фатима Их хатанг өргөөний хатан суудалд хүргэнэ. Их хатан Дөргэнэ хатан суудалдаа сууна.Фатима сэнтийн дэргэд зогсож нүдээ нуун зогсоно.)(Бүрэнхийлэл)

(Тайзны наана Их хаан Өгэдэй хар үнэгэн дах нөмөрсөн байх ба Абдулхман мэхийн ёслоод явна. Хаан ганцаар үлдэнэ. Тайзны гэрэл зөвхөн хаан дээр тусна)

Их хаан Өгэдэй:

- Их хаан би алтан ургийнхныгаа аян дайны алс холоос эх нутагтаа эргүүлэн дуудах нь зөв үү?

Мөнх Хөх Тэнгэрийн хүчний дор Дэлхийг хураан засаглах зарлигийн их үйлсийн замд эвгүй гай тотгор тохиов. Алтан ургийнхан бүгд хуран цуглаж, ерэн есөн тэнгэрийн тахилга тайлгаар илбийн хар харанхуй ертөнцийн ёр ёзоорыг бүр мөсөн таслах хэрэгтэй байна. Гэтэл Дайныг түр зогсоох зөв үү? Эзэнт Гүрний баруун зүүн гарын их замын их цэргүүд уртын уртыг туулан харьж ирнэ. Умардыг бүрнээ дагуулахад тун ойрхон байна. Өмнийг үтэр түргэн эрхшээхэд хүч арай багадав. Умардыг номхотгоод ирэх Батын зүүн гарын их цэргийг аваад Их Монголын Эзэнт Гүрний бүх цэргийг цэрэглэн Их хаан би өөрөө Өмнөдийг их хүчээр үтэр түргэн бүрнээ хураана. Дэлхийд нэгэн гүрэн засаглах тунхаглах цагийг үзэх холгүй. Тийм ээ.. тэгэхээр дайныг түр зогсоон эх нутаг руу нь эргэн дуудах зөв үү? Их төрийг улаан эврээр сэжих муу ёр хаан биеийг минь эртнээс нааш оролдов. Хан дүү Толуй минь хагасыг нь авч үхэв. Ай хайран дүү Толуй минь. Алтан ураг руу ассан аймшигт гайг одоо яахав? (Өгэдэй хаан зовнино) (Тайзны гүнд Их хатан Дөргэнэ, Фатима нар дээр тусах бүдэг гэрэл тодорно. Фатима алгаа ташна. Арабын Ханхүү Алмат Исман хүрч ирнэ)

(Бүрэнхийлэл) (Их хаан дээр гэрэл тодорно.)

Их хаан Өгэдэй:

- Их төрд нүүрлэсэн хараалын хар гай түйтгэрийг бүр мөсөн далд оруулах хэрэгтэй. Хачин юм. Талын гуу жалганаас Сартуулын тас хар хатны ясыг олсон. Гарцаагүй мөн гайг түйтгэрийг шатаан үнсэлсэн. Мал адгуус айл хотлыг тэр газраас нүүлгэж, газарт шингэсэн хор бузарыг арилгахаар их түймэр тавьсан. Алтан ургийнхны аминд нь халдах энэ аюумшиг бол яах аргагүй хав харанхуйн хар хүч ,энэ хар аймшиг хаа тэнүүчилнэ вэ? Эрх хонгор Хүчү ханхүү минь бөө бэгийн хүч нэн их заяагдмал. Заяагдмал билгүүн цомирлогоо дөнгөж дэлгээд ирэхийн үед ишийн тас татав. Эртнээс мэдрээд явсаан би... Нэг л хачин хорлол, Их хатны биенд хүрэхээр хүйдэс мэдрэгдэх болсон.. Хаан хөвүүдээ хатан бидэн хайраар бүтээсэн. Хан хөвүүдийнхээ эх чамаас би цэрвэн сэжиглэх гэх үү? Хан хөвүүдийн эх халамжит хатнаа элдэвлэх хэрэг үү? Төрийн их хатныг чичих хэрэг үү? Их хаан бүү хэл иргүн эр, эр чоно,эр буга, эр төрөлт амьтан ч ингэхгүй. Их хатнаасаа огих болов. Ёр өөр юу гэж нэрлэх юм бэ? Ёр гэгч юуг үзэх минь энэ болов. (шаналалд автана)

(Бүрэнхийлэл)

(Тайзны гүнд гэрэл тодорно Их хатан Арабын ханхүү Алмат Исмантай самуурна. Фатима хатны торгон хөшгийг хааж засаад Фатима тайзны гүнээс наашлан ирнэ) (Бүрэнхийлэл) (Их хаан дээр гэрэл тодорно)

Их хаан Өгэдэй:

-Яс минь гэнэт сийгээд хүйтэн оргих чинь. Юу вэ чи! (Сэлмээ гартаа барьж дошгирно) Өрөөсөн нүдэнд нь цагаа унасан, өөдгүй дүрт унжсан уруулт чи хэн бэ? Доошоо тонгойгоод нүүрээ нуучихлаа. Өөдөөс хар чи. Хар муу ёр чи. Царайгаа үзүүлэхгүй гэнэ ээ...Чи чинь. Юу билээ. Аан! Зарц шивэгчин. Их хатны өргөөний үүдийг өргөж өгөхдөө үргэлж нүүрээ нуудаг шивэгчин байна. Олчихлоо. (Цочно) Юу вэ чи. Нэг дэлэнтэй эм дүрт албины өрөөсөн хөхнөөс нь хар хор садарч байна. Зайл! (Сэлмээрээ агаар сийчнэ)

(Фатима чичирнэ. Биеэ улмаа хөвчлөн гараа чанга атгана)

Алга болчихлоо. Абдулхман сүлбээтэй. Харж байна. Тийм байна. Сорхагтан бөө сэцэн минь чиний зөв.. Чөмөг минь маш их сийгж байна. Сэжиглэж байна би энэ биенээсээ. (сэлмээрээ өөрийгөө цавчих гэснээ сэлмээ хаяна) Бохир өмхий самхай цэвдэг хар булай нэвчиж гүйцлээ. Тэсэхгүй нь... Алтан ургийн яс эсийг мэргэж байна. Мөнх хөх тэнгэр минь! Энэ биенээс минь алтан гэрэлт аялгуут сүнсийг минь сугалан ав! Оломлогч хөх мөнх тэнгэр минь оосорло намайг! Алтан дээд аялгуу минь ир! Оломлож оосорлон авар! Ирчихлээ. (Хөгжим. Тэнгэрлэг гайхалтай аялгуу сонстоно) Алтан аялгуу минь тантайгаа нэгдэх минь. Аврагдлаа. Мөнх хөх тэнгэр минь өгүүлшгүй ариун гэгээ. Гайхамшиг минь. Амарлаа. Мөнхийн амгалан минь. Ангижирчихлаа. Би. Мөн ч сайхан. Тэнгэрт хүрэв.(Хааны бие нуран унах агшинд харанхуйлна) (Фатима их хатан руу эргэн харна. Их хатан Дөргэнэ түгшүүртэй алга ташна. Нэг жанжин ирнэ. Хатан түүнд нэгийг шивнэнэ. Удалгүй цэргүүдээр хамгаалагдсан Алтан Дээд гэриэг хатанд авчран өргөөд цэргүүд явна. Тайзны гэрэл тодорно. Алтан Дээд гэриэг Их хатан барин өндийхөд Фатима хатан руу очно) (Хааны бие алга болсон байна. Гэрэл тодорно)

Их хатан Дөргэнэ:

-(Аймсангуй судрыг дээш өргөнө) Алтан Дээд Гэриэ алтан аялгуу энэ.

Фатима:

- (хүйтнээр дөхнө. Зөөлөн ялдмаар) Дууд даа.

Их хатан Дөргэнэ:

- (судрыг сөхнө) Улсын үндэс нь зон ард,иш нь айл ард, цомирлог нь гэгээрэл мөн .Тэнгэрт мөнхөд тэмүүлэн соёолох босоо энэ жаяг болбоос их засаг мөн. (Фатима чихээ дарна) Тархи өвдлөө.

Фатима:

-(заана) Алив энэ хар хүлээтийг үз.

Их хатан Дөргэнэ:

- (эмээнгүй)Хар их ертөнц юун бэ гэвээс ..(Фатима руу харна.)

Фатима:

- (олз олох мэт баясна.Их хатнаас булаах шахам авна.)Үл үзэгдэх алуур билээ. Үл мэдэгдэх устгал билээ. Устгах тэнгэрт арван зургаан арга буй. Үхүүлж устгах дөрвөн алуур буй доройтуулж устгах долоон алуур буй, тамлаж устгах таван алуур буй. Хар ертөнцийн харын хар хорын хор алуураас айтугай. (инээнэ) Нэгэн зүйл үхүүлэх алуур. Өсөлсөнг өс сануулахгүйгээр үхүүлэх алуур. Ухаангүй балай сархадад шунуулан үүрд өс санахгүйгээр баярласаар үхэх, увьдастай адтай нэгэн устгах хар ертөнцийн алуур (бүр доогтой болж ирнэ.) Тиймээ.Мэднэ. (Фатима их хатанд өгнө.) Дууд дууд сонсьё.

Их хатан Дөргэнэ:

-(Чичирсэн хоолойгоор)Бөлөглөн бэхэжсэн олныг бөөс мэт үхүүлье гэвээс бурууг нь магт тэгш эрх олго! Бүгд тэгш эрх олбол Зүгээ олохгүй зүсгүй алуурыг жаргал бодсоор зовж үхэх хар ертөнцийн алуур Айтугай! Амин зоргоор болгож аяыг дагуулж үхүүлье гэвээс хар шуналаар тэжээж харсан бүхний нь өг. Хагартлаа баярласаар үхлээ сэтгэхгүй халих хар алуур. Догшин хүчирхэг олныг доголлон аалз шиг болгож дотрыг нь баярлуулсаар үхүүлье гэвээс хийж чаддаг бүхнийг нь бэлдээд өг. Өөхөнд хордох өрөвдөлтэй алуур тэр. Айтугай.(Дуу нь алгуур чангарна.) Тэрслэн тэмцэлдэх хүчит өстөнг тэлж сунгаж устгая гэвээс тархийг нь олгой гүзээ мэт болго.Төрд өс санахгүй үхэх төвөггүй хар ертөнцийн нэгэн арга. Өсөлсөн дайсанг өршөөж болохгүй аваас өөрийг нь өөрөөр нь доройтуул. Өр зээлэнд татан оруул өөрөө амиа хорлоно. Өстнөө танихгүй үхэх хар алуур.

Фатима:

-(бахтайгаар)Харанхуйн хатан минь зөв.

Их хатан Дөргэнэ:

-Захирагдан засахад мохошгүй дайсныг зовоож доройтуулан устгая гэвээс заншил бусыг шүтүүл, заяа нь төөрөгнөөсөө сэрэхүй нь төөрч алсын мөрөө харлуулан аяндаа доройтсоор үхэх хар ертөнцийн нэгэн арга. Айтугай. (эрэмшсэн байна.)

Фатима:

- Дэлхий ертөнцийг хувиргах арга чинь энэ боллоо. Харанхуйн хүчний хатан минь.

Их хатан Дөргэнэ:

-(Судрын өмнөх алтан олсот бичээс рүү орно.) Гэгээрсэн улс үндэстэн болбоос хүсэл зорилго бүхий ард түмний иргүншил.

Фатима:

- (зэвүүрхэн догширч) Болно.Энэ ертөнц харахуйн эрхшээлт харанхуйн улс болно.(Хөгжим. Ёрын элдэв чимээ.)

(Харанхуйлал)

Наймдугаар үзэгдэл.

8. Төрийн хайрцаг онгойн алтан дээд гэриэ алдагдсаныг мэдэв.

Тайз: Бөө сэцэн Сорхагтан бэхэ хатны өргөө. Сорхагтан бэхэ хатны өргөөнд Өгэдэй хааны отгон дүү охин Алалтун бэхэ хатан, Жалайрын ноён Мэнгэсэр орж ирнэ. Алалтун бэхэ, Мэнгэсэр ноён хоёр ард хувцас өмсчээ.

Сорхагтан бэхэ хатан:

- Алалтун бэхэ хатан дүү минь. (Алалтун бэхэ хатан, Сорхагтан хатан хоёр тэврэлдэн уулзана)

Алалтун бэхэ хатан:

-Сорхагтан Бэхэ бөө сэцэн авга эгч минь. Амар мэнд сайн сууж байна уу? Та минь!

Сорхагтан бэхэ хатан:

-Мэндээ мэнд! Алалтун бэхэ хатан минь. Мэнгэсэр ноён та нар чинь зүсээ бууруулаад ирэх чинь.

Алалтун бэхэ хатан:

-Аварч хайрла. Хатан эгч минь. (Уйлна) Зовлон нөмөрлөө. Их Хаан Өгэдэй ах минь..

Сорхагтан бэхэ хатан:

- Мэдсээн. Мэдсэн. Алтан биеийн олон иргүн алтан өргөө рүү залсныг нь дуулсан.

Алалтун бэхэ хатан:

- Хатан эгч минь. Их хаан Өгэдэй ах минь миний эзэмшин захирах нутаг Уйгарын орноо морилон ирээд буцах замдаа Өтөг Хулан ууланд ав хоморго хийн хээрийн ордонд буудаллаад ан ав үйлдэн яваад ав хомрогын салхинд төгсөв. Гэтэл Их хатан Дөргэнэ авга эгч маань өнчин дүү намайг ах хааны үхэлд сэжиглэн нэрлэж буруутгахаар завдана. Аюумшигтай. (уйлна)

Сорхагтан бэхэ хатан:

-Ээ, Мөнх хөх тэнгэр минь. Юутай аюул вэ? Эзэн Чингис Богд хааны минь отгон охин үрийг ийн айлгаж цочоох гэж.

Мэнгэсэр ноён:

-Их хатан, охин дүү нь Их хаан ахаа хөнөөсөн гэж нэрлэсэн нь үнэн.

Сорхагтан бэхэ хатан:

- Их хатан уу? Хатны ухаанд багтахгүй ёрын бодол байна. Хачин юмаа. Үгүй байлтай.

Мэнгэсэр ноён:

-Мэдэхгүй. Бөө сэцэн бэхэ хатан минь, хаан төрийг аюул хучин хаа сайгүй түгжиж байна.

Сорхагтан бэхэ хатан:

- Мэнгэсэр ноён минь. Та бүхэн тэгээд цөллөгийн ясу зарлиг зөрчин зүрхэлж нааш ирэхээр аюул та нарыг гарцаагүй авна шүү дээ. Амь нас хохирно.

Мэнгэсэр ноён:

- Нууцаар Жиндэнд бид жин тээх мэт арайхийн тань руу нуугдан ирлээ.

Алалтун бэхэ хатан:

-Их хаан ах минь нутагт минь морилон ирээд тийм ч амгалантай байсангүй. Хаан ах гүн бодолд автаад аюул ирвээс Алалтун дүү минь Сорхагтан бэхэ бэр эгчдээ миний өмнөөс заавал мэдэгдээрэй гэж захисан. Хаан намайг гомдоосон ч гэлээ Хан дүүгийн хатан өндөр төрийг өмгөөлөн босох учиртай. Эрээ золиосонд одсонд ихэд хилэгнэсэндээ тэр болов уу? гэж гуниглан хэлсэн билээ.

Сорхагтан бэхэ хатан:

- Их хаан Мөнх Тэнгэр өөд явчихсан. Би зүүдээр харсан. Өндөр тэнгэрээс гайхамшигт аялгуу эгшиглээд багана мэт босоо гэрэл буун ирж алтан аялгуут гэрэлт сүнсийг нь биеэс нь аваад явахыг үзсэн. Салбарах биеийг нь харин үхээрийн ёр барьж хоцорсон. Ав хоморго бүрээ гунин урамдахад адгийн үхээр зайлан гэнэт алга болсон. Алтан биеийг нь орхисон тэр муу ёр.

Алалтун бэхэ хатан:

- Муу ёр гэнэ ээ.

Мэнгэсэр ноён:

- Их хааныг алтан биеийг ужиг өвчин оролдсон. Энэ шалтаг биш үү?

Сорхагтан бэхэ хатан:

- Хар хүчний хаалга онгойсон.

Алалтун бэхэ хатан:

-Мөнх хөх тэнгэр минь.

Мэнгэсэр ноён:

-Ээ. Бүү үзэгд!

Сорхагтан бэхэ хатан:

-Айж бүү чичирцгээ. Айдас олз болно.

Мэнгэсэр ноён:

- Жа, Бөө сэцэн хатан минь.. Тэгэхээр харахуйгаас хар ороолон амилжээ.

Сорхагтан бэхэ хатан:

-Ахиад бүү дурс.

Алалтун бэхэ хатан:

- Аварч өмгөөл, хатан эгч минь.

Мэнгэсэр ноён:

-Нэргүй тэр их төрд минь эврээ сэжжээ. Тийм байх нь. Халаг Их төрийн тэргүүн сайд Илюй Цуй Цай Мэргүн намайг тань руу илгээлээ. Үггүй муу үгээр хэлэхийн эцэсгүй тэр өвгөн мэргүнийг цөхрөөжээ.

Сорхагтан бэхэ хатан:

-Үнэнч Мэргүнд юу учрав.

Мэнгэсэр ноён:

-Сэтгэл сэрдхийм явдал болсон. Их хааны нэгэн бөгжийг хайн Илюй Цуй Цай өвгөн Мэргүнийг айлгасан. Орд өргөөг нь онгичин онгичиж нэгжсэн.

Сорхагтан бэхэ хатан:

- Үнэнд шалгарсан өвгөн Мэргүнийг хулгайд сэрдэх ээ? Олхиогүй явдал. Их хатан атал дорд эмийн зан гаргах гэж. Эвий хүндэт Мэргүн өвгөн минь. Их хатан Дөргэнэ.. жигтэй юм.

Мэнгэсэр ноён:

-Тийм ээ. Их хатан. Танигдахааргүй догшин болсон. Догшрол хилэн, тансаглал жаргал хоёр нэгэн биенд зэргэцэх болсон. Их хааны минь хаан ор залгах хөвүүнээр нэрлэгдэж асан Хан хүү Хүчүгийн нялх балчир хүү Ширэмүнийг хаан ширээ залгана гэж дэргэдээ авсан. Нас бага байна гээд Их төрийн хэргийг өөртөө хамааран Эзэнт Гүрний төрийн туг тамгыг мэдэх

болов.

Сорхагтан бэхэ хатан:

-Их хаан нэгэнт нэрлэсэн гэрээсийн дор бүгд нийтээр бөхийнө.

Мэнгэсэр ноён:

-Их төрийн тэргүүн сайд Илюй Цуй Цай мэргүн аманд үг нуув. Их Хатны дэргэд ирсэн нялх Ширэмүн айж үргэлж цочно..Хаан Чингис нохойноос цочдог шиг нялх хан хөвүүн нэг юмнаас цочиж нүдээ аниад ер нээхгүй бага сэнтийд үргэлж чичирч сууна.. гэж хэлүүлэв.

Сорхагтан бэхэ хатан:

-Нялх бага эхээсээ холдоод тэр гэхээр нэг өөр, Их хатан Дөргэнээс ширүүн догшинд айгаадаа тэр үү?

Мэнгэсэр ноён:

-Тийм нь ч тийм. Гэхдээ гартаа тэвнэ олж бариад суусныг нь нэг шивэгчин их хатанд мэдүүлсэн байна.Тэвнээр зэвсэглэсэн нялх Ширэмүн тэр шивэгчин рүү тэвнэ чиглүүлээд өрөөсөн нүдийг чинь хатгана гэж босож зогссон байна. Их хатан өөрөө нялх ханхүүгийн гараас тэвнийг нь уйлуулан авсныг өвгөн Мэргүн мэдсэн ч хөвүүнд ойртож асууж чадахгүй байна гэж хэлүүлээ.

Сорхагтан бэхэ хатан:

- Билгүүн гүн зоригтой хан хөвүүн байна. Би нэг нүд нь сөлөр эмийг таамаглан хараад байсан юм аа.

Мэнгэсэр ноён:

- Их хатныг сүүдэр шиг дагах харь гаралт шивэгчин нүүрээ сөхдөггүй ч нэг нүд нь цагаа унасныг мэргүн мэдсэн гэв.

Алалтун бэхэ хатан:

- Нэг улаан эвэртэй үнээ, нэг нүд..

Сорхагтан бэхэ цэцэн:

-Нүгэлт эмийн биенд хүүдгэнэжээ.

Мэнгэсэр ноён:

-Хачин юмаа. Мэргүн сайд надад иймхэн юм хэлэх нь юу юм бол гэж их гайхаж явлаа. Төр үймүүлэх чинээгүй шивэгчинг аргаа барахдаа сэрдэв үү? Эсвэл мэгдэн сандрахдаа өтөл

насны илий тусав уу гэх бодол болон явлаа.

Сорхагтан бэхэ хатан:

- (Нүдээ аниснаа нээнэ) Мөн байна. Яг мөн байна.

Мэнгэсэр ноён:

-Үтэр түргэн өчүүхэн дорд шивэгчинг цавчиж алья.

Сорхагтан бэхэ хатан:

-Үгүй ээ үхэхгүй.

Мэнгэсэр ноён:

-Юуны учир тэр билээ.

Сорхагтан бэхэ хатан:

-Энэ ертөнц чинь нилдээ нүгэлт сэтгэлээр дүүрэн. Хөх нуруутын нутагт хөндлөнгийн улс цугласан. Нэгний биеийг алж устгалаа гэхэд нөгөөд биед нь буглана. Бид хайж барьж олоход хэцүү болно.

Мэнгэсэр ноён:

-Алахгүй гэхээр амьд явуулна гэсэн үг үү?

Сорхагтан бэхэ хатан:

- Ямар ч л гэсэн бугласан биеийг нь олов.

Алалтун бэхэ хатан:

- Сэцэн бөө бэхэ минь. Учрыг хэлээч.

Сорхагтан бэхэ хатан:

-Их том юмны хаалга бол тэр эм. Аргыг нь олох хэрэгтэй. Ай үгээр хэлж барашгүй аюул ирсэн. Алтан ургийнхан бүгдээр хүчээ нэгтгэн зөвхөн хөх нуруут иргүнүүдтэйгээ тэр муугийн муу харын харыг дарах ганц арга бий.

Алалтун бэхэ хатан:

-Ухаарлаа.

Мэнгэсэр ноён:

-Мэдлээ.

Сорхагтан бэхэ хатан:

-Их хатан их аян дайныг цаашид юу гэж үзэв.

Мэнгэсэр ноён:

-Их хатан энэ талаар үг үл дуугарна. Их замын баруун зүүн гарын их цэрэг рүү Их хаан таалал төгссөнийг дуулгах илчүүдийг илгээсэн. Ханхүү Гүюг, Хадаан, Хүдэн тэргүүтэй хан хөвүүд эх нутагтаа ир гэж дуудснаар тэд харьж ирцгээсэн. Харин Их хатан Хар Хорин хотод ноёд түшмэдүүдийг урин ирүүлээд өгөөмрөөс өгөөмөр хандан хэд хэдэн удаа их өглөг хишиг түгээв.

Сорхагтан бэхэ хатан:

-Сайн байна, сан хөмрөгийн нүсрийг дундлах маш сайн. Нүүдлийн засаглахыг баримтлах нь мөн сайн хэрэг. Түшмэд ноёд гэхээс нүцгэн дорой буурайд нь өгөх нь чухал.

Мэнгэсэр ноён:

-Сэцэн бэхэ хатан минь гэхдээ Их хатан Дөргэнэ өгөөмөр тэр өглөг хишгийг өгөхдөө өрсөлдүүлж өгнө. Нэг хэргэмийн ноёдын нэгэнд нь бага нөгөөд нь илүү ихийг өгнө. Ноёд түшмэдүүд хатны гайхал санааг ойлгож эс ядаад хий гайхалдан олонх нь жигшиж ганц нэг нь баярлалдах болов.

Сорхагтан бэхэ хатан:

-Юу гэнэ ээ. Өрсөлдүүлж өгнө гэнэ ээ. Ээ бүү үзэгд. Мөнх хөх тэнгэр минь! (машид цочирдон дуугүй болно)

Алалтун бэхэ хатан:

- Сорхагтан бэхэ эгч минь юу болов?

Сорхагтан бэхэ хатан:

- Их хатны бие олзлогджээ.

Мэнгэсэр ноён:

-Сорхагтан бэхэ хатан минь юу гэв ээ та минь!

Сорхагтан бэхэ хатан:

- Ээ ёр. (Амаа гараараа дарна) Их хатан яах нь энэ вэ? Халаг халаг.. (Хоёр тийшээ биеэрээ ганхан халаглана) Цөвүүн цаг цөмрөөд бүр ороод иржээ. Ай халаг халаг. .. (Хоёр тийшээ

биеэрээ ганхан халаглана) Алтан дээд аялгуу минь аварч хайрла. (Уйлна) Эзэн их Гүрний Их хатныг эрхшээлдээ атган авчээ. Хаан төрийн хайрцгийг онгойлгон Алтан Дээд Гэриэ алдагджээ. Муугийн муу харын хар тэр Их хатны сүнсийг атгаад өөртөө авчээ. Их хатан хаан төрөөс урважээ. Ээ халаг халаг. Их хатан Дөргэнэ та юу хийх нь энэ вэ? Нууцын нууц задлав. Задлаад барахгүй хүн төрөлхтөнг ний гэмээр хөнөөн сүйтгэх алуурыг Их төрийн их хатан бодлогоо болгож барьжээ. Их төрийн аюулын үүдээр их хатан гарч ирлээ. Ай аюумшигт аюул. Тэнгэрийн шийтгэл ирнэ шүү дээ. Ээ хөөрхий их хатан та Мөнх хөх тэнгэрээ юунд орхио вэ? Тэнгэртэй тэрсэлдэж болно гэж үү? Итгэж чадахгүй нь би. Ямар их эмгэнэл вэ? Ертөнцийг түйвээх алуурын мэхийг хэрэгжүүлж эхэлжээ. Ертөнцийг түйвээх цөвүүн цагийг залав.

Алалтун бэхэ хатан:

-Мөнх тэнгэр минь!

Мэнгэсэр ноён:

-(зүрхээ дарна) Элээ халаг. Сорхагтан хатан минь тэгээд ертөнцөд юу юу болох вэ?

Сорхагтан бэхэ хатан:

-Мөн ч олон юм болно. Цөвүүн цагийн хар зөнг билгээр хэлэх минь. Тамлах таван ний гэм, Доройтуулах долоон ний гэм, Үхүүлэх дөрвөн алуур цөвүүн цагийн хорлол. Айл эрдэнийг тарааж, Хаан эрдэнийг харааж, Таван тусгаар тогтнол эрдэнийг харьд идүүлж, Үүслийн гурван эрдэнийг үнс, үлхэг болгож, Оршихуйн таван хүрдэнг удамшил зөв хүчнээс заагламу. Нарнаас нуугддаг болгож амин хүрдэнг хөлдөөмү. Сарнаас дайждаг болгож үржихүйн хүрдэнг хөөсрүүлмү, Сүүн идээг ховордуулж өсөхүйн хүрдэнг хангир болгому. Мэдвэл зохихуйг сүйтгэж гавлын хүрдэнг сэрэлгүй болгому. Их засгийг нь хориглож сүнсний хүрдэнг төөрүүлмү. Удамшил зөв амин хүчнийг хомсдуулж уул усыг шимгүй болгож үхүүлмү. Гэрийн онолыг гээлгэж, гай гэмийг тулгана. Нууцаа задлан ам нь урагдтлаа чалчиж би чадна гэж амлаж хөггүй болму. Утаа замхрах мэт, ултай шүлс хатах мэт артай болно. Хэм шимгүй юманд хүзүүний махаа барж хэрэлдэн хөггүй болму. Ганцаардлыг хүсч тамаа мэдэх сэхээгүй хөгийн болму. Ангижралыг хүсэвч аяганаас халих биегүй болму. Хэрэгтэйгээ мэдүүлэх гэж хорлож хэрээ мэдүүлэх гэж ялламу. Хамгийн муу халуун шулуун нялуун дайн ирмү. Хамаг үнэтэйгээ боольхойд алдаад харлатал ангижирму. Хамгийн сүүлд хар боольхой хаан болж ерэн өвийг сүйтгэж үхүүлмү.

Мэнгэсэр ноён:

-Ерэн есөн тэнгэр минь! Зөнч Бэхэ минь.. (уйлах гэнэ)

Алалтун бэхэ хатан:

- Эцэг тэнгэр минь! Хаан аав минь!

Сорхагтан бэхэ хатан:

-Чингис хааны отгон охин үр Алалтун бэхэ минь чиглээд ирсэн аюулаас бүү айгаарай. Дээд тэнгэрийн үр алтан ургийн амь халуун минь. Айдас бол муугийн мууг, харын харыг барих нэг барьц шүү. Уйлж хэрхэвч болохгүй. Зориг бол тэмүүлэх их хүч. Нэн тунгалаг дүү минь, нэг ч дусал нулимс ахиж бүү гарга. Өрөвдөм дорой сэтгэл өрөөл бусдын идэш болгоно. Гуниг ч дэмий, гутрал гэдэг чинь бараан тэрний барьц шүү дүү минь. Их хааны алтан үр их хүчийг бүтээх чин үнэн. Юунаас ч бүү ай. Эм хэдий ч дүү минь эс чинь ангид шүү. Эрэлхэг зориг эрлэгийг ч ичээн айлгана. Мөнх тэнгэртээ залбирч.. мөч бүрд дууд. Алтан аялгуу чамайг минь аварна. Хатан авга эгч бэхэ нь үнэрлэе. Мэнгэсэр ноён хоёр тийшээ салж яваарай. Бага хатан Мүкэ, Жөн Мөн Тоба хоёр та нарыг минь үдэж өгнө. (Мэнгэсэр ноён, Алалтун бэхэ хатан нар өргөөг орхин явна)

(Бүрэнхийлэл)

Тайз эргэж Тайзны гүн өндөрлөгт сэлэм барьсан цэрэг эрс зогсоно. Тэднийг толгойлох цэрэг хуйлсан зарлигийг дэлгэн урагш нэг алхана. (Гэрэл тэнд тодорно)

Зарлиг дуудагч:

- (Өндөр дуугаар) Эзэнт Гүрний төр засагч Их Хатан Дөргэний зарлиг. Сонстугай. Их Далай хаан эзэн Уйгарын орноо засгийг засан тохинуулахаар морилон одоод эргэн ирэх замдаа хорлогдов. Эзэн хааны алтан биенд ичгүүргүйгээр халдан Их төрд тэрсэлсэн Уйгарын орныг засаглагч Алалтун бэхэ хатныг олны өмнө гэсгээн цээрлүүлж цаазаар авсугай. Алалтун бэхэ хатны хань хамсаатан уйгарын тэрсүүд түшмэдүүд зарц бараа бологсдыг цээрлүүлэн үхүүлтүгэй! (Өгэдэй хааны отгон охин дүү Алалтуны бэхэ хатны сайн хувцастай байх ба тэрээр бүхнийг эмээлгэх ихэмсэг төгөлдөр хатуу зоригтойгоор алхан цаазын дор очно)

Алалтун бэхэ хатан:

- Үнэнч албат иргүн нар минь. Бүү айтугай. Би та нарыг тэнгэрт хөтлөн авч гарна. (Алалтун бэхэ хатан өндөр бортогон малгайгаа тайлан авч цааз гүйцэтгэгч рүү харна) Одоо болно. (Бортогон малгайгаа цааз гүйцэтгэгчийн дэргэдэх цэрэгт өгөхөд тэрээр хатны бортогон малгайг сөгдөн авч эмээн айв. Алалтун бэхэ сөгдөн суув. Ихэмсгээр дээш харна. Итгэл бат дуугаар аяархан)Мөнх тэнгэр минь охин чинь байна!

Зарлиг дуудагч:

- (Хоолойн чичрэн) Цаазлахтүн! (Сэлэм барьсан эр мэгдэн хөдөлж чадахгүй байна) (Үргэлжилсэн зогсоц) (Алалтун бэхэн цэх суун сөгдсөн бие арагш яльгүй суларна, цэхээ алдан нугасхийнэ)

Цэрэг эр:

- (Хатны бортогон малгайг барих тэрээр Алалтуныг харах ба) Хааны охин хальчихлаа.

Зарлиг дуудагч:

- (айсан намдуу хоолойгоор) Цаазал! (Сэлэм барьсан эр Алалтуныг биеийг цаазална)

(Бүрэнхийлэл) (Тайзны өмнөх гэрэл тодорно)

Сорхагтан бэхэ хатан:

- Алтан аялуут Алалтун бэхэ минь газраас тэнгэр лүү өөрөө гэрэлтэн одлоо. Алтан аялгуунаас нь уягдан араас нь олон иргүн даган одлоо. Гайхамшигтай тэнгэрийн охин минь газар чамайг үгүйлнэ. Үгүйлнэ. Халаг, Халаг.. хайран хайран.. (ганхан гунина)

(Харанхуйлал)

Есдүгээр үзэгдэл.

9. Их хатан дөргэнэ ханхүү гүүгийг их хаанд өргөв

Тайз:Их хаан Өгэдэйн өргөө. Фатима шивэгчин төрөхөөсөө гарч араб маягийн хатны хувцас өмссөн байх ба нүднийхээ өмнүүр гивлүүр унжуулж нэг гартаа алтан хумстай эрх мэдэлтэн болсон байна. Их хатан Дөргэнэ сэнтийд сууна.

Фатима:

- Их Засаг баригч төрийн их хатан та тайвшир.

Их хатан Дөргэнэ:

- (түгшүүрт авгсан хүйтэн дуугаар) Фатима минь, Отчигон ноён цэрэг цуглуулж, зэвсэг, хуурай хэрэглэлийн бэлтгэлтэй нааш айсуй. Энэ бол миний засаглалын төгсгөл. Энэ бол сүйрэл.

Фатима:

- Тийм ээ. Харин ч чамгүй удаан тогтож, санаснаас ихийг та минь амжууллаа.

Их хатан Дөргэнэ:

- (цөхрөнгүй атлаа ширүүнээр) Фатима чи намайг их хүслээ үзээд төгсөнө гэж зөгнөсөн. Гэтэл хаа байна?

Фатима:

-Үзнэ ээ үзнэ. Эзэнт Гүрний Их Хатан таны аль хэдийн одуулсан аюулт агуу хүсэл чинь биелнэ.Би ч хэн ч Их хатны энэ агуу хүслийг зогсоож чадахгүй.

Их хатан Дөргэнэ:

-Ахиад л чи намайг гайхшруулах гэж байна уу?

Фатима:

-Миний хүч мөн. Гэхдээ таны хүсэл л таныг гайхшруулна.

Их хатан Дөргэнэ:

- Миний хүсэл нэгэнт одсон тэгэхээр би тайван байх хэрэгтэй. (зогсоц) Тийм ээ тийм.

Фатима:

- Их хатан таны агуу их шуналт хүсэл биелнэ. Би ч хорьж чадахгүй тийм их хүсэл.

Их хатан Дөргэнэ:

-(Фатима руу эвгүйцэн харна. Айдастайгаар) Тэнгэр минь. (залбирсан залбирлаасаа эмээнэ)

Фатима:

-Засаглал руу чинь тэр ноён халдахгүй. Бүү ай.

Их хатан Дөргэнэ:

- Би аюулыг яаж зогсоох гэж би мэдэхгүй байна. Заналт дайсан өөдөөс цэрэглэн ирж явна. Би тайванг олж хэрхэвч чадахгүй нь. Аюулыг би яаж зогсоох гэж?

Фатима:

-Их хатан та хүс. Тэгээд бол оо. Юуг яаж хүснэ яг тэр ёсоор биелнэ. Бүгд биелсээр ирлээ түүн шигээ хүс. Ингэхэд Их хатан руу дүрэлзэн бадрах тэр ноён тэгээд алтан ургийн өндөр хувьт гэл үү.

Их хатан Дөргэнэ:

-(Айдас нь ихсэнэ) Мэдэхгүй.

Фатима:

- Өрсөлдөгчөө надаас нуух, дайснаа өөрөөсөө нуух, ойлгоход хямдгүй бодол байна.

Их хатан Дөргэнэ:

- (цөхрөх атал зэвүүрхэнэ) Намайг орхиж үз.

Фатима:

- Хатан аврал хайна. Авралаа түлхэнэ. (их хатанд мэхийнэ) Өршөөгөөрэй. Их хатан таныг тааллаар тань би орхие.

Их хатан Дөргэнэ:

- Хүлээ. Фатима.(түүн рүү үл харна) Чи мэдэх хэрнээ надаар хэлүүлэхийг хүсч байна. (бухимдлаа дарна)Аан чи эзэн хааны нэрийг сонсохоос эмээжээ.Тэгээд надаар хэлүүлэхийг хүсчээ. (Дооглон инээнэ.Түүнийг айлгаж бахаа хангахаар) Их Монголын Эзэнт Гүрний Эзэн Чингис хаан, хааны хан эцэг Есүхэй, хатан Эх Өэлүний отгон хөвгүүн,(Фатима царайн цонхийно) Их Далай хаан Өгэдэйн авга ах, алтан ургийн сүүлч өвгөн Отчигин ноён гэж мэдэх үү? Айж байна.(тавлан инээнэ)

Фатима:

-Хатан та хаан эрээ дотроо зүхсэн түүн шиг ээ ...

Их хатан Дөргэнэ:

-(Эвгүйцнэ.Дотоод айдсаа дарахыг оролдоно.) Отчигин ноёнг үхээсэй гэж үү?

Фатима:

- Ертөнцийг мэдэх Их хатан таны төрийг чинь булааж, тэргүүнийг чинь хяргая Отчигон ноён уураа өвөртлөөд айсуу. Төгсгөл чинь ирж байна.

Их хатан Дөргэнэ:

- Тийм, тийм тийм тийм. Фатима. Фатима чи намайг орхиод өг.

Фатима:

- Харанхуйн хатан минь. (мэхийнэ)

Их хатан Дөргэнэ:

-(царай нь догшрон хувирна) Сорхагтан хатанг би зайлуулж чадсан.(инээнэ) Отчигон чамайг би үзэн ядаж байна. (Үргэлжилсэн зогсоц) Өөдгүй дорой чи миний өмнөөс зэвсэглэнэ гэнэ ээ. (Улам уурлана. Дөнгөж сонсогдохуйцаар зүхнэ.) Хатан миний төр хагарахаас урьтаад хар толгой чинь хагарах болно. Өндөр хатныг өшиглөхөөр чи зүрхлэх гэнэ ээ. Отчигон чи үхвэл таарна.(хашгирна) Зэвсэглэн яваа тэр одоохон ороод ирнэ. Тийм амархан үхүүлж чадахгүй болов уу байз. Фатима би яахав. Чи надад туслаач. (Хойш эргээд харах гэтэл Фатима алга байна.Гэвч Фатима түүний сэнтийн ард байна) Ухаан урсан орж ирлээ. Отчигин ноён “Би чиний сүйт бүсгүй чинь байна чамдаа найдсаар байна. Яагаад болохгүй гэж? (гунигт эмэгтэй болно) Эзэн Чингисийн дүү Далай их хааны минь авга ах Отчигин ноён та намайг төр улстай минь авч өмгөөлөн хамгаал.. Өндөр төрөлт таны хатан болох хүсэлтэй байна. Та минь цэрэг зэвсэг, хуурай хэрэглэлийн бэлтгэлтэй гарлаа гэдэг чинь юу гэсэн үг вэ? Бүх цэрэг улс маань нийт иргэд маань түгшүүртэй байна.Тийм ээ...(Инээнэ) Отчигины хөвгүүн Отойг явуулъя. Үгэнд минь итгэнэ.

Фатима:

- Их хатан таны хүсэл биелнэ.

Их хатан Дөргэнэ:

- (ихэмсэг хүйтнээр) Фатима чи байж л байна уу? Сүүдэрт минь хэвтэнэ үү? (зогсоц) Отчигин ноён сэдсэн хэргээ болих болов уу? Чи юу мэдэрч байна.

Фатима:

- Салбарсан алтан ургийн салаа нэг мөчир тасарна тасарна. Дөнгөж сая их хатан та тасаллаа.

Их хатан Дөргэнэ:

-(гараа өргөнө) Одоо амаа тат. Өр лүү минь авирах нь ганцхан Отчигон ноён биш боллоо. Би эрхшээсэн төрөө ганхахыг мэдэрч байна. Надад түшиг минь ганцхан Ханхүү Гүюг минь байна.

Фатима:

- (Аймшигтайгаар) Их хатан!

Их хатан Дөргэнэ:

- Хүүгээ би Их хаанд өргөмжилнө.

Фатима:

- Үгүй ээ. Их хатан минь, би танаас гуйя. Үүнийг одоо бүү хий.

Их хатан Дөргэнэ:

- Засаглал минь балран унахаас урьтан би хийх болно. Цаг минь ирлээ.

Фатима:

- (өвдгийг нь тэврэн авна) Болохгүй ээ. Их хатан минь үүнийг бүү хий.

Их хатан Дөргэнэ:

- Энэ бол их хатан миний сүүлчийн ганц арга, хүч мөн. Миний ханхүү, хатан эх минь тань руу аюул айсуй гэж айж цочин хэл ирүүлэв. Хүүгээс минь өөр хэн ч надад алга.

Фатима:

-Болохгүй. Дөргэнэ чи Эзэнт Их Гүрний Хатан Хаан. Ганцхан та.

Их хатан Дөргэнэ:

-(Зандарна) Хөлийг минь тавь. (Фатима хатны хатуу харцнаас эмээн хөлийг нь тавина) Замаас минь зайл. (Фатима биеэ хөдөлгөн зай тавина.) Би эх. (Сэнтийн очиж сууна.)

Фатима:

-(аймшигтай муухайгаар инээнэ) Хос хайрын сүүн дусал.

Их хатан Дөргэнэ:

-(Гараараа Фатима руу чичнэ) Би хан хөвүүдийн эх. Эх үр гэж чи юу болохыг мэдэхгүй. (Фатима муур шиг босно. Их хатан төв болно. Алгаа ташна. Ордны ноён Аригун орж ирнэ.

Аригунд хандан) Отчигины ноёны хөвүүн Отойг хөл хориогоос өргөөнд ирүүл. Хан хүү Гүюгийг өргөөнд морил хэмээн Хатан эх би дуудав. Төрийн бусад хэргийг түр азна.

Аригун ноён:

-Жа,Их хатан. (Мэхийн гарна)

Фатима:

- Хэрхэвч болохгүй. Их хатан минь. (Их хатан нүүр үл өгөн Ихэмсэг хүйтэн дүртэй байна. Зогсоц. Фатима Хатан руу ойртоно) Их хатан намайг алаад өг. Чавч. Намайг чөлөөлөөд өг. Гуйя. Түргэн үхүүлээд өг.

Их хатан Дөргэнэ:

-Үтэр түргэн өлмийнөөс минь бос. Бохир хар, хан хар чи. (Энэ үед ордны бараа бологч орж ирнэ. Фатима мөн муур шиг)

Ордны албат:

-Ханхүү Гүюг морилон ирлээ.

Их хатан Дөргэнэ:

-(Их хатан баяртай болно) Ханхүүг минь оруул. (Албат гарна. Фатима юмнаас айсан муур шиг хөдлөн хатны сэнтий хажуу ард зогсон хөшөө мэт үл хөдлөн доош тонгойн зогсоно. Ханхүү Гүюг орж ирнэ)

Ханхүү Гүюг:

- (Гүюг эхдээ сөгдөн ёсолно) Их хатан эх минь та амгалан уу?

Их хатан Дөргэнэ:

-Амгалаан амгалан.(Гунигтай царай эсгэнэ) Хан хүү минь өндий өндий. Харж байна уу? Бүх цэрэг улс маань түгшүүртэй байна.

Ханхүү Гүюг:

- Отчигин авга ах арван хоногийн газар явна гэнэ.

Их хатан Дөргэнэ:

-Ханхүү Гүюг минь хатан эх чинь чамайг хаанд өргөх цаг ирлээ.

Ханхүү Гүюг:

- Их хатан эх минь.

Их хатан Дөргэнэ:

-Их хааны минь тэнгэрт одсон тэр цагаас Эзэнт Гүрний Их төрд тэрслэх аюулын хэнгэрэг үл тасрав. Эцгийн чинь эрхэндээ хураасан улсыг Их хатан эх чинь төрийн нэг жолоонд шуудруулан оруулахаар ихэд зүдэн хичээв. Хаа сайгүй энгэрээ дэлдэн мэдэмхийрч ихээ мэдэгчид бий болж илийрэх болов. Бие минь сульдана. Хан хүү минь чи хатан эхээ өмөөрөх цаг ирлээ. Хамхисан Их хаан аавынхаа орыг залган миний ханхүү Гүюг чи одоо Их Гүрний Их хаан.

Ханхүү Гүюг:

-Хаан аавын минь нэрлэсэн Хүчү хан дүүгийн хүү Ширэмүн..?

Их хатан Дөргэнэ:

-(Инээмсэглэнэ) Их хаан эцгээ биширсэн хүү минь. Би ууган хөвүүн чамайгаа бусдаас илүү энхрийлэн хайрладаг билээ. Гүюг ханхүүгээ би хаан болохыг хичнээн их хүсэв.

Ханхүү Гүюг:

- Хатан ээж минь, Их хаан эцгийн зарлигийг хэн ч үл зөрчинө.

Их хаан Дөргэнэ:

- Хатан эх чинь хаан эцгийн зарлигийг үл зөрчинө. Төр засагч их хатан би хаан суудал эзгүй төр энэ жилүүдэд элэг барин инээх элдэвлэх тэрсэх элдвийг үзэв. Цаг өөр болсоон хүү минь.

Фатима:

-Их хатны их хүсэл энэ дэлхийн тэнгис далай гүн шиг, тэнгэрийн дэвсгэр газрын өргөн шиг тийм их билээ. Эх нь хүүгээ хаанд өргөхөд хүү нь хөлөө өргөөд урагш хоёр алхахад Эзэнт Гүрний Хаан сэнтий тосно.

Ханхүү Гүюг:

-(Фатима рүү ууртайгаар) Чи хэн бэ? Их хатан эхийн минь урьдуур орон үг хавчуулах чи хэн бэ? (Хатан эх рүүгээ хандан) Их хатан ээж минь мөнхөд таны дэргэд сүүтийх энэ хэн бэ?

Их хатан Дөргэнэ:

-Орхио, миний сүүдэр.

Хан хүү Гүюг:

-Хатан эх минь, сүүдэр гэхээсээ сүг шиг амьтан байна. Сөгд чи.

Их хатан Дөргэнэ:

-(Хүүгээсээ эмээнгүй байна. Фатима хатныг харна. Хатан түүн рүү харснаа нүүр бууруулна. Фатима сөгдөхөөс аргагүйд хүрэн сөгдөнө.) Мөөн мөн.

Ханхүү Гүюг:

-Их хатан эх минь, таныг ханхүү Ширэмүнийг төрийн хишигтэн цэргүүд хүрээлэн авчирч бага алтан олбогт өргөснийг тань хамаг бүгдээр мэднэ.

Их хатан Дөргэнэ:

-(Уурсана) Дэлхийг эрхэндээ хураах Гүрний Их хаан нулимсандаа холилдсон нялх хүү байж болох уу? Хаан ширээг чи хуруун чинээ хүүд өгөх гэв үү? Их хаан эцэг чинь хилэгнэн уурлахдаа чамайг шийтгэсэн. Хууль ёсоор Хааны ууган ханхүү чи Хаан болох ёстой. Хаан төрд халдах аюул, өлөн бөөс шиг үржив. Харж байна уу чи. Хатан толгой руу минь орж ирж байна.

Ханхүү Гүюг:

- Их хатан эх минь, Их төрийн хүнд ачааг үүрэх өндөр их зүтгэл тань өгүүлшгүй. (Сөгдөнө.Энэ үед Фатима босно)

Их хатан Дөргэнэ:

-Фатима.

Фатима:

-(мэхийснээ) Их хатан жа.

Их хатан Дөргэнэ:

-(эгдүүцэн зэвүүрхснээ) Байз хүлээ. (Шаналлаа нуун, ханхүүд хандана) Би чиний алдааг залруулж хаан сэнтийд чамайг хүргэхээр замын чинь чулууг биеэрээ зайлуулж, хуруун чинээ хүүгийн биеийн ард нуугдан чамайг хаан ор эзэгнэх чинь бэлдлээ. Их хатан миний үр удам хаан ширээнд суух ёстой. Би их хатан. Миний хүү (Фатима руу харснаа болин) чи Их Монголын Эзэнт Гүрний хаан. Албат боол эм чи Аригун ноён болон түшмэдийг өргөөнд оруул. (Ширүүнээр) Зогсч бай. Хүлээ.(Хан Гүюгт хандана) Орж ирэгсдийн өмнө урьтаад ханхүү чи ханхүү Ширэмүний бага алтан олбогийг эзлэн суу.

Ханхүү Гүюг:

- Их хатан эх минь ухаж ойлгов би.(Ханхүү Гүюг Их хатны дэргэдэх бага алтан сэнтий рүү явна.Олбогт сууна)

Их хатан Дөргэнэ:

-Тиймээ. Эхлээд энэ олбогийг эзэлснээ харуул.(Фатимаруу хандана.) Үзэв үү. Өргөөнд оруулахгүйн.(Фатима мэхийн ёслоод холдон алга ташна.)

(Аригун ноён тэргүүтэй ордны түшмэдүүд албатууд орж ирнэ. Өргөөнд ханхүү бага олбогт сууж буйд алмайрнаа сандралдан үтэр түргэн доор сөгдөцгөөнө. Фатима зогссон газраа хөдөлгөөнгүй болно. Албатууд цартай зоос барьсан байна.)

Их хатан Дөргэнэ:

-Аригун ноён Эзэнт Гүрний Төр засагч их хатан, төрийн төмөр өмгөөлөл болох ханхүү Гүюг бидэнд өгүүлтүгэй.

Аригун ноён:

- (Дорд мэхийнэ) Эзэнт Гүрний Төр засагч Их хатан, Төрийн төмөр өмгөөлөл Ханхүү Гүюг та бүхэн таалан болгоно уу? (алга хавсран ташна. Албатууд цартай зоос авчирна) Төр Засагч Их хатан таны зарлиг дор Их Монгол Эзэнт Гүрний үнэт хөрөнгө Монгол улсын мөнгө гэсэн бичээст зоос цуглуулав. (Албатуудаас цартай зоосыг авч Аригун ноён их хатанд барив) Таалан болгоно уу?

Их хатан Дөргэнэ:

-(Цартай зоосноос нэгийг авч үзнэ) Төмөр өмгөөлөлт Ханхүү Гүюг минь таны төрийн их зоос. (Ханхүү Гүюг хатан эхийнхээ гараас авна) (Ханхүү үзээд Их хатан руу харна. Хатан түүн рүү үл харна)

Ханхүү Гүюг:

-Таалалд минь нийцэв. (Гүюг зоосыг буцааж таваг руу шиднэ)

Их хатан Дөргэнэ:

-Төмөр өмгөөлөлт ханхүү Гүюгийн минь таалалд нийцсэн тул Эзэнт Гүрний сангийн хэрэгцээнд гүйлгэ. (Их хатан ханхүү Гүюг рүү харна.ш)

Ханхүү Гүюг:

- Ёсчилон гүйцэтгэ.

Аригун ноён:

-Жа,зарлигийг хичээнгүйлье. (Албатууд Аригун ноёноос цартай зоосыг авч явна)

Ордны түшмэл:

-Төр засагч Их хатан минь баруун гарын их цэргээс илч иржээ.Сүн улс 200000 лан мөнгө, төдий хэмжээний торгоор жил бүр алба барьж найрамдья гэж ноёдоо илгээхийг хүсчээ.

Их хатан Дөргэнэ:

- Тун сайн. (баяртай өндийнө) Сүн улсын энх найрамдлыг хүсэх хааныг өрөвдөв. Их хатан би бээр Сүн улсын ноёдыг хүлээн зөвшөөрөв. Төр засагч цолт Их хатан эх би бээр Их төрийн их хуралдайг зарлах цаг сая ирэв. (Их хатан гараа дээр өргөнө) Сүн улс руу довтлох дайныг Их төрийг засаглагч их хатан би зогсоолоо. Их Монголын Эзэнт Гүрний баруун зүүн гарын их цэргийг эх нутагт эргүүлэн дуудах болов. (Улмаа омог тодорно) Эзэн хааныг өргөмжлөх Их хуралдайг Их хатан би зарлав. Эзэнт Гүрний цараагаар Их хатан миний зарыг ордны түшмэдүүд та улс цааш нь түгээ. (Догшин болно) Сонсохтүн. Буруу зөвөө үл мэдэн зарим ихэс хаан төр лүү заналхийлнэ. Их хатан миний зарлигийн эсрэг тэрслэн өндөр санааг минь үл ухан заналгч Отчигин ноён тэргүүтэн олширсон тул их хуралдай үнэн мөнийг ялгах болно. Өндөр цааз дор зарлиглах нь хаан төр ханхүү Гүюгийн төмөр өмгөөлөлд орсон тул харин төрийн энэ нууцыг ордноос гадагш хэрхэвч бүү алд. Их хатан миний энэ зарлигт та улс тэрсэлдвэл өчиггүй цээрлүүлж, хар толгойтой бүхэн чинь хагаран унах болно. Мэдтүгэй.

Өргөөнд хурагсад бүгд нийтээр:

- Их хатан таны зарлигийн дор сөгдье. Сөгдье. Сөгдье.

Их хатан Дөргэнэ:

-(Фатима руу хандана.) Фатима хатан чи Отчигин ноёны хөвүүн Отойг их хатан миний өргөө рүү хүргэ.

Фатима:

- Их хатан таны зөв.

Ханхүү Гүюг:

- Юу гэнээ. Дорой заяат эм чи.

Их хатан Дөргэнэ:

-Хүлээ хүү минь. Их Төрийг засагч их хатан эх би, түүний зөнч билигчийн үнэлж их хараачаар өөртөө авсан. Хэлэх үгээ хэлэх болно. Араб энэ дорд эм ордонд харь хатдын хэмжээт эрхтэй.

Ханхүү Гүюг:

- (Эх хатан руу гайхан харснаа Фатима руу хандана. Ширүүнээр хяламхийн) Харийн хатан чи Их хатанд үг өчихдөө сөгдөж өч. Эзэнт Гүрний Төрийн ясу ёсыг мөрдөх жаягийн дор ихсийн өмнө дорд бөхийн явах орд өргөөний ёсыг мэд.Зарлигийг дагахтун.

(Бүрэнхийлэл)

(Тайзны өмнө талд саях түшмэдүүд албатууд ирж зогсоно. Тайз ард талд Их хатан, ханхүү

Гүюгийн суух сэнтийтээ эргэнэ. Тайзан дээр Их хааны сэнтий ганцаар ирнэ. Гэрэл тодорно. Ордны түшмэдүүд дээр бусад дээдсүүд албат иргэд бүгд нэмэгдэн цугларна. Ханхүү Гүюгийг Их хаан ширээнд өргөмжлөгдөх ёслол болно. Их хатан Хаан Гүюгийн дор зогсоно)

Аригун ноён:

- Их хуралдай дор Их Монголын Эзэнт Гүрний Далай Их хаан Өгэдэйн орд их хааны ууган хөвүүн Далай Их хаан Гүюг тодрон өргөгдлөө.

Нийтээр бүгд:

-Хурай. Хурай. Хурай.

Бөө зайран:

-Далай Их хаан Өгэдэйн алтан гэрээсийг Далай Их хаан танд өргөсү би. Их хаан алтан гэрээсээ мөнх тэнгэрийн хатуу хүчин дор Эзэн Чингисийн хабсу хасу бөгжөөр бөгжлөн хадгалуулсан билээ. Далай их хаан алтан гэрээсээ хаан орыг хэн залгана тэр гагцаар мэдэхгүйн хэмээн зарлигласан. Далай Их хааны гэрээсийг Их хаан Гүюг тань өргөн барьсу. Би. (Гэрээсийг хасбуу бөгжтэй өгнө. Их хатны царай хувиран хөл нь нугарсхийснээ өөрийгөө цэгнэн зогсоно)

Их хаан Гүюг:

-(Эцгийн гэрээсийг үзнэ) Мөнх тэнгэрийн хүчин дор, Эзэн Богд Чингис хааны суу дор Их Монголын Эзэнт Гүрний Далай хаан Гүюг миний зарлигийг сонсохгүйн! Мөнх Хөх Тэнгэрийн зараалаар дээд тэнгэрээс заяат төрсөн хөх нуруут бид тэнгэрийн дор Нэгэн Эзэнт Гүрэн, Нэгэн Хаант улсыг бүтээн Их Монголын ясу зарлиг, хуулийг дэлхийд мөрдүүлэн тулгах эрхтэнгүүд билээ. Далай Их хаан эцгийн алтан гэрээс юуг атган Их Монгол улсын босоо оршихуйн жаягт Алтан Дээд Гэриэг хаан би бээр мөрлөн Их засахуйн ясу зарлигийг бататгахаа андгайлав. Эзэнт Гүрний улс иргүн бүгд нийтээр Алтан Дээд Гэриэнд мөргөн биширч ясу хуулийг мөрдөхийг зарлиглан тунхаглав. Хүн төрөлхтөнд ариун чин шударгуу хууль цаазыг тогтоохоор хөх нуруут бид мордох болно.

Нийт бүгдээр:

- Уухай .Уухай Уухай.

Жүжгийн титэм төгсгөл.

Плано Карпини:

- Үнэн сүсэгтэн Ромын элч зараал Плано Карпини би Их Гүрэнг нүдээр үзлээ. Монголын Эзэнт Гүрний Их хаан Өгэдэй Хар Хорин хотоо тойрон Алтан өргөө хэмээх нэн гоёмсог эсгий өргөөнд амьдрах ба хааны өргөө хотоо тойрон хэдхэн хоногийн газарт улирал улирлаар байнга газар сэлгэн нүүдэллэнэ. Эрх баригч гэр бүл хүчирхэг бөгөөд сүрлэг, тансаг. Тэд Хархорин хотоо нийтээр эзэмшинэ. Хот бидний хотоос өөр хаан хааяа нэг морилно, заримдаа

эс морилон үл тоох ба тал нутагтаа үргэлж сууна. Их хот ямар нэг том агуулах мэт. Эд баялаг чихээтэй ба дайны олзонд зориулж барилгууд нэмэгдэн босно.Тэд хотоо эд бараа урчууд, дархчуудаа хадгалах зорилгоор ашиглана. Их хаан Өгэдэй Хархорин хотод нэг үе удаанаар морилсон ба өдөр бүр зоог барьсныхаа дараа ордныхоо гадаа залрахад энэ дэлхийн өнцөг булан бүрээс эдийн дээд бүхэн өмнө нь овоорно.Тэдгээрийг иргэддээ тараах бөгөөд том биетэй эрчүүдийг даахынхаа хэрээр авахыг баяртайгаар шаардана. Баяр цэнгээний үеэр архи дарсыг асар том савнаас заанууд оньсот нүсэр том хөдөлгүүр хөдөлгөхөд хоёр бөхтэй тэмээнүүдийн нуруун дахь том шавар вааранд дүүргэн хүмүүс зөөнө. Их хаан Өгэдэй таалал төгсч түүний ууган хүү Гүюг их хааны ширээг авлаа. Бүх л юм гайхамшигтай аймшигтай. Хамгийн хачирхалтай гайхамшиг нь энд бие биенээ үл тэвчих шашингууд ямар ч тэрсэлдээнгүй бүгд адил тэгш зэрэгцэн орших ба дэлхийн бүх шашны сүм дуганууд зэрэгцэн байна. Олон шашин шүтлэг ингэж энх тайвнаар зэрэгцэн орших энэ энхийг бүтээсэн тэр улсын Мөнх тэнгэрийн хүч гээч агуу гайхамшигтай. Эзэнт гүрний хаан Чингисийн морьтон улсын нууц агуу ухаан сүрдэм. Сөгдөм.(Их хэнгэрэгний дэлдээн, бүрээн их дуу дуурсав) (Хөшиг)

(Их хаан Өгэдэй дэд жүжиг өндөрлөв)

Мөнх Хааны санаа

Магад гарахын үнэн Алтан дээдийн аялгууг

Мартваас чи үжирч өөрийн өөдгүйд боолчлогдму

Маргаваас чи хөшиж хөндлөнгийн идэш болму

Мөрлөвөөс чи мөнх тэнгийн хүмүүнд хүрмү

Жүжигт тодрох дүрүүд:

Их Монгол Эзэнт Гүрний Төвшитгөх Их хаан Мөнх

Их Монгол Эзэнт Гүрний хатан эх Сорхогтан бэхи бөө цэцэн

Их Монгол Эзэнт Гүрний их хатан Хутухуй

Их Монгол Эзэнт Гүрний Төр түшигч хан Хүлэг, Хубилай, Ариг бөх

Их Монгол Эзэнт Гүрний төрийн бичгийн сайд Чингай Чинсан Бэхэ

Их Монгол Эзэнт Гүрний засагч бага хатан эх Мүкэ

Их Монгол Эзэнт Гүрний хаан Мөнхийн хан хүү Ширхэ

Их Монгол Эзэнт Гүрний төрийн их шүүгч ноён Мэнгэсэр

Их Монгол Эзэнт Гүрний алтан дээд гэриэний амьд ном Жөн Мон Тоба

Жүжгийн тодрох ба илрэх дүрүүдийн хамжаа туслах дүрүүд:

Чабун хатан, Хан хүү Хөхөө, Нүлүн ноён, Аригун ноён, Салжидай ноён, Өлжий бэхэ охин, Францын элч лам Гильом Де Рубрук, Буддийн лам Пагва, Армяны ван Гетум, лал, христос бусад шашны лам санваартан нар Марко Поло ордны албат түшмэдүүд, хишигтэн, цэргүүд, хэвтүүл, аягач шивэгчид...

Жүжигт илрэх сөрөг дүрүүд:

Их хатан Огул Хаймиш, Өгэдэй хааны хан хөвүүд Гүдэн, Хадан, Мэлиг, Цагаадай ханы хан хөвүүн Муу тогоон, Хар Үлэхү, ач Есөн Мөнх, Бүри, Гүюгийн хан хөвүүд Нагу, Хажу...

Дөтгөөр жүжиг

Жүжгийн явдал

- Гутгаар жүжгийн эхлэл титэм

1. Их хаан Мөнхөд Өгэдэй Цагаадайн хан хөвүүд нум сум зэхэв.
2. Их хатан Огул Хаймиш энгэр юугаа дэлдэв.
3. Их хатан эх Сорхагтан амьд хүн ном бүтээв.
4. Гүрэн батжиж, Их хаан гүрний сан хөмрөгийг түгээв.
5. Хатан эх Сорхагтан бэхэ бөө сэцэн тэнгэрт морилов.
6. Их хаан Монгол дээвэрт дэлхийн бүх шашинг хэлэлцэв.
7. Их хаан Мөнх хөх мөнх тэнгэр болов .
8. Их хааны сэнтийд тэнгэрийн тэмдэг үзэгдэв.
9. Тэнгэрт өрсөлдөн хоёр хаан Хубилай, Ариг бөх тодров.

-Жүжгийн төгсгөл ба дөтгөөр жүжгийн эхлэл титэм

Дөтгөөр жүжгийн эхлэл титэм.

Тайз: Өндөрлөгт хааны сэнтий байна. Их хаан Мөнх өндөрт байна. Ард иргэд түүнийг доор байх ба үзэгчид рүү харсан байна. Санваартан Гильом Де Рубрук тайзны өмнө хэсэгт тэднээс тусгаар байх ба мөн ард иргэдийн адил доор бохирон үзэгчид рүү харж суусан

Байна. (Төрийн хэнгэрэг бүрээ дуугарч их хэнгэрэгний дуу үүснэ)

Их хаан Мөнх:

- (Гараа дээр өргөөд) Мөнх тэнгэрийн хүчин дор, Эзэн Богд Чингис хааны суу дор Их Монголын Эзэнт Гүрний их хаан Мөнх миний зарлигийг сонсохгүн! Мөнх Хөх Тэнгэрийн зараалаар дээд тэнгэрээс заяат төрсөн хөх нуруут бид тэнгэрийн дор Нэгэн Эзэнт Гүрэн, Нэгэн Хаант улсыг бүтээн Их Монголын ясу зарлиг, хуулийг дэлхийд мөрдүүлэн тулгах эрхтэнгүүд билээ.

Франкийн элч зардас чи ихэс дээдэстээ хэлэхгүн. Дээд гагц Мөнх тэнгэр дор газарт ганц эзэн Чингис хаан байдаг хэмээн Мөнх тэнгэрийн бошго зарлиг буй. Та нар Мөнх тэнгэрийн зарлигийг сонсовч нэвтэрхийлэн олгож итгэхийг хүсэлгүй бидний газар хол, уулс өндөр, тэнгис далай их хэмээн бүү мунхагла. Эзэнт гүрний их хаан миний та бүхэнд хэлэх үг ману хүмүүний чих сонордох, хүлгийн туурай хүрэх аливаа газар үгүйг ману биширтүгэй. Дагатугай. Ману зарлигийг сонсож ухсан атлаа үл биширч, бидний өөдөөс цэрэг хөдөлгөх аваас тэр нүд байвч харж эс чадах, хөл байвч явж үл чадах буй за. Энэ болбоос Мөнх тэнгэрийн тогтоосон зарлиг болой. Мөнх тэнгэрийн суу залиар их Монгол түмний нэрийн өмнөөс франкуудын эзэн ноён Людовик ван болонбусад эзэд, санваартан, их франк түмэнд хүргэх Мөнх хаан миний зарлиг энэ болохыг мэдтүгэй. Мөнх тэнгэрээс Чингис хааны буулгасан бошго сургаал дараах хаадын бошго мөн энэ мэдтүгэй. Та улс бидний үгийг

дагагугай. Илч юугаа бидэнд илгээхтүн. Та нар мөнх тэнгэрийн зарлигийг эс сонсон бидний эсрэг дайлбал бэрхийг хялбар, холыг ойр болгодог мөнх тэнгэрийн хүчийг үзтүгэй. Дэлхий ертөнцийн хүмүүн төрөлхтнийг сэхээрүүлэхээр хөх нуруутнууд бид ариун чин шударгуу хууль цаазыг тогтоохоор мордох болно. Мөнх тэнгэр мөн франкууд та нарын хувь заяа юу болохыг мэдтүгэй..

Уэллъяа Рубрик:

-(Сүмийн хонх дуугарна.Тайзны өмнө биед байна.Тэрээр доош суусан байна.Үзэгчид рүү хандана) Франкийн хаан Людовик эрхэм дээдэс таны элч Уэллъяа Рубрик би Их Монголын Эзэнт гүрний Их хаан Мөнхөд бараалхан их замын бэрх аянаасаа эргэн ирлээ. Бурханы энэ дэлхий ертөнцөд үнэн хүчит нэгэн гүрэн мандсан гэдэг үнэн болохыг үзлээ. Тэр их улсын өмнөх хаан Гүюг догшин хэрцгий бөгөөд хаан ширээнд суусан богинохон хугацаанд эзэнт гүрэн даяар их шүүхийг зарлажээ. Их дуулиант атал маш нууц тэр хэрэг, ертөнцөд боссон чөтгөр шуламтай холбоотой гэхээс өөр үг эс сонсов. Хэнд ч үл худалдагдах хөх нуруут гэх иргэд тэдний нэгний ч амнаас үг олж чадсангүй.Тэдгээр монгол хэмээх ард иргэдийн гайхалтай итгэл, гуйвшгүй зан тэдний их гүрэнг бүтээжээ. Эгэл малчин гэх эр ч эм ч үг үл алдана. Мөнх тэнгэр нь газар дэлхийн ихэмсэг дээрэнгүй, үрэлгэн тансаг байдлыг таалаагүй учраас олон улс хотыг шийтгэсэн ба бид мөнх тэнгэрийн иргэн улс бөгөөд тэнгэрийн зарлигийг тулгагч гэж их гүрний морьтон эрийн алин ч өөдөөс хэлнэ. Тэднийг засаглах тэнгэрийн хүч хууль цаазын хатуу чангыг нь гайхан айв би. Тэр Чингис хааны тогтоосон амар амгалан, найдвартай аюул осолгүй агуу торгоны замын худалдаачид өдгөө арилжаа наймаагаа айдас хүйдэс дор эрхэлнэ. Чингис хаан энэ торгоны замын олон салаа салбарыг нэгэн том гол болгон Монголын тал нутаг руу урсгажээ. Элдэв өнгөт торго алт эрдэнэсийн хөврөх ачаа хөсгийн уртын урт цуваа гагц тал нутаг руу чиглэх бөлгөө. Гэтэл олон газрын худалдаачдын ашигтай наймаа хямарч, тэд дэлхийн хэрэг явдал үнэний замаас гажиж, шударга хэлэлцээний жолоо цулбуур голч шударгын их замаас хазайв. Даян дэлхийн сав ертөнц албин хорлолд автав. Худалдаа арилжааны ажил зөв шулуун замаасаа гарав. Монголын Их гүрэн сүүдэрт дайруулан, зовлон бэрхшээл бидэнд үүсэв гэж их гүрэнд захирдах элдэв улс орны албат иргэд өөрийн бус Чингис хаан, Өгэдэй хааны үеийг дуудан гасална. Бидний бурханы авралаар хаадын хааны ач хүү тэр харгис хаан үхэв. Гэвч оронд нь мөн л Чингис хааны бас нэгэн ач хүү Мөнх хэмээх хаан тодров. Асар том ургаа мод мэт ертөнцийн төвд баг орших Монгол төрийн жолоонд дэлхий ертөнцийг нэгтгэх үүргийг Их хаан Мөнх жолоодох болов.Эрхэм дээдэс минь, Монголчууд Мөнх тэнгэрт шүтлэгтэй. Тэд мөнх тэнгэрийн иргэн улс бөгөөд ертөнцийг аврахаар тэнгэрээс Чингис хаанаа бас өөрсдийгөө заяагдсан гэнэ. Тэнгэрийн тэр тэмдэг нь хөх тамга ба өөрсдийгөө хөх нуруутангууд гэнэ.Үнэхээр тэдний нуруунд хөх толбо бий ажээ. Эхээс төрөх нялх хүүхдүүд нь мөн тэнгэрийн тамга гэх нуруундаа хөх толботой төрнө. Дэлхийн хүн төрөлхтөн дотор бусдаас содон тэмдэгт тэр улс цаашид франкууд бидний хувь заяаг хэрхэхийг үл таав. Ертөнцийн эзний хүү Есүс минь! Айдас хүйдсээс биднийг аварч нүгэл хилэнцийг маань өршөөж хайрла!

Нэгдүгээр үзэгдэл.

1. Их хаан мөнхийн өөд өгэдэй, цагаадайн хан хөвүүд нум сум зэхэв.

Тайз: Их хааны өргөө. Их хаан Мөнх өндөрлөгт сэнтийд сууна. Их хатан эх Сорхагтан бэхэ, бага хатан эх Мүхэ, Их хатан Хутухуй, хан Хүлэг, Хубилай, Ариг бөх, Жөн Мон тоба, Нүлэн ноён тэргүүтэй хатад ноёдод монгол дуучин хөгжимчин бүжигчид дуу хөгжмөө өргөнө.

Нүлэн ноён:

-Их Монгол Эзэнт Гүрний их хаан Мөнх танд хүчээ өргөхөө андгайлахаар Өгэдэйн хааны хан хөвүүд Хадан, Мэлиг, Цагаадай ханы хан хөвүүд Муу тогоон, Хар Үлэхү нар алтан өргөөнд морилон ирлээ.

Их хаан Мөнх:

-Их хаан Мөнх би дээдсийн хан хөвгүүд тэднийг хүлээж байлаа. Хан хөвүүд өргөөнд морилон орж иртүгэй. (Нүлэн ноён руу гараараа дохино)

Нүлэн ноён:

-Хан хөвүүд өргөөнд морилохтүн.

(Гаднаас Хадан, Мэлиг, Муу тогоон, Хар Үлэхү нар орж ирж их хааны сэнтийн өмнө сөгдөн ёслоно)

Хадан хан:

-Их хааны түмэн амгаланг эрье.

Хан хөвүүд цугаар:

-Их хааны амгаланг эрье.

Хар Үлэхү хан:

-Эзэн хаан Мөнх та алтан ургийн хан хөвгүүд биднийг өршөө.

Хан хөвүүд цугаар:

-Их хаан биднийг өршөө.

Хар Үлэхү хан:

-Их төрийн төмөр жолоо цулбуурыг эрхэндээ хураасан их хаан таны Мөнх хөх тэнгэрийн дор үүсгэх сүрт их найранд хожимдож ирсэн хан хөвүүд биднийг хүлцэн өршөөнө үү! Эзэнт

Гүрний их хааны сэнтийд заларсаны тэнгэрт өргөх их найр баяр цэнгэлийн дээдийг хуваалцахаар эзэнт төрд үнэнчээр зүтгэхээ андгайлахаар хан хөвүүд бид ирэв.

Хан хөвүүд цугаар:

-Их Монголын Эзэнт Гүрний их хаан Мөнх таны алтан төрд хүчээ өргөхөө..

Хадан хан:

-Өгэдэй хаан эцгийн хан хөвүүн Хадан би..

Мэлиг хан:

- Өгэдэй хаан эцгийн хан хөвүүн Мэлиг би..

Муу тогоон хан:

-Цагаадай ханы хан хөвүүн Муу тогоон би..

Хар Үлэхү хан:

- Цагаадай ханы хан хөвүүн Хар Үлэхү би..

Хан хөвүүд цугаар:

-Андгайлахаар ирлээ. Андгай үгийг маань хаан та автугай.

Их хаан Мөнх:

- Алтан ургийнхаа хан хөвүүд та бүгдийг үзээд их хаан миний сэтгэл зүрх машид баясан дэлгэрэв.

Хадан хан:

-Далай их хаан Өгэдэй эцгийн алтан нумыг, Цагаадай ханы мөнгөн сумыг бид авч ирэв. Алтан ургийн хөвүүд бид Эзэнт Гүрний их төрийн алтан өргөөний тооноор мөнх хөх тэнгэр өөд сум тавьж Мөнх их хаанд хүчээ өргөхөө андгайлъя бид. (Алтан нум сумыг хамтдаа дээр өргөнө)

Их хаан Мөнх:

-Их хаан Мөнх би эзэнт гүрний хаан Өгэдэй, хан Цагаадайн хан хөвүүдийн эл тангаргийг ихэд хүлээв. Алтан ургийн бөх хэлхээ, алтан гагнаас юуг их найрын өргөөнд морилох ихэс дээдэс, хатад бүгд бишрэн үзтүгэй. Хэн энэ сумыг тэнгэрт хүргэх буй. Хаан миний бодлоор Өгэдэй хааны ууган хөвүүн Далай их хаан Гүюгийн удаах хан дүү Гүдэн тэнгэрт хүргэх ёстойсон. Хан Гүдэн та нарын дунд алга.

Хадан хан:

-Их хаан Мөнх та хан ах Гүдэнг өршөөн болгоо. Ах ханы бие чилээрхэв. Ирж амжсангүй өршөө. Хадан би түүний өмнөөс сум тавья.

Их хаан Мөнх:

-Хадан хан чиний хүчийг бид мэднэ. Харин хаан би Мэлиг хөвүүний хүчийг үзье.

Мэлиг хан:

-(Сандран) Жа.

Их хаан Мөнх:

-Хан хөвүүн Мэлиг дүү минь, хонгор нялх байхад чинь би чамд Бурхан Халдун уулын оройгоос өглөөний нар тэнгэрт хэрхэн манддагийг үзүүлэх гэж нуруундаа үүрч явж билээ. Тэгэхэд чи хатан эхийнхээ мээмний сүүг надаас нэхэж уйлахдаа мөрийг минь тас хазаж билээ. Чиний сүүн шүдний сорви миний мөрөн дээр үлдсэн. Одоо чи тэр үүрийн ухаа шаргал нарыг санадаг уу?

Мэлиг хан:

-Их хаан ах минь би их жаахан байсан.

Их хаан Мөнх:

-Тийм дээ. (Гуниглана) Буурал өвгөн хаан Чингисийн өвөр дээр эрхлэн сууж байхдаа чи хаан сэнтийд сууж үзсэн. Их хааны өвөр дээр эрхэлсэн Мэлиг хан дүү чи эзэн хаадын тэнгэрт их гүрний исгэрэн нисэх алтан нумын мөнгөн сумны хөг аялгууг хүргэ. Алтан өргөөнд хурсан олон аялгууг нь олж сонсог.

Хар Үлэхү хан:

-Мэлиг хан дүү. (Нум сумыг түүнд өгнө)

Мэлиг хан:

-(Нум сумыг эмээнгүй авна) Жа...

Хадан хан:

- Далай их хаан Өгэдэй эцэг, Далай их хаан Гүюг ахын өндөр их алдар нэрийг Мэлиг хан дүү чамд бидний өмнөөс тэнгэрт мэдүүлэх аз ирж андгай тангаргийг өргөх ёсыг чи үйлдэх боллоо.

Мэлиг хан:

- (Сулхан дуугарна) Жа...

(Мэлиг алтан нум мөнгөн сумыг тооно рүү тэнгэр өөд хөвчлөн татсанаа гэнэт их хаан Мөнх өөд чиглүүлэв. Их хаан эс хөдлөв)

Их хатан эх Сорхагтан:

-(Өндийн босно) Мөнх тэнгэр минь!

(Мөнх хааны хан дүү нар Хүлэг, Хубилай, Аригбөх нар сэлмээ сугалан хааныг хамгаалахаар босон ирцгээнэ. Сорхагтан хатан эргээд сууна)(Хадан, Хар Үлэхү, Муу тогоон нар гутлын түрийнээсээ мэс сугалан өрцгөөнө. Толуйн хан хөвгүүд тэдэн рүү сэлэм чичлэн тулан ирж зогсоцгооно. Мэлигийг ар нуруугаараа хамгаалан Хар Үлэхү, Муу тогоон, Хадан нар хутга барин тойрон зогсоно. Мэлиг нум сумаа буулган сөгдөн уйлав)

Мэлиг хан:

- Намайг өршөө. Их хаан ах Мөнх та минь, хан ах нар минь намайг өршөө.

Хүлэг хан:

-Их хаанд халдахаар та нар ирнэ гэнэ ээ.

Хадан хан:

-Мэлиг чи юунд уйлав. Толуй ханы хан хөвгүүд та нар, Өгэдэй хаан аавын хаан сэнтийг хан хөвгүүд биднээс булаав.

Ариг бөх хан:

- Хаан төрд та нар тэрслэв үү?

Хар Үлэхү:

-Харва... Мэлиг чи ёс бус Толуйн зулбасага үхэх ёстой. Харва...

Хубилай хан:

-Алтан өргөөний үүдээр хөндлөн гарах цагийг та нар өөрсдөө авч ирлээ.

Жөн Мон Тоба хан:

-(Гаднаас орж ирнэ. Тэднийг харснаа хаанд сөгдөнө) Их хаан ах минь Бат ханы хөвгүүн хан Бэрх ах намайг нааш илгээлээ. Хаан төрлүү гэнэт халдахаар зэхсэн Хан хөвүүн Гүдэн, Халзай нарын цэргүүдийн сөгдсөн нь үлдэж, сөрсөн нь үхэв. Отоонд баригдсан Гүдэн Халзай хан хөвүүд тэргүүтэй далан долоон ноёдын гарыг хүлж морьдоор чирэн ирэв.

Муу тогоон:

-Хаан хар авчээ. Хадан одоо яах вэ? Өршөө. (Хутгаа газар алдана. Газар сөгдөнө) Хүлэг, Хубилай, Аригбөх, Жөн Мон Тоба, Муу тогоон миний амийг өршөө.

Хар Үлэхү хан:

-(Хутгаа унагана) Өршөө. Их хаан Мөнх биднийг өршөө. (Хадангийн гараас зуурна) Сөгд. Хадан минь.

Ариг бөх хан:

-(Хаданы эрүү рүү сэлмээ чичнэ) Эзэнт гүрний их хаан Мөнхийн өмнө сөгд. (Хадан хутгаа шидэн арайхийн сөгдөнө) Чиний хаан Толуйн ууган Мөнх гэдгийг мэд. (Хадан хөмхийгөө зууна)

Их хатан эх Сорхагтан:

-(Хилэнтэйгээр) Амнаас үг төрүүлнэ гэдэг ариун үйл. Алтан гавалд үг бүрэлдэж, амнаасаа утгыг төрүүлдэг бус уу. Андгай тангаргийн эхийг булингартуулж, амьгүй үгийг юунд та нар тээн төрүүлэв. Хадан хан чи өөрийгөө харахтүн. Хан хөвгүүд та нар өөрсдийгөө үзэхтүн. Хаан намайг үл зөвшөөрөх хэлэх үнэн та нарт бийсэн бол их хуралдайд хүрэлцэн ирж харцаа нумлаж хэлээ хөвчилж, хан гавалдаа найрснаа шударгаар юунд эс өгүүлэв. Харцгаа та нар өөрсдийгөө... Хурсан бүгд бас тэднийг мэдэцгээ. Мөнх хөх тэнгэрийн ухаан, билэгт үг, ариун андгайг улаан нүүрний уранхайгаар унагаж, үнэн хэмээн үл ичин зусраар өгүүлж, худлыг хутга мэт нууж, нэгэн биед хоёр толгой ургуулж, амьтаныг айлгаж, түмнийг цочоох та нар хэн болов? Харцгаа. Дөнгөж сая би олон толгойт могойг үзэв. Алтан хэлмэлд юу гэж засагласныг та улсаас хэн хэлэх вэ?

Мэлиг хан:

-Сорхагтан бэхэ та өвлийн анд эрчүүд одоход үдшийн үлгэр өргөөнд хайлдаг. Өвөг өтүгэ улирлын тахилга, олон толгойт могой цас унахад орох нүхээ эс олно. Нэг толгойт мянган сүүлт могой орсон цаснаас зугтаж зурамны нүхээр ч зүтгэж орно. Буман жилийн настай өтүгэ мон ухамсрыг хан хөвүүд бид эвдэв.

Их хатан эх Сорхагтан:

-Нэгэн толгойт, зургаан биет өвөг Монгол өтүгэ сүлдийг өргөж та нар мөрлөх ёстой бусуу. Мэддэгээ мэрж, таньсанаа таглах чинь юув? Буман жил өртөөлөн авчирч ирсэн сүлдийг алтан ургийн хан хөвүүд алтан төрд асаах байтал төрлөө унаган булхайд баригдаж, төрсний язгуур эхээ буртаглах юун?

Мэлиг хан:

- Алтан гэриэгээ алдаж осолдсон.

Хадан хан:

- Амаа хамхи Мэлиг чи.

Муу тогоон хан:

- Сорхагтан бэхэ минь бидний буруу, Их хаан Мөнх минь бидний амийг өршөө.

Их хаан Мөнх:

-Буурал өвгүн хаан эзний хаан сэнтий бүү хэл их хааны өвөр дээр гуч бид бултаараа гарч эрхэлж өссөн. Тэнгэрийн өвөр газар дээр тэр мэт бид гэрэлтэх учиртай. Бүхний амгаланг зохиохын тулд бүлээн бие бүлэгнэсэн хэрэг. Алтан ургийн амин голоор алтан аялгуу бус аймшигт ёр унаж, алтан өргөөний тооноор тэнгэр арайтай л шархадсангүй.

Хадан хан:

-Үхэл бидний амийг хэдийн зөөж эхэлсэн. Гүдэн, Халзай нарынхаа хамт Хадан би үтэр түргэн одьё. Харин хаан чиний үүрийн зүүдэнд чинь давхилдан ирж үхлийг чинь бид мэдэх болно.

Хүлэг хан:

- Хүлэг би Хар харанхуйд ховсдуулсан хатан Дөргэний Хадан чиний өрцийг чинь нээж үхээр ёрд эзэмдүүлсэн зүрхийг чинь сугална.

Хар Үлэхү:

-(Хашгиран) Үхсэн хойно ч сүнс маань та нарын дээгүүр эргэлдэх болно.

Ариг бөх хан:

- Элээг ирэх бүрд сийчнэ.

Их хаан Мөнх:

-Хадан, Хар Үлэхү хан нарын аманд чулуу чихэн үхүүлтүгэй.

Муу тогоон хан:

-Амь өршөө. Алтан ургийн хан хөвүүд бидний амийг өршөө.

Их хатан Хутулуй:

-Алтан ургийн хан хөвгүдийн амийг өршөө. Алдас болно. Хаантан минь.

Хатан их Сорхагтан:

-Алтан төрөө гутаасан алтан ургийн хөвүүдийн алд биеийг аалзны дайтай хайрлаад яахав. Алтан дээд үнэний аялгууг гээсэн засгийг нь адуу малын дайтай үнэлээд яахав. Цагаан мөргүй хүнтэй айлыг царцаа голионы дайтай хайрлаад яахав.

Их хаан Мөнх:

- Хэнхдэг цээжийг чинь ярвал, хар ёроор зүрх чинь дүүрснийг үзнэ. Гавлын чинь аяга гашуун хилэнгээр уугина. Ариун андгай хорлолтой холилдон арз хорз болон тархинд чинь шуугина. Ариун цагаан, хайр энэрэл, алтан гэрэлт аялгуу алга. Алдарчээ. Урхагт булхай үүрлэсэн зүрхнүүдийн уг салаа салбарыг тастан хаях минь. Ургийн ураг хүртэл үндсээр суга татан таст. Аригбөх, Хүлэг, Хубилай хан дүү нар алтан ургийн үжсэн мөчрийг чавчиж хая. Хавханд орсон чоно хөлөө өөрөө тасаддаг шиг хан дүү та нар Муу тогооныг үдшийн сар бүү үзүүл, Мэлигийг үүрийн нар бүү харуул. Аваад яв!

Милэг хан:

- Мөнх хаан ах минь дөнгөж төрсөн хүүг минь бүү алаач!

(Хөгжим) (Харанхуйлал)

Хоёрдугаар үзэгдэл.

2. Их хатан огул хаймиш энгэр юугаа дэлдэв.

Тайз: Хээр газар. Их хаан Мөнх, Их хатан Сорхагтан, хан Хүлэг, Хубилай, Аригбөх, Жөн Мон Тоба, төрийн шүүгч Мэнгэсэр ноён, Гүюг хааны их хатан Огул Хаймиш, Төрийн бичгийн сайд Чинхай Чинсан бэхэ, Өгэдэйн хан хөвүүд Гүдэн, Халзай, Хадан, Мэлиг, Гүюгийн хан хөвүүд Нагу, Хажу, Хөхөө, Цагаадайн Хар Үлэхү, Муу тогоон тэдний угсааны Есөн Мөнх, Бүри болон хишигтэн цэргүүд байна.

Мэнгэсэр ноён:

- Эзэнт Гүрний өндөр төрд тэрсэлсэн алтан ургийн айлынхны өсөлсөн булхайг шүүн хэлэлцэж, тэнгэрийн дор тэргүүн юуг нь дарж, газрын халцгайд өвдөг юуг нь сөгтгөн, алтан язгуурт салбагар модны хараалд идэгдсэн салаа мөчрийн хорт алим жимсний хордуулах төвгийг тасдан ариун төрлийг аврах мөнх тэнгэрийн гүрний их хаан Мөнхийн зарлигийг сонстугай. Этгээд энэ айл Их Монголын Эзэнт Гүрний айл эрдэнийн эрдмээ гээж, анд хэмээх амин чанараа хаяж, гэрийн онолт хамтын хариуцлагаа нурааж, гэгээрлээс мунхаглал руу унаж, моныг гул болгон, огул биеийн уянга асган хоослов. Өглөгчийн шулуун дайн, өвгөдийн амжилтыг гутаагаад, өрсөлдөхийн халуун дайн Моныг харлуулаад хөх Монгол амин чанар үнс, үлтэг болгов. Айлыг тарааж хамтын хариуцлагыг хуйхлаад нийхэмийг хөөсрүүлж, нийгэмийг ургуулаад Их засгийг гутааж доройтуулаад жоргүй булхайнууд өөрсдийгөө засаг мэтээр зарлан гай гамшгийг бугшуулж, ядуугийн ясыг зовлонгоор буталж, олны махыг урж, жаягаар уялгагдсан олзыг цөөхүүлээ залгиж, булай, булхай, боульхайгаар бусдыг торлов. Өндөр дээдсийн үгийг хаяж Өгэдэй хаан эцгийнхээ нэрийг гутаасан хан хөвүүд тэднийг үндэс мөчиргүй болгох, Цагаадай ханы хүчийг зээлж, захиргаагаа алдсан тэдний үр үртсийг хийсгэх их хааны хагуу зарлигт нийтээр мөргөтүгэй. Алтан ургийн ясу ёсоор цус урсгахгүй цаазыг тулгав. Гүдэн, Халзай, Мэлиг, Муу тогоон, Есөн Мөнх, Бүри ханы нурууг нугалахтүн. Хадан, Хар Үлэхү хан нарын хар амыг шороо чулуугаар дүүргэн үхүүлэхтүн. Их хатан Огул Хаймиш, төрийн бичгийн сайд агсан Чингай Чинсан бэхэг хатан нарыг эсгийд боон усанд живүүлж үхүүлтүгэй. Их хаан Гүюгийн суу омгийг унаган Ширэмүн хантай үгсэн цэрэглэсэн Нагу, Хажу, Хөхөө хан нарыг нугасыг таслахтүн. Этгээд хатан хан нартай эвссэн далан долоон ноёдыг чавчин алтугай.

Их хатан эх Огул Хаймиш:

- Ээ, Хөх тэнгэр минь биднийгээ авар. Эзэн хаан Мөнх минь биднийгээ өршөө. Их төрийн шүүгч Мэнгэсэр минь ингэж болохгүй. (газар мөлхөнө)

Мэнгэсэр ноён:

-Хатуу цаазын дор язгуурын та хамгийн сүүлд хэлэх үг байвал өчтүгэй.

Их хатан эх Огул Хаймиш:

- Мөнх тэнгэр минь! Эзэнт төрийн их хатан явсан Огул Хаймиш миний мяндсан чинээ улаан амь тасраг ээ. Тасраг. Эзэнт төрийг эрхийг авсан их хаан Мөнх минь, эх хатан Сорхагтан бэхэ минь, өндөр заяатын үр удмыг л харин үлдээ. Хүүхэн хэвлийд минь хэвтсэн үрүүд минь тэнгэрийн үрс шүү дээ. Эх би хэвлэсэн болохоос их хааны цус эс шүү дээ. (Энгэр цээжээ балбана) Их хатан би хэнхдэг цээжээ хэнгэрэг болгон нүдэх минь хөх мөнх тэнгэр минь сонсоод өгөөч дээ. Эзэнт төрийн эзэд минь, их хатан би өвчүү цээж юугаа дэлдэхийг минь сонсоод өгөөч ээ. Үр удмыг минь өршөөгөөд өгөөч ээ. (Цурхиран уйлна) Бүгдийг нь бүү бүрэлгэ. Багачуудыг нь үлдээ. Гуйя.

Их хатан эх Сорхагтан:

-Хар амиа бодогч хар айлын хатуу булхайн үр үртэс амь нэгт гэр төрийн хураасан улсыг тараах болно. Булхай толбо туг хиарт байваас бүтэн төрийн өнгө гундана. Булай болон улай хүсэх үр үлдвээс бүхний амгалан багадаж бүтэн нойр зовлон болно. Бузын өсний үс үлдвээс бумны хайр айдас олно. Этгээд булхай нарт амь өгөх болвоос их төрийн ирээдүй зовно. Эрх эдлүүлэх гэвэл та нар их хэргийг шийдэх тэнгэр дутна.

Их хатан эх Огул Хаймиш:

-Алтан үнэний аялгуу амьдралын дуун болоогүй үрс Нагу, Хажу, Хөхөө хан хөвүүд минь дээ.. Ай энэ цагийн зовлон, номын оройгүй өссөн хөвүүд та нар минь, мунхаг зовлонгийн адагт унасан хан хөвүүд та нар минь унаж яваа морио бүдрэхийг угтан мэдрэх ухаангүй болсон хөвүүд та нар минь үр удмаараа сүйрэх болжээ. Гүжир хар хүзүүг чинь хатан эх чинь татаад ч дийлээгүй. Харж байна уу та нар. Дөргүй бух шиг зүтгэсэн миний мунхаг хөвүүд минь мэдэв үү та нар? Хатан эхийнхээ үнэн үгийг үзэв үү?

Нагу, Хажу, Хөхөө хан нар:

-Их хатан эх минь, Өршөө , өршөө , Өршөө. (Уйлалдана. Хөхөө нас бага байна)

Их хатан эх Огул Хаймиш:

-Сэцэн бөө Сорхагтан минь, чи минь Нангиагийн орон Жиндэд цөлөгдөөгүй бол хайран хан хөвгүүдийн алтан гавал хар толгой болон хувирахгүй л байх байсан даа. Ай азгүй хан хөвүүд, азгүй хатан миний төр. Мэргэн цэцэн бөө бэхэ минь, Толуй ханы хажир үнэний өрх гэрийн сургууль хаагдаж, харь чи одоогүй сэн бол миний хөвгүүд мунхагт живэхгүй байх байсан даа. Ай Чингис хаан эзний алтан төр алтан цагийг үзэх хувьгүй хан хөвгүүд минь. Мунхаг хатан эхийгээ өршөө. Тэнгэрийн хөвүүдээ би алтан дээдийн аялгуугаар амлуулж өвлүүлж өсгөсөнгүй. Мунхаг хар толгой би үрсээ үхэхийг үзэх нь. Үр удмаа мөхөхийг харах нь.. (Уйлна)

Гүдэн хан:

-Идэр залуу нас ирвэс базах бөх энэ биед цогцловч бодсон минь бодьгүй. Будан мэт хөөрөн дэгдэнэ. Гишгэсэн минь хагарч, алхсан минь ангалд хүргэнэ. Зогссон ч занганд орно. Ай юутай их гуниг вэ? Үнэнээс төөрнө гэдэг энэ үү? Өгэдэй хаан эцгийн удмыг үхлийн замд би

оруулчихлаа гэж үү? Тэнгэр намайг ниргэг. Алтан төрөөс ад үзэгдсэн хувь хатад эм хүүхдүүдтэйгээ, газрын гүрнээс хөөгдөн, ертөнцийн саваас хасагдахаар хаа хүрэх вэ? Хаан аавын халуун цагаан мөрийг хан хөвүүн Гүдэн би харлуулав. Үйл бүхэн минь үнэн юм шиг атал худал. Өршөөлгүй тамын ёроол руу Өгэдэй удмыг гулдран гулруулна. Ай, аймшигт ёр биднийг орхиогүйг ах хаан Гүюг минь мэдсэн байна. Өршөө, хаан эцэг Өгэдэй та минь, хаан ах Гүюг та минь. Хан Гүдэн би гэмшив. Мөнх тэнгэрийн хүч минь муу ёрийн мунхагт эзэмдүүлсэн тэнгэрийн ач үрсийнхээ сүнсийг тамын амнаас татаж ав.

Чинхай Чинсан бэхэ:

- Мөнх хөх тэнгэр минь ээ! Чингис хаан, Бөртэ хатнаас төрсөн Цэцэйхэн Бэхэ, Ойрадын түрүү Хутугийн охин Чинхай Чинсан бэхэ би мөнх тэнгэр хүрэх үгээ өчье. Өгүүлшгүй хүчний дээд минь, худлаас үнэнийг сугалж, буртгаас ариуныг хайлж, амь наана там цаана ач үрсийн алтан аялгуут сүлд сүнстэй зууралдсан, хүлээ уяаг тасчиж хайрла. Хаадын ач үрс бүгдийг харанхуй тамын нүхнээс булааж ав. Гэгээ гэрэл бидэнд мяндасын төдий үлдсэн бол гохдож дэгээдэж авар. Дэм дэмэндээ эрчлэгдэж дэлхийг орхин дээшилье. Тэнгэрт морилсон дээдсүүд минь татаж биднийгээ ав. Үнэн бий надад. Үнэмшүүлэхийг үл хүсэв би. Өчил үгний минь үнэнг үхэл ялган салгаг.

Их хатан Огул Хаймиш:

-Төрийн тамга сахисан хатан би төв төрийг бүү зовоо гэж хаадын хабсу тамгыг тэвэрч хааны өргөмжлөлд ирсэн. Алдар гавьяа биш ч гэлээ эх миний сэтгэл хан хөвүүдийнхээ амийг хаан танаас гуйх гэж алтан өргөөнд ирсэн юм сан. Ачлалт хаан минь эх миний сэтгэлийг анагааж хайрла. Авралт тэнгэрээс миний сүнсийг бүү холтго. Хаан Гүюгийн хөвүүдийн нэгийг нь ч болтугай амийг хэлтрүүл. Мөнх хаан чиний дэргэд тэнгэрийн тэр хөвгүүн чиний улсыг үзээд тэгээд өөрийнхөө үхлээр үхэж тэнгэрт харьж ирэг. Чингисийн сайн цагийг чамайг авч ирэхийг үзэг.

Нагу хан:

-Ээ мөнх тэнгэр минь, амийг минь хэлтрүүл.

Их хаан Мөнх:

-Эх хатан чиний сүүлчийн үгийг их хаан би авав. (Мэнгэсэр лүү гараараа дохино)

Хадан хан:

-Их гүрний хаан Мөнх минь, Өгэдэй хаан, Цагаадай ханы ач зээг ав. Амийг нь өршөө.

(Их хаан гараа өргөөд буулгана. Хааны цэргүүд Гүдэн, Халзай, Хадан, Хар Үлэхү, Муу тогоон нарыг цаазаар аваачна. Цааз Мэлиг дээр ирнэ)

Милэг хан:

-Үүрч өсгөсөн Мөнх хаан авга ахынхаа өөдөөс үзүүрт зэв зүглүүлсэн өөдгүй муу Мэлиг би

өглөөний нарны бүтэн биеийг үзэхгүй хувь үгүй. Өнгөт нарны бүтэн биеийг үзсэн шиг үзэхсэн. Гийгүүлэгч нарны бие тэнгэр тэмтрэн айсуй. Харанхуй цайрна. Гэгээн эрчимт үзэсгэлэнт цацрагийг нь ганцхан мөч үзэх эрх өгөөч. Авга ах минь.

(Их хаан Мөнх гараа дээр өргөнө)

Мэнгэсэр ноён:

-Түр хүлээ. Хаан руу харвах сумаа цуцалсан Милэг чамд Эзэнт гүрний их хаан үхлийн чинь өмнө өглөөний нар цацрагийн үзүүрийг үзэх хувь өгөв. Их хааны хайр хишгийг чи хүрттүгэй.

(Мэлигийг цаазлах гэж байсан хааны цэрэг Мэнгэсэр ноёнд захирагдана)

Мэлиг хан:

-Их Монголын Эзэнт Гүрний дээр миний үзээгүй гэгээн их наран мандаг.

(Мэлигийг хааны цэрэг цаазална) (Мэнгэсэр тэргүүтэй хааны цэргүүд Их хатан эх Огул Хаймиш, Чинхай Чинсан бэхэ нарын дэргэд ирнэ. Чинхай Чинсан бэхэ цэх шулуун алхана. Огул Хаймиш хан хөвүүдээ харан цэргүүдэд туугдан явна)

Их хатан эх Сорхагтан:

-Мөнх тэнгэр минь! Чинхай Чинсан бэхэ, хааны зээ охин минь! Их хаан Мөнх минь их хааны зээ охин хааны амийг хөнөөх тэрслээчдийн хань хамсаатанд сэжиглэгдэн хилсээр хөнөөгджээ. Мөрний гүнээс Чинсан бэхэгийн алтан аялгуу дуурсан ухаа ягаан мандмал гэрэл мандлын дээгүүр эргэлдээд хан хөвгүүдийн зурвас цагаан гэрлэн сүнсийг хураан хөх тэнгэр лүү одлоо. Ээ! Хөх тэнгэр минь. Тэднийг сансрын харанхуйгаас ав. (Нүдээ дарна)

Их хаан Мөнх:

- Мөнх хөх тэнгэр минь!

Мэнгэсэр ноён:

-Их хаан эзэн минь үгсэн цэрэглэсэн далан долоон ноёдыг цаазлав. Их цэргийн хатуу ерэн есөн хүрээний цаана цагаан тэмээ унасан Канлы аймгийн Хишиг нэрт мөнөөх тэмээчин их хаанд айлтгах үг байна хэмээн цагаан тэмээгээ унан нааш цааш тэшжээ. Ширэмүн, Нагу нарыг цэрэглэн гурав хоногийн газарт ирэхэд энэ Канлы аймгийн Хишиг нэрт тэмээчин ирж бидэнд ирж хэлсэн.

Их хаан Мөнх:

-Өмнө минь авч ир.

Хишигт:

-(Тэмээчин хааны өмнө ирж сөгдөнө) Төрийн бичгийн сайд Чинхай Чинсан бэхэ буруугүй. Хаан тан руу халдахаар цэрэглэснийг Канлы аймгийн тэмээчин Хишиг намайг Чинхай Чинсан бэхэ хаан танд хэл өг хэмээн явуулсан билээ. Миний хатан бэхэ алтан өргөө рүү хүлээтэй явсныг хээр тэмээгээ хариулж яваад гэртээ ирээд мэдлээ. Үнэн үгээ гэрчилье. Хаан Чингисийн мөнгөн буйл энэ байна. Хатан Чинхай Чинсан бэхэ надад өгөхдөө хадгалж яв. Миний үнэнг өөртөө агуулж яв хэмээн шагнасан юм.

Их хаан Мөнх:

-(Нулимсаа арчина) Тэмээчин чи хожимджээ.

Мэнгэсэр ноён:

- Энэ үгээ чи бидэнд их мэдээ дуулгахдаа юунд эс хэлэв?

Хишиг:

- Хатан бэхэ хаанд өөрийгөө хэлэх хэрэггүй гэсэн. Өршөө. Энэ буйлыг танд өргөө.

Их хаан Мөнх:

-Канлы аймгийн тэмээчин чамд иржээ. Үнэнч иргүн чамайг бэхэ хатан шагнав. Яв даа. Үнэнч албат минь. (Хишиг явна) Тэнгэрийн дор төрсөн хөх нуруутын эздийн сүнс амгалан байх болтугай.

Их хатан эх Сорхагтан:

-Их хаан Мөнх минь, цаазын үйлийг зогсоо. Мөнх тэнгэр тайвширна.

Хубилай хан:

-Их хаан ах минь, Хаан Өгэдэй, хан Цагаадайн алтан ургийн үр үндсийг үүрд үгүй хийх хэрэггүй. Өр зүрх өвдөн шаналав.

Их хаан Мөнх:

-Нар энэ орчлон дэлхийг гийгүүлж байдгийн адил Бат хан бид хоёрын эрх мэдэл бүхий улс түмэнд хамаарна. Бид нэг толгойн хоёр нүд адил тус тусдаа хэдий ч нэг л зүгт хардаг болой. Цагаадайн угсааны Есөн мөнх, Бүри нарыг Бат ханд хүргэ. Хэрхэхийг тэр мэдэг. Хаан би Өгэдэй хаан, Цагаадай ханы ач гучийн амийг өршөөлөө. Нагу ханыг Сүн улс руу дайлах дайны өмнийн цэрэгт одуул. Ширэмүн Хажу хан нарыг Хархориноос баруун биед Шар горхины адагт насаар нь хорь. Нялх Хөхөө хан хүүг Хубилай чи эрдэмд сургаж Эзэнт төрийг минь мандахыг үзүүлтүгэй.

Их хатан эх Сорхагтан:

- Мөнх тэнгэр минь!

Хубилай хан:

- Алтан ургийн хан хүү чамайг би алтан аялгуугаар амлуулан өсгөнө. (Нялх Хөхөөг Хубилай тэврэн авна.Нагу Хажу хан нар тэнгэрт залбиран мөргөнө)

Их хаан Мөнх:

- Их Монгол Эзэнт Гүрний их тайлгыг Их хаан Мөнх би үйлдсү. Эзэнт гүрний төвшитгөгч Мөнх их хааны зарлигийг сонстугай. Их төрийн их тахилга тайлгыг ирэх ес дэх хоногт зарлав. Эл өдөр эзэнт гүрний иргүн хүмүүн бүр амарч, мөн амьтан адуу малыг үл зүтгүүлж, ачаа хөсөг үл зөөлгөх ба амьтны амь тэвчин ан гөрөө үл агнан, мод үл хугалан, мөчир үл тастах, газарт гадас үл хатгатугай! (Хан дүү нар түүний дэргэд зогсоно)

Хубилай хан:

-(Хөхөө хан хүү хуруугаараа тэнгэр заана) Тийм байна. Нар мандлаа (Хөгжим)

(Харанхуйлал)

Гуравдугаар үзэгдэл.

3. Их хатан эх сорхагтан алтан дээд гэриэт амьд хүн ном бүтээв

Тайз: Их хааны өргөө. Их хаан Мөнх, Их хатан эх Сорхагтан бэхэ, Бага хатан эх Мүхэ, Их хатан Хутулуй, Хүлэг, Хубилай, Аригбөх, Жөн Мон Тоба, Ханхүү Хөхөө болон хан хөвүүдийн хатад нар байна.

Их хатан эх Сорхагтан:

-Есөн зуун мянган жилийн тэртээ Эрэгнэгийн улаан бургадад хөх нуруут хүүхэд мэндэлжээ. Эрэгнэгийн хондоос хойш нүүжээ. Алтай, Хангай, Хар жодоотоос есөн мөрөнд ирж үржсэн ажгуу. Хөх нуруутнууд нөмрөгөө дэуло гэжээ. Агуу гоо бүхнийг нэүрит гэмой. Найман зуун мянган жилийн олз нэүрит үнэнийг манай нуруутнууд тарвайж арвайж олоогүй ажгуу. Таван мөчний яс элэгдтэл хүсэж, шүлсээ шимэн ундаалж, шүдээ мөлжин хооллож, учрыг олж, усыг илч болгон олсон ажгуу. Буман жилийн наст Алтан дээд үнэний аялгууг хөх нуруутнууд Өтүгэ, Мугулюй, Манукол, Хөх Монголын дөрвөн их улирлыг туулан ирэхдээ ертөнц тэнгэрээ олж таньж, ясу ёсыг бүтээн огулаас дотахуйн хүртэл олзын дээдээ хураасан билээ. Тэнгэрийн зарлигийн жаягаар хаан эрдэнэд мэргэшсэн Огулаас дотахуйн хүртэл долоон дээд эцгийнхээ, эзэн хаан Чингисийн найм дахь онож үйлдэхүйн зөнд мөр гүн зэрэгт шалгарсан, газар болоод огторгуйн онолд иргүн зэрэгт хүрсэн, бие оюуны зөнгөөр бөө бөхөд шалгарсан, хар зөнгийн онолд хаан зэрэгт онцгойрсон, мянга найман зуун ерэн найман мэргэшлээр нэүрит их засгийн удирдагч зэрэгт тодорсон Эзэнт Гүрний Их хаан Мөнх хөвүүндээ Хөх Монголыг төрөөр бадраах хутагтай нэүрит засгийн алтан дээд үнэний аялгуу түм наслах ном өргөж байна би. Алтан дээд аялгуут гэриэг алдахаас сэргийлж амьд хүн ном зохиов би. Алтан ургийн хөвүүн Жөн Мон Тобогийн алтан гавал юунд агуулан нуув. Хан эцэг Толуй, бага хатан Мүхэн отгон хөвүүн Жөн Мон Тоба ургийн урагт амнаас ам дамжуулан үеэс үед цээжилж алтан тархиндаа агуулан авч явах боллоо. (Жөн Мон Тоба босно)

Жөн Мон Тоба:

- Анхны амь үүссэн гэх домогт манай Алтай Тоулын орон Хасхах Ёл уулын Тоулчу мэргүн, Эзэнт Гүрний хаан Чингис нарын ач Жөн Мон Тоба би билээ. Эцэг минь, Төр түшигч Хан Толуй, Эх минь засагч бага хатан Мүхэ билээ. Их хатан эх Сорхагтан бэхэ намайг алтан аялгуугаар амлуулан бойжуулав. Алтан аялгууг надаас автугай.

Их хатан эх Сорхагтан:

- Алтан аялгуут Жөн Мон Тоба аялгуу эхлүүлтүгэй.

Жөн Мон Тоба:

-Их Монгол улс үргэлжийн мөнхөд босоо орших тэнгэрийн хууль болбоос Их засаг. Их засахуйн мэдлэгийн дээд нь чин үнэн, чу үнэн, хажир үнэн хэмээх гурван үнэн. Орчлон ертөнцөд байгаа бүхэн чин үнэн. Орчлон ертөнцөд байгаа бүхэн хувирч өөрчлөгдөх чу үнэн.

Орчлон ертөнцийн чин үнэн, чу үнэн хүмүүний амьдралд орчилдох нь хажир үнэн болно. Оршихуйн гурван үнэн өөрөө Алтан дээд үнэн мөн. Улсын үндэс нь зон ард, иш нь айл ард, цомирлог нь гэгээрэл мөн. Тэнгэрт мөнхөд тэмүүлэн соёолох босоо энэ жаяг болбоос тэнгэрт төрөх заяа мөн. Оршихуйн гурван үнэн бол Их засгийн жаяг мөн билээ.

Их хаан Мөнх:

-Ухаант удган эх минь, гэгээн номч хатан эх минь, Ардын билэг аман ухаанаас угтай өвгөдийн сэдсэн элчийн аманд үгийг нуух эрдмийг их зэрэгт хүргэсэн тод зөнт хатан эх минь. Аяа их гайхамшиг. Алтан өргөөнд хурсан алтан ургийнхан минь Алтан дээд гэриэ мөнх оршихуйгаа олов. Хурай.

Бүгд цугаар:

-Хурай..., Хурай..., Хурай...,

Их хатан эх Сорхагтан:

-Нар сарны шим хөрсийг гэрэлтүүлээд

Найралт үр хэрхэн боловсорч соёолоод

Найман зүгтээ цоморлигоо дэлгэрэх мэт

Тэнгэрийн тэр хууль жаягаар тэтгэгдэх

Тэнгэр дээд заяанд өөд татах

Удаах нь оюун ухааныг боловсруулах

Эцэст нь оюун ухааныг дэвшүүлэх мөн болно. За Жөн Мөн Тобо алтан өргөөнд хурагсадад Алтан Дээд гэриэг дагуулан аялгуулан дуудтугай.

Жөн Мөн Тоба:

- Намайг дагаад дуудаарай

Мөнх тэнгэрт төрөх хүч үнэн

Мөнх тэнгэрийн хүсэл таалал үнэн

Мөнх тэнгэр өөрөө оюун ухаан үнэн.

Бүгд цугаар:

- (Хаанаас бусад)

Мөнх тэнгэрт төрөх хүч үнэн

Мөнх тэнгэрийн хүсэл таалал үнэн

Мөнх тэнгэр өөрөө оюун ухаан үнэн.

Жөн Мөн Тоба:

- Мөнх тэнгэрийн улс Монгол үнэн.

Бүгд цугаар:

- (Хаанаас бусад) Мөнх тэнгэрийн улс Монгол үнэн.

Жөн Мөн тоба:

- Жөн Мөн Тоба би алтан аялгууг цааш хөтлөө.

Гэгээн тархи болбоос дээд бодис мөн

Гэгээрэл болбоос дээд мэдлэг мөн.

Гэгээрэх болбоос дээд тэнгэрт хүрэх мөн.

Бүгд цугаар:

- (Хаанаас бусад)

Гэгээн тархи болбоос дээд бодис мөн

Гэгээрэл болбоос дээд мэдлэг мөн.

Гэгээрэх болбоос дээд тэнгэрт хүрэх мөн.

Жөн Мөн Тоба:

- Гэгээрүүлэх иргүн болбоос хөх нуруутнууд мөн.

Бүгд цугаар:

- (Хаанаас бусад) Гэгээрүүлэх иргүн болбоос хөх нуруутнууд мөн.

Их хатан эх Сорхагтан:

-Чин үнэн. Маш сайн.

Гэгээрсэн улс үндэстэн болбоос

Хүсэл зорилго бүхий ард түмний иргүншил

Гэгээрсэн ард түмэн болбоос

Хүслийн зүйт тэнгэрт тэмүүлэх иргүнүүд

Гэгээрсэн улс үндэстэн болбоос

Хүслийн орой мөнх тэнгэрт хүмүүнийг хүрэх ил ир. Хурай...Хурай...Хурай...

Бүгд цугаар:

-Хурай...Хурай...Хурай...

Их хатан эх Сорхагтан:

-Энгийн нэгэн элсний ширхэгт урт, өргөн, үүсэл, оршил, хувирал амин эрчим бий. Нүдэн дусал усанд ч хаяа, гүн, мандал, ууршил, хөлдөл урсгал амин эрчим хур бий. Үсний үзүүрт дэх агаарт ч хүнд, хөнгөн, дулаан, хоол хор хур эзэрхэл ноёрхол тохируулга бий. Жөн Мон Тоба амин хүрдэнг дуудтугай.

Их хатан Сорхагтан:

- Таван амин хүчний хүрд тайлан суутугай

Нарнаас удамшил зөв хүчин аваад амин хүрдэндээ хурааж

Сарнаас удамшил зөв хүчин аваад үржихүйн хүрдэндээ хурааж

Сүүнээс удамшил зөв хүчин аваад амьдралын хүрдэндээ хурааж

Газраас удамшил зөв хүчин аваад огул биеийн хүрдэндээ хурааж

Их засахуйгаас удамшил зөв хүчин аваад гавлын хүрдэндээ хурааж мон амин чанарыг олно.

Их хаан Мөнх:

- Мөн. Хөх толбот хүн нар наран, саран, сүүн эх, газар, их засахуйгаас удамшил зөв хүчин авч байж бугшмал хэцүү явдалгүй төвшин сайхны цаг уур орон зайн улс болму. Иргүн мэдлэгээр боловсрон орон зайндаа эзэгнэхүй аялгууг их хатан эх минь та дуудаач. Өрөвгөр жаахандаа өвөр тань хан хөвүүд цуглараад үстэй дээлээр хучуулаад өвлийн уртыг жаргаадаг сан.

Их хатан Сорхагтан:

- Бэлтрэг амьтан барих гүн болж, мэргэн гарах болбоос боловсрол нь чоно бөгөөд хөвч хангайд эзэгнэнэ. Тугал цадаж янцаглаж, өлсөж мөргөлдөх мөрд гүн болж мэргэн гарах болбоос боловсрол нь үхэр бөгөөд бэлчээр эзэгнэнэ. Авгалдай цус шүүсийг сорж үржих мөрд гүн болж мэргэн гарах болбоос боловсрол нь ялаа бөгөөд өвс чийг усанд эзэгнэнэ. Араатан, мал, авгалдай зэрэг амин- эхт аль ч амьтанд орчноо эзэгнэх мөргүн боловсрол байдаг. Амь,

амь зуулга, амьдрал гурвыг хоол, хор, тархи гурваар эзэгнэдэг.

Амин –эхт аль ч амьтанаас иргүн төрөхдөө таван түвшинтээр боловсорно.

Хубилай хан:

- Хөхөө хан хүү чи миний дуудаж өгсөн аялтан аялгууг Их хаан ах, Их хатан эх, энэ өргөөнд бүрэлдсэн их ургийнханд дуудаж өгөх үү?

Хөхөө хан хүү:

- Жа, Хаан та чихээ нааш, хатан та мэлмийгээ нааш нь, хамаг бүгд хүзүүгээ нааш болготугай. Идэхийг зорилгоо болгогч босоо гөрөөсийг хижи гэнэ.

Идсэндээ сэтгэл ханагч босоо гөрөөсийг хүн гэнэ.

Ир нь бадарч гэгээрэлд гүнзийрэгчийг иргүн гэнэ.

Дэвших сайн төрөл дээд сайн заяа энэ мөн

Хоолоо олоход хоосролыг ашиглагчийг булай гэнэ

Хоолоо булаалгаж дасагчийг булхай гэнэ

Хоолыг булаан идэгчийг боульхай гэнэ

Дорой муу төрөл дорд муу заяа тэр мөн.

Хүлэг хан:

- Хараач гэм. Хэлмэн цолмон мөн шүү. Хов хөөцөлдөж хонжоо хайваас боульхайд тоологдоно. Хонь мал хулгайлваас булхай болно. Хоньчин адуучдаар хэсэж ходоод цатгаваас булай болно. Тийм үү зөнгүн дүү минь.

Хөхөө ханхүү:

-Тийм. Хориотой энэ үйлийг Чингис хаан цаазалсан.

Их хаан Мөнх:

-Өнчин өрөөл дор Хөхөө хөвүүн өсөвч өвгөдийн аялгуунд гэгээртүгэй.

Бүгд цугаар:

- Зөн гүн хүү хурай... хурай... хурай...

Их хаан Мөнх:

-Булгаараа сонстугай.

Босоо тэр хижиг гөрөөсийг

Боловсорсон иргүн болгох

Хөх тэнгэрийн хүсэл тааллын зүйн

Хөх монгол улсын иргүн болгох мөн болно.

Энх амрын өсхэ хурдаар Их гүрэн үүсэх гэрийн онолоор өвгөдийн тайлсан төрийг онохуйг Алтан гэриэт Жөн Мөн Тоба аялгуулан дуудсугай. Их хаан би бээр алтан аялгуун хөг хаан биеэр дуурсахад дурлана.

Жөн Мөн Тоба:

- Их хаан ах минь. Эгшиглэн дуудсу би.

Гэрийн онолт ур дүйтэн улсуудыг огул гэмү

Гийчилж ирэгсдийг огул болгодог цаг уур орон зайг гэр гэмү

Хамтын хариуцлагаар улсаа хамгаалахыг төрөөн гэмү

Тэнгэрийн зарлигаар амьдралдаа харилцаа болгохыг уман гэмү

Төрөөн, уман хоёрыг гэрийн онолоор нийхэм болгочийг башхараачу гэмү

Их Монгол улс ерэн таван уман билээ.

Амин ний хэмээр хамгаалагддаг ерэн уман, уман улс

Өвгөдийн хүрсэн иэгээр хамгаалагддаг.

Алтан таван уман улс хамтын башхараачу дор амин хэм болсон

Их Монгол улс болохыг улс гэр гэмү. Гэр төр гэмү.

Хамтын башхараачу бол мон амин чанар билээ.

Аминаар хамгаалж, моныг голлож, умнаар жигүүрлэж байж,

Гэр хэмээх орон зай, цаг уурт зуун найман төвшин сайхныг тогтоодог

Гарцаагүй тэр байдлыг гэрийн онол гэмү.

Их хаан Мөнх:

- Зүйтэй. Их хаан миний үгийг сонстугай.

Хөх нуруутны хөх монгол улс болбоос

Хөх мөнх тэнгэрийн хуулиар

Хөрстийг энхжүүлэх, хүмүүнийг өөд татах

Хүчийг өгөх Их Монгол Эзэнт гүрэн мөн. Уухай...

Бүгд цугаар:

- Уухай... Уухай... Уухай...

Их хаан Мөнх:

-Агуу их эзэнт гүрэнд хуран ирсэн улс орон иргэн тэд алтан оосорт гэрт гийчилж ирсэн хүмүүн төрөлхтөнгүүд тэд авралаа олон гэгээрэн гийж Их Монгол Эзэнт төрөөр бадраах хутагтай алтан дээд үнэний аялгуунд оломлогдож мөнх хөх тэнгэрт хүрэх болтугай. Хурай.

Бүгд цугаар:

-Хурай... Хурай... Хурай...

Хатан эх Сорхагтан:

- Алтан дээд аялгуут Жөн Мөн Тобаг алтан төрийн дэргэд авч явахтүн. Тоул Алтайн Тоулчу мэргүний ач чи үр удамдаа ёст илд цээжлүүлж хадгалтугай. Их хаан Мөнх чи ёрын бүхнээс нууж хамгаалтугай. Мөнх их хаан чи Алтан дээд үнэний аялгуугаар алсад мөр цагаан үлдтүгэй. Хурай.

Бүгд цугаар:

- Хурай...Хурай...Хурай...

Их хаан Мөнх:

- Алд биений алтыг ахуй хэвлий юундаа бүрэлдүүлсэн ачлалт эх тандаа мөргөмү. Алтан төрийн агуу хэлмэлт их хатан эх бөө сэцэн бэхэ эх тандаа мөргөмү. Эгэмнээс минь татаж та намайг их төрийн хаан болов. Өндөр төрийн өргөөний алтан оосрыг билгээр бүтээж. Өгүүлшгүй их ачлалыг өргөв..Их хатан эх тандаа мөргөмү.

(Их хаан их хатан эхдээ мөргөнө. Хан хөвүүд Хүлэг, Хубилай, Аригбөх нар эхдээ мөргөнө)

Хан хөвүүд цугаар:

-Их хатан эх таны өгүүлшгүй ачлалд мөргөмү. (Суудалдаа сууна)

Их хаан Мөнх:

-(Өргөөнд хурагсадад) Эзэнт Гүрний их хаан Мөнх миний зарлигийг сонстугай. Хөх монголыг бадраах күүн долоон биет их засагтай эзэн Чингис хааны их монгол, уялгын онолоор уягдан, гэрийн онолоор гэгээрэх тэнгэрийн бөө тархитан билээ. Үндэсний алтан дээд гэриэ жаягт, гэр онгондоо багтах мөнх тэнгэрийн иэ улс болбоос буган соёлт, мянган хүнст, мон ухамсарт, огуул зөнт, тэнгэр тархит малчин бөө күүн нар билээ. Буман өршөөлийн орон нар сарны газарт хөх нуруутнуудын нээсэн алтан дээд аялгууг мон ухамсарт тархинаас төрсөн ээжтэйгээ хамтад есөнтээ санах ариун ёстонгууд, Чингис хаан эрдэнийг ээж маань эргэн төрүүлснийг аавтайгаа хамт хоногт есөн удаа санаж, Алтан дээд гэриэг өвлийн зуун найман хоногт гучин зургаан удаа тайлж, тэнгэр тархит орон гэдгээ бататгаж, хаан дор хамтдаа жилд гурван удаа гэгээрэн тайлж, ерэн есөн тэнгэрээ тахихтүн. Их монгол Эзэнт гүрэн дэлхийчлэн гэгээрүүлэх цоо эл гарагч Чингисийн улс билээ. Их дэлхийн хэн боловч хорловоос сүйрэхүйд унах тэнгэрийн зурхайт орон билээ. Ухааныг уухайлахтүн. Улсыг хурайлахтүн.

Бүгд цугаар:

- Уухай... Уухай... Уухай... Хурай... Хурай... Хурай... (Хөгжим) (Харанхуйлал)

Дөрөвдүгээр үзэгдэл.

4. Их монгол гүрэн батжиж, их хаан гүрний сан хөмрөгийг түгээв.

Тайз: Хөдөө хээр буудаллан байна. Их хаан Мөнх, Их хатан Хутулай, Хатан эх Сорхагтан, бага хатан Мүхэ, Хубилай хан, Хубилайн хатан Чабун, Жөн Мон Тоба, Мөнх хааны хүү Ширхэ, Аригун ноён, Нүлэн ноён, Салжидай ноён, Өлжий бэхэ, Армяны ван Гетум, Гуулин улсын Чун Нё Рол, санваартан Гильом Де Рубрук нар болон ордны албат нар байна.

Нүлэн ноён:

-Их хаан эзэнд Гуулин улсын ван Ко-Жон найрамдья хэмээн төрсөн хөвүүн Чун Нё Ролоо дөчин ноёд ихэстэйгээ ирүүлэв. (Их хаан оруул хэмээн гараараа дохив. Нүлэн ноён алга ташив. Гуулин улсын ая дуу эгшиглэж, солонгос эмэгтэйчүүд хөгжмийн аянд бүжиглэнэ. Хааны өмнө бэлэг сэлт өргөнө. Чун Нё Рол орж ирэх ба хааны өмнө сөгдөнө)

Их хаан Мөнх:

- Хэрэв танай ван дайсагнан тэрсэлснээ гэмшин Их Эзэнт Гүрний ясу зарлигийг даган найрамдья хэмээн чин сэтгэл агуулж буй бол Гуулин улсын вангийн хөвүүн чи хаан эцэгтээ илч зартугай. Их Монголын Эзэнт Гүрний хаан Мөнх би танай Гуулин улс руу дайлахаа зогсоон энхийг олгоё. Харин Гуулин улсын хан хүү чи миний эзэнт гүрний хот Хархоринд танж болон суутугай.

Чун Нё Рол:

-Эзэнт гүрний их хаан таны нигүүлсэл өршөөл тань агуу ажээ. Их хаан та Манай Гуулин улсад энх амгаланг соёрхож байгаад хаан хүү Чун Нё Рол би дуулаад өршөөл энэрэл дор тань сөгдөн мөргөмү. Хааны зарлигаар хан хүү би их хотод үлдсү. (Олон мөргөнө)

Их хаан Мөнх:

-Ордны ноён Нүлүн чамд тохирох суудлыг олгох болно. (Нүлүн ноёд дохино. Гуулин улсын хан хүүд Нүлүн суудал заана. Бүжиглэгч эмс ордны доод биеэнд очин сөгдөн сууна)

Нүлүн ноён:

- (Их хаанд хандана)Эзэнт Гүрэнд дагаар орохоор Армяны ван нэгдүгээр Гетум хүрэлцэн иржээ. (Их хаан толгой дохино. Нүлүн ноён алга ташина)

Гетум ван:

-(Армяны эмс бүжиглэн хааны өмнө эд эрдэнэс өргөнө. Ван Гетум хаанд ёсолно) Энэ дэлхийг захирах эрхийг бурханаас танд оноосон болохыг ван Гетум би мэдэв. Ханьцашгүй хүчит Гүрэнд манай Армян улс, ард иргэд багтан дэлхийн агуу их хаан таны төр дор захирагдахыг хүсэв.

Их хаан Мөнх:

- Мөнх тэнгэрийн суу хүчинд итгэн ирсэн ван Гетум чиний улсыг миний их гүрэн өмгөөлөл, өршөөлдөө авлаа. Мэргүн дайчин ван чиний ухааны билгээр танай ард түмэн тэнгэрээр тэтгэгдэн энх амгалангийн өсөх хурдыг үүнээс хойш хүртэх боллоо.

Ван Гетум:

-Их Монголын Эзэнт гүрний их хаан танд мөргөж байна. (Гетум ван мөргөнө. Хаан таалан толгой дохино. Ван Гетум Нүлүн ноён суудал заана. Эмсүүд бөхийн ёсолсоор өргөөний доод биенд сөгдөн сууна)

Нүлүн ноён:

-Их Гүрэнд дагаар орохоо илэрхийлэхээр Аннамьн хааны агь Чан Пи ирэв ээ. (Нүлүн ноён алга ташина.Вьетнам эмс дуу бүжгийн дор хааны өмнө бэлэг сэлт өргөнө. Агь Чан Пи хаанд мөргөнө)

Агь Чан Пи:

- Их хааны сүр хүчинд сөгдөж манай Аннам улс таны Эзэнт төрийн зарлиг хуулийг бишрэн дагах захирагдах болсоноо агь Чан Пи эцгийнхээ өмнөөс ирж илэрхийлэв. Аннамьн ард түмэнг хүлээн авна уу?

Их хаан Мөнх:

- Их гүрэнд хязгаарын усны улс ирсэнд их хаан би баясав.Та улс эзэнт гүрэнд үнэнчээ илэрхийлэн гурван жилд нэг удаа алба татвар өргөхтүн.

Агь Чан Пи:

- Их Монгол Эзэнт Гүрний агуу хаан эзний өршөөлд манай Аннам улс багтаж байгаад ихэд талархав. (Вьетнамьн агьд Нүлүн ноён суудал заана.Эмсүүд өргөөний доод биед ирж сөгдөн сууна)

Нүлүн ноён:

-(Их хаанд хандан) Их хаан танд бараалхахаар... (Их хаан гараа өргөн болиулна. Нүлүн ноён ёслоод өөрийн суудалд сууна)

Их хаан Мөнх:

- Надад бараалхахыг хүсэгчдийг дараа хүлээн авья. Харин Хан Хубилай чиний ухаан билиг олз омгийг хаан би сонсохыг хүснэ.

Хубилай хан:

-(Хубилай хааны өмнө ирнэ. Алга ташина. Хятад албатууд том даавуун дээр хотын гоёмсог зураг барин хааны өмнө газар дэлгэнэ. Бүгд сөгдөнө) Эзэнт гүрний их хаан Мөнх таны зарлигаар Хан Хубилай би өмнөдөд Шанду хотыг бүтээж эхлэв. Суумлын ертөнцийн ахуйг хувиргах ухааныг олов. Суумлын ертөнцийн хүмүүнийг асрах ухааныг турших цаг удахгүй бүтнэ.

Их хаан Мөнх:

-Асар бэрх үйлийг ах хаан чинь чамд итгэн даатгасан. Мэргүн дүү чамайг их хатан эх минь үүрдийн энх амгаланг зохиох хаан ухаанд сургасан. Билигт дүү чиний ухааныг харан ихэд баясав. Их хатан эхээс элбэн тохинуулах ухаан нэмж сураглахтун.

Хатан эх Сорхагтан:

- Хан хөвүүн Хубилай минь суумлын ертөнцийг засах мэргэн санааг чинь үзлээ. Гэхдээ энэ суумлын ертөнцийн ухаа билигт мэргэдийн гавлын олзыг гайхан би шагшнам. Мөнх тэнгэрийг хар нүдээр харахуй үзэхүй ухаалаг багаж хэрэглэл сэдсэн нь их сайн аж. Алив Персийн мэргүн та иртүгэй.

Персийн мэргүн:

-Мөнх их хааны зарлигаар дор Меру хотод одон орон судлахуй ордонг байгуулж буй билээ. Од руу хараа сунгах дуранбайг хан Хубилай танд би үзүүлсү. (Том дуранбайг Хубилайд өргөнө) Харанхуй шөнийн цагаар тэнгэр өөд тавибал хар нүднээ түмэн бээрийг нааш тодруулна.

Хубилай хан:

-Тэнгэр унших эрдэмд их тусыг өргөх эд хэрэглэл байна даа. Эрдмийн мэргүн чи энэ шөнө надад үзүүлтүгэй.

Хатан эх Сорхагтан:

-Билиг билгүүнт Хөх нуруутнууд зөнт нүдээр тэнгэрийг таан тааварлах ухаан агуу билээ. Цагаан үүл хүндэрч, газар элэгдэн доошилж, аянга гэрэл тачигнаж, аадар мөндөр буухыг аль хэдийн мэдээд, адуу малаа хамгаалж, орон гэрээ бөхлөх огторгуйн зөнч билээ. Хар нүднээ ил, од шинжлэх ордон гүрэн их улсын хамсан иргэн ардад арга билиг заахад тусыг өгөх гойд эрдэм болно. Хубилай хан хөвүүн минь суумлыг засаглах шинэ орноо энэ мэтийг өргөн автугай. Суумлын иргэд ган, зуд, үер усны аюулыг угтаж мэдээд тосож зэхээд тэсэж гарахын ухааныг олон нүүхүй ертөнцөөр хойшдоо аврагдах билиг билгүүнд тус авчирна.

Хубилай хан:

- Жа, Гэгээн мэргүн бөө сэцэн эх минь. Цоо ухаан тань сөгдсү. Бөө сэцэн хатан эх минь та миний туршин бүтээх Шанду орноо морилно уу?

Хатан эх Сорхантан:

- Дуртайяа морилон очсу. Хаврын урь орохоор танай Шандун орноо зочилъё.

Хубилай хан:

- Танд гялайлаа. (Эхдээ мөргөөд хаанд хандана) Шанду орноо эрдэм мэдлэг ихт хүмүүн олон ажээ. Их хаан ахын тэнгэр тайлах ордноо өөрийн засах улсын мэргэдүүдээс илгээе.

Их хаан Мөнх:

- Зүйтэй. (Хубилай хаанд ёслоод суудалдаа сууна) Аригун ноён та минь ялгуун аялгуут билээ. Хан дүү Хүлэгийн их цэргийн ялалтын ялгуун улаан аялгуунаас дуудаач. Их хаан би алсын аян дайныг хэрхсэнг хүлээн сэтгэл донсолно.

Аригун ноён:

- Их хаан минь болгоон соёрхоно уу. Аригун ноён би Хан Хүлэгү баатрын арслантай тулсан тулалдааныг аялгуулан дуудсу. (Их хаан баяртай толгой дохино) Хан Хүлэгү жанжны их цэрэг аажим бөгөөд сүртэй урагшилж явлаа. Энэ удаа Чингисийн морьтонгууд аян замын цэрэг мэт бус нүүдэлчдийн гүрэн улс болон нүүх явах ажээ. Их цэрэг умардын урчуудын гүүр, ухардага, өмнөдийн урчуудын хэрэм дөрлөгч, хана буулгагч, хаалга эвдэгчийг түрэн хөдөлнө. Хүлэгийн их дайны нүүдлийг нарийн харвал зад бэгийн бөө бөхийн бүл, дорны анагаахуйн шалгарсан бүл, хууль цаазын бүл, их цэргийн хүнсний бүл, ая дуу хуурын бүл айл гэрүүд, мал хуй, аяны хүнс улаан цагаан будаа амжилтаа дуудах айраг эсгүү, амтаг дарс тэргүүтэн ачаа хөсөг нүүдлэн явна. Хүлэгү ханы хөх нуруутан морьтон цэргүүд Аму-дарьяа мөрнийг гатлахаар уулын модыг буулган зангидаж мөрнийг хялбархан гатлав. Гэтэл Хүлэгүгийн цэрэг Аму-дарьяа мөрний эрэг дээр буун ирэх үест мөрний эрэг дээр хүрхрэх их чимээ үүсэн олон бүл арслан зам хэрэн архиралдав. Хүлэгү морьтнуудын морьд үргэн арслангийн өнөр сүргийн зүг үл ойртох агаад зэрлэг арслангуудын бархираан мөрний усыг ч дуусган уухад дөхөх өлсгөлөн авай. Хан Хүлэгү баатрын цэргүүд арсланг дарах мэхээ мэдэж олон ормол буур унаж очоод арслангууд агнан авлан даржээ. Хамгийн хүчит арсланг хан Хүлэгү хайрлан амийг нь үлдээж, зэрлэг арсланг номхтгон хүзүүвчилж их цэргийн нүүдлийн магнайг Аму дарьяа мөрний арслан тэргүүлэх болов.

Их хаан Мөнх:

- Аргагүй хан баатар эр мөн дөө. Хаан минь цээж омогшин Аму дарьяа мөрний хүйтэн салхийг мэдрэв. Аригун ноён чи надад их цэргийн хийморийг авч ирэв. Өөр надад хэн үгний цагааныг зөөх вэ?

Их хатан Хутухуй:

- (Сэнтийнээс босон Хааны өмнө сөгдөн) Их хаан минь, Бөө сэцэн Сорхагтан бэхэ их хатан эх, Мүхэ бага хатан эхүүд минь, Их хатан Хутулай би, Жөн Мон Тоба хан хөвүүнд хатан шинжин Хонгират аймгийн ноён Салжидайн бага охин Өлжий бэхэг шилэв. Их хаан их хатан эхүүдийн гэгээн мэргэн хараа таалах сан болов уу?

Их хаан Мөнх:

- Зүйтэй.

Нүлэн ноён:

-(Алга ташина) Хонгирад аймгийн ноён Салжидай, охин Өлжий бэхэ. (Салжидай ноён, Өлжий бэхэ нар хааны өмнө ирж ёсолно)

Салжидай ноён:

-Хонгирадын ноён Салжидай миний отгон охин Өлжий бэхэ энэ билээ. Өндөр төрийн дээдсийн билигт таалж, алтан ургийн хэлхээг бөхлөх аз охинд минь бий болов уу хэмээн ихэд эмээж байна.

Их хатан эх Сорхагтан:

-Өнгөлөг гуа охин минь, Чингис хааны Алалтун бэхэ охин Уйгарыг мэдэх хатнаар суун харьд бэрлэгдэн морьдохуй Хаан охиндоо юу айлдсанг мэдэх бол хэлтүгэй.

Өлжий бэхэ охин:

-Их хаан Чингис Алалтун бэхэ охиндоо эм хүний ухаан юуг илтэд буулган засагласан билээ. Хатан хүнд гурван нэртэй бий. Анхны эр нь алтан төр. Удаах эр нь ариун нэр. Түүний дараах эр нь авсан эр мөн билээ. Алтан төрийг хатуужиж дагавал ариун нэр бэлэн болно. Ариун нэрийг бэхэлбэл, авсан эр ангид үл одно хэмээн засагласан билээ.

Хатан эх Сорхагтан:

-Сайн байна. Өлжий хэмээн билэгтэй нэртэй юм байна. Хаан та юу гэж болгооно вэ?

Их хаан Мөнх:

- Язгуурын төрөлхөн Монгол овог Хонгирад аймгийн охин юм. Үзвээс ахуй бие юунд нь гэрэл бүрэлдсэн охин байна. Алтан ургийн хан хөвүүн Жөн Мон Тобад ирэх хатан мөн байна. Нүдний гэгээ холд тусах харвах хараатай ажээ. Санаанд минь таарав.(Салжидай ноёнд хандана) Сайн Ноён Салжидай чи сайхан охиныг хараад баясав. Их төрд, эцэг тэнгэрт эрдэмтэй эрдэнэ мэт охин төрүүлэн өсгөжээ. Их хаан би чиний охиныг хан дүү Жөн Мон Тобад хатан болгохоор гуйж байна. (Их хатан Хутулай сүйн булган хөнжлийг хаанд барина. Хаан Салжидайд өгнө)

Салжидай ноён:

-Их хаан минь магнай минь тэнийв. Алтан урагтай ураг барилдах аз бидэнд бий ажээ.

Их хаан Мөнх:

-(Жөн МөнТобад хандан)Жөн Мөн Тоба хан хөвүүн чамд Хонгирад аймгийн ухаан билигт үзэсгэлэнт охин юуг хатан болгон өгөв. Хайрын хос ёсыг дээдлэн Өлжийг хатнаа болгон автугай. (Жөн Мөн Тоба хаанд ёсолно.Өлжий дэргэд зогсон Салжидайд хоёул мөргөнө)

Салжидай ноён:

- (Хос хоёрт хандан)Нар сарны газарт амар амгалан жаргатугай. (Нүлүн ноён Салжидай охин хоёр суудал заана.Тэд хамдаа сууцгаана. Ордны албат Нүлүн ноёнд нэгийг дуулгана)

Нүлэн ноён:

-Мөнх тэнгэрийн хүчин дор Эзэнт Гүрний далай их хаан Гүюгийн их төрийн залгамж алтан захиа гэрээс дор Эзэнт Гүрний төвшитгөгч Мөнх их хааны Чингисийн ниргэлтээр тэрсүүдийн орныг дайлах зарлиг дор Их цэргийн жанжин Хан Хүлэгийн дайны талбараас ялалтын уухайг Мөнх хааны хан хүү Ширхэ тэргүүтэй хүлэгт илч нар авч ирлээ. (Ширхэ ханхүү тэргүүтэй цэргүүд орж ирнэ)

Бүгд цугаар:

-Хурай... Хурай... Хурай...

Ширхэ ханхүү:

-Их хаан аав минь амар мэнд үү?

Их хаан Мөнх:

-Амар амгалаан.

Ширхэ ханхүү:

-Хаан төрийн хатан эхүүд амар амгалан уу?

Хатан эхүүд:

-Амгалаан. Амгалан.

Ширхэ ханхүү:

- Алтан өргөөг эзлэх хан ах нар ихэс ноёдын амгаланг эрье.

Ихэс ноёд:

-Амгалаан. Амгалан.

Их хаан Мөнх:

-Хан хүү Ширхэ минь сайн явж ирэв үү? Харваас бие чинь бэхжиж, хүзүү чинь бүдүүрэн

хааны хөвүүний хан зэрэгт шалгаран бөх болжээ. Хайрт хүү Ширхэ минь холын дайнаас өвөртлөн ирсэн ялалтаа дуудан дурдтугай. Хаан аав нь ялалтын аялгуунд яаран байна.

Ширхэ ханхүү:

- Хаан аав минь би сайн явж ирлээ. Их Монголын Эзэнт Гүрний их цэргийн жанжин Хан Хүлэгү ах намайг хаан таны зүг нисгэв. Их хаан Чингисийн өмнө бөхийн дагасан атал гэриэгээ хагалсан тэрсүүдийн орныг Эзэнт Гүрний хүлэг морьтонгууд даран хөнөөв. Исмайлын гашишч хэмээх этгээд имамчуудын тэрсүү заналт эрчүүд бүгдийг уутлан адуугаар чирч хороов. Их цэрэг өргөн Тигрис мөрний хөвөөн дэх асар том Багдадын таван зуун жил мандан бадрахдаа ханаж цадахаа үл мэдэх хувалз мэт бүх дэлхийг залгисан тэр хотыг мөхөөв. Багдад хот урсгасан цус үйлдсэн нүгэл болгоныхоо цээрлэлийг үзэв. Тэдний нүглийн сав мөн их дүүрчээ. Хотыг галдан шатаав. Олзолсон Халифийг бусдаас булааж авсан алт эрдэнэсийн өмнө нь овоолон тавьж ид хэмээн тулган алт мөнгөөр амыг нь дүүргэн үхүүлэв. Тэндээс их цэрэг Дамаскийн зүг хөдлөн тэр хот өмнөх хотын хувь тавиланг адилхан хүртэв. Эзэнт гүрний их цэрэг газар дундын тэнгисийн эрэг дээр дахин очив. Хан Хүлэгү жанжины их цэргүүд хээрийн ордондоо цуглаж, олзоо түгээн найман өдөр найрлах болов. Их хаан таны эзэнт гүрэнд эл улсын ард даган оров. Их гүрний зах хязгаар хөх нуруутнуудын хүлгийн хурдаар тэлэв.

Их хаан Мөнх:

- Алтан амт хөвүүн минь хаан аав чинь энэ мэдээг хүлээн суув. Ертөнцөд боссон тэрсүүдийн урхаг уурхай дарагдав. Мөнх тэнгэр минь.

Их хатан эх Сорхагтан:

- Мөнх тэнгэр минь. Тэнгэрийн авралаар манай цэрэг хүчтэй, морь хурдан тул хар ертөнцийн зовлон дэлхийг бүрэхээс өмнө хаав. Хараалын голомтыг хийсгэв.

Их хаан Мөнх:

-Эзэнт Гүрэн дайснаа дарав. Дархан цолоо мандуулав. Их хаан миний зарлигийг зарлахтун.

Нүлүн ноён:

-(Нүлүн ноён хааны сэнтийн өмнө ирж муутуу цаас дэлгэн зарлиг дуудна) Эзэнт Гүрний Мөнх их хааны зарлиг. Сонсохтун. Их Монголын Эзэнт Гүрний их хаан эзэн Чингис “Хамгийн хаан болсон нь юу бодохоос үл хамааран хамаг монгол улс минь хамтын тархин дор төвшин сайхны төлөө халуун элгүн гэриэтэй байх ёстой хэмээгээд төр түшигч хан Толуй, их хуралдай даргач Сорхагтан бэхэ нарт Үндэсний алтан дээд гэриэ онолыг эвлүүлэн хурааж, үндсэн хууль тогтоохыг даалган зарлигласан дор Төр Түшигч Хан Толуй, хатан Бөө сэцэн Сорхагтан бэхэн хамт их үйлийг бүтээн өндөр төрд өргөсөн билээ. ”Их хаан Мөнх би Төр Түшигч Толуй эцгийнхээ Их Монголын эзэнт гүрний төрд бүтээсэн дээдийн дээд ач тус, тод алдар гавьяаг мөнхлөн Их Монгол Эзэнт Гүрний их хаан цол нэхэн шагнаж, Хатан эх Сорхагтан бөө сэцэн юугаа их төрийн их хатан эрдэнэд өргөмжлөв. Эл төрийн өндөр

өргөмжлөлийг ёслох албыг Аригун ноёд даатгатугай. Их төрийн хатан эхүүд эзэнт гүрний төрийн сан хөмрөгийг задлан их гүрний ард түмэнд дээдэс доодос хэмээн үл ялган маргад эрдэнийн төрийн хувь хишгийг эн тэнцүү тэгш тараан түгээтүгэй. Чингис хаан Бөртэ эх, Толуйн гал голомтыг Хан Аригбөхөд өвлүүлтүгэй. Далай их хаан Өгэдэйн эрхэт хант улс орныг зургаадугаар хөвүүний хүүд, Бишибали орныг, долдугаар хөвүүнд Эрчис мөрний дагуу орныг, дөрөвдүгээр хөвүүний хүүд Харачарын хүү Тогтаход, тавдугаар хөвүүний хүү Хайдуд Ханяал орныг, Гансу Наньсу Наньшаны баруун хэсгийг дэд хөвүүн хүү Мөнхөд тус тус олгон соёрхов. Хааны хан хөвүүд ач нар зарлигт заасан орныг засаглахаар одтугай. Их хааны зарлигийг биширтүгэй.

Бүгд нийтгээр:

- Уухай... Уухай... Уухай... Хурай... Хурай... Хурай...

Их хаан Мөнх:

-Мөнх хөх тэнгэрээс илгээсэн билиг яруу, төгс дэмбэрэл бүрдсэн эл өдрийг найр цэнгэлээр жаргаатугай. Аригбөх ухаа хонгор аялгуу дуут хан дүү минь алтан өргөөнд ая өргөн найр үүсгэтүгэй.

Ариг бөх:

-(Хултай айраг өргөн) Уртын хээрээ....

(Чингис хааны төрийн сүлд уртын дууг эхлүүлнэ. Өргөөнд хурсан ноёд хатад дууг түрэв)

(Харанхуйлал)

Тавдугаар үзэгдэл.

5. Их хаан монгол өргөөнд дэлхийн бүх шашинг хэлэлцэв.

Тайз: Их хааны өргөө. Их хаан Мөнх, Жөн Мон Тоба, Аригун, Нүлүн ноёд ба хатдууд. Буддын лам Пагва, Ислам лам, Христосын санваартан Гильом Де Рубрук, христ, лал, буддын шашны төлөөлөгчид лам санваартан нар...

Аригун ноён:

-Их Монголын Эзэнт Гүрний их хаан Мөнх таны их төрийн алтан өргөөнд дэлхийн элдэв шашны төлөөлөл хуран чуулав.

Их хаан Мөнх:

-(Их хаан гараа өргөнө) Их Гүрний эзэд хөх нуруут Монголчууд бид мөнх хөх тэнгэрийн иргэн улс билээ. Дэлхийг засаглах хутагт Их Монголын төрийн тооно дор та улс цугларав. Тэнгэр бурхан гарын таван хурууг тэгш заяагаагүй шигээ хүмүүст ч харилцан адилгүй зам мөрийг хайрласан Бурхан та бүхэнд ном судар хайрласан, харин та нар түүнийг биелүүлээгүй. Эрдэм мэдлэгээс илүү эд баялагийг эрхэмлэх болсон. Бурхан тэнгэр монголчуудад билиг билгүүн хайрласан, бид зайран, бөө нарыг хайрлаж, өдөр тутмын амьдралд би тэдний хэлсэн бүхнийг хэрэгжүүлдэг. Тэр дагуу бид зохицон амьдардаг. Бид аль нэгэн шашинд хамаарагддаггүй ба хүлцэн тэвчих хийгээд сайн сайханд тэмүүлэн тэнгэрт итгэж түүний төлөө амь насаа зориулж, сэтгэл зүрхээ чиг шулуун байлгадаг. Франкийн хаан Людовикийн элч та үгээ хэлтүгэй.

Христийн санваартан Рубрук:

- Христосын шашны санваартан би бурхны үгийг тээж ирсэн билээ. Бурханы ариун орон руу халдан довглож олон орон хотыг түйвээх гүрэнд бурханы хүү Есүсийн ариун гэриэг авчирлаа. Гүрний хаан эзэн та христосын шашинтныг мөрдөн мөшгихөө зогсоож, гэм нүглээ наминчилан сайн мэдээг сонсохгүн. Бурханыг хэн үл хайрлана, хохирол түүнд ирнэ.

Лал шүтлэгтэн:

-Бурханыг хайрладаггүй хүн бий гэж үү?

Христийн санваартан Рубрук:

-Бурханы сургаалыг дагаагүй хүн түүнийг хайрлаагүй хэрэг.

Жүүдийн сүсэгтэн:

-Бурханы сургаалыг мэдэж байгааг бодоход та лав диваажинд очсон биз. Тэгэхээр Мөнх хаан бурхны сургаалыг дагахгүй байгаа гэсэн үг үү?

Нүлүн ноён:

-Төрийн өргөөнд хурсан та улс бид биенээ үгээр хатгахыг цээрлэхгүйн. Дэлхийн шашинг хэлэлцэн чуулах энэ цаг дор хэрүүлийн үг хэрэглэвэл цаазаар авна. Мөнх хааны зарлиг дор будда, христос, лалын шүтлэгтэн мэргэд их хэлэлцүүлгийг шүүн хэлэлцэх болно. (Зэрэгцэн суух гурван төлөөлөл босч хаанд мэхийнэ) Харгалдаа харгалдаа байх шүтлэгтэнгүүд бие биенээ нэг нэг асуулт тавьтугай. Даогийн ламаас эхэлье..

Даогийн лам:

-Дэлхий хэрхэн үүссэн, хүн хэрхэн үүссэн тухай хэлнэ үү?

Христийн санваартан Рубрук:

-Ламтан буруу асуулт тавьж байна. Бүхнийг бүтээгч бурханаас эхний асуултыг эхлэх учиртай. (Гурван шүүгч нэг нэг оноо түүнд өргөв) Бүтээгчийн номын нэгийн нэгд. Бурхан тэнгэр газрыг бүтээжээ. Газар нь ямар ч хэлбэр дүрсгүй, эзгүй хоосон, гүний гадаргуу дээгүүр нь харанхуй бүрхэж, Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа.

Тэгээд бурхан:

-Гэрэл бий болог! гэсэнд гэрэл бий болов. Бурхан гэрлийг харанхуйгаас салгажээ. Үдэш болоод өглөө болжээ. Тэр анхны өөр болой. Бурхан усан дотор огторгуй бий болж, усыг уснаас салгаг гэж айлдав. Тийнхүү Бурхан огторгуйг бий болгоод огторгуйн дээрх усыг огторгуй доторхи уснаас салгасанд тэр ёсоор болов. Бурхан огторгуйг тэнгэр гэж нэрлэжээ. Дараа нь бурхан газрыг бүтээж, тэр газарт дэлхий нялх ногоо үрт жимсний мод төрөл төрлөөр нь ургуулаг гэсэнд тэр ёсоор болжээ. Тэгээд усанд усны амьтан, газарт газрын амьтан, тэнгэрт жигүүртэнг бүтээж, тэгээд бурхан өөрсдийнхөө дүр төрхийн дагуу эртэй эмэгтэй хүнийг бүтээв. Бурхан тэднийг адислаж, тэдэнд –Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж газар дэлхийг дүүргэн газрыг эзэмш, далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дэлхий дээр хөдөлдөг бүх амьтныг захир хэмээн айлдав. Харин лам чиний шүтээн юу вэ гэж асуумаар байна?

Даогийн лам:

- Лаоз нь Даогийн сургаалыг үндэслэгч юм. Уг сургаалын үндэс нь Дао юм. Дао бол хоосон. Дао үзэгдэхгүй, түүнээс дуу авиа гарахгүй, түүнд хэлбэр дүрс байхгүй, хараад харагдахгүй, чагнаад дуулдахгүй, түүнийг тэмтрээд баригдахгүй, түүнийг нэрлэж болохгүй. Гэхдээ хэзээ ч шавхагдашгүй, гүн. Тэр бол бүх эд юмсын дээд эцэг. Хэрэв түүний бусдад нэвтрэх чанарыг мохоон, хорвоогийн эмх цэгцгүй хумхиас ангижруулах юм бол тэр оршин байгаа нь туйлаас тодорхой болно. Дао нэгийг төрүүлдэг, нэг нь хоёрыг төрүүлдэг, хоёр нь гурвыг төрүүлдэг. Харин тэрхүү гурав нь бүх юм болой. Бүх зүйл өөртөө янь, инь тээж явах бөгөөд ци гээр дүүрсэн байна. Энэ бол зохицлын дээд болой. (Гурван шүүгч нэг нэг оноо өргөв)

Христийн санваартан Рубрук:

- Тэгэхээр энэ бүхэн бурхан гэж хэлэх үү?

Даогийн лам:

-Энэ бол Дао. Бид Даогийн сургаалыг дагадаг.

Христийн санваартан Рубрук:

-Бурхан хаа байна тэгээд?

Нүлүн ноён:

-(Гараа өргөн) Христийн санваартны асуултыг хориглов. Дараагийн асуулт лалын шүтлэгтэн тавьтугай.

Лалын шүтлэгтэн:

-Үхлийн дараах амьдрал юу болох вэ?

Буддын лам Пагва:

-Хойд насны амьдралыг эргэцүүлэн бодох нь дээд, доод хоёр төрлийн жаргал ба зовлон болой. Энэ амьдралд удаан тухлахгүй, мөд үхэх нь гарцаагүй болой. Үхсэн ч ор мөргүй алга болохгүй дахин төрөл авна. Гэхдээ дээд доод өөр гарц үгүй. Тиймээс нэг бол сайн эсвэл муу заяанд төрнө. Үүнийг өөрийн зоргоор үл сонгоно. Үйлийн үрийнхээ аясаар явж сайн, муу үйлийнхээ хэмжээнд тохирсон заяанд төрнө. Өөрийн зовлонг мэдэхийн хэрээр бусдыг энэрэх сэтгэл төрнө. Мөн орчлонгийн зовлонг танин бурханд хүрэх хүсэл төрнө. Зовлонгоос айн жихүүцэж Буддагаас аврал эрнэ. (Шүүгчид нэг нэг оноо өгнө) Орчлонгийн хүний заяа тавиланг юу хэмээн Аллах тань айлдав?

Лалын шүтлэгтэн:

- Мөргөл залбирлыг арабаар ибатаат гэнэ. Мөргөл залбирал нь Аллах эзнийг хүнтгэн мэхийн ёслох, түүний бид бүхэнд хайрласан тоолж барашгүй буян хишигт нь талархах явдал юм. Бид бүхнийг ор хоосноос бүтээн бий болгож амьдрал заяасан нь Аллах эзэн маань юм. Агуу Аллах бидний бие махбодийг харах мэлмий, дуулах сонор, ярих хэл гэх мэт гайхамшигт эрхтэнүүдээр гоёж. бусад адгуусан амьтдаас онцлон оюун ухаан заяаж хамаг амьтдын дээд нь болгожээ. Мөн бидний амин чухал хэрэгцээ болох амьсгалах агаар салхинаас авахуулаад, ундлах усыг хүртэл хувь хишиг болгон бидэнд тэр заяасан.

Христийн санваартан:

-Муу ёр, сайн үйл гэж юу вэ?

Күнзийн эрдэмтэн:

-Сайн юм гэж юу байдгийг хүмүүс мэдсэн тэр цагаас муу юм оршин тогтнох болсон. Бодит,

хийсвэр хоёр ахуй бие биеэ төрүүлж, хэцүү хялбар хоёр бие биеэ бүтээж, урт богино хоёр харилцан шүтэлцэж, өндөр нам хоёр авиа нэгдэж байж яруу тунсаг аялгуу дуурсган, өнгөрсний араас залгах хойч дагаж явдаг билээ. (Шүүгчид нэг нэг оноо өргөв) Санваартан авралыг хэн зохиох вэ?

Христийн санваартан Рубрук:

- Бидний бурханы нигүүлсэнгүй өршөөлөөр мандах нар нь дээрээс айлчлан ирэх нь харанхуй ба үхлийн сүүдэрт суугсдын дээр гийж бидний хөлийг энх тайвны зам руу чиглүүлэхийн тулд юм хэмээн гэрээнд заагдана.

Күнзийн эрдэмтэн:

- Одоо та хаана нь сууж байна. Гэрэлтэйд үү? Харанхуйд уу?

Христийн санваартан Рубрук:

-(Түгдрэв) Бидний дээр нар гийвч харанхуй байна. (Нэг нь нэг оноо өргөв)

Күнзийн эрдэмтэн:

-Нэг нүд гэрлийг нөгөө нүд харанхуйг үзнэ гэж ойлгож болох уу?

Христийн санваартан Рубрук:

- (Илт сандран) Үгүй ээ тэгж хэлээгүй. Там диваажинг харна.

Күнзийн эрдэмтэн:

-Хоёр өөр нүдтэй гэсэн үг үү? (Доогтойгоор инээв)

Нүлүн ноён:

-Күнзийн мэргүнийг асуултыг хориглов.

Лалын шүтлэгтэн:

-Дэлхийгээс тусдаа зүйлийг та заана уу?

Даогийн лам:

-Орчлонгийн бүх юм хувирах мөнхийн үйл оршдог. Хонхоргүй тэгш байдаггүй, буцахгүй одох байхгүй. Хэрэв юмс төгсгөлдөө хүрэх ёстой, төгссөн байдал хадгалагдах ёстой юм бол энэ үйл явц зөв газар, зөв янзаар, зөв цагт явагдах ёстой. Хөгжлийн явцад бүх юм өөрийн үгүйсгэлийг багтаасан байна. Хөгжлийн үйл явцад юмсын төгсгөл үгүй. Амжилт олохын тулд хэтэрхий амжилттай байхгүйн төлөө санаа тавих хэрэгтэй .

Буддын лам:

- Төгс гэгээрэлд хүрэх хүсэл тэгээд юу болох вэ?

Даогийн лам:

- (түгдрэв)

Лалын шүтлэгтэн:

-Ариун оршихуйг үгүйсгэв үү?

Нүлүн ноён:

- Маргааныг хориглов.

Даогийн лам:

-Сүсэг бишрэл гэж хүн бүхэнд заяамал уу?

Буддын лам Пагва:

Сүсэг бишрэл нь гэгээрэлд хүргэх

Сүйх тэрэгт унаа хүлэг мөн

Сүйхээтэй хүн л үүнийг таньж

Сүсгээ хүлэглэн дээшээ дэвжинэ

Өчүүхэн төдий ч сүсэггүй хүмүүнд

Өөдлөх гэгээрэх хүсэл төрдөггүй нь

Үнс болж түлэгдсэн буурцагнаас

Үр соёолох ерөөлгүй адил аа

Сэтгэл зөвтөхөд зам зөвдөж

Сэвтээх садаа өөрөө ховхорно

Алдаагүй зөв дадал эзэмшиж

Амьганд туслах бурхан болно.

Христийн санваартан Рубрук:

-Нүгэлтэн хаа хүрэх вэ?

Буддын лам Пагва:

-Орчлонгийн гэм эрүүг хэлбэл хэдий хүмүүний заяа өндөр гэвчиг нүгэлд баригдвал унал нь тоо томшгүй ба тамын заяа хүлээнэм. Нимгэн, зузаан нүгэлт сэтгэл ямар ч төрөл авсан орчлонгийн орноос хэтрэхгүй бөгөөд ер нь орчлон хэмээх нь ваарчны эргүүлэг юм уу, худгийн ховооны эргүүлэг юм уу хумхан доторх зөгий мэт нэгнээс нэгд эргэхийг хэлнэ. Хувь тавиланг нь хэрхэн Аллах зурах уу?

Лалын сүсэгтэн:

- Хувь тавиланг биеллээ олоход бүх сайн бүх муу үйлийг бүтээгч нь Аллах эзэн юм гэдэгт итгэх итгэл юм. Аллах эзний хүн төрөлхтөнд илгээсэн шашин ном юм. Ислам бол гүн ухаан эрдэм мэдлэгийн ариун цэврийн шашин юм. Ислам бол дэлхий ертөнц болон хойд насны зол жаргалын шашин. Ислам бол дөт хялбар шашин юм. Ислам энх тайван эв нэгдэл бие биеэ хайрлахыг номлодог шашин болоод хүн болон хамаг амьтныг үгүйгээс бий болгосон цорын ганц эзэн болох Аллах тэнгэрт залбирал мөргөл үйлддэг шашин юм.

Христийн санваартан:

- Тэгэхээр бидний Исүс юу болж байна?

Нүлүн:

- Асуултыг хориглов.

Христийн санваартан Рубрук:

-Хаантанаас асуух асуулт байна?

Нүлүн ноён:

-Их хаан мэтгэлцээнд оролцохгүй.

Их хаан Мөнх:

-Санваартан чиний асуултанд хариулья. Асуутугай.

Христийн санваартан Рубрук:

-Мөнх хөх тэнгэр гэдэг бидний дээр хөхрөх тэнгэр мөн үү? Хөх нуруутан гэдгийг тайлбарлан хэлэхийг хаанаас асууна би.

Их хаан Мөнх:-

Өндрийн үл хүрэм, гүний үл очих, өргөний үл туулам бүхий хүчин тэнгэр болой. Хий, тоос,

чийг, дэнс дөрөв нөхцөлдөх амин чанар өөрөө тэнгэр болой. Харанхуйн хязгаар, огторгуйн төгсгөл өөрөө гэрлийн орон болой. Гэрлийн орон өөрөө алтан аялгуу болой. Эл орон зайгаас хувь тавилангаа олсон нь хөх нуруутангууд бид болой.

Буддын лам Пагва:

- Их хаан танаас эрэх асуулт надад байна.

Их хаан Мөнх:

-Гагц энэ асуултанд хариу өгье.Асуутугай.

Буддын лам Пагва:

-Хаан гэж хэн бэ?

Их хаан Мөнх:

-Мөнх тэнгэр нь өөрөө бүгдийн шүтэн багцархуй бөгөөд хаан бол мөнх тэнгэрийн дүр мөн. Хаан нь тэнгэр язгууртай тэнгэрийн төрөлтөн ба хаанд тэнгэрийн үзэл шингэсэн тул түүний эрх мэдэл засаг юунаас ч, хэнээс ч үл хамаарна. Хаан бол мөнх тэнгэрийн багцархуйг хураасан билигтэн бөгөөд хаан тэнгэрийн билиг алтан дээд үнэний аялгуун цацрахуй билээ. Хорвоо ертөнцөд Мөнх тэнгэрийн хүчин болохуй хорин нэгэн үлгэрлэлт хаан эрдэнээр од болохыг аялгуу гэмү. Гэрийн онолт айл бүлийн харилцааг агуу болгож хүн нар амьдралын од болж ертөнцийг засахыг төр гэмү. Гэрт оруулж, тэнгэрт хүргэх зарлигтайг хаан гэмү. Дээд тэнгэрийн хүү Чингис хаан тэр зарлигийг ертөнцөд авчирсан ажгуу.

Буддын лам Пагва:

-Хаан таны гэгээн билиг мэргэн ухаанд бишрэн мөргөмү.

Их хаан Мөнх:

- Их Монгол Эзэнт төрийн эсрэг Загалмайтныг босгон бидэнтэй тэрсэлдэн дайн хийхийг Орос орноо, Пап лам уриалсныг дуулав. Тэнгэр үл таалах жигшүүрийг Пап өднө. Тэнгэр монголчуудад наран ургахаас жаргах хүртэл удам орныг удирдах эрхийг олгосон. Диваажинд гагц мөнх тэнгэр, ертөнцөд гагц эзэн Чингис хаан гэдэг бурхны хүү газрын ганц төр, Монголын Эзэнт гүрнийг түүний үе залгамжилна. Энэ бол тэнгэрийн ясу зарлиг чинхүү мөн.

Жүүд сүсэгтэн:

- Франкуудийн хаан Луи жүүдүүд бидний бүхий л ном судрыг цуглуулж овоолон галдан шатаалаа. Зөвхөн бурхан хүн хоёрыг холбогч түүнд өгдөг гэгээнтэн алдрыг Исүс христийн айлдварыг түгээхэд энэ мэт хүчин зүтгэснийх нь төлөө тэдний сүм дуган Гэгээн Луи хэмээн ариун алдрыг түүнд олгон үнэн сүсэгтэн биднийг гомдоолоо.

Их хаан Мөнх:

- Та улс тэнгэр бурхны зарлигийг дагах ёстой. Гэвч тэдгээр зарлигийг жүүдүүд Муза, арабууд Мухамед, Христосын шашинтангууд Есүс, Бурханы шашинтангууд Будда өгсөн гэлцдэг. Бусад үндэстэн ч ивээлийг нь хүртдэг өөр өөрсдийн тэнгэр бурхныг дээдлэн хүндэтгэдэг. Тэгэхээр бид хэрхэн зөвшилд хүрэхсэн билээ. Тэнгэрт мандах нарыг бид хагалан авч чадахгүйтэй адил газрын тэрсэлдэн маргах нь ухаангүй хэрэг олно. Алтан нар бүгдэд хишгээ хайрладаг бус уу. Энэ мэт тэнгэр бурхан харж, шашин төрийг дээдэлсэн цагт хүн төрөлхтний дотор эвлэрэл тогтоно. Их Монголын эзэнт төрийн их хаан миний алтан өргөөнд цугласан ертөнцийн элдэв шашин номын мэргэд та бүхэн тэнгэр бурхны өглөг оюун ухаан иш санаа бүрээ дор дороо тодорхой бичээд дахин цуглаж энэ асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэхийг цугласан эрдэмтдэд их хаан би даалгав. Сүсэг бишрэлийн амар амгалан дэлхий ертөнцөд бүтэх болтугай.

Аригун ноён:

- Эзэнт төрийн алтан өргөөнд дэлхийн зүг бүрийн улсын мэргэдүүд та бүхэн зүүн өргөөнөө морилтугай. Эзэнт гүрний хатдад зүүн өргөөнөө та бүхэнд их хааны хишгийг түгээнэ.

(Хөгжим) (Харанхуйлал)

Зургаадугаар үзэгдэл.

6. Хатан эх сорхагтан бэхэ бөө сэцэн тэнгэрт морилов.

Тайз: Хатны өргөө. Их хатан Хутулуй аягач шивэгчдийнхээ хамт байна. Гаднаас Их хаан Мөнх, Нүлүн ноён тэргүүтэй хааны цэргүүд орж ирнэ. Их хатан Хутулай хаанд сөгдөнө.

Их хаан Мөнх:

-Хатны өргөөний албатууд өргөөг орхихтүн. (Аягач шивэгчид явна) Хааны эхнэр эр нөхөртөө мэдэгдэлгүйгээр хүн цаазалж болно гэдгийг хаанаас олж мэдсэнээ хэл.

Их хатан Хутулуй:

-Өршөө хаантан минь.

Их хаан Мөнх:

- Хэрхэн хороосноо хэл.

Их хаан Хутулай:

-Өршөө.

Их хаан Мөнх:

- Хаанд үл хэлэн их хатан чи ёрын цааз сэтгэнэ гэнэ ээ. Яаж хороосноо хэл чи.

Их хатан Хутулай:

-Өршөө хаантан минь. (Аврал эрж Нүлүн ноёнд хандана) Нүлүн ноён минь.

Нүлүн ноён:

-Хатны өргөөнөөс ах дүү хоёр албат сувд шүр хулгайлжээ. Их хатан албатуудыг жигштүгэй хэмээн ахынд нь толгойг цаазлан дүүгийнх нь хүзүүнд өлгөн олны дундуур явуулсан байна. Охин тэр дүүг нь улайсгасан тамгаар цохиж хайрч байгаад үхүүлсэн байна.

Их хаан Мөнх:

- Их хатанг хар гэрт хорь. Хоол хүнс ус үл өгөн долоон өдрийн нар сарыг хоосон үзүүл. Тэсэж амьд гарвал тэр хатанд хаан эрийнх нь өршөөл болог. Хэсэж үл чадвал тэр хаан төрийн цааз болог.

Их хатан Хутулуй:

- Хаантаан.

Нүлүн ноён:

- Жа. (Нүлүн ноён тэргүүтэй цэргүүд хатанг барин явна)

Их хаан Мөнх:

- (Гунигт автан) Ямар муу тэмдэг дохио вэ? Их хатан минь эвгүй мууг сэдэн үйлдэв.

(Бүрэнхийлэл) (Тайзны өмнө биед гэрэл тодорно. Шанду дахь Хан Хубилайн өргөө. Их хатан эх Сорхагтан бэхэ, Хан Хубилай, Хубилайн хатан Чабун, Аригун ноён нар байна)

Их хатан эх Сорхагтан:

- Дээлийг минь өмсүүл. (Их хатан эх цонхигор ядруу байна. Хэвтэрт өндийн суусан байна) Сандарч тэвдэх хэрэггүй бэр Чабун минь.

Хатан Чабун:

- Таны минь царай гэрэлтээд урьд шөнийнхөөс илт дээрджээ. Их хатан эх минь.

Их хатан эх Сорхагтан:

-(Дээлээ өмсөнө) Тийм ээ, Босоод тал дундуур гүймээр авираад уулын орой дээр гарчихмаар хүч надад ирлээ.

Хубилай хан:

-Их хатан эх минь, би таныг түших үү?

Их хатан эх Сорхагтан:

- Зүгээр, бие сэргээд хүч ирэв. Тамир дүүрээд тэнхэл нэмэгдэнэ. Хан хөвүүн Хубилай надтай үлдэн харин бусад нь өргөөг орхи явтугай. (Чабун хатан, Аригун ноён нар их хатанд мэхийгээд явна) Хубилай хүү минь, тэнгэрийн дуу хатан надад сонстов.

Хубилай хан:

- Жа, Их хатан эх минь.

Их хатан Сорхагтан бэхэ:

- Тэнгэр минь. (Дуу алдан дальдчина) Ямар хурц гэрэл гэгч нь энэ вэ?

Хан Хубилай:

-Хатан эх минь та минь. (Их хатан нүдээ анина.Хүүгээ тэмтэрнэ)

Их хатан Сорхагтан бэхэ:

- Аа, хүү минь, би зүгээр.. хараа минь хоосров. Бүү ай. Тэнгэр намайг эзэмдэв. Тэнгэрийн хэл ирэв. Хан Хубилай чи сонстугай. Тэнгэрийн улс хөх нуруутанд тэр гэхийн тэмдэггүй зовлон айсуй. Ертөнц дэлхийн Эзэнт их гүрэн бууран доройтох цагийг автугай. Хар зөнгийн дуу хоолойг хаан чи сонс. Халуун, шулуун, нялуун гурван дайн дэлхийд дэгдэнэ. Тэнгэрийн буулт ариун нутгийг тэр дайны хөлөөс авартугай. Ертөнцийн шороон түмэн хүний хөлөөр онгон хөндий дүүрч, тэнгэрт шүргэх ариун уулын зулай хиртэх нь. Айлыг хорлох муу элээ зүйг эвдэх цаг бүтсэн. Арван түгээмлээ бутаргаж ухаантныг хоослох илчээр хаан чамайг гэж заав. Алтан дээд үнэнийг тооцож миний баатрууд, нэг бус мянган тархитай могойнууд болон элээг хордуулму. Уул устайгаа шүтэн барилдаж цаг уур орон зайд зохицож унги үүсэл гучин таван эрдмээсээ тэсэж үлдэх эрдмийг хорлож тэрсэхийг хэрэглэвээс тэрсүү элээн улс хоосонд идэгдэн замхрах буй заа. Итгэл олох малаа өгч, алт мөнгийг гулсуулж, үгээ хорьж могой мэтээр шарлуулагчийн эдийг шүтэж, хуралдаж болох бүгдийг үнэгүйгээр өгөөд цусаа хамгаалдаг. Устгахын тулд муу элээг эдэд захирагддаг болгог. Гунан наснаас хойш зуурдын бусаар үхдэггүй хөх толботын яс хуйхтанд хор билээ. Хуйхтаны цусаар салсан үр нь жүлд ижар амьтай. Чийгийн өг адил үрживч тархийг олох чадваргүй билээ. Хажирт мэргэшсэн миний улс эс тэсэхүйд од болохдоо хар санаа, хар зэм хар зөн бүгдийг зөвшөөрөхгүй. Халуун цусныхаа мон тоба амин хэмийг авч хаан чи үлдэнэ. Үүний төлөө үзэх хохирлыг бас хаан чи тэвч. Хаалгат гэрээс эмс гарч нуруу зовоовол зовоог. Хүүхэд мухар мөрийг хөөж, дагавал дагаг. Хөх толбот эрийнхээс бусдын үрийг битүүлнэ. Өхөөрдөн хорлох бүх аргыг сурвал сураг. Моньг нэү байдалд огоул болгох хүслийн амин хэм нь монд биш яс цусан байдгийг санаж яв. Хөгшид муу муухайд залхаж үхэгсэдтэй атаархвал атаархаг. Хожмын төлөө одоо зов гэсэн нялуун дайн ирвэл ирэг. Хөх Монгол амин чанарын дэргэд эдгээр зийдөр билээ. Малынхаа төлөө үхдэг болгохыг далдуур нөхцөлдүүлдэг дайн Монгол газрыг эзлэх алсыг бодовч удирдагч олдохгүй. Яг энэ үед би дахиад элч зарна. Сархадыг най тухад болгоож хүүхэд даага хоёроор наадаж сайхан цаг гэж магтаж хоосролд бөхөлзөж бүтэн жил мал хүн хоёрынхоо тоог даяарт өгөх цагт бүх удамшил, уламжлалаа сэргээсэн миний элч ирнэ. Тэсэж үлдэх эрдмийн үүслээ бататгахыг хэрэглэмү. Тэр хагуу цагийг тэргүүн билигт хаан үйлдмү Хөх Монгол шарлаж бас улайрсан бол хөл дор түймэр мэт мунхаглалын дай яарт харлуулагдму. Аргалын хурга амьд хүнээс үнэтэй болму. Амьтны эрх хэмээх хар дайн ирж Монголыг шатааму. Хижийн мунхаглалыг дураар нь тавих жаяг зарлаж Хүний эрхийн боол болгож гутааж дарламу. Идэх өмсөхөөр нь хүнийг захирч, эдээр үхүүлж бүгдээрээ мал буюу амьтан байваас санаа амар байх бүдүүлгийг хэм болгосон мунхаглагч нар засгийг орлому. Албаар амьд байлгасан олон эрлийзүүд энэ үед ахуй болоод гэр бүлийг хөгийн болгож хорлому. Боульхай, булхай, булай гурав буханцарууд боловч буур, бух, азарга, ухнын зэрэгт ахуйгаа манаж чадахгүй мунхаглалаас мунхаглал руу тэд улсыг гулдарму. Харласан Монголчууд хоосролоо мэдрэх цаг ирмү. Хамгийг эгзэг дор нь би Тоул Алтайгаас илч ирүүлмү. Далайгаас далай хүртэл гурван зуун хэлийн Монгол улс дай ярын гурван дайнд сүйрээд сүйрээд барагдахгүй. Уул, ус, агаар гурвыгаа хаан болгосон улс устгагдана, мөхнө гэж үгүй гурван онол Монголд байдаг. Удамшил гүн хүчээр хөх толботууд асар ихээр дутагдавч учраа олохгүй нэг хэсэг хүн бус авираар өрсөлдмү. Нарны эрчим хүчийг сүүдрээр хааж нуугдму. Сарны эрчим хүчинд ил гардаг айхуйгаа устгаму. Сүүн эрчим хүч сүрхий ихээр хордму. Эе бэлгэ нь эрчим хүч биш хор өгдөг болму. Эцсийн болоод эхний найдвар домог болму. Амьдрал байхын үндэс нь мөхөж амьд амьмад гүйлдмү. Хараалын мөчлөгийг хаан тасалму. Алтай Тоул

Хасхах Ёлд амьдрал мөнх байму. Хар салхи, галзуу шуурга, ган зуд, харын хар, хараалын муу тэнд үл хүрч чадму. Халуун, шулуун, нялуун дайны дай ярууд тэнд очиж чадахгүй. Тэмтрээд дуусашгүй зөнтэй тэжээх шаардлагагүй малтай Тэнгэрийн жаягт их ухамсар нь зөв эргэх хас байму Төвшин сайхны уялга Алтайн тэр газарт алсын сайныг хаан чи одоо нууж Алтан дээдийн гэриэг нуу.Тэнгэрийн гаралт хөх нуруутны үрсийг тэнд мартан хадгалахгун. Хаан Хубилай чи тэнгэрийн нутаг ариун газрыг авартугай. Тэнгэрийн буулт ариун голомтыг аварч үлдтүгэй. Хаан чи нэрээ ухахтугай. Хаан төрөө хасах тугай. Хожмын хөх нуруутан дотор тэнгэрийн хэлийг хэн тайлна. Тэр хаан болно.Тэнгэрт би (Их хатан эх өөд болно)

Хубилай хан:

-Ижий сүнс эргэж биедээ бууж ирсэнгүй. Мөнх тэнгэрийн хүч хатан эхийг минь мөнх тэнгэртээ залан одлоо. (Мөргөнө)

(Гэрэл бүүдийнэ) (Их хаан Мөнхийн сэнтийд гэрэл тодорно. Нүлүн ноён хааны дэргэд ирнэ)

Нүлүн ноён:

-Хаан таньд бараалхахаар Тоул Алтайгаас нэгэн удган цаа буга унаж бууж иржээ.

Их хаан Мөнх:

-Ирүүлтүгэй.

Удган:

-(Хааны өмнө ирж сөгдөнө) Их хаан минь ээ.Үүрийн үнэгэн харанхуйн зүүдэнд хөх үнэг гүйн ирэв. Алс руу зэхсэн дайнд хаан та минь бүү одтугай. Амь насыг тань шүүрэх аюул угтана. Хөх нуруутан хүлэг морьтонгууд хий хорлолд хуйгаараа хөсөр хэвтэн хиар унана. Их эзэн та муу хүний үгэнд орж, алтан ургийн дотор их нүгэл үйлдэж, мөнх тэнгэрийг хилэгнүүлжээ. Одоо дахин хүний газар дайн хийвэл таны алтан аминд аюултай.

Их хаан Мөнх:

- Хаан төрийн дайны хар тугийг хийсгээд, эзэнт төрийн эмээл юуг оломлоод их төрийн хан бүрээг аль хэдийн бүрээдэн татсан билээ. Өр цээжийг өргөс мэт үргэлж хатгах өмнөдийн Сүн улсад эзэнт гүрний их хаан би өөрийн биеэр дайтахаа хэдийнээ зарлан зарлигласан. Миний нүрний мэргэн удганы нэг чи Сүн улс мөхөх үнэгэн харанхуйн зүүднээ олж харин үзэв үү ? Чи!

Удган:

- Үзсээн их хаан минь. Сүн улсын сүйрлийг үзэн их хаан та мөхөөн өвдөглөнө. Харин хаантан минь та минь харьж ирэхдээ ...

Их хаан Мөнх:

-Мэдлээ.

Удган:

-Өршөө хаантан минь. Их хаан би удган чиний зүтгэлийг хааны шангаар хариулья.

Их хаан Мөнх:

-Мэдэж явья. Сэрэмжилж санаж явья. Нүлүн ноён, мэргүн удганд хишиг өгтүгэй. Хааны хишгийг өвөрлөн хан Тоулдаа та одтугай. (Удган явна)

Их хаан Мөнх:

-Эргэж буцах хараалын ёр их хатнаар минь оролджээ. Хаадын захиас зарлигийг Хаан би гүйцэлдүүлэх ёстой. Эзэнт гүрний өрцийг хатган хясах хараалын хар өргөсийг сугалан хаяж хугалсу. Хаан төр лүү буцан ирэх булай хар хараалын мөчлөгийг энэ цагт хаан би өөрөө авч үхүүлтүгэй. Эргэх мөргүй дуусгах болтугай. Дайлаар мордсу.

(Хөгжим) (Харанхуйлал)

Долоодугаар үзэгдэл.

7. Их хаан мөнх хөх мөнх тэнгэр болов.

Тайз: Хааны өргөө. Хааны ор хөшгөөр халхлагдсан байна. Хааны орыг хишигтэн цэргүүд хамгаалсан байна. Өргөөнд буй бүхэн зөвхөн нүдээ ил гаргаж арабууд мэт нүүрээ халхалсан байна. Хөшигний өмнө Ширхэ хан хөвүүн Нүлүн ноён байна. Хятад эмч тэргүүтэй хүмүүс их хаанд өргөх жижиг мөнгөн тагшнуудтай эм тангуудыг барин цувралдан зогсоно.

Нүлүн ноён:

-Их хаан минь, Хан хөвүүн Ширхэ тулааны талбараас ирлээ.

Ширхэ хан хөвүүн:

- Их хаан аав минь, Сүн улсыг дайлах баруун замын дөчин түмэн цэргийн тулалдааны оройд Арлуудын Боорчи баатрын хөвүүн Бумандай жанжин гоц гарамгай сайн байлдана. Сүн улсын Хэчжоу, Чун –циныг бүслэн авлаа. Их цэрэгт дотор дэгдсэн аюул халуун хижиг өвчинд олон хүлэгтэнгүүд маань нэрвэгдэн, дайны цаашдын үйл түр зогсов. Бумандай жанжин хотын хүнс, усыг таслан боон хүлэх аргыг сонгов. Хаан эцэг минь таны бие хэр шаналгаатай байна? (Хөшигний цаад руу чих тавина) Хаан аав минь, та минь амар амгаланг бай. Халуун хижигт үрэгдсэн цэргийн хүүрийг галаар ариусгасаар байна. (Нүлүн ноён руу толгой дохино)

Нүлүн ноён:

-(Хөшигний ойртон) Их хаантан минь нангиасын орны ангаахуйн эрдэм билигт их хүмүүн ирлээ. (Хөшиг рүү чих тавина) Хаан айлтга хэмээнэ.

Нангиас өвгөн:

- Их хааны амь сахигч нар ухаан билгээ нэгтгэн дэгдсэн өвчин дарах танг найруулан үзэв. Эмийн шинж өвчинд халтай нь илтэд танигдав. Хаан та тан хүртэж соёрхоно уу?

Нүлүн ноён:

-(Хөшигний цаад руу чих тавина. Нангиасийн өвгөнд хандан) Их хаан та бүхэнд талархав. Их цэрэгт хүртээ хэмээн зарлиглав. Харин өөрөө хүртэхийг хаан үл хүсэв.

Ширхэ хан хөвүүн:

-Хаан аав минь, таны илааршин сэргэхийг хан хөвүүн Ширхэ би ихэд хүснэ. Хаан аав минь эм танг таалан болгоохгун. (Ширхэ чих тавина. Эргээд өвгөнд хандана) Нангиасын өвгөн минь, хаан аав тан үл хүсэв. Яв даа та минь. Их цэрэгт эм тан бүрнээ хүргэхгүн.

Нангиасын өвгөн:

- Жа (Мэхийн мөргөнө. Нүлүн ноён олон цартай эм тан барьсан албатуудыг аван гарснаа элчийн хамт хариу эргэн ирнэ)

Нүлүн ноён:

-Их хаан минь, Зүүн замын гучин түмэн цэргийн жанжин Тогучар ноёны элч ирлээ. (Нүлүн ноён элч рүү хандан толгой дохино)

Тогучар ноёны элч:

- Их хаан минь, Монголын зүүн замын гучин түмэн цэргийг тэргүүлэх жанжин Тогучар ноёны цэргүүд Сүн улсын зүүн зүгийн олон хот бэхлэлтийг эзлэв. Их хаан эзэн минь Тогучар ноён Сүн улсын голомт руу зэрэг цэрэглэн хөдлөх зарлигийг танаас хүсэв. (Үргэлжилсэн зогсоц)

Нүлүн ноён:

-(Нүлүн ноён хөшигнөөс нааш эргэн хааны өмнөөс) Их хаан Тогучар ноёныг зүүн замын цэргийг нааш бүү хөдөлгөхтүн хэмээн зарлиглав. Тогучарын элчийг энд үлдээн халуун хижиг өвчний салхийг зүүн зүг бүү одуул, мэхийг сэтгэж хэл мэдээг галаар дохиолон Тогучарын их цэрэгт хүргэ хэмээн засаглав. Тогучар ноёны

элч:- Жа, Их хаан таны бие үтэр түргэн эдгэх болтугай. (Элч явна)

Нүлүн ноён:- Хаан нойрсов.

(Хөгжим) (Үргэлжилсэн зогсоц)

Их хаан Мөнх:

-(Хөшигний цаанаас хаан цочиж сэрэх мэт зовиурт чанга дуугаар) Нүлүн ноён!

Нүлүн ноён:

-Жа хаантаан. (Хөшгөнд дөхөн ирнэ.Сонсоно) Жа, (Хөшигнөөс холдон орж ир хэмээн дохино.Гаднаас Жанжин Тогоон орж ирнэ) Өмнөд Сүн улсыг дайлах дайны сэцдийн хуралдайг ахалсан Жалайр аймгийн Мөнхсарын хөвүүн жанжин Тогоон ирлээ. (Хөшгөнд чихээ наана) Их хаан айлдтугай хэмээв.

Жанжин Тогоон:

-Эзэнт Гүрний их хааныг бие чилээрхсэнд Сүн улсыг дайлах талбарт сэцдийн зөвлөл хэлэлцэн Их хаан Мөнх тань юугаа эзэнт гүрний нутаг орноо буцаан төрөлх нутгийн агаар уснаа хүрэн аюулт өвчнийг гэтлэхэд тус ирнэ хэмээн тогтлоо. Арлуудын Боорчийн хөвүүн Бумандай жанжин их цэргийн баруун замын цэргийг орлон тэргүүлж Эзэнт төрийн аян дайны их хэргийг Бумандай жанжин их хааны орлон гүйцэлдүүлэх нөхцөлтэйг хэлэлцэн их хаан таны таалал дор сэцдийн хуралдайн шийдвэрийг авчирлаа. Хаан та хэрхэхийг зарлиглан шийдтүгэй. (Үргэлжилсэн зогсоц. Хааны ханиалгах чимээ сонстоно. Зогсоц)

Нүлүн ноён:

-Их хаан надад тэнгэрийн товлосон цаг ирэв. Хайрт нутгаадаа хаан би халуун амьтай хүрч үл дийлнэ. Сэцдийн зөвлөлдөөнийг дэмжин Бумандай жанжин их хэргийг цааш үргэлжлүүлтүгэй хэмээн Хаан айлдав. (Чихээ хаан тийш ахин ойртуулан) Ширхэ хан хөвүүнийг хаан дуудаж байна.

Ширхэ хан хөвүүн:

-Хаан аав минь би таны дэргэд байна. (Чихээ тавина. Хөшгийг сөхөж цааш орно. Зогсоц) Хаан аав минь ! (Ширхэ гартаа бортого барин гарч ирнэ) Эзэнт Гүрний их хаан эцэг тэнгэр болов. Их хаан Мөнх өөд болов. (Нүлүн ноён, Жанжин Тогоон нар дор сөгдөн мөргөв. Ханхүү Ширхэ хаан эцэг рүүгээ эргэж газарт сөгдөн тэнгэрт гурвантаа мөргөөд босов. Бортоготойг дээш өргөнө. Нүлүн ноён, Жанжин Тогоон нар Жирхэ рүү харна) Их хаан эцэг алтан гэрээсээ өгөв. Аригбөх ханд хүргэ хэмээгээд алтан бие юугаа их нутгийн мөрөнд ариусгаад Их хаан Чингис, Их хаан Толуй эцгийнхээ

(Хөгжим) (Бүрэнхийлэл)

(Тайзны өмнө зүүн биед Хан Хубилай зогсоно.Түүний дээр гэрэл тодорно)

Хубилай хан:

-Үүрийн зүүдэнд цагаан шонхор үзэгдэв. Хаан ахын сүлд тугны цагаан шонхор амилаад хөх тэнгэр лүү хөөрөөд огторгуй мандал руу цэг мэт алсран төд удалгүй тэнгэрийн үүлнээс чулуу унах мэт миний чанх өөдөөс салхи зүсэн цагаан шонхор шунхан нисэж ирээд баруун гар дээр минь буув. Гэтэл тэр шонхор шувуу гэнэт хувилаад маргад эрдэнийн чулуу болов. Тэр маргад эрдэнийн чулуу өөрөө хагарч үйрэхэд хан би бөгжний чинээг гартаа атгаж үлдэв. Тэнгэрийн дохиог зүүдэндээ үзэв. (Аригун ноён айн түгшин өмнө нь ирж сөгдөв) Аригун өвгүн ноён минь, Амаа хий ангалзуулан мэгдэж сандрах нь юув? Хэлэх үгээ гарган хэлтүгэй.

Аригун ноён:

-Их хаан Мөнх тэнгэрт халилаа. Эзэнт Гүрний их хаан эзэн минь хөх нуруутан биднээ орхиод хөх тэнгэрт одлоо.

Хан Хубилай:

-Мөнх хөх тэнгэр минь. Зүүдний үнэнг хан надад чи авч ирэв. Ай хайран хаан ах минь.

(Хөгжим) (Бүрэнхийлэл) (Тайзны өмнө баруун биед Хан Аригбөх зогсоно. Хан Аригбөхийн гарт Мөнх хааны алтан гэрээст бортого байна. Гэрэл түүн дээр тодорно)

Хан Аригбөх:

-Их хаан ах Мөнх минь, Алтан гэрээс юуг тань гартаа атгав би. Тайлан уншихад бэрх утгыг тань хан би тааварлан яднам. Их Монголын Эзэнт Гүрний Хаан Аригбөх хэмээн намайг та

заасан атал хачирхам утгыг давхар нуужээ. Мөнх тэнгэрийн улс, хөх нуруутны хаан мөрөө
булах чоно лугаа сэрэмжит үйлийг эхлүүлэхтүн. Мөнх хөх тэнгэр минь, тайлал юугаа хаан
надад илгээхтүн! Хамгийг үгэн дотор нуусан үйлийн учгийн үзүүрийг надад хайрла... Өвлийн
чононы бэлтрэг үүрэндээ өлзийтэй. Үнэн. Харин энэ хаант төрийн залгамж ухаан, гэрээс юу
цөсийг минь дэлсүүлэв.

(Хааны сэнтий тайзнаа хоосон үзэгдэнэ) (Хөгжим) (Харанхуйлал)

Наймдугаар үзэгдэл.

8. Их хаан сэнтийд хоёр нар зэрэгцэн мандах болов.

Тайз: Ханбалгас ханы өргөө. Хан Хубилай, Аригун ноён, Хубилай Ханы шадар туслах нар байна.

Аригун ноён:

-Хан Хубилай танд бараалхаар Чжао-Би, Ван-Ө, Яо-Шу түшмэдүүд ирсэн. (Хубилай хан толгой дохино. Өвгүн Аригун ноён жижиг хонх цохино. Хятад түшмэдүүд орж ирэн хаанд сөгдөнө) (Хубилай хан шадар Билигтэд хандана. Нэгийг хэлнэ)

Ханы шадар:

- Хан Хубилай, та улсын бараалхах хэргийг асуув. Өгүүлтүгэй.

Чжао-Би түшмэл:

- Засаглагч Хан Хубилай танд Сүн улсын хаан элчээ ирүүлэв. Таны дорд албат ордны түшмэл Чжао-Би Сүн улсын эзний элчийг түмэнтээ шинжлэн мөн байцаан шалгав. Сүн улсын хааны элч биеэр бараалхах нь зүйтэй хэмээн үзэв. (Хан Хубилай шадартаа нэгийг хэлэв)

Ханы шадар:

-(Ширүүнээр) Сүн улсын хааны элч чи үгээ мэдүүлтүгэй.

Ван-Ө ноён:

- Сүн улсын хааны элч зараал ноён Ван-Ө би Их Монголын Эзэнт Гүрний Төр түшигч Хан Хубилай таны амар амгаланг эрье. Манай Сүн улсын хаан элч түшмэдээ танд ирүүлэн дайнаа зогсохыг хичээнгүйлэн хүсч Наннинд найрамдал байгуулж, улсын хилийг Чинця голоор тогтоож Сүн улс Хан Хубилай танд жил бүр хоёр буман лан мөнгө, хоёр буман хуй торго дурднаар үнэнчээ илэрхийлэн алба өгөхөө мэдүүлэв. (Хан Хубилай шадартаа нэгийг хэлэв)

Ханы шадар:

- Их хаан Сүн улсын хааны элчийн хариуг дараа болгоон өгөхөөр тогтов. (Чжао-Бид хандан) Сүн улсын хааны элчийг амраан цэнгүүлтүгэй.

Ван-Ө түшмэл:

- Хан та түм наслах болтугай. (Мэхийн ухарсаар гарна)

Яо-Шу түшмэл:

-Хан Хубилай тан дор бараалхахаар Гуулин улсын хун тайж морилон ирлээ. (Хан Хубилай ихэмсгээр толгой дохино.Гуулин улсын хунтайж орж ирнэ)

Хунтайж:

- Гуулин улсын Хунтайж би Их Монголын Эзэнт Гүрний хаанд бараалхахаар ирсэн билээ. Хунтайж миний аз дугааж их хаан таалал төгссөн харамсалтай явдалд Хан Хубилай танд Гуулин улсын өмнөөс гүн харамслаа илэрхийлье.

Ханы шадар:

-(Хан Хубилай мөн шадартаа нэгийг хэлэв) Гуулин улсын хунтайж чиний ханыг хүндлэн нааш ирсэн явдлыг ихэд талархав. Танай Гуулин улсыг дайлах дайныг зогсоохыг хүссэн хүсэлтийг хүлээн авлаа. Хан цэргүүдээ татахаа хунтайж чамд амлав.

Хунтайж:

- Хан Хубилай таны агуу их өршөөл нигүүсэл дор мөргөө. (Хунтайж хан Хубилайд мөргөнө)

Ханы шадар:

-Сүн улсын элчээс илүү өндөрт цэнгүүлэн амрааж үдтүгэй.

Чжао-Би түшмэл:

-Жа, Хан таны өргөөнд дуу хуур үүсгэхийг таалан болгооно уу? (Хан Хубилай шадарт нэгийг хэлнэ)

Ханы шадар:

-Хан гагц дан хуучир хөгжмийн уянга яруу аялгууг хүсэв. Түшмэдүүд өргөөг орхихтүн. (Хятад түшмэдүүд мэхийн ухарсаар гарна. Тайзны гүнд гэрэл тодорч хятад эм хуучир намуун аялгууг эхлүүлнэ)

Хубилай хан:

- Хаадын хаан Чингис эзэн Тангуд улсын дайлан мөхөөгөөд тэр улсын хааныг хороохын өмнө хэрхэнийг та мэдэх үү?

Аригун ноён:

-Эзэн Чингис хааны өөрийн биеэр дайлсан Тангудын мөхлийг мэднэ. Гэхдээ Тангудын хааныг цаазлахдаа хаан хэрхсэн сайн санахгүй байна. Нас дээр гарч ухаан минь цуцжээ. Байз. Бурхан гэх нэртэй хаан.

Хубилай хан:

-Өвгүн ноён таны ухаан сийрэг тань гайхам ажээ. Тангудын хаан Дэлүүн Болдогийн Бурхан Халдун хайрхантай адил Бурхан хэмээх нэртэй байсан тул тэр хааныг хороохын өмнө нэрийг нь өөрчлөх зарлиг буулгасан.

Аригун ноён:

-Мөн. Ай гэгээн билигт тэнгэрийн соёрхолт хаан Чингис минь. Сэжгээ арилгаж сүжгээ өргөх өгүүлшгүй билигт их хаан. Мөнх тэнгэр минь.

Хубилай хан:

- Тийм. хан Жамух Таян ханыг айлган сүрдүүлсэн нууц товчооны шүлгийн шаднаас та дуудаач.

Аригун ноён:

-Найманы цэрэгтэй мөр зэрэгцэн явсан Жамухаас Таян хаан асуув. Тэр юун хүмүүс олон хонийг идэж хотонд ортол хөөж ирэх мэт эд юу хүмүүс вэ хэмээн асуув. Тэмүүжин андын дөрвөн нохдыг хүний махаар тэжээж гинжилж уяж байх бөлгөө. Тэд бидний харуулыг хөөн явна тэд. Тэр дөрвөн ноход ширмэн магнайтай, Цүүцэн хошуутай Шивээ хэлтэй, Төмөр зүрхгэй, Илд ташууртай, сүүдрээ элдэж хий унаж яваа тэд. Алалдах өдөр амьтны мах иднэ тэд. Хүрэлцэх өдөр хүний мах хүнсэлнэ тэд. Гинжээ мулталж, одоо эс саатан баясан баягсад тийш шилбэлзэн айсуй тэд гэжээ. Тэр дөрвөн ноход хэн хэн бэ гэвэл Зэв, Хубилай хоёр, Зэлмэ, Сүбэдэй хоёр тэд дөрөв болой хэмээн Жамуха хэлэхэд хаан Таян тэднээс хол байя хэмээгээд уул руу авиран зугтав.

Хубилай хан:

- Өөрийгөө өргөмжилсөн Гүр хаан Жамуха Их Монголын төлөө халуун үгээ хэлж, хурц хэлээн билүүдэв. Жамуха сэцэн Их хааны өргөөнд сүүлчийн удаа уригдан морилоод өргөөнөөс гарч ирээд хурсан олны өмнө хэлсэн өтлөх үгүй үнэн миний мэргэд багш гайхан шагшин өгүүлдэгсэн. Огторгуйд хоёр наран байна уу. Харцгаа. Огторгуйд нэг наран байна. Харлаа. Их Монгол улсад нэг л хаан зөвхөн Чингис байтугай. Дэргэд чинь Чингис хаан байвал чи өөрөө дээд тэнгэрийн хүү, орчлонгийн эзэн гэж мэдтүгэй. Дээр чинь хүн байвал чи өөдгүйн боол, Хижи гөрөөсний идэш гэж бодтугай хэмээгээд Гүр хааны цолоо хаан төрд хураасан билээ. Хаан биеэ буулгасан билээ.

Аригун ноён:

-Язгуурын их хөвүүн Жамуха билээ.

Хан Хубилай:

-Бидний дээд өвөг Өтүгэ улиралын олон толгойтой могойн үлгэрийг хаадын хаан хөвүүдээ дурдан үлгэрлэсэн өгүүлтүгэй. Аригун өвгөн ноён минь, монгол хэлний дуун аялгууг хамтдаа хөгжөөтүгэй.

Аригун ноён:

-Жа, Хаан ширээг залгамжлагчийг тогтоох бага хуралдай эхлэхүйд ахмад хоёр хөвүүн Зүч, Цагаадай нарын харц бие биенээ эсрэг хөвчилсөн нумны сум харвах бэлэн мэт ширтэлцэхийг их хаан үзээд өтүгэ улирлын онго сахиусны үлгэрээр хуралдайг эхлүүлсэн гэдэг. Өвлийн хүйтэн эхэлж цас унах цагаар олон толгойт могой дулаан газрыг ирэн хэрхэн өвөлжихөө хэлэлцэн хэрэлдэв гэнэ. Хэрүүл маргаан үл эцэслэж өвлийн шөнө тасхийв гэнэ. Олон толгойт могой дааран чичрээд орох нүх рүүгээ зүтгэхэд түмэн толгой ийш тийш зүтгэн шөнийг үл гүйцээн тэмцэлдээд үүрээр хөлдөж үхсэн гэнэ. Ухаан санаа чинь алсад оджээ. Хан Хубилай минь бие чинь энд бодол чинь тэнгэр ниснэ.

Хан Хубилай:

-Би шороон түмэн хүмүүсийн дээгүүр нисэв. Үй олон шоргоолжны үүрийг сөхөж үзэв. Үй олон намайг үргэлж айлган цочооно. Их нутгийн дээгүүр бодлоо нисэж үзэв. Онгон тагш нутгийн минь зүг уулын ус шиг хүмүүний урсгал садрахыг харав. Өвгүн ноён минь, Толуй хааны хан хөвүүн би шийдэв. Би хаан. Дэвэн дэлхийн их хаан би байх болно. Өөрийгөө би өргөн өргөмжилж их хааны сэнтийг авах болно. Хан Хубилай, Хаан Хубилай байх хутагтай.

Аригун ноён:

-Мөнх тэнгэр минь!

Хан Хубилай:

- Мөнх тэнгэр надад хэлээ өгсөн. Мөнх тэнгэрийн хүч намайг их хаанд заасан. Цагаан шонхор миний хаан сэнтийн орой дээр суув.

Аригун ноён:

-Хан Хубилай минь! (Сөгдөнө)

Хан Хубилай:

-Киданыг цэрэг зэвсгээр бүрэн эзэлж Монголтой нэгтгэх аваас Монгол Гүрэн мөхнө хэмээх Их Монголын Эзэнт Гүрний Их хаан Чингисийн алтан сургаалыг тайлан би танив. Жиндэн хийгээд Шанду орноо засаглан суухдаа ухааны хайв. Их хатан эхийнхээ сэрж сэтгэтүгэй хэмээн захисныг сэтгэв би.

Аригун ноён:

- Алтан ургийн хан хөвүүн чиний зэрэгт миний ухаан би хичээвч үл хүрнэ. (Зогсоц) (Хуучир тоглогч хөгжмөө тоглохоо зогсоно)

Хан Хубилай:

-(Шадар туслахдаа хандан) Хөгжимч эмийг хороотугай. Аваад яв. (Шадар туслах хан

Хубилайн зарлигийг гүйцэлдүүлэхээр хөдөлнө. Хуучир барин суух эмийг чавчина. Аригун ноён алга ташина. Ордны албат нар орж ирнэ)

Аригун ноён:

-Чихэнд хөггүй хөгжмөөр чимэггүй ая тоглож залхаах эм хан эзнийхээ яриаг бас чагнан ая тасалдуулах эмийг цаазлав. Ордноос гаргаж хая. Монгол цэргүүд хааны ордонг хатуу хүрээнд хамгаалахгүн. (Эмийг чирч явна)

Хан Хубилай:

-(Шадар туслахад хандан) Энэ цагаас хойш хөх нуруутны хэлийг харь хүн сурахыг ханы харьяанд цаазлахгүн. Зарлигийг үйлд.

Ханы шадар:

-Жа. (Гаднаас монгол хишигтэн цэрэг орж ирнэ)

Ханы хишигтэн цэрэг:

- Их нутгаас илч иржээ.

Хан Хубилай:

- Үтэр түргэн өмнө минь ирүүл. (Элч орж ирнэ)

Элч:

- Хубилайн хан таны хатан Чимбай нааш илгээв. Захидал өврөөсөө гарган ирж ханд барив.

Хубилай хан:

- (Захидалыг задлан уншина.Захидалыг гартаа барин) Их хатан Хутухуй, Аландар тэргүүтэй ноёд Хар хоринд Ариг бөхийг хаанд өргөмжлөхөөр зэхжээ. Ордны кидан түшмэлийг ирүүл.

Ханы Шадар:

-(Аригун ноён жижиг хонх цохино. Гаднаас Чжао-Би, Яо-Шу түшмэдүүд орж ирэн бөхийнө) Их Эзэнт Гүрний төр түшигч Хан Хубилай ясу зарлигийг сонстугай. Хан Хубилайн харьяат бүх ноёд, түшмэдийг арван өдрийн дотор их хэрэг хэлэлцэх хуралдайд дуудан ирүүлтүгэй.

Түшмэдүүд:

- Жа, Их Эзэнт Гүрний Хан таны зарлигийг ёсчлон гүйцэлдүүлье. (Мэхийнэ) (Хөгжим) (Харанхуйлал)

Есдүгээр үзэгдэл.

9. Тэнгэрт өрсөлдөн хоёр хаан мандан тодров.

Тайз: Хар хорины хаадын ордон. Их хаан Мөнхийн их хатан Хутухуй, Хан Аригбөх, Жөн Мон Тоба, Нүлүн ноён, Аландар ноён, Ширхэ хан хөвүүн нар болон ордны албатууд.

Их хатан Хутухуй:

-Их Монголын Эзэнт Гүрний тамга сахигч их хатан би их Эзэнт Гүрний Хархорин хотод их хуралдай зарлав. Гүрэн улсын зүг бүрт илгээсэн элчүүдийн Төр түшигч Хан Хубилайгаас бусад хариу эргэн ирүүлэв. Хүлэг хан их цэрэгтэйгээ дайтна. Сири оронг хураан, эзэн султаан Насир Юсиюийг буулгав. Их цэрэг цааш хөдөлжээ. Их цэргийн жанжин Хан Хүлэгийн элч ханы саналыг авчрав. Их хаан Мөнхийн алтан гэрээс Эзэнт Гүрний голомт түшигч Хан дүү Ариг бөхийг заасан тэр ёсоор болтугай хэмээн Хан Хүлэг элчээ ирүүлэв. Төр түшигч хан Хубилай хариу эс ирүүлэн элчийг хоосон буцаажээ.

Аландар ноён:

- Хан Хубилай харьяат ноёдоо нууцаар цуглуулж, хаан сэнтийд санаархан буйг олж мэдлээ.

Хан Аригбөх:

-Хэрхэвч зүйд нийцэхгүй хэргийг хан ах өдүүлэх учиргүй.

Аландар ноён:

-Мөнх их хаанд үнэнч ноён нааш зорин иржээ. Үгийг нь сонсохтүн. (Аландар ноён үүд өөд толгой дохино. Бүгээн ноён орж ирж бүгдэд мэхийн ёслов)

Бүгээн ноён:

-Их хатан Хутулуй минь, Хан Аригбөх минь, би Хубилай ханы хажуунаас ирлээ.

Аригбөх хан:

-Алтан төрийг хэн самууруулахыг хүсэв?

Бүгээн ноён:

- Хан Хубилай. Тэр Хан балигт хаан болохыг хүсэн хуралдай зарлав. Тэр хагарах аюулын үүдийг нээхээр завдана. Үүнийг эс зөвшөөрөв . Эзэнт гүрний хаан төр хагарч бутрахыг харахыг үл төвдөнө. Хаан төрд мөн би тэрслэн урвасан хам хэрэгт шийтгүүлэхгүйн тулд зугтан нааш ирлээ. Үг бүхэн минь үнэн. Кидан дийлэнх ноёдоор Хан Хубилай хүрээлүүлэх билээ.

Ариг бөх хан:

-Харийн сүнсэнд эзэмдүүлэв үү? Хан Хубилай хэний хаан болохыг хүсэх нь энэ вэ!

Бүгээн ноён:

-Хан Хубилай монгол ноёдтой ганцаарчлан уулзаж өөрийгөө хаанд өргөмжлөхийг ятган сэнхрүүлнэ. Үгийн бугуйл цаламд ороогүй дээ урьтан салав. Алаагүй чононы арьсыг өвчих гэж юу болохыг мэдэх монгол ноёд юунд урхидуулж итгэх үнэмших болсныг эс олов.

Ариг бөх хан:

- Итгэх гэнэ ээ. Ямар итгэл үнэмшил вэ?

Бүгээн ноён:

- Мэдсэнгүй. Хан Хубилайг хаанд өргөмжлөхөө шийдсэн нэг ноён намайг хантай уулз хэмээн бас ятгав. Юу өгүүлэхийг өөрөө сонс хэмээнэ. Эзэнт гүрний үнэнг дуулаад Мөнх их хааны ор залгах алтан гэрээсийг мэдээд Хан Хубилайн харьяанаас мултран энд ирлээ.

Их хатан Хутулуй:

-Хан Хубилай хаанд өөрийгөө өргөмжлөхөд энд хэн ч хүлээн зөвшөөрөхгүй. Алтан ургийнхны оролцоогүй өргөгдөх хааны нэр зүүгч тэрийг хэн хаан хэмээн захирагдах гэж? Тийм үү?

Нийтээр:

-Тийм, Үнэн.

Их хатан Хутулуй:

-Эзэнт Гүрний их хуралдай алтан ургийнхан болон ноёд дээдсүүд болзоот Хар хорионд товлосон цагтаа хуралдана. Хаан төрд самуун дэгдээгч этгээд санаа тэрнийг их хуралдай хэрхэхээ шийдэг.

Нийтээр:

-Зөв, Зүйтэй, Үнэн.

Бүгээн ноён:

-Өмнөдийг дайлах эзэн гүрний их цэргийг өөртөө хураан авахыг Хан Хубилай санаархан оролдоно.

Их хатан Хутулуй:

-Энэ үг чинь их хатан намайг айлгав. (Аландар, Аригбөх рүү харна)

Аландар ноён:

-Үнэн болж таарах нь.

Ариг бөх хан:

- Тийм бол тийм. Тэнгэрийн зарлиг, төрийн ясу дор бүгд захирагдах ёстой. Үнэн худлыг их хуралдай олно. Эзэнт Гүрний тамга туг бидэнд байна. Ахиад хатуу сануулгат үгийг элчээр илгээе. Хан Хубилай төрд нэргүй, түмэнд нүүргүй болохоо мэдэг.

Ширхэ хан хөвгүүн:

-Элчээр би авга ах Хубилай руу мордьё.

Ариг бөх хан:

-Хаан төр түүнийг гуйхгүй. Энгийн элчийг одуул.

Их хатан Хутулуй:

-Тийм ээ.

Ариг бөх хан:

- Үүнийг энд тогтлоо. (Бүгд өндийн ёслов) Мэргүн хан дүү Жөн Мон Тоба минь үлд. Хан би Алтан аялгууг сөхөж нэг харахыг хүсэв.

Жөн Мон Тоба:

- Жа, (Тайзны өндөрлөгт тэд өөд өөр өөрсдийн зэрэг дэвийн дагуу зогсоно. Хан Ариг бөх, Жөн Мон Тоба хоёр хамтдаа байна)

Ариг бөх хан:

-Хан Хубилай ах минь, алтан аялгуут гэгээн билигт мөн билээ. Харин хан ах яагаад хаанд өөрийгөө өргөмжлөхөөр шийдэв. Мэргүн дүү минь, оюунд чинь энэ тухай юу байна. Үзсү би.

Жөн Мон Тоба хан:

-Их хатан эх Алтан аялгууг өвлүүлэхдээ Хан Хубилайд газар өгч үүрдийн хаанаар бэлтгэсэн.

Ариг бөх хан:

-Тийм.

Жөн Мон Тоба:

-Үүрдийн хаан төрийн холчийг сэтгэх учиртай.

Ариг бөх хан:

- Мөнх хаан ах минь төвшитгөх их хаанаар бэлтгэгдсэн.

Жөн Мөн Тоба:

- Хаан ах төрийн алдуурсан төмөр жолоог цулбуурыг хурааж гүрэнг төвшитгөж өгсөөр хаан тэнгэрт халив.

Ариг бөх хан:

-Харамсах битүү гуниг минь энэ.

Жөн Мөн Тоба:

- Хүслийн зүйн дээд жаягаар Хүлэг хан ахыг бэлдсэн. Хан ах тэнгэрийн хүслийг газарт мандаан явна. Харин хаан эрдэнийн дээд үлгэрлэлээр Аригбөх хан ах таныг бэлдсэн. Одоо миний хэлэх үг өөрийн бодол тул авах гээхээ та мэд.

Аригбөх хан:

-Мэргүн дүү минь хэл. Авахаа авч хаяхаа би хаясу.

Жөн Мөн Тоба:

- Хан Толуйн хан хөвүүд хамгийн түрүүнд эвийн дээдээр амлуулсан билээ. Хан Хубилай ахын биеэр урсах алтан тэр аялгуу амархан алдрахгүй гэдэгт би итгэнэ. Хан ахын ухаан цоо билээ.

Ариг бөх хан:

- Үнээн дүү минь.Чамд баясав. (Зогсоц) Холч ухааны замыг олон үзүүрт нь хүрэх хэрэгтэй болов. Хаан эрдэнийн хүчээ үзсү. Хувь тавилангаа нэхсү би. Бодол бодлоо алсаас таалцах зам тэмтрэгдэнэ.

(Хөгжим) (Бүрэнхийлэл) (Тайзны өмнө ноёд хатад, түшмэдүүд албатууд зогсоно. Тайзны хойморт хаан сэнтий байна. Хан Хубилайг Их хаан ширээнд өргөмжлөх ёслол болно)

Аригун ноён:

-Мөнх хөх тэнгэрийн хүчний эрхэн дор Их Монгол Эзэнт Гүрний их хаан Мөнхийн хаан ширээг хан дүү Хубилай эрхшээн эзлэв. Их хаан Хубилай Эзэнт Гүрнээ Их Юан гүрэн хэмээн өргөмжлөв. Эзэнт Гүрний хотыг Ханбалиг буюу Кайпинг хэмээн тогтож, шинэ эхлэлт оныг Чжун-тун хэмээн нэрлэв. Их Юан Гүрний төвлөн захирагч эзэн Чантунг их хаан Хубилай.

Цөөн хэсэг албатууд:

-Хурай... Хурай... Хурай...

Ихэнх албатууд:

- Их Юан Гүрний их хаан түм наслаг. Түм наслаг. Түм наслаг.

(Тайз эргэнэ. Хааны сэнтий эргэхэд түүний нөгөө талд мөн хааны сэнтий байх ба түүн дээр Хаан Аригбөх суусан байна)

Нүлүн ноён:

-Их хуралдай Эзэнт Гүрний хот Хархоринд хорин хоног хуралдсан дор Их Монголын Эзэнт Гүрний Мөнх их хааны орыг Толуй хааны дөрөвдүгээр хөвүүн Аригбөх эзлэн, Их хаанд тодрон тогтлоо. Их Монголын Эзэнт Гүрний их хаанаар Аригбөх өргөгдлөө.

Нийтээр бүгд:

-Хурай... Хурай... Хурай...

Их хатан Хутулуй:

-(Бортогийг барин урагш гарна) Эзэнт Гүрний тамга сахигч их хатан би бээр Их хаан Мөнхийн гэрээс ёсоор, ёст Их хаан Аригбөхөд алтан төрийн хабсу хасу тамгыг өргөв. (Их хаан тамгыг хүндэтгэн авна)

Их хаан Аригбөх:

-(Гараа дээр өргөнө) Мөнх тэнгэрийн хүчин дор, Эзэн Богд Чингис хааны суу дор Их Монголын Эзэнт Гүрний Их хаан Аригбөх миний зарлигийг сонсохгүн! Мөнх Хөх Тэнгэрийн зараалаар дээд тэнгэрээс заяат төрсөн хөх нуруут бид тэнгэрийн дор Нэгэн Эзэнт Гүрэн, Нэгэн Хаант улсыг бүтээн Их Монголын ясу зарлиг, хуулийг дэлхийд мөрдүүлэн тулгах эрхтэнгүүд билээ. Далай Их хаан эцгийн алтан гэрээс юуг атган Их Монгол улсын босоо оршихуйн жаягт Алтан Дээд Гэриэг хаан би бээр мөрлөн Их засахуйн ясу зарлигийг бататгахаа андгайлав. Их Монгол Эзэнт Гүрний иргэд хүн төрөлхтөнд ариун чин шударгуу хууль цаазыг хөх нуруут бид тогтоон бөхлөх болно.

Нийт бүгдээр:

- Уухай... Уухай... Уухай...

(Хааны сэнтий эргэхэд түүний ард талд байх Хубилай хаан тайз руу харах болно. Ийн их гүрний хааны сэнтий хоёр хаанд зэрэг эзлэгдэх нь харагдана)

Жүжгийн төгсгөл ба Тавдугаар жүжгийн эхлэл титэм

Их хаан Хубилай:

-(Гараа өргөөд буулгана.Шадар туслах хааны зарлигийг дэлгэнэ)

Хааны шадар:

-Их хааны зарлиг сонстугай. Мөнх хөх тэнгэрийн хүчний эрхшээл дор, Их Юан Эзэнт Гүрний их хаан Хубилай миний зарлигийг дагахгүйн. Эзэнт их Гүрэнд шинэ цагийг их хаан би эхлүүлэв. Би ертөнцөд дэг журам тогтоохын тулд их дээдсийнхээ хууль, алба татварыг мөрдүүлнэ. Их Юан Гүрний их засгийн ясу зарлиг дор тойгтон бүхэн нугарч,толгойтон бүхэн сөгдөхгүйн. Энх амгалангийн хаан би ихэс дээдсийнхээ итгэл үнэмшил дор хүмүүнийг засаж, хөрстийг энхжүүлэн жаргаах хувьт хаан билээ. Тэнгэрийн ерөөлт хаан би бээр ертөнцийг гэгээрүүлэх үрийг дэлхий дахинаа соёолуулан энх амрыг дээдлэх, төвшин сайханг зоригдсон үүрдийн хааны хутагтай билээ. Амар амгаланг хэн хүснэ. Тэр намайг дагахгүйн. Тэнгэрийн жаргалан хэн хүснэ. Тэр намайг биширтүгэй. Их Юан Гүрнийг мандуулахаар хаан би зориглон тэмүүлэв.

Цөөн хэсэг албатууд:

-Уухай... Уухай... Уухай...

Ихэнх албатууд:

- Их Юан Гүрний их хаан түм наслаг. Түм наслаг. Түм наслаг.

Марко Поло:

- Ром, Франкуудын ихэс дээдсүүд минь элч Марко Поло би эзэнт гүрэнд зорчоод ирлээ. Эзэнт гүрний нийслэл бахдам гоо үзэсгэлэнт бөгөөд хятад, персийн урчуудын хүчийг ашигласан ба мөн христос шүтлэгтэн уран дархчууд нэгэн сайхан сүмээ бас барьж байгуулжээ.Их хааны ордонд агуу гайхамшигтай нэгэн том мөнгөн мод байх ба тэр модноос мөнгөн жимс унжиж модны голыг дөрвөн алтан луу орооно. Модны ороонд ташаандаа бишгүүр барьсан тэнгэрийн элч зогсоно. Мөнгөн модны хөндий дотор араа шүдтэй оньс ажиллаж, зарц хамжлагууд ундаа хиймэгц ид шид амилах мэт болно. Хаан зочдодоо ундаа барихыг хүсвэл тэнгэрийн элч бишгүүрээ үлээхэд могойнуудын амнаас дөрвөн зүйлийн исгэлэн ундаа оргилж модны ёроолд тавьсан мөнгөн торхонд асгарна. Могойнуудын амнаас цухуйх цорго бүрээс айраг, будааны болон зөгийн балны дарс зэрэг зүйл зүйлийн ундаа оргилно. Их хотын энэ мөнгөн модны дөрвөн могой монгол гүрэн дөрвөн зүгийг эрхшээн тэтгэх ертөнцийг дөрвөн зүгт эзлэх зорилгыг далдуур бэлэгддэг ажээ. Монголын христос шашинтангууд бурханыг гэрэлтэй ялангуяа өөрсдийнх нь домогт өгүүлдэг алтан шаргал өнгийн гэрэлтэй холбож үзнэ. Христос шүтдэг нэг монгол жанжин өөрийгөө христийн шүтлэгтэн гэдгээр бус харин монгол хүн гэдгээр тайлбарлана. Тэдний шүтлэг бишрэлийг ойлгох амаргүй. Есүсийг талархсан хэрнээ эзэнт гүрний хаан эцэг Есүхэй хэмээн эндүүрнэ. Есийн тоог их бэлэгдэнэ. Эсвэл тэд Есүсийг есийн тоогоор ойлгож байгаа мэт. Монголчууд үхлээс цэрвэдэг ба та нарынзовж шаналан цовдлуулсан шүтээний дүрс муу ёрын шинжтэй хэмээнэ. Магадгүй тэд ассирийн буруу номтонгуудын үгэнд авсан хэрэг. Эзэнт гүрний Мөнх

хаан өвдөж үхсэн ба харин хаан ширээг булаалдан хоёр хаан тодров. Тэдний нэрийг Хубилай, Ариг бөх гэх ба тэд өмнөх хааны дүү нар ажээ. Тэдгээр монголчуудын оюун ухаан таагдашгүй тул хэрхэхийг угтан хэлэхэд бэрх. Тэд юу ч хийж мэднэ бас юуг ч сэтгэж мэднэ. Тэнгэрт зэрэг мандах хоёр нар мэт энэ хаад дэлхийн хавтгай газрыг арслан барсын ноцолдооноор буулган хаяж мэднэ. Эсвээс тэд эвсэн нэгдэж биднийг туулай мэт тасдан хувааж ч мэднэ. Тэднээс сайн сайхныг хүлээх нь ариун шүтлэгт үл нийцэх ба загалмайтангууд нэгэн тугийн дор нэгдэн бурханыг өмөөрөн дайтах цаг иржээ. Дэлхийг эзлэн түрэмгийлэгчдээс биднийг Ариун Мария хамгаалах болтугай.

(Эзэнт Гүрний хэнгэрэгний дэлдээн, бүрээн дуу дуурсана) (Хөшиг)

(Мөнх хаан дөтдүгээр жүжиг өндөрлөв)

Хубилай Хааны санаа

Хөх Монголыг төрөөр бадраах хутагтай нэүрит засгийн

Алтан дээд үнэний аялгууг хөх монгол иргүн эс дагаваас...

Хоёр ертөнцийн устгалд доройтон тамлагдаж алагдаад

Хүн болж төрсний хэрэг нь хэрээг цатгахад зориулагдмой.

Тавдугаар жүжигт тодрох гол дүр:

Их Юан Гүрний Их хаан Хубилай

Их Юан Гүрний их хатан Чибан

Жүжгийн илрэх бэлэгдэлийн дүрүүд:

Их Монгол Эзэнт Гүрний Эзэн хаан Чингис

Их Монгол Эзэнт Гүрний Их хатан Өүлэн

Их Монгол Эзэнт Гүрний Далай их хаан Өгэдэй

Их Монгол Эзэнт Гүрний Далай их хаан Толуй

Их Монгол Эзэнт Гүрний Их хаан Гүюг

Их Монгол Эзэнт Гүрний Их хаан Мөнх

Их Монгол Эзэнт Гүрний Их хаан Аригбөх

Их Монгол Эзэнт Гүрний Их хатан Сорхагтан

Их Монгол Эзэнт Гүрний Төрийн хан Хүлэг

Их Монгол Эзэнт Гүрний Төрийн хан Жөн Мон Тоба

Жүжгийн сөрөг дүрүүд:

Хан Хайду, Наян ноён, Хан Жирхэ, Хан Юбугур, Ноён Сүнсбай, Жанжин Тугтөмөр ба бусад ноёд

Жүжгийн хамжаа туслах дүрүүд:

Их хатан Хутулуй, Мөнгөнүхэн охин, Хатан Алалтун бэхэ, Бага хатан эх Мүхэ, Өлжий бэхэ, Хан Хөхөө, Аландар ноён, Бөө, удган, Чжао-Би, Ван-Ө, Яо-Шу, Бенедикт сүмийн лам Матью

Парис, Ромын элч санваартан, Буддын лам Пагва, Пласано Карпини, Франкийн элч санваартан Гильбом Де Рубрук, Марко Поло, Гумилев Аригун ноён, Нүлүн ноён, түшмэдүүд, хишигтэн, цэргүүд, хэвтүүл, аягач шивэгчид, бусад

Тавдугаар жүжиг

Жүжгийн явдал

Нэг бүлэгт-Есөн үзэгдэлт

-Тэргүүн жүжгийн эхлэл титэм

1.Тэнгэрт хоёр нар мандах мэт газарт хоёр хаан тодров

2. Арслан барсын ноцолдоонд хөрс хөрвөв

3.Маргад эрдэнийн хаант улс хагарав

4.Их хаан Хубилайд,Их хаан Ариг бөх ирэв

5. Их хаан Ариг бөх тэнгэрт гарав

6.Монгол ноёд тал нутгаа эрхэмлэн одов

7.Цагаан дэлт чононы сүнс тал газрыг эзэгнэв

8.Дэлхийг мэдсэн Их хаан Хубилай дээд тэнгэрт морилов

9.Алтан дээд гэриэт Хөх нохойхон Алтайн ууланд нууцлагдав

-Дөрөмсөн жүжгийн жаргаах төгсгөл титэм

Тавдугаар жүжгийн эхлэл титэм

(Тайзны өмнө ноёд хатад,түшмэдүүд албатууд зогсоно. Тайзны хойморт хаан сэнтий байна. Хан Аригбөх Их хаан ширээнд өргөмжлөх ёслол)

Их хаан Аригбөх:

-(Гараа дээр өргөнө) Мөнх тэнгэрийн хүчин дор, Эзэн Богд Чингис хааны суу дор Их Монголын Эзэнт Гүрний Их хаан Аригбөх миний зарлигээг сонсогтүн! Мөнх Хөх Тэнгэрийн зараалаар дээд тэнгэрээс заяат төрсөн хөх нуруут бид тэнгэрийн дор Нэгэн Эзэнт Гүрэн, Нэгэн Хаант улсыг бүтээн Их Монголын ясу зарлиг, хуулийг дэлхийд мөрдүүлэн тулгах эрхтэнгүүд билээ. Далай Их хаан эцгийн алтан гэрээс юуг атган Их Монгол улсын босоо оршихуйн жаягт Алтан Дээд Гэриэг хаан би бээр мөрлөн Их засахуйн ясу зарлигийг бататгахаа андгайлав. Их Монгол Эзэнт Гүрний иргэд хүн төрөлхтөнд ариун чин шударгуу хууль цаазыг хөх нуруут бид тогтоон бөхлөх болно.

Нийт бүгдээр:

- Уухай... Уухай... Уухай...

(Хааны сэнтий эргэхэд түүний ард талд байх Хубилай хаан тайз руу харах болно. Ийн их гүрний хааны сэнтий хоёр хаанд зэрэг эзлэгдэх нь харагдана)

Аригун ноён:

-Мөнх хөх тэнгэрийн хүчний эрхэн дор Их Монгол Эзэнт Гүрний их хаан Мөнхийн хаан ширээг хан дүү Хубилай эрхшээн эзлэв. Их хаан Хубилай Эзэнт Гүрнээ Их Юан гүрэн хэмээн өргөмжлөв. Эзэнт Гүрний хотыг Ханбалиг буюу Кайпинг хэмээн тогтож, шинэ эхлэлт оныг Чжун-тун хэмээн нэрлэв. Их Юан Гүрний төвлөн захирагч эзэн Чантунг их хаан Хубилай.

Цөөн хэсэг албатууд:

-Хурай... Хурай... Хурай...

Ихэнх албатууд:

Их Юан Гүрний их хаан түм наслаг. Түм наслаг. Түм наслаг.

Их хаан Хубилай:

- (Баруун гараа дээш өргөнө.Хааны шадар туслах зарлиг дэлгэнэ)

Хааны шадар:

-Их хааны зарлиг сонстугай. Мөнх хөх тэнгэрийн хүчний эрхшээл дор, Их Юан Эзэнт Гүрний их хаан Хубилай миний зарлигийг дагахтун. Эзэнт улсад Их Юан Гүрний шинэ цагийг их хаан би эхлүүлэв. Би ертөнцөд дэг журам тогтоохын тулд их дээдсийнхээ хууль, алба татварыг мөрдүүлнэ. Мөнх тэнгэрийн хүч дур хүслэн дор , их засгийн ясу зарлигт Их Юан Гүрний тойгтон бүхэн нугарч, толгойтон бүхэн сөгдөхтүн. Энх амгалангийн хаан би ихэс дээдсийнхээ итгэл үнэмшил дор хүмүүнийг засаж, хөрстийг энхжүүлэн жаргаах хувьт хаан билээ. Тэнгэрийн ерөөлт хаан би бээр ертөнцийг гэгээрүүлэх үрийг дэлхий дахинаа соёолуулан энх амрыг дээдлэх, төвшин сайханг зоригдоно. Амар амгаланг хэн хүснэ. Тэр намайг дагахтун. Тэнгэрийн жаргаланг хэн хүснэ.Тэр намайг биширтүгэй.

Марко Пологийн зараал:

- Венецийн ихэс дээдсүүд минь, Марко Пологийн зараал байна би. Их Эзэнт Гүрнийг нүдээр үзээд ирлээ. Тэр их эзэнт гүрний хаан ширээг булаалдан хоёр хаан зэрэг гарч ирэв. Тэдний нэрийг Хубилай, Аригбөх гэх ба тэд өмнөх хааны дүү нар ажээ. Тэд дэлхийг байлдан дагуулагч аймшигт Чингис хааны ач нар бөгөөд хаан ширээгээ булаалдав. Хэрхэхийг нь угтан хэлэхэд бэрх бөгөөд эл монголчуудын оюун ухаан таагдашгүй. Тэд юу ч хийж мэднэ бас юуг ч сэтгэж мэднэ. Тэнгэрт зэрэг мандах хоёр нар мэт энэ хаад дэлхийн хавтгай газрыг арслан барсын ноцолдооноор буулган хаяж мэднэ. Эсвээс тэд эвсэн нэгдэж биднийг туулай мэт

тасдан хувааж ч мэднэ. Дэлхийг эзлэн түрэмгийлэгчдээс биднийг Ариун Есүс хамгаалах болтугай.

(Эзэнт Гүрний хэнгэрэгний дэлдээн, бүрээн дуу дуурсана)

Нэгдүгээр үзэгдэл.

1. Тэнгэрт хоёр нар мандах мэт газарт хоёр хаан тодров.

Тайз: (Өмнөх тайз хэвээрээ байна. Хаан сэнтий эргэж Аригбөхийн эзэгнэлт төр үзэгчид рүү хандана. Их хатан Хутулуй, Аландар ноён, Жөн Мон Тоба ба ордны албатууд)

Аландар ноён:

-Хан Хубилай хаан гэж өөрийгөө заан нэрлэж ёсолжээ .Эзэнт Гүрний хураасиуа хугалж, ичгүүрээ илчилж их гүрний төрийн заналт дайснаар өөрийгөө зарлалаа. Булхай тэр этгээд булаасан газар орноо Юан улс гэж харь санаатны хэлийг дэвшүүлж, хаант төрийн цэргийн хагасыг засаглан булаав. Ичгүүргүй боулүхае өөртөө урьд Чанчунь гэх хятад алдар соёрхож босоо хижи гөрөөсний хаанд дэвшив. Ёс их хаан Ариг бөхийг ёроор ёдорлов. Тэнгэрээс урвагчийн тэр хар толгойг хэрхэхийг Их Монгол Гүрний хаан та мэдтүгэй.

Их хатан Ариг бөх:

-(Сэнтийнээсээ босно. Буцаж сууна) Монгол гүрнийг хасаж, миний төрийг хясна гэнэ ээ. Этгээд алдар, эв эвдэх гутамшиг. Аландар жанжин чи дагах ёсон ноёныг авч тэнгэрийн ёс ясуг тулгах хаан миний үгийг мандуулан харь хятадад толгойгоо зарсан миний мунхаг ахыг сэхээн сэхээрүүлэхээр одтугай. Алун гоо эхийн сургаалыг сануулж ах дүү таван алт, мөнгө, хүрэл, мод чулуун, зэвт сумыг өргөн очтугай. Миний ахын ухааныг бөглөсөн мунжийн зовлонгоос мултран бүчсэн боолуудыг түлхэн, бүрэн эрхээр ноёд түүнийг түшин төв төрд улсыг эргүүлэн хураатугай. Учир бүхнийг дуулж Аландар жанжин чи хариу иртүгэй.

Хан Жөн Мон Тоба:

- (Хааны өмнө ирж ёслно) Хаан ах минь би хамт явья.

Их хаан Аригбөх:

-Хаант төрийн номын ёсоор хаан миний гарт ойр өргөөнд минь мэргэн дүү чи үлдтүгэй..

Их хаан Хутулуй:

-(Суудлаасаа босож ирнэ) Ариг бөх хаан та, ах дүүгийн ёс, эвийг эрхэмлэх нь гайхамшигтай. Гэвч хаан та, засаглалыг таллан тэрслэгч түүнийг ноёдын үгэнд номхорно гэдэгт бүү итгэ. Басамжлал, доромжлол суудлыг өндөрт өргөөд, алтан төрийг адаглан доройтуулах түүнийг, бөтүүхэндээ хайрласаар бүхнийг та зовоох бус уу? Хэрхэвч үл тэвчих хэргийг хан Хубилай өдүүлэв. Хэрэгт нь таарах цээрлэлийг тулгах бус уу?

Аландар ноён:

-Даруй дайтан дарах хэрэгтэй. Тэнгэрийг уландаа сэтгэж, төрийг хөлдөө жийж, тийрэнгүүдийг хөлөглөх тэрслүүдийн орныг газарт сэрээх тэр хэн бэ? Их төрийн дайсан.

Эвийг залгисан арван толгойт атгаалжид илбийн ухаан бий тул тэр булхай өмнийг эрхэндээ шүүрч, улсын цэргийг хийморийг булаалдав. Өмнөдийн хан ноёд түүнд хэдийн бөхийсөн хэрэг бус уу. Дайлан дарах хэрэгтэй. Өрөвдөх бус үзэн ядах түүнд зохилтой.

Жөн Мон Тоба:

-Алаг дэлхийн инд арслан барс ноцолдвол амьтан бүхэн сүйтэх аюултай. Хөх тэнгэрийн үнэнг хүргэж мэдүүлэх нь зөв. Их ах нар элс цасыг цусаар зурвал их мууг эзэнт төрд хураан авчирна. Дайтан бүү тулалд. Хэн ч ялахгүй. Хаан төр хохирно. Хүмүүн бүгд зовно. Аргыг тэнгэрээс эрж, билгийг газарт буулгатугай.

Их хаан Аригбөх:

-Мэргүн дүүгийн зөв. Уулнаас ухна унаж ирсэн, хангайгаас буга унаж бууж ирсэн удган, зайранг урьтугай. Тэд надад тэнгэрийн үгийг хэлсэн. Олуул одоо сонстугай.

Зайран:

- Тоононд тас өндөглөж, тогоонд чоно гөлөглөж, туурга нэвт туяа тусаж, гэр нэвт гэрэл гийж, эрүүгээ авч, нуруугаа маажиж, эхнэр хүүхэд хаданд гал цахиж эмээлтэй морь эзэнгүй давхиж, үхэр мал үлий оготоно барьж, үзээгүйгээ үзэж, хараагүйгээ харж, үүл нар саранг манаж, өвс ногооны үндэс хийснэ. Аргалын оронд чулуу үүрч, адууны оронд шуурга унана. Гай гамшиг шургах бүхнээр шургаж, гадаа гэрээ ялгахаа болино.

Удган:

-Зүүд харласаан. Харласан. Хар зөн татаж сэрээж хашгирч босон ирэв би. Тодорхой цагаан сарны толинд хүний толгой хүзүүндээ зүүсэн хүүхэн ёрын инээдээр инээв. Ахын минь толгой энэ гээд алиа дуу гарган баясав.

Бүгд цугаар:

-Ай бүү үзэгд!

Их хатан Хутулай:

- Юу гэнэ ээ? (Суудлаасаа босож ирнэ) Зүүдний ёр (эргэн сууна)

Удган:

-Хатан минь ээ!

Их хатан Хутулуй:

-Цааш бүү ярь. Агаарт аймшиг ёр дэгдэнэ. Амаа үдтүгэй.

Жанжин Аландар:

-Гай түйтгэрээс мултрах цагаан зөн ирэв үү.

Удган:

-Сүйрэл, сүйтгэл хаа сайгүй нөмрөх аюулын дохиог л ирэв. Уулын магнай л ариун тунгалаг сэрүүн үлдэнэ. Хормой бэлээр хиарч үхсэн амьтны сэг зэм хаа сайгүй сэрийн сарайж дажин, түжингийн зовлон хөллөөд, гаслан гамшиг удна. Сарны толь бүтэн хиртэж дуусаад сая нэг амирлинг олно.Энэ цаг хэр удахыг их тэнгэрээс асуун хэнгэргээ нүдлээ.Тэнгэр таг дуугүй.Тэнгэрээс хариу олсонгүй.

Зайран:

- Амирланг үзэх нь үзнэ. Одоо биш гэхнээ алсдаа харна. Нэгэн сувд нүхэнд нуугдаж, тэр газар салхины гараар илбүүлэн илбүүлэн, унасан нүх нүх биш дов болоход газраас эрдэнэ гэрэлтэнэ. Гэрлийг нь олсон олон иргэн гэгээрэн дээшилнэ.

Их хаан Аригбөх:

- Бүчсэн бүхэн бүгд сонсов. (Зайран удган хоёр мэхийгээд явна) Их засагт зааснаар гэрийн онолыг нийтээр хэлэлцсү. Мэргэн хан дүү Жөн Мөн Тоба алтан аялгууг дуудсугай.

Хан Жөн Мөн Тоба:

- Алтан аялгууг дуудсу би. Дэлхийчлэн гэгээрч, тэсэж магад гарахуйн тэнгэрийн бөө тархийг гэр онгоноор төсөөлж, улсаа өмөөрөн босоо орших есөн ухааныг ханаар нь болгон соёрхжээ. (Гэрэл бүүдийн бүрэнхийлнэ.Их хатан Хутулуй дээр гэрэл цохон очно)

Их хатан Хутулуй:

- (Хатан суудлаасаа өндийнө.Зөвхөн түүн дээр гэрэл тусна) Миний хийсэн нүгэл, төрд ёр болох тэмдэг дохио боллоо. Ах дүү хоёрын нэгийг нь эхлэн цаазлаад дүү охинд нь толгойг нь зүүлгэсэн даажигнал. Бүү үзэгд. Удганы зүүдэнд ирэв. Мөнх хаан эр минь хатан миний хийсэн нүглийг цээрлүүлж, хоол ундгүй хар гэрт долоон өдрийн нар саран үдүүлсэн. Сүүлчийн гэсгээлт өдөр амь бүлээн таслахын алдад аманд минь сүү цутган хатан би үхлээс эргэн ирсэн. Тэр нүгэл нимгэрэн дууссан гэж би бодсон. Эгэл эмийн нүглээс илүү их хүндийг их төрийн хатан үүрдэг ажээ. Нэг нүгэлт үйл нижгээд хүндийг дагуулах нү ээ. Мөнх тэнгэр минь өршөө. (Суудалдаа сууна) (Гэрэл тодорно. Жөн Тобо гэрийн онолоо үргэлжлүүлнэ.Саях хатанг хэн ч үл сонссон байна. Хатны бодол байх болно)

Жөн Мөн Тоба:

- Ухааныг хана мэт хатгаж, төрөл бүлээ төвөг хэцүүгээс хамгаалж, төвшин сайхныг хашиж,мэдлэгийг унь болгон нүүдлийн соёлоор өргөж, зөн жаягийг тооно болгож төрөл бүлээрээ гэгээрсэн тэнгэрийн бөө тархины онолт гэр улс билээ.

Нүлүн ноён:

- Их хаан минь ээ. Хар хоринд олон хөлийн наймаачин худалдаачид талцан зодолдов. Их үймээнийг нэгэн ноён үүсгэжээ. Авдар сувд газраар асгарч амьтан хүн түүн дээр булаалдан зодолдоно гэнэ.

Их хаан Аригбөх:

-Хаанахын хэн хэмээх ноён тэр вэ?

Нүлүн ноён:

- Мянгатын ноён Цээж бөх

Их хаан Ариг бөх:

-Эмх журам алдарч, эдийн хэрүүл энд тэндгүй дэгдэх болов. Үтэр түргэн цэрэглэн бүгдийг нь барин хүл. Чанга хатуу шийтгэлээр олны өмнө тэр ноёныг цавч.

Нүлүн ноён:

-Жа. (Явна)

Их хаан Ариг бөх:

- Гэр хийгээд гийчдээ гэгээрүүлэх буман жилийн тэнгэрийн алтан хурыг хураасан билиг билгүүний өв их хөрөнгөтэй гүрэн билээ. Эзэнт гүрнийг засан засаглахаар Их хаан би төрд тэрсэлсэн хан Хубилайг гүрний тэргүүн дайснаар нэрлэн заав.

Бүгд цугаар:

- (Жөн Мөн Тоба, Их хатан Хутулуйгаас бусад) Зөв. Зүйтэй. Мөн. Тэр мөн.

Аландар ноён:

-Аюул биднийг өмнөөс урив. Алсын зовлон зүдгүүрээс өрсөн дарцгаая.

Бүгд цугаар:

- (Жөн Мөн Тоба, Их хатан Хутулуйгаас бусад) Тийм. Дарцгаая. Зөв. Зүйтэй. Мөн. Тэр мөн.

Хан Жөн Мөн Тоба:

-(Хааны өмнө ирнэ. Мэхийнэ.) Аригбөх хаан ах минь, Хаадын хааны зарлиг ёсоор гэрийн хэргийг гэрт шийдэх ясу ёс бий билээ. Хүлэг хан ахыг дуудан гэрийн хэргийг хан ах нар гэрт хэлэлцвэл зөвийг олох болов уу? Хэдийгээр холын аянд Хүлэг хан ах одсон ч эргэн ирэхийг хүлээх зөв болов уу?

Аландар ноён:

-Мянган уул, түмэн гол гатлах их цэргийн явдал их болно.

Их хатан Хутулуй:

-(Хааны өмнө ирж сөгдөнө)Эзэнт Гүрний их хаанд айлтгах үг байна. Их хаан Мөнхийн их хатан би эзэнт төрийн хэргээс амсхийн холдох цаг ирлээ. Шинэ улирлын нялх ногоо ургахад урьд зуны өвс тэглэнэ. Хар хорин хотын хатан миний мэдлийг хаан төрд эргүүлэн би өгч байна.Төрийн их хатан миний цаг дуусав. Гэрийн хатнаар галаа сахъя. Буурал өтгөсийг асарч, буйд газар одъё.

Их хаан Аригбөх:

- Төрийн хатан таны ачлал их билээ. Тааллаар тань болгоё. (Их хатан суудалдаа сууна.Их хаан сэнтийнээсээ босно) Мөнх хөх тэнгэрийн ясу ёсоор тэнгэрт нэг нар газарт нэг хаан тодрон мандах хутагтай. Их Монгол улсын ёст их хаан би бээр Эзэнт Гүрний жолоог булаалдан төв төрийг хагалан хуваахыг санаархсан тэнгэрт тэрсэлж өөрийгөө хаанд өргөмжлөх ёс бус Хубилай ханыг номботгон дарж төрийн жолоог нэгэн гарт зангидан хураахаар дайтан тулах болов. Хан Хүлэг рүү элч довтлог. Хаан төрд ханы цэргийг эргэн ир хэмээн зарлиглав би. Эзэнт Гүрний дайны тэнгэрийг урьж хар сүлдийг асаан хүлэгт их цэргүүдээ аван хаан би мордох болов. Их Монгол Эзэнт Гүрний цэргүүд хаан миний ташуурын чигт дайлахаар аянд мордохгун.

(Хөгжим) (Харанхуйлал)

Хоёрдугаар үзэгдэл.

2. Арслан барсын ноцолдоонд хөрс хөрвөв.

Тайз: Монголын хээр тал. Дайны бүрээ хангинана. Их Монгол Эзэнт Гүрний дайны хар сүлдний дор Их хаан Аригбөх, Хан Жөн Мон Тоба, Аландар, Хундагай жанжингууд Хан Алгуй, мөн Нүлүн ноён болон хааны цэргүүд байна.

Аландар жанжин:

- Дайсан минь хэт ухаалаг байна. Харав уу? Их талын өрөг дээрхи шатрын нүүдлийг тэр мэргэн сэтгэж нүүв. Нэг морьтон цэргийг даган богино жадат дөрвөн явган цэрэг явна. Аравтыг задалж тавд хуваан, тавтыг нэг хүлэгтэн тэргүүлэн тус бүрдээ тулааныг удирдаж байна. Тус тусдаа өрөгтэй шатар болов. Хан Хубилай явган цэргүүдийг тулалдаанд ашиглаж бүрнээ чадахыг хар даа.

Их хаан Аригбөх:

-Тавина гэж байхгүй таван хурууны ухаан энэ байна.

Аландар жанжин:

-Морьтон довлон орох, арагш ухрахад ч богино жад илдээр зэвсэглэсэн явган цэргүүд өмнө нэг гарч, ард нь нэг орж мөн морьтонг даган чадамгай эргэж хатгалдан тулалдана.

Их хаан Аригбөх:

-Нүүдлийн суумлын хоёр их ертөнцийн ухааныг нэгтгэхийг харж байна.

Хундагай жанжин:

-Тийм ээ. Тавтыг хэрхэн хуваах вэ?

Их хаан Аригбөх:

-Тулгын гурван чулуу мэт тулан гурван ухаан, гурван үзүүрт чичих зэв, гурван хүлэгтнүүдийн холбоо дийлнэ. Гэхдээ дайсан минь үүнийг таасан байгаа. Бидний хүлэгт цэрэг тэднээс илт цөөн. Ихийг урвуулан эзэмдэх хүчээ эхлүүлсэн байна.

Хундагай жанжин:

-Аравтыг тулалдааны замд гуравт хуваах уу?

Их хаан Аригбөх:

-Гурван хүлэгтэн тавт руу зэрэг довглоход тавгууд хоёроор үржинэ. Ахиад аравт болоход тав

руу тавг нийлж дахин тавг ирж дахин дахин үржинэ. Хүний олон явганууд хүлэггүй атал бүгд хүлэгтэн, морьгүй атал морьтон болов. Хан Хубилай явгануудад хий морь унуулав. (Зогсоц)

Хан Алгуй:

-(Бахархангуй) Харийн явгануудыг хаан Хубилай хийморлиг болгов. Тэдэнд зориг гэхээсээ зүтгэл их байна. Монгол нэг хүлэгтэн дөрвөн явган хятадыг өөртөө засаглан сургасан хэрэг.

Их хаан Аригбөх:

-Санаснаас минь илүү ихээр чадвар суулгажээ. Дайсан маань ухаантай магтах хэрэгтэй.

Нүлүн ноён:

-Залуу Хубилай Та Ли хотыг нэг ч амины гарзгүй буулгаж авсан. Хүний амь хороохыг цаазлан хорилоо гэсэн бичигтэй туг хиарыг бариулан гурван элчийг том хот руу оруулсан гэдэг. Бид хүн алж болохгүй юм байна тэд ч биднийг алахгүй юм байна гэж бодцгоон их цэрэг орж ирэхэд сэлэм далайлгүй бууж өгсөн гэдэг. Арга үгүй сэцэн билигт. Хубилай хятад хүнийг мэднэ. Хан Сүн улстай дайтах албыг түүнд л тохоодог.

Хан Алгуй:

- Тийм. Тэрнээс болж урьд газар түүнийг урхиндаа авчээ.

Их хаан Аригбөх:

-(Тэднээс холдоно өөртөө) Хубилай ахад уурлах тутам аргаддаг. Хэн хичнээн оволзоно төчнөөн арга хайна. Тэр аргалах арга олж чаддаг юм. Бухимдаж оволзож болохгүй. Ухаан нь гаарах болно.

Хан Алгуй:

-Хан Хубилай цэргүүд их талыг эзлэв. Ганга нуурын наана гарч ирэхээр зэхэв. Ялалт дайсны зүг эргэв.

Их хаан Аригбөх:

-Хүлэг баатрууд минь намайг сонс. Миний дайсан, миний ах энэ удаад энэ талд ялаг. Бүгд ухарцгаая. Хойд зүг одон, хүчээ хурааж эргэж байлдя.

Хан Алгуй:

-Дайсантай нэгийгээ үзэж нэхий дээлээ тайлъя. Ялалтыг булааж авч аолно. Харин Их Монголын их хаан Аригбөх та ахаа гэх сэтгэлээ хураатугай.

Их хаан Аригбөх:

(Түүн рүү ширүүн харна) Юу?

Нүлүн ноён:

-Аймшигт үгийг их хаанд Хан Алгуй чи юунд халдан хэлэв.

Хан Алгуй:

-Их Монгол Гүрний төр бидэнд ганц...

Их хаан Аригбөх:

- (Зогсоц) Тийм ээ. Цагаадайн салбар үр чиний зөв. Нүлүн ноён минь, хатуу үнэн. Хаан төрд тэрсэлсэн дайсан минь, намайг үүрч өсгөсөн. Зулай зулайгаа гишгэж төрөөд дааган дээр дэрвэж, дахан дор хамтдаа өсцгөөсөн болохоор би дайснаа хайрласаар байна. (Зогсоц) (Хаан бүсээ тайлан хүзүүндээ зүүнэ.Өвдөглөнө.Бүгд даган өвдөглөнө)Мөнх тэнгэр хүч минь сонс! Эзэнт төрд тэрслэх хан ахаас их хүчээ автугай. Дайны тэнгэр надад хилэнгээ хайрла. Өр зүрхний зовлонг арилгаж өстөний өөдөөс өслөх хилэн өг! Тэнгэр надаас энэ хайрыг эргүүлэн автугай. Дайчин хүлэгтэн ахан дүүс, хөх нуруутнуудын тэрсэлдээн тулалдааныг бүү ажин хартугай. Мөнх хөх тэнгэрийн үнэн, хэнд буй түүнд нь өгтүгэй. Мөнх тэнгэр биднийгээ өршөө!(Их хаан Аригбөх босно.Бүгд мөргөөд даган босно) (Жанжингууд руу эргэнэ) Есөн сумны харвах хөдлөл мэт дайсны гүн рүү хүлэгтэнгүүд сумлан шургаж дотор нь тойрог үүсгэ. Тойрог хүлэгтэнгүүд арыг хамгаална. Хэрхэвч тойргийг үл тэл. Бүчсэнийг нь бүл. Бүү урагш довтол. Тэргэний дугуй тэлж томордоггүй шиг үүсгэсэн тойргоор дороо эргэлд.

Аландар жанжин:

-Зүйтэй зөв. Хасбуу хасугаар хамах эргэлтээр цавчицгаая.

Их хаан Аригбөх:

-Дайсны хүч тарамдвал, Аравгууд, аравт аравтаар таран эргэлд!

Хундагай хан:

-Мэргэн санаа. Мөн байна.

Их хаан Аригбөх:

-Хэрэв хүч мөхөсдөн ирвэл есөн сум нэг цүүц болон дайснаа сэтэлж сугаран гарч ирэх хэрэгтэй

Аландар жанжин:

-Мориндоо!

(Бүрэнхийлэл. Их хаан сэнтийнээсээ алсыг харан үлдэнэ.) (Дайны их дуу чимээ үүснэ. Гэрэл

тодорно)

Их хаан Аригбөх:

-Хаан Чингис эцгийн дэргэд ач хөвүүд бид дайны урлагаар тэмцэлдэн наадахад Хубилай ахыг би дийлсэн. Гэтэл хар нялхын тоглоом наадгайны миний сэдсэн аргыг өөдөөс минь одоо хэрэглэв. Тэнгэр минь! Ахын инээмсэглэх дулаан харц нь илт үзэгдэв. Тэнгэр юунд надад дайсны минь царайг харуулах нь энэ вэ? Хайрыг минь үл авлаа. Нэг л зөв ахын хийморийг бадрааж, зоригийг хөглөж байна. Тэнгэр түүнийг тэтгэж, тэгээд ивээлдээ авсан хэрэг үү? Ах багын наадгайг надад илгээв. Доогтой бус өрөвдсөн инээмсэглэлийг нь дотроо би үзэв. Ахын сэтгэлийн аялгуу надад ирэв. Ай. Тэнгэр минь миний буруу хаа вэ? Хаан төрийг хагалсан тэр. Илбэ шид надад ирсэн хэрэг. (Нүүрээ дарсанаа болино) Тойрог дотор дүүгүүрээр гал шидлэв..

Нүлүн ноён:

- Их хаан Аригбөх минь, Аландарын цэргийн магнай нааш тэмүүлэн ирлээ. (Аландарын цэрэг хааны өмнө сөгдөн ёсолно)

Аландарын цэрэг:

-Их хаан минь, Хундагай жанжин алагдав. Хан Алгуй ноён тулалдаанаас сугаран гарч цэргүүдээ аван баруун зүг эргэлээ. Аландар ноён , хаан таныг хамгаалан дайны талбараас холдон одтугай хэмээн биднийг илгээв.

Их хаан Аригбөх:

-(Догшноор) Аландарыг та нар авар. Тэрслэгч Хубилай намайг барихаар хий хүлэгтэнгүүдтэйгээ элдэн хөөгөөд хэрхэн барихыа нү харья. Эргэн морд! Аймшиггүй зоригт, чин үнэнч Аландар жанжны амь биеийг хамгаалан надад авч ир.

Аландарын цэрэг:

-Хаан таны амийг бид сахин хамгаалж авч явах Аландар жанжны тушаалтай.

Их хаан Аригбөх:

-Хайран хүлэг баатар минь! (Зогсоц) Хан Жөн Мон Тоба чи Хархорин хот руу од. Их төрийн билигдэл бүхнийг хамгаалалдаа автугай. Хэрхэвч түүнийг дайсандаа үл алдтугай. Айл иргүдийг хойд зүг нүүдлийн замд оруулагтүн. Ар талыг нь бид хамгаалах болно.

Хан Жөн Мон Тоба:

-Жа, (Их хаанд ёсолно)

Аландарын цэрэг:

-Хаантан мордох уу?

Их хаан Аригбөх:

-Байз, Хүлээ. (Тэртээг харна) Миний хүлэгт сайн эрсийн нэг хааны дайны туг хиарыг аван гарч ирж байна. Угтан аваад холдье. (Хаан суудлаасаа босов. Цэргүүд түүнийг дагав. Нүлүн ноён зогсоно)

Нүлүн ноён:

-Хаан Чингисийн ач нар ач тач тулалдахыг үзэв. Мөнх тэнгэр минь! Ганга нуурыг цусан өнгөөр будав. Будах будахдаа ах дүүсийнхээ цусаар будав. Цөвүүн хүйтэн төрийн голомтонд халдлаа. Алсдаа амгаланг үзэхгүй л болов уу . (Хааны араас дагав)

(Хөгжим) (Харанхуйлал)

Гуравдугаар үзэгдэл.

3. Маргад эрдэнийн хаант улс хагарав.

Тайз: Эхлэлийн тайз эргэнэ. Хубилайн Юан гүрний сэнтий байна. Их хаан Хубилай хань үндэстний хаан болсон нь илтэд мэдэгдэнэ. Их хатан Чибан, өвгүн Аригун ноён, хааны шадар Хөхөө, хааны монгол хишигтэн цэргүүд байх ба тогосын өдөт дэвүүрт эмс хааныг сэрүүцүүлэн мөн толгойгоо бөхийлгөх хятад бараа бологчид зогсоно.

Түшмэл Ван-Ө:

-(Нялуун хазгай дуудлагаар) Юан Гүрний тэнгэрт алтан луу эргэлдэж их хаан Хубилай таны ялгуулсан их цэргийн агуу ялалтыг хүрхрэн зарлалаа. Тэнгэрийн луу хүлэглэсэн алтан унаат эзний цэргүүд их говийн өмнө Аригбөх хааны цэргийг даран бөхөөлөө. Хубилай их хаан таны захиргаанд их монгол ирлээ. Юан Гүрний хаан Хубилай түм насал.

Бүгд цугаар:

- Их хаан түм насал. Их хаан түм насал. Түм насал.

Цөөн ард:

-Уухай... Уухай... Хурай... Хурай...

Түшмэл Чжао-Бо:

- Эзэнт Юан Гүрний их хаан Хубилайн цэргүүд хойдын орныг мохоон хураан засагласан ялгуулсан ялалтын бахархал дуулалт магтууг их хааны таалалд өргөө.(Алгаа ташна)

(Хятад ший янгууны жүжигчид урт лууны дүрийг дээрээ өргөн бүжиглэн орж ирнэ. Лууны ард гарыг нь тэлж хүлсэн Аландар жанжинг цэргүүд харгалзан авчирна)

Их хаан Хубилай:

-(Царай нь барайн хувирна.Шадар Хөхөөг ойрт гэж гараараа дохиход түүний дэргэд зогсох хан Хөхөө хаанд чихээ ойртуулна. Чжао алга ташна. Жүжигчид тоглолтоо зогсоон хааны өмнө сөгдөнө)

Хааны шадар Хөхөө:

-Их хаан үл таалав.

Чжао-Би түшмэл:

-(Хааны өмнө нь хоёр гараа урьдаа атгаж барин сөгдөх Ван-Ө, Яо-Шу ард ирж сөгдөнө) Юан Гүрний эзэн хаан мунхаг намайг өршөө!

Ван-Ө, Яо-Шу түшмэлүүд:

-(Хоёр гараа өмнөө барин зэрэг дуугарна) Өршөө их хаантан!

Ший янгууны жүжигчид бүгд:

-(Мөн сөгдөцгөөнө) Их хаан Өршөө!

Их хаан Хубилай:

-(Хаан шадар Хан Хөхөөгийн чихэнд удаанаар нэгийг шивнэнэ)

Хааны шадар Хөхөө:

- (Догшноор) Баатар жанжин Аландарын духан дээр хэн аймшиггүйгээр их хаанаас үл асуун халуун тамга дарав? Үтэр түргэн хэлтүгэй!

Чжао-Би түшмэл:

-(Урагш өвдгөөрөө мөлхөн) Их Юан Гүрний хаан Хубилай та өчүүхэн түшмэл миний амийг өршөө! Монгол баатар жанжины духан дээр боол гэсэн үсэг дарсан. Энэ бол манай уламжлалт ёсонд дайснаа дарж сөгтгөсөний баталгаа билээ. Энэ цагаас тэр хааны боол боллоо гэсэн тэмдэг билээ. Ёс алдаж хаан танаас үл асуун дураар шийтгэсэн захирагчийг өршөө!

Их хаан Хубилай:

-(Хаан машид хилэгнэж буй нь илт байна. Хан Хөхөө рүү харна)

Хааны шадар Хөхөө:

- Баатар жанжин Аландар духан дээрхи үсгийг халуун сэлмээр хайрч арилгахтүн!

Чжао-Би түшмэл:

- Жа. (Чжао-Би жүжигчид рүү харж алга ташна. Жүжигчид урт лууг сүүлнээс нь хойш ухраан бөхөлзсөөр тайзнаас гарна. Хааны монгол хишигтэн цэрэг өргөөний голомтны галд сэлмээ дүрэн хэсэг байзнав. Их хаан Хан Хөхөөгийн чихэнд нэгийг шивнэнэ. Хан Хөхөө сонсож дуусаад зогсоно. Энэ үед хааны цэрэг улайсгасан сэлмээ авч Аландар жанжны зүг ирэн духын халуун сэлмээр хайрч үсгийг арилгана)

Хааны шадар Хөхөө:

-Их хааны зарлиг. Их хааны Юан Гүрэн Чингис хааны их засаг хуулийг голлон мөрдөнө. Хүмүүний сүнс тэргүүндээ буй тул мөнх тэнгэрийн хаан үүнийг үл таалав. Эл шийтгэлийг

үүрд хэрэгсэхгүй болгов. Тэнгэрийн дор Их Юан Гүрний иргэд үүнээс хойш хэн ч боол хэмээн нэрлэгдэн боолын явдлаар үл явах ба зөвхөн хаан ба дээдэс ард иргэдүүдийн улс байх болно.

Чжао-Би:

-Нигүүлсэнгүй агуу хааны өршөөлд мөргөө!

Бусад түшмэдүүд:

-Нигүүлсэнгүй агуу хааны өршөөлд мөргөө!

Хааны шадар Хөхөө:

-(Аландар жанжинд хандан) Тэнгэрийн ясу ёсоор үхэх түүний үгийг автугай хэмээх их засагт зааснаар Юан Гүрний Их хаан Хүлэгт баатар жанжин Аландараас ам асуув.

Аландар жанжин:

- Ёс бус хаан Хубилай чиний төр мөхнө. Мөнх тэнгэрийн гүрэн Их Монголын алдар суу мөнхөд үлдэнэ. Монгол хэмээх нэр мөнх орштугай. Үхэх амь надад бий тул үхүүлтүгэй. Үлдэх нэр надад бий тул үхлээс үл айна.

Их хаан Хубилай:

-(Омогшилоо нууна.Зөөлнөөр) Баатар эрийг баатар жанжины ёсоор үхүүлтүгэй!

Хааны шадар Хөхөө:

-Хүлэгтэн баатар жанжин Аландарыг хүлэг морьтой хамт тэнгэрт одуулахтүн!

(Аландар жанжиныг хааны монгол цэргүүд авч явна)

Хааны шадар Хөхөө:

- Ван-Ө түшмэл их хаанд үгээ айлтга!

Ван-Ө түшмэл:

- Эзэнт гүрний их хот Хархоринг орхин нүүдэлчин улс хойд зүг арилан одохдоо хамаг бүхнээ тэр чигт нь хаяжээ. Зөвхөн эмх замбараагүй айж цочсон олон орон газрын түм буман ард иргэд өөр өөрийн сүм дуганы өмнө багширан залбиралдана. Ялгуусан их хаан Хубилай танд аймшиггүйгээр халдан хэлэх үг байна. Их гайхамшиг цогцолсон хотыг эвдэн сүйтгэх зарлигаа эргэн харж дэлхийн өнцөг булан бүрийн гайхамшигтай урлал бүтээлийг авралдаа авна хэмээнэ. Ван-Ө миний үг уур хилэнг тань дэгдээсэн бол толгойг минь авсугай!

Их хаан Хубилай:

-(Хаанд шадар ойртоно. Үгийг нь сонсоно)

Хааны шадар Хан Хөхөө:

- Өгэдэй хааны босгосон хотноо Мөнх хааны бүтээсэн агуу гайхамшигт мөнгөн модыг үл эвдлэн буулгаж бусад өнгөт үзэмжит бүхнийг эвдэн авч урчууд хийгээд дархчууд эрдэмтэн мэргэдүүдийг олзлон их хаан Хубилайн өмнөд орноо бүтээн буй Их Юан Гүрний төв хот Ханбалиг буюу Кайпинг руу зөөтүгэй!

Хишигтэн цэрэг:

-(Хааны өмнө ирж ёсолно) Их хааны хан хөвүүн Есүнхэй хаан тань руу намайг илгээлээ. Их хаан таныг их говийн өмнө тулалдан байх бүхийд Аригбөх хааны албат ба цэргүүд хаан Аригбөхийн төрийн үнэт бичгийн сан хийгээд нэгэн гайхамшигт мөнгөн модыг хөндөн авч амжжээ.

Их хаан Хубилай:

-(Баяслаа нуун Шадар хан Хөхөө рүү дохино. Хан Хөхөө хааныг сонсоод эргэн цэх байдалд орж өндөр дуугаар)

Хааны шадар Хөхөө:

-Хан хөвүүн Есүнхэйн элч чи Их хаан Хубилайд зарлигийг хүргэтүгэй. Хар хорин хотыг Хан Есүнхэй ноён их цэрэгтэйгээ сэргийлэн хамгаалж үлдтүгэй. (Их хаанд Есүнхэйн элч ёслоод явна) Хурсан олон сонстугай! Их Юан Гүрний их Хаан Хубилай хойдын орныг хураан засаглахаар мордсон аян дайнаа үүгээр зогсоов. Их Юан Гүрний алдар суу ялалтын баяр цэнгэлээ их хаан өмнөдийн хотноо үүсгэн зарлана. Их Юан Гүрний хаан Хубилай их цэргүүдээ аван өмнөд рүү өглөөний нарнаар хөдлөхийг зарлиглав.

Бүгд цугаар сөгдөнө:

-Юан Гүрний их хааны алдар бадартугай! Их хаан түм наслаг! Уухай! Хурай!

(Хөгжим) (Харанхуйлал)

Дөрөвдүгээр үзэгдэл.

4. Их хаан хубилайд, их хаан ариг бөх ирэв .

Тайз: Их хаан Хубилай, Их хатан Чибан, Хааны шадар Хөхөө, өвгүн Аригун ноён, Чжао-Би, Ван-Ө болон хааны монгол цэргүүд ордны бараа бологсод байна.

Чжао би түшмэл:

- (Нялуун гуншаа дуудлагаар) Юан Гүрний Эзэн өргөмжит Чантунг Хубилай их хаанд хааны дүү отгон дүү их гүрний голомт сахигч Аригбөх өөрийн биеэрээ хүрч ирлээ. (Аригбөх өөрийгөө дагах цөөн цэргийн хамт өргөөнд орж ирнэ) Их хааны өмнө сөгдөгтүн. (Аригбөхийн цэргүүд сөгдөнө. Аригбөх үл сөгдөнө. Хубилайн цэргүүд түүнийг сөгдүүлэхээр түүн рүү ирнэ)

Их хаан Хубилай:

-(Зөөлнөөр шадар Хөхөөд хандан хэлнэ) Бүү сөгдүүл.

Хааны шадар Хөхөө:

-(Захирангуй) Бүү сөгдүүл. (Цэргүүд холдоно)

Их хаан Хубилай:

-Их Монголын хаанд нэрлэгдсэн Аригбөх надад үл сөгдөнө. Дүү чиний зулай дээр би гишгэж төрсөн ч чи их монголын хаан явав. (Зөөлнөөр шадар Хөхөөд хандана) Бидний цаг ирэв.

Хааны шадар Хөхөө:

-Хаадын учралт цаг бүрдэв.Тэнгэрийн цагийг дээдлэн ерөөлт өргөөг чөлөөлөн бүгд орхигтүн. (Өргөөнд байгсад бүгд мэхийн явна.Хөхөө хааны өмнө ирж ёсолно)

Их хаан Хубилай:

-Хан Хөхөө чи үлд. (Аригбөхөд хандана) Дүү чамайг өөрөө ирэхийг үзээд ихэд баясна би.

Их хаан Аригбөх:

- Ах таны ухааныг таньж аваад үхэх хүслээ хүлэглэхээр өмнө чинь би ирлээ. Ахын буруу зөвийг эс мэдээд үхэх хүсэл хаан надад алга. Сүүлчийн орь хүслийг минь биелүүлэгтүн.

Их хаан Хубилай:

-Ах дүү бид хоёрын хэн нь хаан суух ёстой юм бэ?

Их хаан Аригбөх:

-Миний ёсоор бол би суух ёстой, одоо чи суужээ.

Их хаан Хубилай:

-Чиний зөв.

Их хаан Аригбөх:

-Зөв минь байтал ах та юунд буруу бүхнийг хийв. Тэнгэр хийгээд алтан төр, төрөлхтний дээд хөх нуруутан, дээд эрхэм бүхнээс нүүр бууруулан тэрсэлдэн юунд зүтгэв. Толуй хаан аав, Сорхагтан хатан эхээ умартав уу? Хамаг бүхнийг хамсан хаан Чингисийн улсыг бүрэлгэх, хар ухааныг хаанаас олов? Алтан ургийн саглагар модыг үндсээр нь булгалахаар чи зүтгэв. Хаан сэнтий зүүдлэн зүдсэн бол надаас ав энэ сэнтийг.., Их гүрний голомтыг харин бүү самард. Хар хорлолд идэгдсэн бол надаас илд ав. Их тэнгэртээ харь. Харин хааны алтан гавал чинь хар толгойд хувирсан бол хаадын тэнгэр эцэг Хубилай чамайг ниргэг.

Их хаан Хубилай:

-Мөнх тэнгэрийн хүч намайг хаанаар сонгов.

Их хаан Ариг бөх:

-Худлаа. Би итгэхгүй байна. Хаан ах та минь, тэгээд Ханбалиг хаалттай хот байгуулж нүүдлийн оршихуй суумлын оршихуйд бүтээмэр болж харайх морины хурдгүй газар хаан төр зохиов гэж үү? Хэрхэвч би итгэхгүй. Нүүдлийн соёлоор бадраах хутагт их засгийн алтан дээд гэриэ юуг ийн мөрлөх болов уу? Ичиж байна. Би.

Их хаан Хубилай:

-Ёст хаан чиний зөв. Толуйн дөрвөн хан хөвүүн Алтан дээдийн аялгуугаар амлуулж өссөн хаадууд билээ. Хөх нуруутын эзэд алтан ургийн хаад бид бие биенээ тэтгэх тэнгэрийн хутагтай.

Их хаан Аригбөх:

-Тийм ээ. (Хоолой нь зангирна) Гуниг минь энэ. Танд гаслан гутах минь энэ.

Их хаан Хубилай:

-Харин одоо хаан дүү чи намайг сонсож тэвч. (Зогсоц) Нөмрөн ирэх цөвүүн цагийн зовлонг Сорхагтан бөө цэцэн эх минь угтаж мэдээд тэсэж магад гарахын цагаан зөнгөө дөрвөн хаад хөвүүдийн нэг Хубилай надад буулган гэрээслэв. Хөх монголын эзэнт гүрний хаан төрийн өргөө гэрийг хаалган ухаанаар барих хаан эзнээр намайг заав. Тэнгэрийн зарлиг тэр болов.

Их хаан Аригбөх:

-Гэрийн онолт төрийн үүдийг сөхөн ирсэн гийчдийг сэхээрүүлэн гэгээрүүлж тэнгэрт өөд татах ухаан тэнгэрийнх билээ.

Их хаан Хубилай:

-Тэнгэрийн улс босгосон их төрийн гал голомт өргөөнийхөө үүдийг сөхсөн бол бас буулгах цаг бас бий ажээ.

Их хаан Аригбөх:

- Мөнх хөх тэнгэр минь.

Их хаан Хубилай:

-Хааны ухаанд эрдэмшсэн дүү чи надад итгэх итгэлээ ширгээж дуусгавч сүүлчийн дусал сүүг нүдэндээ тээгээд ирлээ. Ухаан билиг төгс Толуй хаан, Сорхагтаны хатны хөвгүүн байж дүү минь чи чадлаа. Би итгэж байсан. Итгэл минь чин үнэн байв. Хайрт хаан дүү минь.

Их хаан Ариг бөх:

-Тэнгэрт даажигнал бий гэж үү?

Их хаан Хубилай:

-Үгүй. Энэ бол Мөнх тэнгэрийн зарлиг. Хүн төрлөхтний голомт өлгий нутаг, хүмүүний эхлэл хөх нуруутны ариун орон амар амгалан дотор орших учиртай. Дэлхийн улс нийтээр дээшлэн дэвшинэ. Гэхдээ тэр цаг хол. Тэнгэрийн буулт ариун орон түм бумны хөлд талхлагдах ёсгүй. Алтан хурын орон амьтны хөлд дарагдах зовлонгоос аврагдаж алив бүгдэд мартагдах учиртай. Алтан ургийн гайхамшгийг ах дүү бид алалдан байж агуулан үлдээв. Тэнгэрийн энэ гайхамшгийг авч үлдэхийн тулд тэнгэрийн хөвүүд газрын хаад бид тэмцэлдэн зовов. Агуу хүчийг ах дүү хаад бид л агуулан нуух чадалтай. Өөр бусдын хүч мөхөстөнө.

Их хаан Аригбөх:

-Эзэнт гүрний хот Хархоринг эвдсэн шалтаг энэ байв уу?

Их хаан Хубилай:

-Тийм байв. Эзэнт гүрний хот хэзээнээс хавт эрийн сум тусах газар, харайх морины уушги тэлэх чөлөөнөөс үл хэтрэх ясу ёстой билээ. Гэвч хүмүүний урсгал үерлэж, хөх нуруутангууд түүнд шингэж, ихийн ихээр ихдэж, элбэгийн элбэгээр элбэгдэв. Тэнгэрийн мон тоба бодист хөх нуруутангууд минь атга будаа мэт цөөхөн бидний засагласан улс нь шуудайлсан элс мэт их. Уусан алдарч, дуусан сүйрэх аюулыг угтан бөө сэцэн эх минь тэнгэрээс улаачлав. Дэлхийн дээд сав элдвээр дүүрч мэдэх гайт дохиог газарт эх минь буулган мэдээлэв.

Их хаан Ариг бөх:

- Мөөн. Хачир үнэн. Тааж байсантай минь тохиров. Хөх тэнгэрийн төрөлхтөнгүүд минь төөрч, торго болгоноор гоёж, тогос шувуу мэт үзэгдэх болсон нь үнэн. Өдөр өдрөөр монголчууд минь өнгө өнгийн дээлээр гоёж, үзэгдэх нь урамтай байлаа. Гэхдээ алтаар хумс бас шүдээ хүртэл бөгжлөх болсон ард олныг би үзэв. Сүүн шүд, ясан шүд ертөнц заяасан билээ. Хаан би ард олон минь алтаар шүдлэхэд айн сэжиглэв.

Их хаан Хубилай:

- (Ууртайгаар) Бидний ариун орон түмний бөөлжис, бумны баасаар халих учиргүй. Дэлхий ертөнцийн өлгий дээдийн дээд заяатай.

Их хаан Аригбөх:

-Гэхдээ хаан ах минь эл нууцаа надаас юунд нууцлав. Намайг хаанд заасан Мөнх хаан ах минь, мөн эх нутагтаа эргэн ирээч гэж хаан миний гуйсанд батгалзсан хан Хүлэг ах минь та нар их учрыг бүгд мэдэж байсан хэрэг үү?

Их хаан Хубилай:

-Агуу хүчит хаан бол чи. Бас бид. Их хаан Толуй, Их хатан Сорхагтаны хөвгүүд бүгд хаадын хаан Чингисийн хаан эрдмээр ханасан гавалтангууд.

Их хаан Аригбөх:

-Үгүй ээ. Эзэнт гүрний төрд дайсагнасан тэргүүн дайснаар ах таныг цоллон би зарласан.

Их хаан Хубилай:

-Хаан чиний зөв байлаа. Хүлээсэн их итгэл минь тэр байв. Хаан эрдмийн зөвд итгэх учиртай дүү чамд дотроо баясаж гаднаа хий зангирч хар хүлгийн жолоог чинь эргүүлж, хавт сумыг дүү чиний өөдөөс ах би чичив. Ихийн ихийн ихдэх зовлонгоос ураг төрлөө авч үлдэх хаан төрийн хаалган ухааныг барих хар бодлого хаан минийх ажээ. Харин хаан дүү чи их төрийн голомт өргөөний үүдийг хаах ясан цагаан эсгий, хар шуурганаас халхлах хамгаалах хан хаалга нь байв.

Их хаан Аригбөх:

- Эцэг тэнгэр минь. Хязгааргүй цаглашгүй сэтгэшгүй агуу хүч та минь. Их хаан миний цээжний гунигт үг багадав. Нулимснаас өөр хэллэг газарт би олохгүй. Их тэнгэр минь намайг өөртөө ав.

Их хаан Хубилай:

-Тэнгэрийн дүү минь тэвчих хэрэгтэй. Хүлэгт баатрууд итгэлт хөх нуруутан иргүнүүдийнхээ бадрангуй галыг бөхөөн бууруулах, хамгийн хүнд ачаа надад оногдсоон. Тэнгэрийн зоригийг дарах бэрх тэр зовлонг үүрэх нь бэрхээс бэрх гуниг. Их шударга, их үнэн, их зоригийг нугалахад ирэх шаналан амар үгүй.

Их хаан Ариг бөх:

-Тэнгэрийн хүчинд мөргөн залбирья гэвч гомдол надаар дүүрч хаан биеийг минь хөшөөнө. Ах минь.

Их хаан Хубилай:

-Аригбөх хаан чи хэл, одоо хэний зөв бэ?

Их хаан Аригбөх:

-Миний зөв байлаа. Одоо таны зөв боллоо.

Их хаан Хубилай:

-Хэн хэнийх нь зөв байв. Их гүрний зовлонг их хүчтэнгүүд бид үүрнэ. Арсланг арслан л дийлнэ. Агуу ихийг агуу их ухаан л хийнэ. Хабсу хасуг эзэнт төрд нар зөв эргүүлэх нь Ариг бөх хаан чи, нар эсрэг эргүүлэх нь хаан Хубилай би болов. Их гэрээсийн хүчит нэг нь чи нөгөө нь би байв. Хүчирхэг хос хасу хаад бидний гарт эргэлдэв. Хөрстийг хөрвүүлж, хүмүүний өлгий мөн хөх нуруутныг би авч үлдэв. Хаан надад энэ цагийн хөх нуруутангууд гомдож, ирээдүй цагийн хөх нуруутны үрс баярлах болно. Хүмүүн төрөлхтөн ч алсдаа зовлонгоо таньж дэлхийн гайхамшигт Монгол хэмээх ариун оронг онголох болно. Тэнгэрийн тамгат үрсийн удам тэсэж үлдвээс дэлхий ертөнцийн шинэ цагийн авралын үүд болно. Хүмүүн төрөлхтний эхлэл ариун өлгий сэвгэшгүй мөнх сэрүүн тунгалаг орших болтугай.

Их хаан Аригбөх:

-Тэнгэр минь. Төрсөн бол үхэх. Мандсан бол буурах дэлхий ертөнцийн чин чу хажир үнэнг би их эзэнт төрд ирэхийг мэдсэн тэр үдшийг гуниг дунд тэнгэр гэнэт ухаанаа нээхэд хаан дүү тань айн чичирсэн. Их Монгол хэмээх хүчит нэгэн алдрыг ч хааны нэгэн сэнтийг ч авч чадах хүчит ах юунд төрийн сэнтийг булаагаад улсын нэр алдарыг орхив. Цагаан шонхорын салхи намайг илбэсэн тэр үдэш ухаан минь сийрч учрыг таав. Мөн байгаасай хэмээн би таньд ирэхийг хүсэв. Зовлон минь төгсөв. Аймшиг гайхамшиг энэ биеэр минь зэрэгцэн урсав. Үүрдийн хаан эрдэнэ өвлөсөн хаан та мөн ажээ. Хаан ах минь цөвүүн цагийн зовлон төгсөх цаг хаа вэ? Алсын хараагаа хэлтүгэй.

Их хаан Хубилай:

-Найман зуун жилийн адагт бий.

Их хаан Аригбөх:

-Тэнгэрийн ухаан оньсогоор дүүрэн энэ ертөнцийн цагт ирэх бэрх юм аа. Гэхдээ дэлхийн зуун зуун их жил сансрын цагт бага хугацаа.

Их хаан Хубилай:

-Тиймээ. Одоо ах хаан би дүү чиний нуруунд тохсон хаан төрийн алтан эмээлийг буулгалаа. Онголсон хүлэг морь мэт нутгаадаа од. Хээрийн омголон салхинаас бусдыг нуруундаа үл хүргэн дүү чи дураараа давхи. Хөх нуруутан хүлэгтэнгүүдийн үнэнээ өмөөрөн оволзон ирэх омгийг хаан би дарсу. Бүхлээрээ мөхсөнөөс бүлгээрээ мөхсү.

Хааны шадар Хөхөө:

-(Гэнэт ихээр уйлна) Ай алтан ургийн ах нар минь. Энэ бүх учрыг сонсоод эс тэвчив. Намайг өршөө. Тэнгэрийн нууцыг сонсох хувь өгсөн та нар минь намайг өршөө. Нулимсаа үл тэвчив. Хаан Өгэдэй, Хан Цагаадай эцгийн хөвгүүдийн бас миний аав зовлон энэ мэт бэрх байсан уу? Хэлээд өгөөч?

Их хаан Хубилай:

-Бэрх зовлон дуусаагүй. Дөнгөж эхэлж байна. Хүү минь. Үнэний гэрчээр чи өөд одох хүртлээ явна. Алтан ургийн хан хүү чи газарт сонссон үлгэр далай мэт аялгуугаа тэнгэрт авч одно. Газарт зовсон тэнгэрийн хан хөвүүд Өгэдэй Цагаадайн үрсийн сэтгэлийг жаргаан чи баясгах болно. Бүгд тэнгэрийн оньсого. Тэдний үхэл бас энэ мэт байв.

Их хаан Ариг бөх:

-Шороон түмэн дотор хан хэрэм босгоод адуу мал, өргөө гэр, ахуй юугаа агуулахыг зорьжээ ах та минь. Харь хүмүүн дотор хаан ах Хубилай та энх амар суух болтугай. Хаан таны алтан гавалд гэрэлтэх ухаан бүхэн биелэх болтугай.

Их хаан Хубилай:

-Төрөлх эх орон Монгол нутгаадаа одтугай. Эргэж учрахын ерөөлийг мөнх тэнгэр мэдсүгэй. (Ах дүү хаадууд тэврэлдэн салах ёс гүйцэтгэнэ)

Их хаан Хубилай:

-Хаан Аригбөхийг миний цэргүүд алсаас харгалзан үдтүгэй.

Хааны шадар Хөхөө:

-(Бүрэнхийлэл. Гагц Хан Хөхөө дээр гэрэл тусна. Хан Хөхөө нулимсаа арчиад өндөр дуугаар) Юан Гүрний Их хаанд өөрийн биеэр ирж буун өгсөн хааны хан дүү Аригбөхийг хишигтэн монгол морьтонгууд үүрийн бүрийгээр их нутаг руу алсаас харгалзан үдтүгэй.

(Хөгжим) (Харанхуйлал)

Тавдугаар үзэгдэл.

5. Их хаан аригбөх тэнгэрт гарав.

Тайз: Онго тахилгат газар. Их хаан Аригбөх, Хан дүү Жөн Мон Тоба, Нүлүн ноён бөө удган, Цагаадайн угсааны Хан Алгуй хэдэн цэргүүдийнхээ хамт хаанд сөгдсөн байна. Их хааны цэргүүд мөн байна.

Их хаан Аригбөх:

-Оны өвлийн тэргүүлэгч сарын эхэнд Их Монголын Аригбөх хаан би Ханбалигт руу дайлан хаан төрийг эргүүлэн авахаар дайлахаар довтлоход Цагаадай ханы үр Алгуй ноён баруун гар болон дайтах амаасаа няцаж ёс бус хаан Хубилайн талд урâаснаас их хаан би ялагдлыг ахин дахин амсаж их цэрэг нэн ихээр хохиров. Аригбөх их хаан би Цагаадайн угсааны Алгуйтай Илийн хөндийд байлдан урваачийг олзлон барив. Цагаадайн угсааны үр чиний амь егүүтэх ял энэ мөн. Их Монголын хаан би Эзэнт Гүрний агуу билигдэл мөнгөн модны сүлд хийморийг алтан ургийн хөвүүн Алгуй чиний сүнсээр сахиулан хамтад нь онголтугай! Алтан ургийн хан хөвүүнд ерэн есөн цагаан хүлэгт ерэн есөн шадар цэрэг дагуулан тэнгэрт өргөн одуултугай!

Хан Алгуй:

-Их хаан та Цагаадайн ач хан Алгуй намайг үхлийн дээдээр шагнав. Мөнх хөх тэнгэрийн улсад мөнхөд зүтгэсү!

Их хаан Аригбөх:

-Их гүрний хийморийг Алгуй ноён түүний жанжин цэргүүд үүрд сэрүүн сахихтүн! Онгон тагшин уулийн өвөрт Их төрийн билэгдэл юуг онгологтун!

Удган:

- (Хэнгэргээ нүдсэнээ)

Мөнх тэнгэрийн онгон шүтээн минь ээ Мөрөн голын олон лус савдагууд минь ээ

Бөртэ чину сахиулсан тэнгэр минь ээ

Бүргэд шонхор сүлд тэнгэр минь ээ

Өндөр дээдсийн голомт бадарсан

Өвгөн буурал Бурхан Халдун хайрхан минь ээ

Шоог шоог шоог

Хурай хурай хурай

Бөө:

- (Хэнгэргээ даган цохиод)

Дээр ерэн есөн тэнгэр

Дэвжид найман аймаг

Баруун зүгийн тавин таван тэнгэр

Зүүн зүгийн дөчин дөрвөн тэнгэр минь ээ

Шоог шоог шоог

Шоог шоог шоог

Төр улсын шүтээнийг хадгалж хайрла

Түмний билигдэлийг онголж хайрла.

(Чоно шиг их дуугаар улина)

Аауунгаа Аауунгаа Аауунгаа

(Их хааны хишигтэн цэргүүд Алгуй ноёны нугасийг таслан егүүтгэж, түүний есөн жанжинг хороон үхүүлнэ. Адууны янцгаах дуу дуурсана)

Бөө:

- (Хэнгэргээ дээр өргөн цохиод)

Эзэн уулны сахиул хан чи болов

Ерэн есөн хүлэгтэнгийн эзэн чи болов.

Хаан төрийн шүтээнийг

Их Гүрний бэлгэдэлийг үүрд чамд өг

Хамгаалтугай. Хадгалтугай. Сахьтугай

Хэнд бүү үзүүлэхтүн

Хэн халдана ниргэхтүн

Үеийн үед үргэлжлүүлэн тахису хан чамайг

Үрийн үрдээ залгамжлуулан аргадсу хан чамайг

Уухай уухай уухай

Хурай... Хурай... Хурай...

Удган:

- (Сүү өргөнө)

Есөн ес наян нэгэн цацлыг өргөсү

Ерэн есөн тэнгэрт сүү өргөсү

Өглөө болгон дээжээ өргөн ундаалья

Үдэш бүр утаа гарган унааг чинь цатгая

Удган бөө хамтдаа:

- Хурай... хурай... хурай...

Их хаан Аригбөх:

-(Газар сөгдөнө)

Хаад хаадын сүнс залрах

Халдун хайрхан минь ээ

Хатуу цагт хаацайлсан

Хаан аав шүтээн минь ээ

Их хаан Аригбөх би

Их Монголын эзэнт төрөө танд өгөв

Их хаан Аригбөх би

Их монгол гүрний сүр сүлд хадгалуулав би.

Мөнх тэнгэрийн улсын хойч ирээдүйг

Мөнхийн дээдсүүдэд даатгасу

Их хаан намайг Их тэнгэр өршөө!

Бүгд цугаар:

-Мөнх тэнгэр биднийгээ өршөө! Мөнх тэнгэр өршөө! Өршөө!

Бөө:

- (Хэнгэргээ дэлдэн)

Өөрийн тэнгэрийг өршөөж явдаг

Харийн тэнгэрийг харж явдаг

Хаан заяат сахиусан тэнгэр минь

Хамаг монголын заяа түшиж ав

Их Монголын ирээдүйг ивээж хайрла

Удган бөө хамтдаа:

- Хурай

Бүгд цугаар:

-Хурай... хурай... хурай...

(Бүрэнхийлэл) (Тайзны өмнө. Гэрэл тодирно. Хан Хайду дээр гэрэл тодирно. Жинхэнэ чононы улих дуу сонсогдоно)

Хан Хайду:

-Талын дэлт азарган чоно зүүдэнд ирж улив. Цагаан дэлт азарган чоно өмнө минь ирээд тастахын алдад дэлдэн авч даран унав. Догшин тэрээр намайг авч давхин долоон уулыг нуруугаар өгсөж давхисаар цаст уулын магнай дээр тогтон зогсов. Их дэлт чононы тэнгэрт улих их дуугаар би зүүднээсээ сэрэв. Мөнх хөх тэнгэрийн дуудлага Өгэдэй хаан Дөргэнэ хатны хүү Хашийн хан хөвүүн Хайду миний зүрхийг сэрээн дуудав. Булаагдсан төрийг би Толуйн хөвүүдээс буцааж авахаа тангараглая. Өгэдэй хаан Цагаадайн ханы үр удам Эзэнт төрөөс үеийн үед хасагдан хавчигдахын үүрд би эцэслэнэ. Хаан төрөөс хөөгдөн цөлөгдсөн хан хөвүүн Хайду миний зүрхийг хаадын онго эргэв. Монголын эзэнт төрөө мөхлөөс аврахыг мөнх тэнгэр надад хэлэв.

(Бүрэнхийлэл)

(Их хаан Ариг бөх дээр гэрэл тодирно. Аригбөх Жөн Тоба хоёр байна.)

Их хаан Аригбөх:

-Хан дүү Жөн Мон Тоба чи бага хатан Мүхэ эхийн хамт өрх гэрээ аваад хаан ах Хубилай руу одтугай. Хэрхэхийг тэр чамд заана. Хасарын удам чамайг халхлан хамгаалж авч явна.

Хан Жөн Мон Тоба:

-Жа, хаан ах минь.

Их хаан Аригбөх:

-(Тэврэлдэнэ. Хан Жөн Мон Тоба ах хаанд мөргөөд явна. Хаан гунигтайгаар) Нүцгэрсэн тал нутгийг минь тэнгэрийн ташуур цасан шуурга л ороолгоно. (Архи өөртөө аягална) Ган зуд өлсгөлөн энэ нутгийг хоослов. Аригбөх хаан би нүцгэн талд эр би ганц болов.(Архиа ууна)Тэсгим хүйтэн бүрнээ хаанчиллаа. Мөнх тэнгэр нууцаа биеэрээ дарав. Мөн их аймшиг, мөн их гайхамшиг. Тэнгэрийн хүчин намайг автугай. Ганцаардал ганёхралаас миний алтан аялгууг сугалтугай! (Архийг том ваартай нь авч бүгдийг нь ус шиг залгилна) Аан! (Архины хоосон ваарыг чулуудан хагална.Эвхрэн унаж согтууран хөлчүүрнэ. Газраас босно. Дээлээ нөмрөн цааш харж зогсоно)

Нүлүн ноён:

-Хаантаан!

Аригбөх хаан:

-Намайг авахаар ирэв үү? Мөн байна. Буурал сахал чинь хаадын хааны шинжтэй юм байна.

Нүлүн ноён:

-Арз хорзноос ганцхан өдөр өнжсөн сөн. Хаантан минь одоо бүү уу?

Аригбөх хаан:

-Хаан ах минь үнэнийг хэлсээн надад. Их хүчийг мохоох амаргүй. Энэ бие бөхөөс бөх ажээ. Надад яагаад бөх нэр өгсөнг хэл та. Энэ чинь биеийн бөх шүү дээ. Хаан аав Толуй, хатан эх миний биеийг бөхөөс бөх зангидсан хэрэг.

Нүлүн ноён:

-Тийм ээ. Энэ үнэн.

Аригбөх хаан:

- Биений бөхийг би өөрөө л дийлж барна. Цул чулуу, цутгасан алт юмаа энэ. Арз хорз ч амжихгүй нь. (Нөмөрсөн дээлний энгэрийг татаж хэдийнээ зүрхэндээ хатгасан мэсийг сугалан авна)

Нүлүн ноён:

-Хаантан минь. (Хий сөгдөн ганхирна)

Аригбөх хаан:

- (Дээш харна) Мөнх хөх тэнгэр минь. (Мэсээ газар алдана)

(Хөгжим) (Харанхуйлал)

Зургаадугаар үзэгдэл.

6. Монгол ноёд тал нутгаа эрхэмлэн одов.

Тайз: Перс маягын ордон. Наян ноён, Хайду хан, Юбугур ханхүү, Жирхэ ханхүү Тугтөмөр, Сүнсбай, Дува тэргүүтэй ноёдууд байна. Хан Наян ноён, Хайду хан хоёр гол суудалд суусан байна. Бусад нь түүнийг тойрон сууна. Наян ноён ахмад ба хамгийн отгон нь Ёбугур байна.

Наян ноён:

-Наян ноён миний өргөөнд алс ба ойроос хуран ирсэн алтан ургийн хан ноёд та нарыг үзээд сэтгэл зүрх минь эхэд баясан гийв. Ерөөлт болзоо бүрдсэн энэ учралыг дээдлэн хүндэлж хан ноёдын чуулганг билэг дэмбэрэлийн аялгуугаар эхлэсү. Хан Жирхэ аялгуу дуу үүсгэтүгэй.

Жирхэ хан:

-Жа. Алтан ургийн ахан дүүсээ харж мөн баясав би. Таалан болгооно уу? (Уртын дуу эхлүүлнэ)

Сүнсбай ноён:

-(Босож ирээд) Миний монголын мянган хөг түмэн аялгуу минь. (Уйлна)

Туг төмөр жанжин:

-Нутаг минь нүдэнд үзэгдэв. Мөн ч сайхан даа. Тэр минь.

Сүнсбай ноён:

-Эх нутгаа би санаж байна. Дээлийг минь дүүргэх хүйтэн жавраа санаж байна. Цээжийг минь тэнийлгэх тал нутгаа үгүйлж байна. Хараа минь хязгааргүй руу уусах хөх тэнгэрээ санаж байна. Хүлэг минь босоо төрөх хүй нутгаа үгүйлж байна. Чононы улианд цовоо болох цуу цагаан гүүний цолмон унага төрөх билээ тэнд. Ач минь хүлгээ хайна. Хан хэрмэнд харин би өтлөв. Харьж одуё. Сүнсээ төөрүүлэхээсээ өмнө төрсөн нутгаа одуё. Хэвтрийн шившигт үхлээр хэлхэвч би үхэхгүй.

Наян ноён:

-Тэнгэр муудсан ч нар гардагаараа л гарна. Өвгөдийн үгийг өв болгож өр зүрхээ чагнацгаа. (Үргэлжилсэн зогсоц) Өрцөө нээж уушигаа дэлгэх цаг ирэв.

Хайду хан:

-Алтан ургийн хан ноёдууд минь бидний үгийг тэнгэр сонсохоор дөхөв. Бидний төр улсын ёс ясу хятадаас тэс өөр билээ. Гэтэл Мөнх тэнгэрийн хөх нуруут хүлэгтэн бид хот балгадад хоригдов. Харын ёс заншилд автаж, хүний зохиосон хуулийг мөрдөх болов. Гэтэл хөрстөд

тэнгэрийн жам, түүний хуулиас өөр дээд үгүй. Их Монголын эзэнт төр дээд үнэнг газарт олгов. Чин үнэний иргүн бид морин дээр төрж, морин дээр үхэх жамтай. Тэнгэрийн хөдлөл хуулийн эрхээр нүүдэллэн амьдрах тэр ухаан биднийх. Суу ухаан маань дээд тэнгэрээс заяамал.

Сүнсбай ноён:

-Мөн. Чин үнэн. Үүнээс хойш уул ус бараадан тал хээр газарт амьдран сууна. Хот суурингийн ойр орчимд эргэлдэн хоргодохгүй. Сүнсбай би хөх нуруут иргүнүүдээ аваад төрөлх нутагтаа хүрье.

Бүгд цугаар:

- Мөн. Зөв зүйтэй. Зөв. Мөн.

Хайду хан:

- Тэгвэл бид бүгдээр шийдлээ. Эх нутаг руугаа одоцгооё. Хүлгийн жолоог эх нутаг руугаа залцгаая.

Бүгд цугаар:

- Одоцгооё. Нутгаа зорьё. Зөв зүйтэй. Бүгдээрээ харьцгаая. Зөв. Мөн.

Наян ноён:

- (Босно) Дэлхий ертөнцөд тэнгэрээс заяагдсан хөх нуруутнууд бид дэлхийд гагц нүүдлийн засаглалыг тогтоох хутагтай Мөнх тэнгэрийн хүчний зарлигт Их эзэн Чингисийн Их Монгол Эзэнт гүрний эзэд бид билээ. Монгол ноёдууд минь бид хаанаас ирсэн хэн гэдгээ хэзээ ч умартах ёсгүй. Мөнх хөх тэнгэрийн ясу зарлиг одоо хаанаа мандана вэ? Ёс бус хаан Хубилай дээдийн зарлигийг гагцаар мэдэн хөсөр шидэв. Чингис хааны отгон хөвүүн Тэмүгэ отчигон хүү Наян ноён би бээр амьд яваа цагтаа энэ гутамшгийг мөн үл тэвчинэ. Мөрөн дээрх толгой мултравч эс тэвчинэ. (Эрхийгээ эсгэн мөнгөн аяганд цусаа тусаагаад Хайду ханд өгнө)

Хайду хан:

-(Босч ирнэ) Тэнгэрийн хасбу тамгыг атгаад тэнгэр өөд нулимах ёр энэ хаанахын буй? Бидний хаад эцгүүдийн цусаа урсгаж, хөлсөө шавхан байж байгуулсан Их Монгол Эзэнт төр одоо хаана байна? Оюун ухааны орь гагц гайхамшигаар цогцолсон Мөн тархины гол улс гул болон гуларч ул бол улбарах уу? Чингис хаан эцгийн хөвүүн Өгэдэй хааны ач хүү Хан Хайду би үүнийг хэрхэвч үл тэвчинэ. (Эрхийгээ эсгэнэ. Мөнгөн аяганд тусаана.Туг Төмөр ноёнд өгнө)

Туг төмөр ноён:

-(Аягыг авна) Амьд явахын утгаа бөхлөв би. Тугтөмөр би бээр харьд харайн давхиж, хаан төрдөө зүтгэсэн сэн. Харин төр минь харь санаатын төр болов. Хаан нь хана хэрмээс намайг

заах болов. Тэнгэрийн хүчинг газарт буулгах ёс үгүй болж эмээлтэй морио ийш тийш харайлган элдэв улсыг юуны дор засаглах гэж! Мөнх тэнгэрийн үнэн, ёс ясуг би тэнгэрт одсон бол тэнгэрт гарч, далай унасан бол далайд шумбаж би авчрах даа л авчирна. (Эрхийгээ эсгэн аяганд цусаа бодсана) Андгайлъя. (Сүнсбай ноёнд цустай аягыг дамжуулна)

Сүнсбай ноён:

-Сүнсбай ноён би хүний зохиосон хуулийг хэрэглэн тэнгэрийн хуулийг эс хэрэгссэн урваачийн зүг хорин нэгэн хатад эмсийнхээ хөвүүн бүрээр сум хийн харавсу. Миний хөвгүүд та нарт ирэн эсгэрэх сум мэт нисэлдэн алтан ургийн үрсийн нуманд чивчирэх болно. Гавал бүрт нь гал асаана би. (Эрхийгээ эсгэнэ.Цусаа аяганд дусаана)

Дува ноён:

-Бүтэн төрийг буцааж авчиран хэн тэнгэрийг дээдэлж хаан болно. Түүний унаа, тэргүүлэгч зэв, тэмтрэгч нүдэн Дува би байх болно. (Эрхийгээ эсгэн аяганд мөн тусаагаад Юбугур ханд өгнө)

Юбугур хан хүү:

-Ариг бөх хааны ханхүү Ёбугур би алтан ургийн ёсноос гажсан тэр хааны өөдөөс тэнгэрийн ёсыг авчрахаа тангарайлаж, хаан аав Аригбөхтэй дайсагнасан өст түүнтэй үүрд нэгээ үзсү.

Жирхэ ханхүү:

-Мөнх тэнгэрийн хууль тэнгэр тулж газар тамгалсан их төрийн ёс ясуг Мөнх хааны хан хүү Жирхэ би үеийн үедээ өвлүүрэн өгөх үйл хэрэгт үнэнчээр зүтгэнэ. Хэрэв би няцан цуцваас хэнхдэг цээжийг минь өрлөн хаан Мөнх эцгийн нэрээр хойчийг минь бүү нэрлэтүгэй. (Эрхийгээ эсгэн цусаа аяганд урсгана)

(Мөнгөн аяга Наян ноён дээр эргэж ирнэ)

Наян ноён:

- Эрдэнийн дээд эв мөн боловч хилэнцэт нөхөртэй бүү нөгц. Ашиг хорыг бодолхийлбээс хойноо гэмшивч оройтмой хэмээн дээдсийн үгийг иш болгон дээдэлсү. Алтан ургийн хан ноёд цугларсаар аливаа сэжиг ажиг алдрав. Андгай тангаргийг үйлдсү. Өрнөсөн галыг усаар дармой. Үргэсэн дайсныг цэргээр дармой. Хэрэв бидний дотроос хэн нэгэн урван тэрслэвээс амьд үлдсэн нь түүнийг хороо.

(Мөнгөн аягатай цуснаас балгаад Наян ноёнд өгнө. Наян мөн ууж цааш дамжуулна. Монгол ноёд бүгд дамжуулан тангаргийн ёсыг гүйцээнэ)

Наян ноён:

- Зөвхөн ертөнцийн үнэн сэрэхүй нүүдлийн оршихуй гагц бидний чанар. Та нар нэг нэгэнтэйгээ санаа нийлж байсан цагт та нарыг заяа буян даах бөгөөд дайсан ч дийлэхгүй гэж

хэлсэн Их хаан Чингисийн сургаал зарлигийг мөнхөд мөрлөтүгэй.

Хайду хан:

- Хормыг алдсанаар эринийг алдана. Уухай.

Бүгд цугаар:

-Уухай... Уухай... Уухай...

Наян ноён:

-Алтан ургийн хан ноёдууд найрлан цэнгэцгээ.

(Бүрэнхийлэл) (Гэрэл тодорно. Ноёд найрлана)

Туг төмөр:

- Туг төмөр би энэ ичгүүрээр хооллон амьд явбал намайг газрын зулбасагат тооцогтүн! Ертөнцийн эд баялаг эрх мэдлийг булаан олоод тэнгэрээс урвасан тэрний яс махаар би өөрийгөө хоолловол намайг тэнгэрийн хүлэг морьт хөх нуруут мөн гэж тооцогтүн!

Сүнсбай ноён:

-Согтсон байна. Тугтөмөр ноён аяд.

Тугтөмөр ноён:

-Алив, Өмнөх минь дууссан байна. Надад айраг авч ир! (Хултай айраг барьж ирсэн хүнийг хараад сэлмээ суглан босч ирнэ) Аа муу үг чагнаач чамайг даа. (Сэлмээрээ айраг сөгнөгчийг цавчиж хаяна)

Хайду хан:

-Туг төмөр чи юунд цуст муу үйлийг хийв.

Тугтөмөр ноён:

-Үг чагнаачийг үхүүлэв. Би. (Сэлмээрээ чичин) Харваас энэ хар толгойтон харь этгээд байна. Цус холилдсон муу заяат гэдгийг нь би хултай айраг сөгнөхдөө эрхий хуруугаараа амсрыг нь дарж өгөхөд мэдэв. Алтан ургийнхны үг андгайг сонсоод хэлээ худалдана гэдгийг би танин мэдэв. Эндээс зайлуул. (Ноёны албатууд түүнийг авч явна) Хананд чихээ наасан хар элэг хуухай.

Наян ноён:

- Сайн цааз, андгай тангарагийг бодлого охор дарсан дор битгий эвд.

Тугтөмөр ноён:

-Би үл эвдэв. Харийн нутагт хүний сүргийг маллах гэж би сүүдрээсээ цочиж, нойрноосоо ухасхийн босож зовлон зовлонгоор зүдэрсээн. Хатан тэвэрч хэвтэхдээ хан сэлмэндээ итгэн хэвгдэг би. Үдэш унтаад өглөө босоход хөх нуруутан хүлэгтэн минь өшилсөн бүгдийг бүрэлгээд үүдийг минь дарж унасаныг ч үзлээ. Хуурамч эд баялгаар өвчилсөн шуналт түшмэдүүд тэдний дунд суухад дотор минь муухайрч бөөлжис минь цутгадаг. Итгэл эр зориг үгүй тэднийг би үнэрээр нь мэднэ. Ариун үгүй тэд араас хутга, өөдөөс хор аягалах бөгөөд тэдний бохир өмхий самхай сэтгэлийг үнэртээд би мэднэ. Зөн совин минь л зөвхөн намайг аварч явна. Аан! Би бурууг эс хийв. (Өмнөх явган ширээг өшиглөнө)

Наян ноён:

-Их согтсон байна. Чи. Энэ зовлонг бүгд мэднэ. Өргөөнөөс явж амрагтун.

Тугтөмөр хан:

- Үгүй ээ би ууна. Би согтоогүй байна. Согтсон ч яадаг юм. Та нар намайг алахгүй. Алив надад архи авч ир.

Сүнсбай ноён:

- Өг өг! Ууг ууг! Биднийг үзээд цээжний бөглөрсөн нөж бүлтрэн гарав. Болохгүй бол би өвдөглөн дарж унтуулна. Уулга! Дарсанд зовлонгүй нэг цадаг!

Тугтөмөр хан:

-(Том хултай айргийг түүнд Наян ноёны албат авчирна) Чи бол монгол байна. (Чиний гараас би ууна. Айргийг авч залгилана)

Хайду хан:

-Хүйтэн булгийнхаа уснаас...(Түүнийг дагаж бүгд түрэн дуулна)

(Хөгжим) (Харанхуйлал)

Долдугаар үзэгдэл.

7. Тал нутгийг дэлт чононы сүнс эзэгнэв.

Тайз:Монгол тал нутаг. Их хаан Хубилай, Хан Жөн Мон Тоба, хааны шадар Хөхөө, Аригун ноён хааны цэргүүд тайзны өндөрлөгт байна. Доод талд Ван-Ө, Чжао нар байна.

Ван-Ө түшмэл:

-(Сунадаг урт дурангаар тэртээ рүү харна.Хөөрнө) Хөнгөн хөлт буман шоргоолжнууд үүрнээсээ зэрэг буух мэт их хаан таны баруун гарын дөчин зургаан түмэн цэрэг, дайсан Наяны цэргүүдийн нойрмог цагийг нөмрөн урагшилж байна. Дайсны цэрэг сэжиг аваагүй л байна.

Чжао түшмэл:

-(Мөн өөрийн дурангаар дурандана. Түүний дэргэд Ван-Ө эргэн ирж зогсоно. Ван-Ө д хандана) Эд бууж өгнө. Эсвэл зугтаана. Тэдэнд хоёр сонголт л үлдэв. (Ихэмсгээр ахин дурандана) (Үргэлжилсэн зогсоц) Дайсан биднийг мэдчихлээ.

Ван-Ө түшмэл:

-Дайснууд үймэж эхүллээ. (Хаанд яаран ирж ирнэ)

Их хаан Хубилайн:

-(Хааны шадар Хөхөө дуранг авна. Их хаанд өгнө. Хаан сэнтийнээсээ босч ирж дурандана) Тулаан эхлэв.

Чжао түшмэл:

-Ямар аймшиг вэ? Жад сэлмээ шүүрч амжаагүй дайснууд гар нүцгэн чигтээ манай цэргүүд рүү уулгалан гүйн дайрч орлоо. (Ахиад дурандана.Дурангаа нүднээсээ холдуулж үзсэндээ алмайран таг зогсов. Ихэд цочирдсон байна)

Ван-Ө түшмэл:

- Манай цэргүүдийн өөдөөс аймшиггүйгээр гүйлдэн ирж жад сэлмийн булаан аваад тэд зэвсэглэж байна.

Их хаан Хубилай:

-(Шадар Хөхөөд хандана) Наян ноёныг хэрхэвч алдаж болохгүй. Түүний амьд үхсэн аль нэгийг би үзэх ёстой.

Хааны шадар Хөхөө:

- Хааны хишигтэн цэргүүд!

(Хишигтэн монгол цэргүүд шадар Хөхөөгийн өмнө ирж сөгдөн ёсолно) Хааны хишигтэн цэргүүд тусгайлан зориглож тулаанд ор! Наян ноён амьдаар нь олзлон барь!

Цэргүүд:

-Жа .(Явцгаана)

Өвгүн Аригун ноён:

-Их хаантан, Зүүн зүг одсон Жанжин Боракийн зүүн гарын их цэргээс элч нааш довлон ирлээ.(Хаан гараараа дохино. Боракийн элч орж ирж хаанд ёсолно)

Боракийн элч:

-Их хаан Борак жанжны зүүн замын цэргүүд арван өдрийн газарт Хайду хааны цэргийн замыг хаан хориглох тулаанаа эхлүүлэв.

Их Хаан Хубилай:

-(Толгой дохино) (Үргэлжилсэн урт зогсоц) (Шадар Хөхөөд хандана) Сайн байна.

Хааны шадар Хөхөө:

-Элч алжаалаа тайлаад эргэн ирэхгүйн! (Элч ёслоод явна)

Ван-Ө түшмэл:

-Дайсны цэргүүд тун хурдан сэхээ авч дайралтыг тогтоов. Гайхам шалмагаар тэд буцан эгнэн жагсав. Жинхэнэ цуст тулалдаанд орохоор тоо цөөн морьтонгууд морио унан цэгцрэв. (Чжао түшмэл рүү харна) (Дайны бүрээ урамдана)

Чжао түшмэл:

-(Дурандсанаа дурангаа буулгана) Монголчууд байлдахын төлөө төржээ.(Хаан руу харна. Хаан түүн рүү харна)

(Бүрэнхийлэл)

(Тайз эргэнэ. Хаа сайгүй жад сэлэм сүхэнд жадлуулж үхсэн их цэргүүд байна. Тэр цэргүүдийн дунд Наян ноён, Хан Жирхэ нарын хоёр гар модонд тэлүүлэн хүлээгдсэн байх ба тэд дор сөгджээ. Туг төмөр жанжныг мөч бүрээс гинжээр татан хүлжээ. Хааны шадар Хан Хөхөө, Чжао түшмэл болон хааны цэргүүд гарч ирнэ.)

Хааны шадар Хөхөө:

-Их Юан Гүрний хаан эзний нэрийн өмнөөс Хааны шадар Хан Хөхөө би их гүрний төв төрд эс захирагдан тэрсэлдсэн та ноёдын амыг асуухаар ирэв. Үг байвал үгүүлсүгэй!

Наян ноён:

-Ёс бус хаан тэрэнд бус харин эзэнт гүрний урваачийн зараал хан Хөхөө чамд Өүлэн эхийн отгон хүү Отчигон Тэмүгэгийн ач Наян надад хэлэх сүүлчийн үг байна.

Хааны шадар Хөхөө:

-Өчтүгэй

Наян ноён:

-Алтан ургийн ах дүү нарынхаа цусаар хэн гараа угаав. Мөнх тэнгэрийн хуулийг хэн уландаа гишгэв. Маргад эрдэний төрийг хэн хагалав. Гүүг их хааны хан хөвүүн Хөхөө чи сэр хар. Чи хэний яс чи хэний цус вэ? Чиний мөрөн дээр чиний өөрийн толгой бий юу? Эрт багын явдлаа сана. (Үргэлжилсэн зогсоц)

Хааны шадар Хөхөө:

-Үгийг сонсов.

Чжао түшмэл:

-Энэ баатар зоригт ноёд бүгд үгээ хэлэх үү? Үхэх хүн худал хуумаггүйгээр үгээ хэлэх ёстой юу? Тэдний үг үнэн гэдэгт итгэх бас ёстой юу?

Хааны шадар Хөхөө:

-(Чжао түшмэл рүү муухай харна) Хэрэв ахин элдэв үг хэлбэл би тэдэнд хүзүүг чинь зааж өгөх болно.

Чжао түшмэл:

-(Айн хойш ухарна) Хааны дүрийн нэг та минь мунхаг түшмэл намайг өршөө!(Хойш ухарсаар тайзнаас сэм холдон явна)

Хан Жирхэ:

-Мөнх хааны хан хөвүүн Жирхэ би хаан эцгийн өргөсөн Их Монгол Эзэнт Гүрний их төрийн төлөө зүтгэв. Монгол түүх шашгирт миний нэрийг сайнаар эс биш гэхнээ муугаар эс бичихтүн. Мөрлөсөн үйлс минь мөнх тэнгэрийн улсын эзэн хаан Чингисийн зарлиг мөн байв.

Хааны шадар Хөхөө:

-Амыг авлаа.

Тугтөмөр жанжин:

- Ха ха.. (Инээнэ) Би төрсөн орон эх нутагтаа үхэж байна. Үүнээс өөр сайхан хаа байна. Миний сүнс, миний аялгууг ялгуун. Мөнх тэнгэр энэ газар сүнсийг минь шонхор шувуу мэт шүүрэн авна. Боллоо. Би үхэх газраа ирээд үхэв. Харин Хөхөө дүү чиний үхлийг би харж байна. Хаан Хубилай бас чи хана хэрэмд өгөрч дуусна. Ха ха...Чөлөөт салхины жавар хойноос хүрэлцэн ирнэ. Аз жаргалант ахуй нутгийн минь салхи цээжинд минь үүрлэнэ. Хүлгийн туурайгаар дэлхийг тамгалаад хүү чинь ирэв. Үгээ би эх нутагтаа өгөв. Үхэх минь, Одох минь.

Хааны цэрэг:

-Хятад түшмэл Чжао морьт сүйхэнд суугаад хөдлөв. Хаан эзний аян дайны буудлын зүг ихэд яаран хөөгдөх мэт холдох чинь Хан Хөхөө та хэрхэхийг заан хэлнэ үү? Морьд руу нь сум тавих уу?

Хааны шадар Хөхөө:

- (Цэрэг юуг ч эс хэлэн ширүүнээр түүн рүү харснаа) Их хааны зарлигийг дуудсугай!

Хааны цэрэг:

-Их Юан Гүрний Их хаан Хубилайн зарлиг. Их Гүрний төв төрд тэрслэн эвсэн цэрэглэсэн хэргээр алтан ургийн Хан ноён Наян, Хан Жирхэ, Жанжин Тугтөмөр нарыг хороохтун. Их хааны удам, алтан ургийн ноёдыг ихэс дээдсийн ёсоор эс цусийг газар үл тусаан алтан биеийн муутгахыг агаар наранд үл үзүүлэн цагаан эсгийд боон чивчлэн татаж амийг нь таслахтун !

Хааны шадар Хөхөө:

-Цаазыг гүйцэтгэ.

(Хөгжим) (Бүрэнхийлэл) (Тайз эргэнэ. Гэрэл тодорно. Их Хаан Хубилайд албат эмсүүд хааны дээлийг өмсгөн үйлчилнэ)

Чжао түшмэл:

- (Хааны өмнө ирж сөгдөн мөлхөнө) Их хаан минь, таны буулгасан цаазын дор тэд аймшигт үгийг өгүүлж, хан шадар Хөхөөгийн ухааныг эргүүлэхээр завдав. Болгоомжлох хэрэгтэй хаан та. Монгол ноёд нааш цааш урвана. Сэрэмжлэхтүн.

Их хаан Хубилай:

-Монгол хэлийг та их сайн сурчээ. (Инээнэ. Царайгаа үтэр түргэн хувиргана) Үгийг чинь мэдэв. Чжао таныг олзны ихээр шагнаана.

Чжао түшмэл:

-Агуу хаан түм наслаг. (Мөргөнө)

Их хаан Хубилай:

-Яв. (Хаан сэнтийдээ морилно) (Хааны шадар Хөхөө орж ирж хааны өмнө ёслоно)

Хааны шадар Хөхөө:

-Их хаан таны зарлигийг ёсоор гүйцэтгэв. (Хаан толгой дохино)

Ван-Ө түшмэл:

-(Тайзны өмнө гарч ирнэ) Юан Гүрний дайны баруун замын цэргээс элч ирлээ. (Хааны шадар Хөхөө хааны дэргэд зогсоно)

Хааны шадар Хөхөө:

-(Хаан руу харна. Хаан түүн рүү толгой дохино) Элчийг оруул!

Хааны цэрэг:

-(Монгол цэрэг хааны өмнө ирж ёслоно) Их Юан Гүрний баруун замын их цэрэг Хайду хантай тулалдан үлэмжийн их хохиролыг амсав. Умардын дайнд нэрээ дуурсгасан баатар Хан Хайду цэргийн эрдмээр цоо ажээ. Хайду хан цэргээ аван дөлөн холдов. Их хаан таны зүүн гарын цэргийг яаран ирүүлэхийг жанжин Борак хүслээ.

Их хаан Хубилай:

- Өгэдэй хааны ач Хашийн хан хөвүүн Хайдугийн хүч чангаран хүчирхэжснийг таллан цохиж цуцаав. Наян ноён, Хайду хан хоёрын хүчийг нийлэхээс өмнө амжив. Чингис хааны ордонд бид хамтдаа өсөж хүмүүжсэн. Өгэдэй хааны өвөр дээр эрхэлж, Мөнх хаан ахын минь дэргэд эр бие гүйцээж, Бат ханы даган тулалдаж тэр эрэлхэг занг олсон. Тиймээ. Их шүүхээр Ил тарвагатайд хоосон цөлөгдсөн тэрээр эргэж хаан төрд ирэхдээ ирсэн шиг ирж чадав. Ухаалаг хүчирхэг хан тэр мөнөөс мөн. Хайду хан чи дээдсийн өвийг сахин, тал нутгийг эзэгнэж хааны явдлаар явах болтугай. Мөнх хөх тэнгэр хувь заяаг чинь мэдтүгэй! Их хаадын сүр сүлд сүнс Хаан Хубилай намайг өршөөхтүн! Хайдугийн хойноос бүү хөөхтүн! Өмнөдийн орон Ханбалиг руу хоёр замын их цэргийг эргүүл! Буцацгаая!

(Хөгжим)

(Харанхуйлал)

Наймдугаар үзэгдэл.

8. Дэлхийг мэдсэн их хаан Хубилай дээд тэнгэрт морилов.

Тайз: Хааны ордон. Их хаан Хубилай их хатан Чибан нар хаан хатны алтан сэнтийд сууна. Тэдний өмссөн хувцас өмнөхөөс нэн онцгой эрхэт сүрийг илтгэнэ. Хаан илт өтөлсөн байна. Хан Жөн Мон Тоба, Бага хатан эх Мүхэ, Өлзий бэхэ хатан, Мөнгөнүхэн охин, Хааны шадар Хөхөө болон Монгол цэргүүд хааныг хамгаална. Монгол ноёд хатад дийлэнх нь байна. Чжао түшмэл тэргүүтэй хятад албат нар тэдний өмнө сөгдсөн байна.

Ван-Ө түшмэл:

-(Их хаанд хандана) Ил ханы орноос элч ирлээ.

Өвгүн Аригун ноён:

-Хаанд бараалхуул!

Хүлэгү ханы элч ноён:

-Их Юан Гүрний Их хаан Хубилай та амар амгалан уу?

Их хаан Хубилай:

-Амгалаан амгалан. Сайн явж ирэв үү?

Хүлэгү хан элч ноён:

- Сайн явж ирлээ. Ил ханы орноос Хүлэгү хан их хаан танд дайны олз илгээлээ. Таалан болгооно уу? Илгээсэн олзны дээд үнэт чулуун сэлмийг хаан ахдаа хан Хүлэгү бэлэг болгон өргүүлэв. Их хаан таалалдаа хүлээн авна уу? (Үнэт чулуун сэлэм өргөнө. Хаан өөрийн биеэр авна. Үзээд Аригун ноёнд өгнө)

Их хаан Хубилай:

-Хан Хүлэгү дүүгийн бэлэгт ихэд баясав. (Гараараа өөдөө суу хэмээн дохино. Элч ноёнд Аригун ноён суудал заана. Элч өргөөний дээд суудалд сууна)

Ван-Ө түшмэл:

- Их гүрний Юан Гүрний мэдэл дор шинээр ирсэн Бенгал тэргүүтэй Цейлэн, Явын арлуудын орон Чампа, Тонкин, Аннам, Комбож, Сингасари орон улсуудын элч ноёд Их хаанд бараалхан өргөл өргөхөөр ирлээ.

Их хаан Хубилай:

- (Хааны дохиолтоор Аригун ноён хаанд дөхнө)

Өвгүн Аригун ноён:

-(Хааны хэлэхийг сонсоод Ван-Ө хандана) Их хаан тэдгээр орны элч ноёдыг гурван хоногийн дараа хүлээн авна.

Ван-Ө түшмэл:

-(Алга ташина) Хааны хаалттай хотын үүдэнд ирсэн. Элч ноёдыг буцаа. (Нэгэн албат мэхийгээд гарна)

Өвгүн Аригун ноён:

- Олзны хуврагийг хааны өмнө авчир! (Япон хувраг орж ирэн хааны өмнө хэдий ч хол зайнд сөгдөнө. Мөргөнө)

Их хаан Хубилай:

-(Шадар Хөхөө рүү харна. Шадар Хөхөө хааныг сонсоно)

Хааны шадар Хөхөө:

-(Ширүүнээр олзны хуврагт хандан)Танай арлын Япон улс тэнгэрт тэрсүлж далай хөдөлгөсөн үү? Биднийг юун улс гэж сэтгэв та нар!

Япон хувраг:

-Манай Цюсима арлын загасчид өглөөний манан шингэрэхэд туг хиараа сэрийлгэсэн үй олон хар хөлөг онгоц далайн мандлыг бүхэлд нь дүүргэхийг анх үзсэн билээ. Айж цочирдсон загасчид анх танай улсыг нүдээр харсан тэр. Энэ бол зүүд зэрэглээ ид шид гэхээр тийм зүйл байлаа. Япон улсын хаан ард түмэн үүнийг тэнгэрийн бошго,хилэгнэл хэмээн хүлээн авсан. Хамгийн цочирдом тэр зүйл бол арал усны улс бус их газрын хүлэгтэнгүүд байсан гэдгийг мэдээд ертөнцийн агуу гүрнийг бид төсөөлөх хэрэгтэй болсон. Бурханы авралд багтахын тулд манай арлын эзэнт улсын эрдэмт лам Ничран тэргүүтэй хоёр зуун тавин лам бүх сүм хийдийг уриалан Камэяма Гоуда ордонд бясалгал үйлдэн, нэг хүн өдөрт мянга хоёр зуун ном, нийлээд гурван зуун ном уншиж бясалгал үйлдэн бурханы авралыг эрсэн.

Их хаан Хубилай:

-(Шадар Хөхөөд нэгийг хэлнэ)

Хааны шадар Хөхөө:

-Та нар бурханы авралыг бус хараал аятгыг дуудсан тийм үү? Зөвхөн үнэнийг хэлтүгэй. Үгүй бол сүнсийг чинь бид там руу тонилгоно.

Япон олзны хувраг:

-Агуу хаан өршөө! Тэр хараал. Хараалын ном. Биднийг өршөө!

Их хаан Хубилай:

- (Шадар Хөхөөд нэлээд удаанаар нэгийг хэлнэ)

Хааны шадар Хөхөө:

-Та нар тэнгэрийн илгээсэн ясу зарлигийг эс хүлээн авч манай элч нарыг удаа дараа элэглэн доромжилж, алж хороогоод бас далайг тэнгэрийн зүг билэгнүүлж усыг босгон их эзэнт гүрний дөрвөн мянган хөлөг онгоц зуун мянган цэргийг усанд автуулан хохироов. Мянган лам хараалын хар ном нийлэн уншсан гэдгийг бид мэдэв! Олзны хувраг чи хараалч лам нарын тоог нууна гэнэ ээ!

Япон олзны хувраг:

- Тиймээ, Мянган лам. Сүнсийг минь өршөө! Бурхан минь. Тэнгэрийн салхийг дуудсан. Тэр үнэн.

Хааны шадар Хөхөө:

-Үгүй тэр бол муу ёрын хүч. Хар дом хараал аятгыг үйлдсэн танай улс ариун ном уншиж лусыг аргадан авралаа олохгүй бол дахин дайлан дуусгана. Тэнгэрийн зарлигтай тэрсэлсэн улс хэрхэн хөрстөөс арчигддан гэсгээгдгийг энэ хуврагт харуулахаар Ил хаадын элч ноён авч яв. Их Юан Гүрний цаха хязгаарыг төсөөлөл юунд таниулахгүйн! Дараа нь арлын орон руу нь хөө! (Аригун ноён алга ташна. Албатууд олзлогдсон ламыг авч явна)

Өвгүн Аригун ноён:

-Эзэнт Гүрнийг зорин ирсэн энэтхэг орны элчийг өргөөнд урьтугай!

Ван-Ө түшмэл:

-(Алга ташна) Өргөөнд элч төлөөлөгчийг оруул! (Энэтхэг орны ая дуу эгшиглэн, энэтхэг эмэгтэйчүүд хөнжмийн аянд бүжиглэн орж ирэх ба хааны өмнө бэлэг сэлт өргөнө. Элч ноён хааны өмнө ёсолно)

Энэтхэгийг элч:

- Юан Гүрний их хаан таалалдаа болгооно уу! Танай их гүрэнтэй найрсаг харилцааг үүсгэн энх амгаланг дэлхий ертөнцөд бүтээх их үйлсэд хүч тус өгөхөө манай Малабарын захирагчид хичээнгүйлэн хүсч эл сэтгэлээ илтгэн эд баялгийн дээжээ илгээв. Их Гүрний хааны эрдэнийн санд эрдэнийн дээд Бурхан Буддагийн ариун шүдийг хүндтэйгээр өргөв. (Алтан савыг элч ноён өргөнө. Пагва лам босон алтан саванд мөргөнө. Ордны албатад алтан савыг хүлээн авахыг урина. Албат алтан савыг хүндэтгэлтэйгээр авна. Тайзнаас явна)

Их хаан Хубилай:

- (Таатайгаар толгой дохино. Шадар Хөхөө хаанд дөхнө. Шадар хааны үгийг нь авна)

Хааны шадар Хөхөө:

- Их хаан өгөөмөр сэтгэл, саруул ухаант улсын хаанд талархан баясав. Ван-Ө түшмэл элч ноёнд өргөөнд суудал олго! (Ван-Ө түшмэл тохирох суудал заана. Элч ноён суудалд сууна)

Их хаан Хубилай:

-Өвгүн ноён Аригун, Миний гүрний их цэргийн ялалтын ялгуун аялгуунаас дуудаач. Нүднээ үзэж, сэтгэлийн цэнгэл эдлэн жарган суухыг хүсэв.

Өвгүн Аригун ноён:

- Жа, Хаантан, Баян цатгалан Бенгалын орноо манай хөх нуруут хүлэг морьтонгууд заант цэрэгтэй тулалдсан онцгой содон ялалтын аялгууг дуудсу би.

Их хаан Хубилай:

- (Баясан толгой дохив)

Өвгүн Аригун ноён:

-Тэнгэрийн зарлигийг атгасан хүлэгтэнгүүд Бенгалийн орноо хүрэлцэн ирэхэд тэр орны хаан дээд тэнгэрт эс итгэн их гүрний их цэргийг үгүйсгэн дарахаар нэг заанд арван хоёроос их нумт эрсийг гоёмсог жуузат асартаа ачсан тийм найман зуун заант цэрэг, арван мянган морин цэргийг засаглан угтав гэнэ. Газар доргион нүүгэлдэн ирэх халуун орны зузаан биет олон заанаас тал нутгийн хүлгүүд үргэн янцгаалдав гэнэ. Урт хошуут амьтдын орилох их дууг урьд өмнө сонсоогүй хүлэг газар өавчин дороо эргэлдэхэд хүлгийн эзэд хөх нуруутнууд мэргэн ухаан сийлэв гэнэ. Гэдрэг ухран шугуй руу зугтах мэх хийн нуугдав гэнэ. Шугуй руу элдэн орж ирсэн заант цэргүүдийн сүрт заануудыг хүлэгтэнгүүд модон дотроос мэргэн сумны хүчийг буулгав гэнэ. Шархандаа галзуурсан заануудынхаа хөлөнд тэр тэнгэрийн зарлигт эс итгэх улс мөхөв. Их хаан таны хүчийг үхэж мэдэв.

Их хаан Хубилай:

- (Шадар Хөхөө рүү зүг толгой дохино)

Хааны шадар Хөхөө:

-Их хааны зарлигийг дуудсугай!

Ордны монгол албат:

-Юан Гүрний Их Хаан Хубилай зарлиг сонстугай! Түвэдийн Пагва ламд “Улсын багш” цол

олгож, бурханы шашны хэргийг эрхлэхтүн! Юан Гүрний шинэ бичгийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд хааны сангаас хөрөнгө шийтгэхтүн! Монгол хүн хятадтай суух, хятад хэлээр ярихыг хориглож, жил бүр Хонгирад аймгаас зуун охидыг авчруулж монгол ноёдод хатан болгосугай! Чжүн-тун-Юань-Бао-Цзяо-Чао цаасан мөнгөөр ядуу дорой амьдралтай, өнчин, бэлэвсэн эмэгтэй зэрэг хүмүүст жил бүр тэтгэмж олгохтүн! Их хаан өөрийн хөвгүүн Чингэмийн ууган ханхүү Гамалад язгуурын Монголын хэргийг барих Хархорины язгууртан вангаар өргөмжлөв. Мөнхүү их хааны хөвгүүн Номгон Чингис хаан эзний дөрвөн ордыг захиртугай! Бат ханы хөвүүн Мөнхтөмөрийг Алтан орд улсын ханаар өргөмжлөв! Алгуйн хөвгүүн Мубарак Цагаадай хан улсын ханаар өргөмжлөв! Ордосын орноо барьсан найман цагаан өргөөнөө өвөг дээдсийн сүнсийг тахисан их тахилын дор Эзэн Чингис хаанд “Асрал, өглөгч хийгээд элбэрэлт хаан” хэмээх цол алдрыг Их хаан Хубилай нэхэн өргөв өө!

Бүгд цугаар:

-Хурай... Хурай... Хурай...

(Гэрэл бүүдийж гагц Чжао түшмэл дээр тусна. Тэрээр сөгдөн суусан газартаа урагш унана. Ван-Ө түшмэл түүний дэргэд яаран ирнэ)

Ван-Ө түшмэл:

- (Сандарч мэгдэн) Чжао түшмэл үхчихлээ. Түүний зүрх гэнэт зогсов. Юан гүрний үнэнч түшмэл Чжао үхлээ. Хаантан минь. (Уйлагнана)

(Хөгжим хятад гуниг эмгэнэлт аялгуу) (Бүрэнхийлэл)

(Тайз эргэнэ. Хааны өргөө гэр. Их хаан Хубилай дээдсийн хэрнээ даруу монгол дээл хувцастай байна. Хан Жөн Мон Тоба, хааны шадар Хөхөө хийгээд монгол хатдууд байна. Монгол хатад хөгжим тоглоно. Бага балчир Мөнгөнүхэн охин монгол бүжиг бүжиглэнэ)

Их хаан Хубилай:

- Алив хаан аавдаа ир! (Мөнгөнүхэн охин хаан дээр очно. Үнсүүлнэ) Мөнгөнүхэн охин минь, Мүхэ хатан эх, Хан Жөн Тоба авга ахаа даган миний төрөлх эх нутаг, өвөг дээдсийн гал голомт өөд маргаашийн мандахын улаан нарнаар мордоно. Олон хөвүүд охид төрүүлэн, энх тунх амьдран суух болтугай.

Мөнгөнүхэн охин:

- Жа, хаан аав аа! Таны нүдээс нулимс унав.

Бага хатан эх Мүхэ:

-Ухаалаг цовоо охин минь, Хааны мөнгөн нулимсыг арчиж өг! (Мөнгөнүхэн охин хаан аавынхаа хацрыг үнсэнэ)

Их хаан Хубилай:

-Охин минь хаан аав нь чиний зулайн үнэрийг авч үлдье дээ! (Зулайг нь удаанаар үнэрлэнэ) Монголчууд мөнх хөх тэнгэрийн дор өөрөө бүтэж өөрөөсөө сэргэн мандана. Хөх тэнгэрийн дор, хөрст дэлхийн хөвд өвсний дээр хөх Монголын үрсийн заяа өндөр. Хөх нуруутны өлгий нутагт нүүдлийн оршихуй мөнх орших болтугай. Хэзээнээс дэлхий ертөнцөд хүмүүн төрөлхтөн нүүдлэн орших хутагтай. Эхлэл нь ч энэ. Төгсгөл нь ч тэр. Тэнгэрийн буулт хүмүүний өлгий, гал голомтыг өмөөрөн авч үлдэхэд Өгэдэй, Цагаадайн үрс Толуй үзүүр, сэлэмний ир болж явсан та нар минь цөвүүн цагийн давхар гамшгийн золио болон одов. Хаан би алтан ургийн та нараа золихын зовлондоо ихэд нэрвэгдэн гунив. Ухаан минь нэгэн цагт хойч үед минь тодрох болтугай.

Бага хатан эх Мүхэ:

- Хаан минь, Алтан дээд аялгуунд үнэн хаан хэмээгчийг олны сэтгэл хаан мэт үзмой хэмээдэг. Тэр ёсоор энэ цаг биш гэхнээ ирээдүй олны сэтгэлд та бүтнэ.

Их хаан Хубилай:

-Төрийн хатан эхийн үгэнд сэтгэл уужрав. Эзэн хаан Чингис Хятадыг цэрэг зэвсгээр бүрэн эзэлж Монголтой нэгтгэх аваас Монгол гүрэн мөхнө хэмээн гэрээсэлсэн. Эзэн хааны алтан гэрээсийг би мөрлөв. Мөрлөх энэ гэрээс мөн хатуу бэрхийг хаан надад үүрүүлэв. Мөнх хөх тэнгэр минь, үнэнч шударга хөх нуруутны дээдэс алтан ургийн сүнсийг тайвшруулах болтугай! Их Хаан би хаан орыг минь эзлэн суух түүнийг миний хан хөвүүн Гамала хэмээн нэрлэн заав.

(Бүрэнхийлэл) (Тайз эргэнэ. Гэрэл тодорно. Тайзны өмнө биед Хан Хөхөө гарч ирнэ)

Хааны шадар Хөхөө:

- Их Монгол Гүрний Далай хаан Гүюг, их хатан Огул Хаймишийн ханхүү Хөхөө намайг нялх балчирт минь аюумшигт цаазаас өршөөн авч Их хаан Мөнх хан Хубилай авга ахад минь өгсөн билээ. Их Хаан Хубилай, Их хатан Чибан нар намайг алтан дээдийн аялгуугаар амлуулан өсгөв. Их хаан авга ах та надад амь хийгээд тэнгэрийн дээд алтан аялгуугаар өсөх их хувь өгчээ. Их хаан та, миний үзэн ядах өс эсийг тэнгэрийн ухаанаар устган тэтгэжээ. Хайрлан энэрэхийн холч мэргэн хаан эрдэнэ төгс таны, агуу их ухааныг тань үзлээ. Дэлхий ертөнцийг голлон мандан бадрах тийм төрийг би үзэв. Агуу том улаан нар тэнгэрт ганцаар гэрэлтэх тийм цаг таных байв. Эзэнт Гүрний Их хаан Хубилай мөнх тэнгэрт морилов. Их хаан тэнгэр болов.

(Хөгжим) (Харанхуйлал)

Есдүгээр үзэгдэл.

9.;Алтан дээд гэриэт хөх нохойхон алтайн ууланд нууцлагдав.

Тайз: Уул усны онго тахилгат газар. (Хөгжим.Хөөмий)(Хан Жөн Мон Тоба, Хатан эх Мүхэ, Мөнгөнүхэн охин, Жөн Мон Тобагийн хатан Өлжий, Аригун өвгүн ноён, Хасарын албат ардууд байна. Тэд бүгд дээдсийн хувцасаа тайлсан ба эгэл иргүн ардын хувцсыг өмссөн байна. Алтай Тоул уул, төрөлх эх нутагтаа тэд эргэн ирж, Мөнх хөх тэнгэрт хандан мөргөх үйл)

Бага хатан эх Мүхэ:

- Мөнх хөх тэнгэрийн хүчинд мөргөмү. Дээд тэнгэрийн язгуур Бөртэ чино, Гоо Марал мину алтан үрс биднийгээ аврал ачлалдаа авч хайрла.

Бүгд цугаар:

-(Бүгд цугаар мөргөнө)

Хан Жөн Мон Тоба:

-(Нулимсаа арчина) Ариун цагаан зам хайрласан аав уул минь алсад одоход авралаа хайрласан алтай уулс минь хатан эх,хатад үртэйгээ хаан ах Хубилайн зарлигаар Хан Жөн Мон Тобо хөвүүн чинь харьж таньдаа ирлээ. Ахуй биеийг минь анх тоссон газар минь алтан биеийг минь угаасан рашаан мөрөн минь амгалан уу?

Аригун өвгүн ноён:

- Хөх нуруутны өлгий Хөхий хан Алтай минь ээ, амар амгалан уу? Үлгэр мэт ертөнцөөр өвгүн болтлоо аялаад өндөр ууландаа эргэн ирлээ. Онъсогоор дүүрэн ертөнцөд олныг үзээд ирлээ. Ертөнц дэлхийг алтан төрийн жолоонд хураасан агуу хаадын дэргэд шадарлан явсаар ;өвгүн ноён би мөнхийн амгалангаа үзэхээр мөргөн залбирч Алтай Тоул чам юундаа ирлээ. Ай олон аймшиг, гайхамшигийг үзлээ. (Уйлна) Амар амгалан уу? Алтай Тоул минь ээ.

Бага хатан эх Мүхэ:

- Тоул Алтай мину. Мөнх тэнгэрийн ариун зулай, буурал Алтай мину. Анхны амины эхлэл Алтай Тоул мину. Тэнгэрийн Алтан дээд үнэний аялгуут Алтан ургийн үрс биднийгээ агуу ачлал өмгөөлөлдөө автугай. Тэнгэрийн Тоулаас язгуур эхтэй хөх нуруутны үрс бид таньдаа эргэн ирлээ. Өлгий нутаг минь ээ, Хүмүүний голомтыг манасан Тоулчу мэргүн эцэг минь ээ. Алтан аялгуугаа тээгээд алтан үрс тань буцаж ирлээ.

Жөн Мон Тоба:

-Долоон дээд өвгийн нэг Тоулчу мэргүний хөх нохойн удам, Найм дахь дээдэс Чингис хааны алтан ургийн зангилаа ач үр, ;Алтан дээдийн аялгууг аминдаа агуулсан ;Жөн Мон Тоба би

билээ. Алтан дээд аялгууг ;Хөх нохой овгийнхон Хавт Хасарын удмаар хамгаалан сахиулж үеийн үедээ амнаас аманд, үрийн үрдээ аминаас аминд нуун хадгалтугай хэмээх Их хаан Хубилайн зарлигаар харьж бид ирэв. Хайрхан Тоул Алтай минь хаадын үр, дээдсийн удам Алтан гэриэт биднийгээ асралдаа авч, агуулан нууцалж, хойчийн минь үр удмыг мөнхөд ивээж тэнгэрийн цаг сэрэх тэр гайхамшигийг үзүүлтүгэй.

Бага хатан эх Мүхэ:

-Бурхан Халдун хаан аав алтан ууландаа мөргөн гуйж, Хэрлэн онон хатан ээж ариун мөнгөн мөрөндөө мөргөн залбирч Их Монгол Улсын гал голомтыг манасан Бөртэ хатан эх Толуй ханы галаас таслан Алтай Тоулдаа бид авчирлаа.Үл тасрах болтугай. (Мүкэ хатан эх,Өлжий бэхэ хатан цацал өргөнө)

Хан Жөн Мон Тоба:

- Үүслийн гурван үнэн, ;үнэний таван хүрдэн, Долоон дээд эцэг элэнцийн зөн, Найм дахь их Чингис эцгийн зөн Арван түгээмэл, Ерэн есөн тэнгэрээр тэтгэгдэх Зуун найман төвшин сайханд төгөлдөрт хүрэх хаан ;Гэсгээн нэргэгч Тохинуулан тогтоогч, ;Гэгээн Тэнгэрт өөд татагч Мөнх Тэнгэрийн аялгууг үр удамдаа өвлүүлэхээ андгайлúa. Мөнх тэнгэр үр хойчийг минь асартугай.

Өлжий бэхэ хатан:

-Бадраагч их хаадын алтан үрсийг хан Жөн Мон Тобагийн хатан би Төгс Үлэмж Хөг Бүтээгч, Төрөөр Иргүнийг Бадраах Хутагтай Нүүдэлт Засгийн Алтан Дээд Үнэний аялгуугаар амлуулан өсгөхөө андгайल्या. Алтан оосрыг билгээр харах, арван түгээмлийг түгээх, нэүрит үнэнг нээх сайн цагийг үзэх болтугай. Хөх тэнгэрийн хүч иртүгэй.

Хан Жөн Мон Тоба:

- Хабсу их ертөнцийг онож бойжих хаадын онго шүтээн монголыг тэтгэх болтугай. Хаан эрдэнийг дуурайх билиг хүчийг харцын үрс иргэдэд өгөх алтан аялгуу миний удамд мөнх оршиг. Өндөр тэнгэр минь,өвөг дээдэс минь заяагаа хайрлагтүн.

Бага хатан эх Мүхэ:

- Толуй ханы бага хатан Мүкэ би Айл бүлийн нийхэмт засагч хатнаар өргөгдөн ирсэн билээ. Төрөөр иргүнийг бадраах хутагт Алтан дээд гэриэ аюулаас нууцлагдаж алсдаа алтан цагийг урих болтугай. Хөх нуруутнуудын үрс хүчийг нээн үзэх болтугай.

Мөнгөнүхэн:

-Толуй хан аав Мүкей хатан ээжийн Жөн Мон Тоба би. Хорвоотой хосгүй зохицохуй хөх нуруутны хөхрөгч төбэ дээд бодисоор ерэн цэвэр шударга бүхий ерөн есөн аргыг олох тэнгэрийн аялгуу сонсов. Мянган сэтгэхүй нэгэн оюун дор ;тухалж, гал болсон гэрийн онолт улсууд болохын гэгээрэлт ухамсарт суралцан ухааныг тайлж үзэв. Хан ах нараа түшиж, хамаг

-Мянган сэрэхүй нэгэн оюунд гал болохын, мэргэд гарах гүн утга, Сүнс болоод эзэн биеэ тайлан уухайлж, Сүлд болоод гавалт бүрээний уянга дор ертөнцийг хурайлж, тэсч магад гарахын чанга хүчийг эзэгнэх, Дэлхийн улсууд монгол тархитай байхын үлгэр Алтан дээд гэриэ мөнх орших болтугай. ;Алтай Тоулаас гаралт ;манай хөх нохойн удам ;хаадын нууцыг хадгалан, хөрстийг энхжүүлэн, хөх тэнгэрт хүнийг өөд татах хүчит олом Алтан дээд үнэний аялгууг үл таслан энэ ертөнцдийн авралын аялгууг ;ирээдүй хойчдоо залгуулах тэнгэрийн билиг билгүүний улаач болох болтугай. Алтан дээд аялгуугаар ахуй энэ дэлхий аврагдан оломлогдох болтугай.

Аригун өвгүн ноён:

-Ариун агаараар шидэт намууныг үүсгээд Алтай Тоул мөн ч сайхан байна аа. (Нулимсаа арчина) Тоул Алтайдаа мөргөө.

Бүгд нийтгээр:

-Алтай Тоулдаа мөргөө.

Бага хатан Мүхэ:

- Өтүгэ, Мугулюй, Манукул, Хөх Монгол улирлын газар болоод огторгуй үнэн бөө бүх ертөнцийн долоон дээд өвөг эцэг элэнцийнхээ сүр сүлдэнд сүнсэнд мөргөмү.

Бүгд цугаар:

- Долоон дээд өвөг эцэг элэнцийнхээ сүр сүлдэнд мөргөмү.

(Бүгд цугаар мөргөнө)

(Мөнгөнүхэн бэхэ хатан, Бага хатан эх ;Мүхэ, Хан Жөн Мон Тоба, Жөн Мон Тобагийн хатан Өлжий, Аригун өвгүн ноён, ;Хасарын албатууд. Бүрэнхийлэл)

(Хөгжим, “Уяхан замбуутивийн наран“ уртын дуу эгшиглэнэ)

(Мөнгөнүхэн өтөлсөн байна.)

Мөнгөнүхэн:

- Мөнгөнүхэн эх миний хэлсэн бүгдийг тогтоо. Үүслийн гурван эрдэнээр бадарсан, хайрын хос дуслаас ургасан хөх нуруут дээд төрөлт үрс бүхэн яс цусны алтан бүсээр оломлогдсон билээ. Ерэн есөн тэнгэрт мэндэлж, арван хоёр их ертөнцөд бойжиж, агуу гурван үнэн, зуун найман билгүүнд мөнхрөөд Алтай, Хангай, Хар жодоотыг эзэгнэх хөх монгол иргүнүүд Их Монголын босоо голч нь билээ. Мөнх хөх тэнгэртээ мөргөмү. (Бүгд мөргөнө) Дагаад дуудаарай. Хүмүүн суумлыг хохироохоос аврах ;мөн тоба дээд бодисыг тээгч хөх нуруутнууд хондод унахгүй болмой. Хөх монголыг нүүдлийн соёлоор бадраах хутагтай Алтан дээд үнэний аялгуугаар чиглээд төрийн найман цаха аялгуугаар ёсыг мөрвөөс хөх монголууд нүүдлийн засгаар бадармой. Хөх Чингисийн нэргэлтээр бадрагдмой.

Бүгд цугаар:

- Хөх монголыг нүүдлийн соёлоор бадраах хутагтай Алтан дээд үнэний аялгуугаар чиглээд төрийн найман цаха аялгуугаар ёсыг мөрвөөс хөх ;монголчууд нүүдлийн засгаар бадармой. Хөх Чингисийн ниргэлтээр бадраагдмой.

(Бүрэнхийлэл тайзны өмнө гэрэл тодорно. Харь орны мэргэд гарч ирнэ)

;Бенедикт сүмийн лам Матью Парис:

- Бенедикт сүмийн санваартан Матью Парис би байна. Бидний үйлдсэн нүглийн сав дүүрч бурхан гэсгээн цээрлүүлэхээр дорноос зэрлэгүүдийг нааш илгээжээ. Тэр зэрлэг хүлэг морьтонгууд бүх дэлхийг эрхэндээ оруулахыг зорих ба ертөнцөд өөрсдийнхөө хуулийг тулгахаар иржээ.

Ромын элч санваартан Плано Карпини:

- Ромын элч санваартан Плано Карпини би Их Монгол Эзэнт Гүрнийг нүдээр үзлээ. Бүх юм аймшигтай бас гайхамшигтай. Хамгийн гайхамшигтай нь дэлхийн бүх л шашингууд үл тэрсэлдэх ба бүхий л сүм дуганууд энх тайвнаар зэрэгцэн орших бөгөөд тэр энхийг бүтээсэн улсын мөнх тэнгэрийн хүч хэмээх агуу аймшигтай. Чингисийн морьтон гэх тэр улсын нууц агуу ухаан сүрдэм басхүү сөгдөм.

Франкийн элч санваартан Гутьом Де Рубрук:

- Франкийн элч санваартан Рубрик би байна. Эзэнт гүрний эзэд гэх тэр хөх нуруутан ард иргэдийн гайхалтай итгэл үнэмшил, гуйвшгүй зан тэдний их гүрэнг бүтээжээ. Тэд тэнгэрийн иргэн улс гэж өөрсдийгөө нэрлэх ба ертөнцийг аврахаар Чингис хаантайгаа ирсэн хэмээнэ. Тэнгэрийн тэр тэмдэг нь хөх тамга хэмээн нуруугаа заана. Үнэхээр тэдний нуруунд хөх толбо бий ажээ. Эхээс төрөх нялх хүүхэд нь ч тэнгэрийн тамга гэх толботой төрнө. Хүн төрөлхтөн дотроос бусдаас содон тэмдэгтэй улс цаашид хэрхэхийг таашгүй.

Италийн худалдаачин Марко Поло:

-Их хаан гэдэг бол албат иргэд, газар нутаг, эд баялгийн хувьд ч хамгийн хүчирхэг хүн бөлгөө. Эзэнт гүрний их хааны дэргэд залуу насаа үдсэн жуулчин Марк Поло би хүний биед хүч чадал хэрхэн бүрэлдэж болдгийг нүдээрээ харлаа. Жинхэнэ хаанд тэнгэрээс шонхрын нүдээр газрыг үзэх нүд заяагдмал ажээ.

Хятадын Ван-Ө:

-Их хаан Хубилай тун хэцүү ухаант хаан. Юан гүрний тэнгэрт луу хүрхэвч тэр алтан луу дотор гуурст хүлэг янцгаахыг олж сонсож болно. Үзэгдэх нь аадрын үүл хэмээвч баригдах нь үгүй үүл мэт энэ хаан хэний хаан болохыг хэлэхэд хэцүү. Алтан луу биш тэр янцгаах гуурст хүлэг ;хааны цээжинд бий. Хан үндэстэнгүүд минь болгоомжлогтун.

Буддын лам Пагва:

- Монгол орон ариун бумбын орон. Тэнд гайхамшиг бүтнэ. Хойд насандаа ариун оронд төрөх ерөөл тавих хүмүүн өнөр болтугай!

Оросын эрдэмтэн Гумилев:

-Дэлхийд засаг төрийг, улс үндэстэнг ялангуяа Орос, Хятад их гүрнийг бүтээж өгсөн энэ монгол хэмээх нүүдэлчин морьтонгууд Гумилев миний зүрх сэтгэлийг өөртөө эзэмдэн авчээ. Монгол нутагт нарны гэрэл бусад газрынхаас өөр өнцгөөр тусдаг учир монголчууд нэн өвөрмөц нэг л өөр... Магадгүй бөөрөнхий дэлхий хязгааргүйд эргэлдэхдээ энэ орноор дээшээ доошоо харж байгаага олж болох юм. Гайхамшигт энэ орны газар шороо нарнаас нэг л сонин хүчийг цуглуулдагаас гарцаагүй. Онгон дагшин орших болтугай. ;

(Гэрэл тэднээс авагдана. Тэд тайзыг орхино. Гэрэл тодорно)

Бүгд цугаар:

-Мөнх хөх тэнгэрт мөргөмү. (Бүгд цугаар мөргөнө)

Хан Жөн Мон Тоба:

- Их Монголын Эзэнт Гүрний Мохоон гэсгээгч Богд Эзэн Чингис хааны сүр сүлд сүнсэнд мөргөмү

Бүгд цугаар:

- Богд Эзэн Чингис хааны сүр сүлдэнд ;мөргөмү. (Бүгд цугаар мөргөнө)

(Бүрэнхийлэл) (Тайзны гүнд гэрэл тодорно. Гүний өндөрлөгт Их Монгол Эзэнт Гүрний Эзэн хаан Чингис, Их хатан Өгэлүн, Их хаан Өгэдэй, ;хаан Толуй, Их хаан Гүюг, Их хаан Мөнх, Их хаан Ариг бөх,Их хатан Сорхагтан, Хан Хүлэг, Хан Жөн Мон Тоба, Хатан Алалтунбэхэ нар зогсоно)

Тавдугаар жүжгийн жаргаах төгсгөл титэм.

Чингис хаан:

- (Эзэнт Гүрний их хэнгэргийг дэлдээн, Хаан баруун гараа дээш өргөнө) Мөнх тэнгэрийн суу хүчин дор, Эзэн Богд Чингис хаан миний зарлигийг сонсогтүн! Дээд тэнгэрийн ;зарлигаар хөх нуруут бид ертөнцөд дэг журам тогтоохын тулд тэнгэрийн зараалаар ирж дэлхий ертөнцөд төрсөн. Бидний хөх нуруут Монгол, тэнгэрийн улс иргүнүүд билээ. Тэнгэрийн төрөлт алтан ураг түүний хөх нуруут ;иргүнүүд ;ертөнцийн хүмүүн төрөлхтөн бүгд нийтээр гагц шударга, чин үнэн, энх амрыг ;эрхэмлэх тэнгэрийн судар Алтан дээд үнэний аялгууг газарт буулгаж хүмүүн бүр хөл хөсөр, гар газар жарган суух энх цагийг ;үзэх ;мөнх тэнгэрийн хүчийг газарт агуулав. Дэлхий ертөнцийг ;ирээдүйн их устгалаас аврах Мөнх хөх тэнгэрийн ;алтан дээд үнэний аялгуу хөх нуруутан бидний өлгий нутгаас өөрөө өндийнө. Тэнгэрийн тэр цагт ;дэлхий ертөнцийг аврахаар бид эргэн ирэх болно. Аз хийморьтой хөх нуруутны үрс алтан дээд гэриэг тэр цагт мөрлөн зогстугай. Тэнгэрийн цаг сэр... Агуу цагийг Мөнх хөх

Их хаад дахин төрнө

Их гүрэн дахин сэргэнэ.

Б. Батрэгзэдмаа

Түүхэн сурвалжийн он дараалалын хураангуй товчоон

1. Их Эзэн Чингис хааны төр барьсан сүүлчийн жилүүдийн түүхэн цагийн товчоон.

- 1216 он. Дөрөвдүгээр жарны 10 дахь Улаан хулгана жил

Чингис хаан Хэрлэн мөрний Их аураг ордондоо байсан үе. Цагаан сарын шинийн нэгэнд өтгөс настандаа хишиг хүртээв. Чингис хаан

анхныхаа элчийг зарж худалдаа хийхээр одуулав. Хорезм шахын жаран мянган цэрэг Эрчис гол дээр Жүчи, Сүбээдэйн цэрэгтэй анх удаа байлдав. Хорезм Шах гурван түмэн цэргийн хохирол үзсэн гэдэг. Алтан улсын Вань –ну буун өгч, Мухулайтай найрамдав.

-1217 он. Дөрөвдүгээр жарны 11 дэх Улаагчин үхэр жил

Багдадын Халиф Хотон мөргөлчдөөр Чингис хаанд захидал явуулсан. Загалмайтны тавдугаар аян дайн эхлэв. 8- сард Мухулайд төрийн сайд хэргэм шагнан, Умард Хятадыг байлдан эзэлж, захиран барих онцгой эрх олгов. Мухулайд Алтан тамга, есөн хөлт цагаан туг шагнасан. Хорезмын худалдаачин Валчикэн тэргүүтэй гурван худалдаачин Чингис хаанд ирсэн бололтой. Чингис хаан

Ухнаа тэргүүтэй дөрвөн зуун тавин хүний бүрэлдэхүүнтэй, таван зуун тэмээн ачаатай элч худалдаачдыг Валчикэнийхэнтэй хамтаар Хорезм улсад явуулав.

-1218 он. Дөрөвдүгээр жарны 12 дахь шар барс жил

Оны эхээр Их монгол улсын элч, худалдаачид 450 хүнийг Хорезм улсын Отрар хотод алж, ачаа барааг дээрэмдсэн эмгэнэлт хэрэг явдал гарав. Энэ цуст хэргийг Мухаммед шахын заавраар Инальчук хан гүйцэтгэжээ. Жинчдийн тэмээ хариулж байсан нэг Монгол хүн дуулаад эх нутгийн зүг нэг тэмээгээр зовон илэн явж хил дээр ирж улмаар хаанд мэдээ дуулгажээ.

Чингис хаанд Багдадын Халифийн захидал ирж, Хорезмыг байлдахыг ятгажээ. Өвөл Чингис хааныг цэрэглэн хөдөлсөнд Хорезмын шах хөвүүн Желал- Ад-Динаа иранд үлдээж, өөрөө Дундад Ази уруу хөдөлжээ.

Чингис хаан онц буухиа элч зарж Мухаммед шахаас худалдаачид алж, их нүгэл үйлдсэнд ял асууж, хэрэгтэн Инальчукийг барь ирүүлэхийг шаардахад Хорезмийн шах Хоёр монгол элчийг нь алж, эцгийнхээ үед зүтгэж явсан Түрэг угсааны Бугурын сахал үсийн тайрч доромжилон буцаагаад Чингис хаанд хандан “Би чам руу хөдөлнө, чамайг элч шиг чинь болгоно ” гэж хэлүүлсэн нь үндсэндээ дайн зарлажээ. Оны эцсээр Их хуралдай зарлан хуралдуулж Хорезмыг дайлах асуудал хэлэлцэгдэв. Чингис хаан Өгэдэйг Их Монголын хааны орыг залгамжлуулахаа гэрээслэв. Хар Кидан улс мөхөв.

Илюй Цуй Цай Монгол төрийн хэрэгт зүтгэх болов.

- 1219 он. Дөрөвдүгээр жарны 13 дахь шарагчин туулай жил

Гуулин улс, Монголын жанжин Жала, Хабжин нар “ .. бидний хоёр улс үүрд ах дүү байж, түмэн үе үр сад маань энэ өдрийг бүү мартаг” гэсэн гэрээ хийж найрсаг харилцаа тогтоов. Солонгос улсын Гао-Цзи Монголд алба өргөв. Чингис хаан Тангудын Бурхан хаанд (Цзунь - Сянь) элч явуулж баруун гар болно уу гэхэд Аша хамба их үг хэлж “...хүч хүрэхгүй байж хаан болдог нь юун билээ ” гэж элчийг буцаасан бөгөөд хожим тэр нь их дайны шалтаг болжээ. 1218-1219 оны өвлийн тэсгэм хүйтнээр далайн түвшнээс дээш 5000-7000 м өндөр өргөдсөн хоёр метр зузаан цастай, урьд хэн ч давж байгаагүй өндөр нурууны аль дөт замаар Зэв жанжин цэрэгтэйгээ давж дэлхийг түүхэнд байгаагүй хосгүй эрэлхэг гавьяаг байгуулан гайхамшигийг хийжээ. Памир, Тэнгэр уулыг хавцлаар давж Ферганы хөндийд орж очихыг Ала-Ад-Дин Мухаммед шахыг цочирдуулжээ. Зэв жанжин тэд рүү цүүц хатгалтаар дайралт хийж гэнэт цацсан одны уран арга хэрэглэж алга болжээ. Чингис хаан биеэр 150.000 цэрэг авч Хорезмыг дайлаар мордов. Чингис хааны дүү Отчигон ноён Их Монголын улс төрийн хэргийг хамаарч үлдэв. 1219 оноос Алаха бэхэ говийн өмнөхийг захирах эрхтэй болж “Төр захирагч гүнж” болов. Чингис хаан Нанхиадын Бумбын шашны Чан Чунийг урьж, Лиу жүн Лүр, Жибэр нарын тусгай элчийг Хятад нутагт зарав. Билгийн тоолын 12 сарын сүүлчээр Чан чин арш арван есөн шавиа дагуулан Чингис хааныг зорив.

- 1220 он. Дөрөвдүгээр жарны 14 дэх цагаан луу жил

Хорезм улсын Үргенч-д байсан эх Турхани хатан Мухаммедын эхнэр хүүхдийг дагуулан, Мацадарын ууланд Илаль цайзад гарч байгаад Сүбэгэйдэйд баригджээ. Чингис хааны таван түмэн цэрэг арван таван түмэн агттайгаа 600 км өргөн Кызыл-кумын цөлийг нэг сарын дотор туулжээ. Өдгөө “Хааны зам ” гэдэг. Чингис хаан Бухар хотыг, Отрар хотыг эзлэв. Чингис хааны цэрэг Нишапур, Термез хотыг эзэлжээ. Ургенч хотыг авав. Зэв Сүбэгэйдэй нарын цэрэг Азербайжаныг дайран Гүржийн нийслэл Тбилис өөд довтолж, Каспийн тэнгисийн эрэг дагуу Муганы талд өвөлжив. 12 –р сарын 11 нд Мухаммед шах Каспийн тэнгисийн Мазандеран гэдэг нэгэн бяцхан арал дээр хорогдон удалгүй 1 сарын 21 нд уушигны хатгаагаар нас баржээ. Хорезмын Турхани хатан олзогдоод Монголд ирэн 1233 онд нас баржээ. Инальчукийг барьж Хөх сарай дахь Чингис хааны ордонд хүргүүлэхэд хортой архи өгч алжээ. Зарим түүхэнд цагаан мөнгө хайлуулж цутган алсан гэж байдаг. Есүхэй баатрын дэд хөвгүүн Хасар нас барсан бололтой. Чингис хааны эх Өэлүн үжин цагаан сарын сүүлээр нас барсан байж магадгүй.

- 1221 он. Дөрөвдүгээр жарны 15 дахь цагагчин могой жил

Мухаммед шахын хөвүүн Желал-Ад-Дин 7-8 түмэн цэрэгтэй болж хүчирхэжив. Желал-д-Дин Бараан хээр гэдэг газар Есагур ноёны удирдсан монголын хошууч мянган цэргийг олзолж, улмаар анх удаа Шихшутугийн удирдсан цэрэг анх удаа ялагдал хүлээв. Бала, Дөрбэй нарын Монгол цэрэг Желал-Ад-Динийг нэхсээр Энэтхэгт цөмрөн Мультаг, Пенджаб, Лахор, Пешавар зэрэг хотуудыг эзлэв.

-1222 он. Дөрөвдүгээр жарны 16 дахь хар морь жил

Чан Чун Бумба Самаркандад очиж Чингис хаанд бараалхажээ. Толуй Хорасаны олон хотуудыг эзлэв. Зэв, Сүбээдэй нар Брюдникуудтай холбоолж Хибчагийг Бузулук гол дээр бут цохив.

- 1223 он. Дөрөвдүгээр жарны 17 дахь харагчин хонь жил

Оросууд Монголын 10 элчийг Киевт алжээ. Галицын вангийн санаачлагаар Киев хотод чуулган хийж, холбоо байгуулан Монголчуудын эсрэг байлдах болов. Чингис хаан цэргээ авч, Сырьдарьяа мөрөнд Цагаадай, Өгэдэйн цэрэгтэй нийлэв.

Зэв, Сүбэгэйдэй нар Крым, Судак, Денепрээс Азовын тэнгис хүртэл эзэлж, Каспийн тэнгис Арал тэнгисийн усгүй талыг гаталж, Сырьдарьяад ирж Чингис хаантай нийлэв.

-1224 он. Дөрөвдүгээр жарны 18 дахь хөх бич жил

Тангудын хаан Ли-Тэн ван Алтан улстай холбоолж Монголын эсрэг нууц холбоо байгуулав. Хавар Чингис хаан Шейхун мөрний баруун эрэг орчим Их Хуралдай зарлан хуралдуулж, нутаг буцах тухай асуудал хэлэлцэв. Намар монгол цэрэг дундад азиас нутаг буцав.

Хулан хатан нас баржээ. Мухулайн хөвгүүн

Бор цэрэг авч Тангудыг хоёр замаар дайлав.

- 1225 он. Дөрөвдүгээр жарны 19 дэх хөхөгчин тахиа жил

Чингис хаан хавар -2 сард их цэргээ авч эх цэргээ авч эх нутагтаа ирээд “Туул голын Хар түнэ” дахь ордондоо амран саатав. Чингис хаан Тангудад элч илгээв. Тангудын Аша хамбу их үг хэлэв. Зун нь Чингис хаан засаг “Их засаг” буюу (Алтан гэрэгэ мөн гэж Зохиолчоос үзэв.) билиг сургаал нийтлэх зарлиг буулгажээ. Энэ үед Чингис хаан билиг сургаалаа хайрлаж, ерөнхийд нь бичүүлсэн бололтой байдаг. Энэ сургаалыг жил бүрийн эхэн адагт хоёр удаа том ноёдоос энгийн ард хүртэл хүмүүст сонсогдог байжээ. Онон мөрний эхээс, Хар Хүрэм хүртэлх нутгийг отгон хөвүүн Толуйд дахин хувь болгон өгөв.

Намар Чингис хаан арван түмэн их цэргээ авч Тангуд улсыг дайлахаар мордов. Чингис хаан өвөл нь Ар буха гэдэг газарт их ав хомрого хийж байгаад сүрэг хуланд дайруулан мориноосоо унаж бэртэв. Дайнд Есүй хатан, хөвүүдээс Өгэдэй, Толуй, жанждаас Сүбэгэйдэй, Боорчи Елюй Цуй цай зөвлөхөөр явжээ. Цагадай үндсэн нутагтаа үлдэж улс орноо удирдах болсон.

- 1226 он. Дөрөвдүгээр жарны 20 дахь улаан нохой жил

Желал-Ад-Дин Карс, Гаг, Ани, Тбилис, Гандзаг, Нахичеваныг эзлээд Румын захын мужуудыг талж, Муганы тал руу ухрав. Гүрж, Рум, Сири, Армян Желал-Ад-Диний эсрэг холбоо байгуулав. Тангудын эзэн Ли-Дэ ван үхэж, түүний ач хөвүүн Ли-Ши-Ян эзний орыг залгамжлав. Тангудын хаан Чингис хаанд элч явуулж бууж өгье гэж их бэлэг ирүүлжээ.

Хаврын тэргүүн сард Тангудыг эзлэн, Хар балгасыг авав. Чингис хаан Тангудыг цэргийг бут цохисноор бүх цэргийн гуравны нэг нь устаж хүч суларчээ. Өвлийн тэргүүн срд Тангудын баруун зүгийн нутгуудыг эрхшээлдээ оруулав.

- 1227 он. Дөрөвдүгээр жарны 21 дэх улаагчин гахай жил

Хаврын тэргүүн сард Чингис хаан Хатан голыг гаталж Алтан улсыг довтлон эхлэв. Тангуд улсын эзэн хаан Бурхан биеэр ирж Чингис хаанд бууж өгснөө илэрхийлэв. Чингис хаан Лю-Пан-Шаньд зусав. Чингис хаан сайд ноёддоо “Өнгөрсөн өвөл таван од найрсах цагаар миний бие алж талахгүй гэж ам тангараг өгч байсан үүнээ зарлиг бичиг болгохоо мартжээ. Одоо үүнийг дотоод, гадаадад зарлан тунхаглаж, дэлхий дахинаа хүн бүрт мэдүүлсүгэй.” гэж зарлиг буулгав. Чингис хаан, Өгэдэй, Толуй нарыг нутагтаа буцаасан ба тэд ирээд удалгүй байтал эцэг хаан өөд болжээ. 7-р сарын 5 нд хар морь өдөр Чингис хаан чилээрхэж, шарагчин үхэр өдөр (аргын 8 сард 66 настайдаа тэнгэрт халив) Тангудын улсын хаан Ли-Сян нийслэл хотоо буун өгч, Монгол цэрэгт алагджээ. Тангуд улс хорин жилийн турш Монголын эсрэг зогсоод мөхжээ. Их хааны шарилийг Хэнтийн нурууны өвөрт Их өтөг гэдэг газар тээн авчирч онголов.

2. Далай их хаан Өгэдэйн төр барьсан түүхэн цагийн товчоон.

-1228 он. Дөрөвдүгээр жарны 22 дахь шар хулгана жил

Толуй Их Монгол улсын төрийн хэргийг хамаарч байв. Толуй эзэн төр хамаарснаас эхлэн хаан эцгийнхээ түүхийг эмхэтгэн бичүүлэх, хөргийг нь зуруулах, тахилга тайлгын асуудлыг үүсгэсэн бололтой байдаг. Их хуралдайн зар тараасан.

-1229 он. Дөрөвдүгээр жарны 23 дахь шарагчин үхэр жил

9-р сарын 11 - нд буюу Хэрлэнгийн хөдөө аралд Их хурилдай 40 гаруй хоног хурж, Өгэдэйг Их Монгол улсын хоёр дугаар хаанд өргөмжлөн сонгож, ”Далай хаан” цол олгов. Хаан суудалд залахад Цагадай баруун гараас, Толуй зүүн гараас авга ах Отчигин бүсэлхийнээс нь тус тус түшиж хаан ширээнд залжээ. Өгэдэй хаан болоод эцэг Чингис хааны сүнсэнд зориулсан их тахилга тайллага үйлдэж дөчин гоё эмэгтэй ба морьдоор хойлоглох ёс үйлдсэн гэдэг.

-1234 Өгэдэй хаан Алтан улсыг мөхөөв. Энэ дайнд Мөнх дагаж явсан.

Их хуралдайгаар Ижил мөрний Каспий хавийн нутгийг байлдах асуудлыг хэлэлцсэн. Хоёр гарт хуваагдаж хоёр газар байлдсан. Өгэдэй хааны гурван замын цэрэг Алтан улс руу, Сүвээдэй Мөнх Ижил мөрөн рүү дайлаар одсон

-1231 он, Дөрөвдүгээр жарны 25 дахь Цагаагчин туулай жил

31-39 онд Монгол цэрэг бүх Кавказыг ноёрхолдоо авав. Толуй төвдийн ууланд ялалт байгуулаад хаан эзэндээ ирж нийлжээ. Өгэдэй хааны бие чилээрхэж бөөгийн ёсоор Толуйг золио болгожээ. Хааны бие угаасан бөөгийн шившлэгтэй ус уусан гэдэг. Толуй 40 насандаа таалал төгсөв. Энэ бол их балмад үйлдэл байсан бөгөөд хойшдын их дайн тэмцлийн шалтаг болсон зүйл байв. Толуй ах Өгэдэйн төлөө амиа золиосолсон гэдэг.

“ ... Намайг хаан ахын дэргэд байж мартсаныг сануулж, унтсаныг сэрээж яв гэсэн билээ. Одоо хаан ах таныг алдваас би хэний мартсныг сануулж, унтсаныг сэрээх билээ... ” гээд Урудын Алаг дэрс гэдэг газар (Алтан худаг) нас баржээ. Бөө нарын өгсөн хор уусан ???

Толуйн хатан Хэрэйдэйн Хонхажин овгийн хүн Жаха хамбугийн-гийн хоёрдугаар охин Толуйн голомтыг түшиж үлджээ. Сорхогтан бэхэ хатан.

Төв бичгийн хорооны тэргүүн сайдаар Илюй Цу Цайг томилсон.

Гуулин улсыг байлдан эзэлсэн.

-1232 он. Дөрөвдүгээр жаран. 26 дахь Хар луу жил

Сүвээдэй, Мөнх Хөхдэй нарын цэрэг Булгарт довтолсон. Өгэдэй хааны бие өвдсөн учир нутаг буцаж хаан эцэг Чингис хааныхаа буудлын ордонд очжээ.

-1233 он Дөрөвдүгээр жарны 27 дахь Харагчин могой жил

Алтан улсад Бяньцзинь хотод хижиг өвчин гарч 50 хоногийн дотор 50.000 хүн үхжээ. Гүюг Алчидай нар Зүүн Ся улсыг мөхөөв.

-1234 он. Дөрөвдүгээр жарны 28 дахь Хөх морь жил

Алтан улсыг бүр мөсөн мөхөөв. Алтан улсын Айцзун хаан өөрийгөө дүүжилж амиа хорлов. Их хуралдай зарлан Сүн улсыг дайлаар мордохыг хэлэлцэв. Илюй Цу Цай засгийн газрын тэргүүн сайд болов. Башкир Жүчийн улсын мэдэлд оров.

-1235 он Дөрөвдүгээр жарны 29 дэх Хөхөгчин хонь жил

Мөнх Гүюг Бат хамтдаа нэг сар байсан. Хуралдай зарласан. Умард Хятадыг байлдан эзэлснээ дүгнээд Булгар Ороа руу дайтах төлөвлөгөө хэлэлцэгдсэн Өгэдэйн хүү Хүдэн, Хүчү, Хасарын хүү Хуту, Тахайг жанжинаар удирдуулсан их цэрэг Хэнинь, Хэбэй мужуудаар цөмрөв. Батад баруун зүгийг байлдах эрхийг бүрэн өгч, Гюүг, Мөнх, Хубилай, Цагаадай хөвгүүн Байдраг Хадан нар оролцож, Сүбэдэйг зөвлөхөөр томилов. Өгэдэйн гутгаар хөвгүүн Хүчү Өмнөд Сүн улсыг эзлэх дайнд нас барав. Энэ хүүг хаан суулгахаар гэрээсүлж байсан. Дайнд ялалт байгуулсан. Гүюг Мөнх Асу улсыг хүчлэн байлдаж эзлээд найрлажээ. Бат Гүюг хоёр эвдрэлцэв. Бат Өгэдэйд нууц элч илгээв. Гюүг нутаг буцав. Сүн улс 200.000 лан мөнгө, төдий хэмжээний торгоор жил бүр алба барьж найрамдья гэв.

-1239 он. Дөрөвдүгээр жарны 33 дахь Шарагчин гахай жил

Кавказыг бүрэн ноёрхолдоо авав.

-1240 он. Дөрөвдүгээр жарны 34 дахь Цагаан хулгана жил

Өгэдэй хааны дуудснаар Гүюг, Мөнх нутаг буцав. Батын цэрэг Унгар, Польш, Герман цэргүүдийг бут цохив. Лалын худалдаачин Абдулхман Дөргэнэ хатантай дотносож, эзлэгдсэн олон хотуудаас гааль, гувчуур авах эрхтэй түшмэл болов.

-1241 он Дөрөвдүгээр жарны 35 дахь Цагаагчин үхэр жил

Өгэдэй хааны бие чилээрхэв. Дөргэнэ хатан Илюй Цу Цайгаас асуухад шорон гяданд байгаа хүмүүсийг өршөөж сулласнаар хааны бие сайжрав. Мэргэд угсааны Дөргэнэ хатан, Лалын худалдаачин Абдулхман нарт хорлогдсон байх гэж түүхчид үздэг. Учир нь Абдулхманы архийг уугаад нас барсан байжээ.

-1241 он Дөрөвдүгээр жарны 36 дахь Хар барс жил

Далан даваанд хэсэг ноёдын хурал болж, Өгэдэйн 6-р хатан (Мэргэд угсааны Тогтоа бэхийн хөвүүн Хутугийн хатан) Дөргэнэ Өгэдэйн хааны гутгаар хөвүүн Хүчүгийн хөвүүн Ширэмүнийг нас бага гэж төрийн хэргийг хамаарав. Энэ явдлыг Баруун этгээдийн Чингай чинсан, лал мөргөлт Мухаммед Ялавач, Өгэдэйн хөвгүүн Гүдэн нар эсэргүүцсэн болно. Чингэж их хөвгүүн хоёр төрийн эрхийг далдуур булаацалдсан асуудал гарав. Лалын эхнэр Фатима гэгч Дөргэнэ хатанд үйлчилж Гүдэнг хорлохыг төлөвлөжээ. Өгэдэй хаан Хүчүг хаан суулгахаар нэр зааж байсан ч тэр Сүн улсын дайнд нас барсан тул Хүчүгийн ахмад хөвгүүн Ширэмүн, Толуйн ахмад хөвгүүн Мөнх нарын нэрийг зааж байжээ. Чингис хааны дэд хөвгүүн Цагаадай нас барав. Цагаадайд Хятад гаралтай Везир хор өгсөн гэж цаазалжээ. Цагаадай мөн Отрараас гаралтай лалын Хабашамид, Уйгураас гаралтай Чинхай гэдэг гурван шадар туслахтай байжээ. Өнчин хөвгүүн Сочи бас хорлогдсон. Дөргэнэ хатан Их хааны гэрээсийг хөсөрдүүлж, Гүдэнг хаан суулгалгүй, өөрийн хөвгүүн Гүюгийг хаан ширээнд суулгахыг оролдов. Дөргэнэ хатанд “Засаг баригч” цол олгов. Дөргэнэ Их төрд аюулын үүд нээсэн.

-1243 он. Дөрөвдүгээр жарны 37 дахь жил Харагчин туулай жил

Бат эзэлсэн улсаа Алтан Орд гэж нэрлэв. Хятадын Жүндүд сууж байсан захирагч Мухаммед Ялавачийг урьж ирүүлж хорлохоор Дөргэнэ Абд-Ар-Рахман, бууны дархан Калаг нарыг элч довтолгов. Ялавач мэдээд Өгэдэйн хөвгүүн Гүдэнгийн дэргэд очжээ. Төр түр хамаарч байсан Дөргэнэ бусдын хов үгэнд орж , төрийн сайд Илюй Цу Цайн гэрт нэгжлэг хийж зохисгүй явдал болов. Хядан гаралтай төрийн сайд Елюй Цу Цай нас барав.

-1244 он. Дөрөвдүгээр жарны 38 дахь жил Хөх луу жил

Түвд Их Монгол улсын хараат улс болохоо илэрхийлэв. Армен улс Их Монгол Улсад дагаар оров. Дөргэнэ Фатиматай олон ихэс дээдсийг хордуулах ажлыг хийжээ. Дөргэнэ Их Монгол улсын мөнгө гэсэн бичигтэй зоос цутгуулав.

-1245 он. Дөрөвдүгээр жарны 39 дахь Хөхөгчин могой жил

Отчигин ноён Дөргэнэ хатанд дургүйцэж, их цэрэг хуралдуулж явахыг завдтал Гүюг байдлыг мэдээд Дөргэнэ хатанд ирэхэд хатан хөвүүн Гүюгийн талд оржээ. Отчигин ноёнд “Ви чиний сүйт бүсгүй чинь байна. Чамдаа найдсаар байна. Энэ цэрэг зэвсэг, хуурай хэрэглэлийн бэлтгэлтэй гарлаа гэдэг чинь юу гэсэн үг вэ? Бүх цэрэг улс маань түгшүүртэй байна гэж Дөргэнэ хэлүүлж Отчигины хөвгүүн Отойг явуулжээ. Отчигин ноён сэдсэн хэргээ болиход хүрчээ.

3.Далай их хаан Гүюг төр барьсан түүхэн цагийн товчоон.

-1246 он. Дөрөвдүгээр жарны 40 дэх улаан морин жил

Их хуралдай хуралдаж Өгэдэйн ахмад хөвгүүн Гүюгийг Их Монгол улсын хаанд өргөмжлөв.

Ромын Пап “Ертөнц дахин чуулган” хуралдуулж 65 настай Плано Карпинийг Монголд илчээр зарсан ба элч Дөргэнэд бараалхаж хариуд нь хатан хүн бүрт үнэгэн дах бэлэглэв. Ромын Папд Гүюг хааны захидал илгээв. Гүюг төр

самууруулсан хэргээр Отчигин ноёныг, Гүдэнг хороосон хэргээр Фатимаг цаазлав. Абд –Ар-Рахманыг цаазлав. (Монголчуудын бүрэн түүхийн товчоон) Гүюг төр самууруулсан хэргээр Отчигин ноёныг, Гүдэнг хороосон хэргээр Фатимагийн бүх нүх сүвийг оёж, сүнсийн гаргахгүй болгоод цусын дусаахгүйгээр эсгийд боож усанд хаяан дарж цаазлав. Дэлхийг нэгжсэн цэвэрлэгээ явуулав. Олон түшмэл ноёд, албат зарц харууатнууд үл мэдэх шалтгаанд сэрдэгдэн алуулав. (Жак Уэтерфорд. Өнөө цагийг үндэслэгч Эзэн Чингис хаан ном)

-1247 он. Дөрөвдүгээр жарны 41 дэх Улаагчин хонь жил

Дөргэнэ хорлогдон алагдав. Гүюг хаан болоод төр үүссэн завхралыг засаж, төв төрийн хүчийг сэргээх талаар тодорхой ажил хийж, хууль цааз, татвар, албанд томилох, зарлиг шийдвэр зэргийг журамлажээ. Есөн Мөнхийг Цагадайн хант улсын хан болгов. Андрейг Владимирин вангаар, Александрыг Киевийн вангаар, Мухамед Ялавичийг Хятад газрын даргач болгосон ба Аригун, Чингай, Элжигдэй нарыг эргүүлэн тусгай албадын даргаар томилов. Масуд бекийг Түрэгстан, Мавераннахр хоёрын захирагч, Аригун ноёныг Хорасан, Иран, Азербайджан, Шервань, Лур, Гүржийг захируулжээ. Төрийн пайз олгохыг хязгаарлаж, ёс бус олгосныг хураав. Өмнөд Сүн улсыг байлдах ажлыг Сүбээдэй баатар, Цагаан ноён нарт даалгав.

Гүюг хааны зарлигаар баруун зүгийн эзлэгдээгүй орны эзлүүлэхээр Элжидэй ноёныг их цэрэгтэйгээр Исмайлтуудын эсрэг хөдөлгөв. Зуун Монгол айлаас нэг эр, Тажиг цэргийн арван хүнээс хоёрыг татан өгчээ. Хүн амын тооллого явуулжээ.

-1248 он. Дөрөвдүгээр жарны 42 дахь Шар бичин жил.

-Их ган зуд болов. Энэ тухай Юан улсын сударт “Энэ жил их гантай тул голын ус бүрнээ ширгэж, Хээрийн өвс өөрөө ноцоод, үхэр морины арваас наймаас есөн нь үхсэн тул хүн амь зууж чадахгүй болжээ.”

-Өвлийн сүүл сард Гүюг хаан “Тэнгэрийн байдал дулаарах тийшээ хандлаа. Эмил нутгийн уур амьсгал надад зохидог юм. Тэндэхийн ус умдаа рашаан өвчинд маань тус болно.” гэж хэлээд баруун зүгт Гүюг хаан хөдөлжээ. Дөргэнэ энэ тухай “Гүюг хаан их цэрэгтэйгээ тэр хязгаар тийш хөдөллөө бэлэн байгаарай” хэмээн хэлүүлжээ. Батад хэлүүлсэн. Бат хан их цэрэгтэйгээ дорно зүг хөдөлж, Тэнгэр уул, Алтайн нуруунд ойртон ирсэн байжээ.

-Гүюг хаан баруун тийш Эмил рүү хөдөлж яваад 4 сард Самаркандын орчим Кум Сенгэр гэж нэрлэдэг элсний дээд хэсэгт 42 настайдаа таалал төгссөнийг, тэнд бунхлав. Гүюг хаан хаан нэг жил найман сар төр барьжээ.

Гүюг хааны их хатан Хаймиш яаралтай элч томилон Бат ханд явуулав.

Сорхагтан хатан “Нэгэнт бусад хан хөвүүд Бат дээр очихоор явахгүй байна. Тэр чинь бүх төрлийнхнийхөө ахмад нь бөгөөд бие нь чилээрхэж байгаа болохоор чи өвчтэй түүнийг эргэнэ гэсэн шалтгаар бушуухан явж оч” гэжээ.

-Их Монгол улсын хаан ширээний төлөө хан хөвүүд хоёр эвсэл болов. Толуйн удмынхан. Цагадай Өгэдэйн удмынхан талцав. Толуйн хөвүүд Бат ханд очиж зөвлөгөө авч, буцахад нь Бат хан хөвүүн Бэрхээ цэрэгтэйгээ дагуулж явуулав.

–Бат ханы зөвлөснөөр Гүюгийн их хатан Огул Хаймиш,

Хутуга бэхийн охин Чингай чинсан нарт төрийн хэргийг хамааруулав. Огул Хаймиш хатан төр хамарч, хөвүүд Хажи, Нагу нар эрх мэдэл булаацалдах болов.

Бат хан, хан хөвүүд ноёдыг ордондоо урьж хуралдай хийжээ. Нэрт жанжин Сүбэгэдэй 73 насандаа төрсөн газар Туул голын хөвөөнд нас барав.

-1249 он. Дөрөвдүгээр жарны 43 дахь Шарагчин тахиа жил

Бат ханы дэмжлэгтэйгээр Мөнхийг хаан болгохоор Алаг тагийн ууланд тогтжээ. Бат хан “..Хан хөвгүүдийн дундаас Мөнх л.. Чингис хааны ясу, зарлигийг нүдээрээ үзэж, чихээрээ сонссон хүн. Төр улс, цэрэг, хан хөвүүд бидний зол жаргал хэрхэн болох нь түүний хан суулгахад буй” гэж хэлүүлжээ.

-Хаан ширээний төлөө Цагадай, Өгэдэйн удмынхан, Гүюгийн хөвүүн Есөн Мөнх нар нэг тал, Жүчи Толуйн угсааныхан нэг болж зөрчил үүсч даамжрав.

-Энэ урьдчилсан Хуралдайд Өгэдэйн үеэл Хадан, Цагадайн талаас ач Хар Үлэхү, Мужиг, Толуйнхнаас Мөнх, наймдугаар хөвүүн Мөн Тоба, Отчигин ноёны омбол Тачар, Тэмүдар, Бэлгүтэй ноёны хөвүүн Есөн Буха, жанждаас Урианхай, Сүнид, Мөнхсар, Бала гэх мэт олон ноёд, хан хөвүүд оролцжээ.

-1250 он. Дөрөвдүгээр жарны 44 дэх Цагаан нохой жил.

Бат хан Бэрхээ Сартагийн хамт гурван түмэн үлэмж их хэмжээний цэргүүд Монгол руу ирүүлсэн байна. Хүү Бэрх “Бид Мөнхийг хаан ширээнд суулгах гэсээр нэгэнт хоёр жил боллоо “ гэж элч зарахад Бат хан “Чи Мөнхийг хаан ширээнд суулга, хэн Яснаас гажваас тэр хүн алдах, үхэх” гэж эргэн хэлүүлжээ.

4.Их хаан Мөнхийн төр барьсан түүхэн цагийн товчоон.

-1251 он. Дөрөвдүгээр жарны 45 дахь Цагаагчин гахай жил.

Их хуралдай зарлаад байхад Цагадай, Өгэдэйн Гүюг хааны угсааныхан ирсэнгүй. 7 сарын 1-нд Хэрлэнгийн хөдөө аралд цэргийн хамгаалалтын дор Их хуралдай хуралдаж, Толуйн хөвгүүн Мөнх дөрөв дэх их хаан болов.

-Хуралдай дуусаж байхад Өгэдэйн зургаадугаар хөвүүн Хадан, дүү Мэлиг, Цагадай ахмад хөвүүн Муу тогоон, Дөрөвдүгээр хөвүүн Хар Үлэхү нар хүрэлцэн иржээ.

–Ширэмүн, Нагу нар цэрэглэн гурав хоногийн газарт ирэхэд бүргэд арчлагч Канлы аймгийн Хишиг нэрт тэмээчин ирж яваад мэдэж мэдээлснээр, Жалайрын Жато овгийн Мөнхсар ноёныг 3000 цэрэгтэй мордуулж, Ширэмүн Нагу хоёрыг бариул 77 ноёдыг цаазлав. Ширэмүнийг нас бага гэж Хархорумун баруун талд Шар горхинд хорив.

-1252 он. Дөрөвдүгээр жарны 46 дахь Хар хулгана жил

Мөнх хаан өөрийн нэрний өмнөөс Рубрукаар дамжуулан Францын ванд бичиг илгээв. Захидал дэлхий дахиныг нэг улс болгох санаа зорилгоо бичсэн байна.

Францун ванд явуулсан Мөнх хааны бичиг... “Та нар Мөнх тэнгэрийн зарлигийг сонсовч нэвтэрхийлэн олгож итгэхийг хүсэлгүй бидний газар хол, уулс өндөр, тэнгис Дээд гагц Мөнх тэнгэр дор газарт ганц эзэн Чингис хаан байдаг хэмээн Мөнх тэнгэрийн бошиг зарлиг буй бөлгөө. Монгол, Найман, Мэргид... бид бүгдээс та бүхэнд хэлэх үг ману Хүмүүний чих сонордох, хүлгийн туурай хүрэх аливаа газар үгүйг ману биширтүгэй. Дагатугай. Ману зарлигийг сонсож, ухсан атлаа үл биширч, ману өөдөөс цэрэг хөдөлгөх аваас тэр нүд байвч эс чадах, хол байвч явж үл чадах сонсох буй за. Энэ болбоос Мөнх тэнгэрийн тогтоосон зарлиг болой. Мөнх тэнгэрийн суу залиар их монгол түмний нэрийн өмнөөс франкуудын эзэн ноён Людовик ван болон бусад эзэнд, санваартан, их франк түмэнд хүргэх Мөнх хаан ману зарлиг энэ болохыг мэдтүгэй. Мөнх тэнгэрээс Чингис хаан буулгасан бошиг сургаалыг Чингис хаан ч, дараах хаад ч таны сонорт уламжилсангүй... Мэдтүгэй хэмээн хэмээж та бүхэнд өгүүлж буйн мөнх тэнгэрийн бошиг мөн болой. Та түүнийг сонсож бидний үгийг дагатугай хэмээвээс илч юугаа бидэнд илгээхгүйн. Тийнхүү та нар манустай дайтах, найрамдахын алин болохыг бид мэдсүгэй. Та нар мөнх тэнгэрийн зарлигийг сонсовч нэвтэрхийлэн ойлгож, итгэхийг хүсэлгүй бидний газар алс хол, уулс өндөр, тэнгис далай их.. бидний эсрэг дайлбаас.. юу болохыг нь.. бэрх бөгөөс хялбар, хол бөгөөд ойр болдог мөнх тэнгэр мэдтүгэй” гэж өгүүлжээ.

-Мөнх хаан, Гүюгийн Их хатан Огул хаймиш, Ширэмүний эх Хадагач хатан нарыг 70 хүний хамтаар цаазлав. Ойрадын Хутуга бэхийн охин Чингай чансан, Энэ охин бол Бөртэ хатнаас төрсөн Цэцэйхэн Бэхэ түүний нөхөр Ойрадын түрүү Хутуга бэхийн охин Чингай чансан болно. Чингис хааны зээ охин. Алтан ургийнхны охин болно. Мөнх хаан Чингай чансанг муу хүний үгэнд орж хөнөөсөн гэх мэргэн удганы үгийн эзэн бололтой. Гүюг хааны нөлөө бүхий хатан Огул Хаймишийг эсгийд боож усанд хаясан гэдэг. Хаймиш хатнаас Хожу Огул, Нагу, Хөхөө гэсэн гурван хөвүүн төрсөн. Хожа Огулыг Мөнх хаан Хархориноос баруун талд Шар горхин гэдэг газар насаар нь хорьжээ. Нагу цэргийн албанд цөлөгджээ. Хөхөө Хубилайн үед өргөмжит итгэлт хүн явжээ.

-Төрийн бичгийн их сайд Чингайг цаазлав. 1260 онд Хубилай цагаатгасан. – Мөнх хаан эхлээд Өгэдэйн угсааныхныг бараг дуусгаж, дараа нь Цагадайн угсааны Есөн Мөнх, Бүри нарыг барьж, Бат ханд хүргэн алуулжээ.

-Хавар Толуйн хатан Сорхагтани өвчнөөр нас барав.

-1253 он. Дөрөвдүгээр жарны 47 дахь Харагчин үхэр жил.

-Өгэдэйн хант улсыг Зургадугаар хөвүүнд Бишибали орныг, Долдугаар хөвүүнд Милигт Эрчис мөрний дагуу орныг, Дөрөвдүгээр хөвүүн Харачарын хүү Тогтаход, тавдугаар хөвүүн Хашийн хүү Хайдуд Ханяал орныг, Гансу Наньсу Наньшаны баруун хэсгийг дэд хөвүүн Гүдэнгийн хүү Мөнхөд тус тус хуваан өгөв.

-Мөнх хаан Бат ханы хүчин чармайлтаар хаан суусан бөгөөд Бат ханыг их хүндэлдэг бөгөөд тэр “Нар энэ орчлонг дэлхийг гийгүүлж байдгийн адил Бат бид хоёрын эрх мэдэл бүхий улс түмэнд хамаарна. Бид нэг толгойн хоёр нүд адил тус тусдаа хэдий ч нэг л зүгт хардаг болой.”

- 1254 он. Дөрөвдүгээр жарны 48 дахь Хөх барс жил.

-Хар хорим орчимд их ган зуд болов. Солонгост 5000 цэргээр цөмрөлт хийжээ.

Армянû ван Бага азийн нэгдүгээр Гетум хаан Мөнх хаанд золгон хэлэлцээр хийв. Их гүрний хэмжээнд хүн амын тооллого хийв.

-1255 он. Дөрөвдүгээр жарны 49 дэх Хөхөгчин туулай жил.

Мөнх хаан төр ёсны их найр хийж, өршөөл үзүүлж гавъяатнаа урамшуулав. Их тахилга тайлга.

-Хүлэгү Персийн ихэс ноёдод илч довтолгов. Персэд дайн зарлав.

-Их хуралдай хийв. Энд Сүн улсын байлдааны талаар хэлэлцэв.

-Алтан ордны Бат хан нас барав.

-1256 он. Дөрөвдүгээр жарны 50 дахь Улаан луу жил.

-Монголын эсрэг Загалмайтны дайн хийхийг Орост, Пап уриалав.

-Хүлэгүд Персийн Рукн-Ад-Дин бууж өгөхөө илэрхийлэв.

-Хүлэгү Аму-дарьяа мөрнийг сал, онгоцоор гаталжээ. Хүлэгүгийн цэрэг Аму-дарьяа мөрний эргийн их олон арслангаас морьд нь үргээд ойртохгүй байсан тул ормол буур унаж очоод арван арсланг агнажээ.

-Аригун Мөнх хаанд дуудагдан Хархоринд эргэж ирэв.

-Мөнх хааны зарлигаар Хубилай удирдан Кайпин буюу Шанду хотыг барьж эхлэв.

-Будда, Ислам, Христос шашны хуврагуудын онолын их маргаан хийжээ.

-Мөнх хааны зарлигаар Меру хотод одон орон судлах барилга байгуулав.

-1257 он. Дөрөвдүгээр жарны 51 дэх Улаагчин могой жил.

-Хүлэгү Хамандад хээрийн ордондоо цуглаж, олзоо түгээн найман өдөр найрлажээ. Мөнх

хаан өөрийн төрөл Китатыг албан татвар хариуцсан илбэн тохниулах сайдаар томилжээ.

–Монгол нутаг, Их ордонг Ариг бөхөөр хариуцуулж, Аландараар туслуулан үлдээжээ.

-Монголын их цэрэг хоёр замаар, Баруун замын дөчин түм Мөнх хаан, Зүүн замын гучин түмэн цэргийг Тогучар ноён удирдан хөдөлж, Өмнөд Сүн улсын олон хот бэхлэлтийг эзлэв.

-Урианхайдай жанжны цэрэг Аннам буюу Вьетнам-ыг төвшитгөв.

-Хүлүгэ Багдад дайн зарлав. Исмайлитуудын төр мөхжээ. Исмайлтууд нь лалын Шийт урсгалын алан хядагч үзэлтнүүд юм. Үүнийг анх удаа даржээ.

-Мөнх хаанд зориулж Ойрадын аймгийн Хутуга бэхийн омбол Тавнан Балито Исицзи гүнж нар Гэрэлт хөшөө босгов.

-1258 он. Дөрөвдүгээр жарны 52 дахь Шар морин жил.

-Хүлэгү хан Халиф Мустасимийг Аббасид гаралтай эрчүүдийн хамт уутанд хийж адуугаар чирүүлж хороожээ. Хүлэгүгийн цэргүүд Багдад, Иран, Дамаскийг дөчин хоног бүслээд эзлэв.

–Аннам буюу Вьетнам улс Монголд дагаар орж, гурван жид нэг удаа алба өргөх болжээ.

–Гуулин улс буюу Солонгос руу довтлох довтолгоон сүүлч рүүгээ оров.

–Хубилай Шанду-гаас морьдов.

-1259 он. Дөрөвдүгээр жарны 53 дахь Шарагчин хонь жил

-Өмнөд Сүн улсад халуун хижиг өвчин гарчээ.

–Гуулин улсын ван Ко-Жон ван өөрийн хөвгүүн Чүн Нё Ролоо дөчин хүнтэй ирүүлж, найрамдан танж болгон суулгав.

-Хубилай Жунаньд ирэв.

-Хубилай цэргээ авч Хөх мөрнийг гатлав.

–Сүн улсад дайлж байсан Монгол цэргүүдийн дунд өвчин халуун хижиг өвчин гарав.

-8 –р сарын 11 нд Өмнөд Хятадын нутаг Дижоу-Ию-Шан ууланд Мөнх хаан хижиг өвчнөөр таалал төгсөв.

1257 оны Мөнх хаан Сүн улсад дайлахаар зэхэж байхад нэг мэргэн удган ирж, “Их эзэн та муу хүний үгэнд орж, алтан ургийн дотор их нүгэл үйлдэж, мөнх тэнгэрийг хилэгнүүлжээ. Одоо дахин хүний газар дайн хийвэл таны алтан аминд аюултай” гэж хэлсэн домог бий. Хутуга бэхийн охин төрийн бичгийн сайд Чингай чансан болов уу, хожим Хубилай түүнийг цагаатгасан байдаг.

–Мөнх хааны шарилыг умарт нутаг буцаахаар болж дөтгөөр хөвгүүн Ширхэ, Асуд, Хондгой, Татардай нараар Монголд аваачиж Дөрвөн хатны ордонд нэг, нэг хоног байлгаж байгаад Бурхан Халдунд Чингис хаан, Толуй хоёрын дэргэд хөдөөлүүлжээ.

–Гуулин улсын хун тайж, Мөнх хаантай уулзахаар ирсэн ч хаан таалал төгссөн тул Хубилайтай уулзжээ.

–Хубилайн хатан Чимбай нууцаар захидал явуулж Аландар, Худуха зэрэг ноёд Хар хүрэмд Аригбөхийг хаан болгох гэж байна гэж захидал өгчээ.

5. Их хаан Хубилайн төр барьсан түүхэн цагийн товчоон.

-1260 он. Дөрөвдүгээр жарны 54 дэх Цагаан бич жил.

-Аригбөх Дорж ноёноор ахлуулсан элчээ Хубилайд ирүүлснээс үүдэн Хубилай хаан болох асуудлаа түргэвчилжээ.

–Билгийн 3 сарын 24 нд Хятад багш, зөвлөхүүдийн хорт явуулганд автсан Хубилай Кайпин буюу Шайду хотод өөрийгөө хаан хэмээн өргөмжилж, Хятад ашигтай, Монголд туйлын хохиролтой, юугаар ч нөхөшгүй алдаа хийв.

–Билгийн 4 сард Мөнх хааны их хатан тэргүүлэн, хааны гэрээслэл бүхий Аригбөхийг Хар Хүрэмд Их хуралдайгаар хаан болгосноор, Хоёр хаантай болж төр самуурч эхлэв.

Хархорины хуралдай 20 хоног үргэлжилжээ.

–Намар билгийн 7 сараас ах дүү хоёр хаан цэрэглэн, Ариг бөхийн цэргийг Аландар захирч, Хубилайн цэргийг Хадан жанжин захирч, хоёр тал их говийн өмнө Шимэлт нуур буюу Ганга нуурт тулалдан Аригбөхийн тал ялагдаж, Алундар жанжин, Хундагай нар алагдав. Хундагай Мөнх хааны шарилыг авчирч 1260 оноос Аригбөхийг дагасан хүн.

–Хубилайн цэрэг Хархоринг эзлэв.

–Хубилай Их монголын нийслэлийг Хятад нутгийн Кайпинд шилжүүлэв. Хубилай Есүнхэй ноёноор Хархорин хотыг сэргийлүүлэн цэрэгтэй нь үлдээв.

–Намар, Ариг бөх Хархорумоос Есүнхэйг барьж, улмаар Хубилай руу цэрэглэн говьд ялагджээ.

–Хүлэгү Их монгол улс руугаа эргэв.

–Сири, Ливан, Израйл, Египетэд хийсэн аян дайны жил байв. Монголын элчдийг Египетэд цаазлан толгойг нь хотын хаалган дээр дүүжлэв. Айн жалудын дэргэд Египетийн Мамлюк, Кутуз Хэтэбухын цэргийг цохиж, Хэтэбухааг барин авч цаазалжээ.

–Хубилай төрийн эрхийг булааж авснаар, Их монгол улсаа Юан улс хэмээн нэрлэж, оны цолоо Чжун-тун гэж өөрчлөн, Чжүн-тун-Юань-Бао-Цзяо-Чао гэдэг цаасан мөнгө гаргасан.

Хархорин хотод өлсгөлөн болов.

–Хубилай хаан Түвэдийн Пагва ламд “Улсын багш” цол олгов. Бурханы шашны хэргийг эрхлүүлэв. Улсын шинэ үсэг зохиох зарлиг өгчээ.

–Их Монгол улсын дөрөв дэх их хаан Мөнх нас барахдаа, хөвүүн Ёлон даш, Шилж нарт, Аригбөхийг хаан суулгах тухай гэрээсэлсэн байдаг.

–Египетийн Мамлюк бол 1237 онд Хибчагийг эзлээд Бэрх хэдэн хэдэн мянган хүн Египетийн султаанд худалсан бөгөөд тэдний дотор Мамлюк байжээ. Хүлэгүгийн хэсэг цэргийг ялсан. Египетийн сор жанждийн нэг болсон. Монгол цэргийн тактик мэддэг цэргийг худалдсанаас тэд эргээд монголчуудыг энэ удаа дийлэв.

-1261 он. Дөрөвдүгээр жарны 55 дахь Цагаагчин тахиа жил.

–Вьетнам Хубилайн шаардлагыг хүлээн авч дагаар орсон. Солонгосын ван Хубилайд бараалхав.

–Өвлийн эхэн сард Ариг бөх Кайпин руу руу довтолжээ. Цагадай улсын хан Алгуй Хубилайн талд урваснаас Аригбөхийн баруун талаас авах туслалцааны зам хаагдав. Хубилайгаас үүдэлтэй дайн самууны хөлд Монголын аж ахуй сүйрч Их улсад эвдрэл үүсч, хар нутагт хаягдсан шалз шиг болж хувирав.

-1262 он. Дөрөвдүгээр жарны 56 дахь Хар нохой жил.

–Монголын наян баатар цэргийг алж, толгойг нь хэрэм давуулж шидсэнээр Монгол цэргүүд тэр хотыг үнсэн товрог болгов.

–Хубилай хаан охин Хутуг бэхэтэй Солонгосын Чүнрёл ванг гэрлүүлжээ. Алтан ордны Бэрх төв төрд тэрсэлж Мамлюктэй холбоо тогтоож Хүлэгүгийн эсрэг дайн зарлав. Бэрхийн Хули, Татар нар хорлогдсон учир Бэрх Хүлэгү нар хоорондоо муудалцжээ.

–Ариг бөх Цагаадайн угсааны Алгуйтай байлдаж, Илийн хөндийд нэлээн зохисгүй үйлдэл хийжээ.

-1263 он. Дөрөвдүгээр жарны 57 дахь Харагчин гахай жил.

-Кайпиныг дээд нийслэл Шанду гэж нэрлэв.

–Хүлэгү Ираны хан болж “Ил хан ” цол авав.

–Ариг бөх хаан, Хубилай хаан нарын тэмцэл үргэлжлэв.

-1264 он. Дөрөвдүгээр жарны 58 дахь Хөх хулгана жил.

-Монголд ган гачиг болов.

-7 сард Монголын их төр булаасан Хубилайд Ёст хаан Аригбөх ялагдаж, арга буюу бууж өгөв. Аригбөхийн талд шудрагаар зүтгэсэн ноёдыг Хубилай цаазалжээ. Хубилай нийслэлээ Шандугаас Бээжинд нүүлгэх шийдвэр гаргав. Хайду Хубилайгийн эсрэг тэмцэхээр Эмилд цэрэг бөөгнөрүүлж эхэлжээ.

–Хубилай хааны зарлигаар ядуу дорой амьдралтай, өнчин, бэлэвсэн эмэгтэй зэрэг хүмүүст жил бүр улсын сангаас тэтгэмж олгох болов. Ёст хаан Аригбөх арга буюу хүчинд автаж ахдаа бууж өгчээ. Энэ хүн эх оронч сэтгэлээ алдаагүй байсан төдийгүй, тун ч удалгүй нас барсан үвдал нь сэжигтэй мэт. Хятад түшмэдийн гар хөл болсон Хубилай хаан ширээг ёс бусаар булаан авснаа өөрөө сайн мэдэрч, Ариг бөхийн амийг өршөөсөн байдаг. Хубилай “Ах дүү бид хоёрын хэн нь хаан суух ёстой юм бэ?” гэж асуухад Ариг бөх “Миний ёсоор бол би суух ёстой, одоо чи суужээ” гэж хариулжээ.

-1265 он. Дөрөвдүгээр жарны 59 дэх Хөхөгчин үхэр жил.

–Мамлюк Сирээс Монголчуудыг шахан гаргав.

–Хубилай хаан хятад хүнийг төрийн албанд томилох дүрэв тогтоов.

–Усан цэргийн флоттой болох зарлиг буулгав. Хубилай хан Япон улсад элч зарах болов.

–Хүлэгү 48 насандаа өөд болоход Аллах Бурханы дайсан өөд боллоо гэж лалууд баярлаж, Шинэ Констаин тэнгэр халилаа гэж загалмайтнууд гашуудаж байв. Хүлэгүгийн ахмад хөвгүүн Абага хан болж, Алтан ордны Бэрхээс эцгийнхээ өшөөг хөдөлж хоёр тал тэнцүү хохирч Бэрх буцах замдаа нас баржээ.

-1266 он. Дөрөвдүгээр жарны 60 дахь Улаан барс жил.

–Бат ханы хөвүүн Мөнхтөмөр Алтан орд улсын хан болов. Алгуйн хөвгүүн Мубарак Цагаадайн улсад хан болов.

–Хубилай ордост найман цагаан өргөө барьж өвгөдийн сүнсийг дахих үед Чингис хаанд “Асрал, өглөгч хийгээд элбэрэлт хаан” гэж нэхэмжилэн өргөв. Есүхэй баатар нас барсны ерэн зургаан жилийг тохиулдуулан “Шен–юан хуанди” цол нэхэн олгов.

–Өгэдэйн хөвгүүн Хашийн хүү Хайду бусад монгол ноёдын хамт холбоо байгуулжээ. Номгон Хар хоринд ирээд цэргээ бэлтгэж, Цагаадайн хант улсыг Хайдугаас сэргийлэх болжээ.

- 1267 он. Тавдугаар жарны 1 дэх Улаагчин туулай жил.

-11 сард анх удаа Хубилай хааны элч Бан Бу Японы Цүшима аралд хүрчээ. Японы түүхэнд анх удаа Монгол гэдэг нэрийг Японы бичээч Моро Хидэг бичиж үлдээжээ.

–Хубилай Бээжинд шинэ хот бариулж эхлэв. Юан гүрний дотоодоо цэгцэлж дуусаад Сүн улсыг бүрэн эзлэх дайны идэвхитэй бодлого явуулж эхлэв.

- 1268 он. Тавдугаар жарны 2 дахь Шар луу жил.

–Хубилайн эсрэг Өгэдэйн ач Хайду-Хашийн хөвүүн, Монгол ноёдын тэмцэл эхлэв.

–Хубилай долоон түмэн хүнтэй усан цэргийн флот байгуулж Сүн улсын Сяньяныг усан ба хуурай замаар довтлов.

–Хубилай хаан үед түүний хөвгүүн Номгон Чингис хааны дөрвөн ордыг захирч байв. Пагва лам дөрвөлжин бичиг зохиов.

- 1269 он.Тавдугаар жарны 3 дахь Шарагчин могой жил.

–Хубилай Солонгост дөрвөн таар аму тавьж болох мянган онгоц хэлхүүл гэж үүрэг өгчээ.

–Сүнгийн цэргийг бут цохив.

-Хавар Өгэдэй, Цагаадайн угсааны Хайду тэргүүтэй ноёдын чуулган болж “Үүнээс хойш уулс батал хээр газарт амьдран сууна. Хот суурины ойр орчимд эргэлдэн хоргодож байхгүй” гэдэг шийдвэр гаргажээ. Хайду чуулган дарга болжээ.

–Хубилай хаан Пагва ламын зохиосон дөрвөлжин бичгийг “Монголын шинэ бичиг” нэртэйгээр хэрүглэх зарлиг гаргав.

-1270 он. Тавдугаар жарны 4 дэх Цагаан морь жил.

–Хайду Алтан ордын Мөнх төмөр хоёр холбоо байгуулав.

-1271 он.Тавдугаар жарны 5 дахь Цагаагчин хонь жил.

–Хубилай хаан Их Монгол улсын нэрээ өөрчилж Их Юан гүрэн хэмээн зарлан тунхаглав. Хаан балгасан буюу Бээжинг гүрний нийслэл болгов.

–Марко Поло Юан гүрэнд очихоор хөдлөв.

-1272 он. Тавдугаар жарны 6 дахь Хар бич жил.

–Өгэдэйн угсааны Хайду хубилай эсрэг тэмцэхээр хүчээ зузаатгаж Цагадайн хант улсыг өөрийнхөө мэдэлд оруулжээ.

–Монголд албан тариалан байгуулав.

-1273 он. Тавдугаар жарны 7 дахь Харагчин тахиа жил.

–Монгол гурван түмэн цэрэг, гурван мянган онгоц, 1500 завиар Японд довтлох анхны оролдлого хийв. Юан-Солонгосын нэг түмэн цэрэг Чезү аралд байрлав.

-1274 он.Тавдугаар жарны 8 дахь Хөх нохой жил.

–Хубилай хааны Хон –Дагү гээр удирдуулсан 15.000 цэрэг Солонгосын 8000 Монгол 4500,

Хятадын 1.5 түм, хайгуул 500, 900 их бага завиар Гуулин улсын Хаппогоос Япон руу довтлов. Хубилай хаан Монголын Юан гүрний гэгдэх далайн цэргийн флот байгуулсан.

– Японы тэнгисийн шуурганд цэргийн флот цохиулан сүйрэв.

-1275 он. Тавдугаар жарны 9 дэх Хөхөгчин гахай жил.

–Вьетнамын хаан өөрийн орноос Монгол Хятад захирагч нарыг гаргахыг шаардав. Сүн улс Хубилайн элчийг алав. Япончууд монгол элчийг цаазлав.

–Хайду Юанд довтлон няцаагдав.

–Өмнөд Сүн улсын элч найрамдахыг гуйн ирсэн боловч хаан эс зөвшөөрөв.

-Марко Поло Бээжинд ирэв.

-1276 он. Тавдугаар жарны 10 дахь Улаан хулгана жил.

– Туг төмөр нар Хубилайд дургүйцэн Аригбөхийн хөвүүн Ёбугуртай хуйвалдан Мөнхийн дөтгөөр хөвүүн Жирхэг их хаанд өргөмжилсөнд дуртай хүлээн авав.

–Хубилай Хятад түшмэл Ёо Шуг бичгийн яамны сайдаар томилов.

-1277 он. Тавдугаар жарны 11 дэх Улаагчин үхэр жил.

–Хубилай өөрийн биеэр Монголд цэрэглэн орж Мөнх хааны хөвүүн Жирхэтэй байлдсан. Жирхийг барьж цаазлав.

–Монголын ноёрхлыг эсэргүүцэж Хятадын 2000 тариачдын бослого гарч дарагдав.

-1278 он. Тавдугаар жарны 12 дахь Шар барс жил.

–Хубилайн анхны элчийг Камбож улсад алав.

–Хубилай хааны даалгавраар Солонгос улс Японтой хоёр жил байлджээ.Энэ нь Япончууд Слонгост цэрэглэн буусан үе юм. Юан улс Японы худалдааны хөлөг онгоцнуудад худалдаа хийх зөвшөөрөл олгожээ.

-1279 он. Тавдугаар жарны 13 дахь Шарагчин туулай жил.

-Өмнөд Сүн улс бүр мөсөн мөхөв.

-Энэтхэгийг элч ирж монгол хаанд бараалхав.

–Хубилай хаан Солонгосын хойгт их хэмжээний цэрэг авчирч япончуудыг хөөн гаргав.

-1280 он. Тавдугаар жарны 14 дэх Цагаан луу жил.

-Японтой байлдах бэлтгэл хангагджээ. Алтан ордны Мөнх төмөр хан нас барав.

-1281 он. Тавдугаар жарны 15 дахь Цагаагчин могой жил.

-Алтан ордны хан ширээг Ногай булаав. Хубилай хаан дайны төлөвлөгөө баталжээ. Баруун замын цэрэг, зүүн замын цэргүүд Япон улс руу довтлох төлөвлөгөө хэрэгжих үед 7 сарын 30-ны шөнө Далайн шуурга болж Монгол цэргийн флот сүйрчээ. Япончууд энэ салхийг “Камиказе буюу Тэнгэрийн салхи ”гэдэг. 7 сарын 30-ны шөнө 4000 онгоц, 100.000 цэргээ Тайфуны нөлөөнд алджээ. Зүүн замын цэргийг удирдсан Монгол жанжинн Шинду, солонгос жанжин Хон-Тагу нар Таван луу ууланд бууж, Япончуудтай байлдан ялагджээ.

-1282 он. Тавдугаар жарны 16 дахь Хар морь жил.

-Хубилай хааны элч Тайландад очив. Ираны монгол хаан Абага нас барав.

-1283 он.Тавдугаар жарны 17 дахь Харагчин хонь жил.

-Камбожи Сулейман жанжны цөөн цэргийг дарав. Бирмийг эзлэв.

-1284 он.Тавдугаар жаран

-Хубилайн их хатан Хонгирад овгийн Ильчийн охин Чинбуи буюу Чинбай нас барав.

-1285 он. Тавдугаар жарны 19 дахь Хөхөгчин тахиа жил.

-Чампа улс Юан улсад жил бүр цагаан заанаар бэлэг өгч хараат байдалд оров. Камбож дагаар улс болов. Алтан ордын амбан захирагч ноён ногай цэрэг Унгар, Булгарт дахин халдав.

-1286 он. Тавдугаар жарны 20 дахь Улаан нохой жил.

-Ногай Польшид довтлов. Хайду Юан гүрэнд дахин довтлов. Хаан төрийг эх нутагтаа авчрах гэсэн тэмцэл байсан.

-1287 он. Тавдугаар жарны 21 дэх Улаагчин гахай жил.

-Отчигины гуч хөвүүн Наян ноён Хасарын угсааны Ван Шатар ноёдын чуулган хийжээ. Хайду ноёнтон холбоолж Хянганы Ляодуны чиглэлд бослого гаргав.

-Хубилай хаан өөрийн биеэр дөчин зургаан түмэн цэрэгтэй ирж Их говийн ард гарч Наянтай хоёр өдөр ширүүн тулалдаж ялав.

-1288 он. Тавдугаар жарны 22 дахь Шар хулгана жил.

-Марко Поло нутаг буцсан. Чингис хааны дүү Тэмүгэ Отчигоны гуч хүү Наян ноёныг Хубилай хаан цаазалж алав.

-Ромын Пап дөрөвдүгээр Никола Алтан ордны ханы эсрэг дайн зарлажээ.

Мянганы ноён Сүнсбай төв төрийг хятад шилжүүлсэнг эсэргүүцэж бослого гаргаж өртөөдийг хаажээ.

-1289 он. Тавдугаар жарны 23 дахь Шарагчин үхэр жил.

–Хубилай хааны эсрэг Хайду Дува тэргүүтэй монгол ноёд бослого гаргаж Хар хоринг түр эзлэн авав.

–Хубилай цэрэглэн ирж Хархоринг Хайдугаас булаан авчээ.

-1290 он.Тавдугаар жарны 24 дэх Цагаан барс жил.

–Ираны Монгол хан Аригун Ромын Дөрөвдүгээр Пап Николад дипломат илч зарав. Аригуны бичиг...

–Юан гүрний бодлогыг эсэргүүцэж Төв Монголд бослого гарч албаны мал булаажээ.

-1291 он. Тавдугаар жарны 25 дахь Цагаагчин туулай жил.

–Алтан ордны амбан Ногайн эзэмшилийн Вадины ван Шишман Булгар Монгол цэргээр Сербид довтолжээ.

-1292 он. Тавдугаар жарны 26 дахь Хар луу жил.

–Монголын элчийг Явын ван доромжлон хацар дээр нь үсэг сийлэв. Хубилай элч доромжлосны хариуд 20.000 монгол цэрэг,1000 завь онгоцоор Явын улс руу довтлов.

-1293 он.Тавдугаар жарны 27 дахь Харагчин могой жил.

–Хубилайн цэрэг Бирмаг эзлэн дагуулжээ. Цейлэн, Индонезийн бүлэг арлууд, Энэтхэгийн далайн өмнөд хэсэг, Чампа, Тонкин, Вьетнам мэт жижиг улсууд Бирм зэрэг бага улсууд цөм Хубилайн мэдэлд оржээ.

–Юан улсын цэрэг Явыг орхин гарчээ.

-1294 он. Тавдугаар жарны 28 дэх Хөх морь жил.

-Хубилай хөвгүүн Чингэмийн ууган хөвүүн Гамала үндсэн Монголын хэргийг барих Хар хүрэмийн язгууртан ван болов. Хайду хаан Юан гүрнийг мөхөхөөр удаа дараа дайлан тулалдав.

–Хубилай хаан Монгол хүн хятадтай суух, Хятад хэлээр ярихыг хориглож, жил бүр Хонгирад аймгаас зуун охидыг авчруулж ноёдын хатан болгож байв.

–Юан гүрний Хубилай хаан нас барав.

Төмөрийн эх Хөхжин хатан хуралдайг удирджээ. Гамал хаан болох гэсэн боловч зонхилгч

ноёд Төмөрийг хаан болгожээ.

Table of Contents

Оршил утга:

Чингис Хааны санаа

Нэгдүгээр үзэгдэл.

Хоёрдугаар үзэгдэл.

Гуравдугаар үзэгдэл.

Дөрөвдүгээр үзэгдэл.

Тавдугаар үзэгдэл.

Зургаадугаар үзэгдэл.

Долдугаар үзэгдэл.

Наймдугаар үзэгдэл.

Есдүгээр үзэгдэл.

Өгэдэй Хааны санаа

Нэгдүгээр үзэгдэл

Хоёрдугаар үзэгдэл.

Гуравдугаар үзэгдэл.

Дөрөвдүгээр үзэгдэл.

Тавдугаар үзэгдэл.

Зургаадугаар үзэгдэл

Долоодугаар үзэгдэл

Наймдугаар үзэгдэл.

Есдүгээр үзэгдэл.

Мөнх Хааны санаа

Нэгдүгээр үзэгдэл.

Хоёрдугаар үзэгдэл.

Гуравдугаар үзэгдэл.

Дөрөвдүгээр үзэгдэл.

Тавдугаар үзэгдэл.

Зургаадугаар үзэгдэл.

Долоодугаар үзэгдэл.

Наймдугаар үзэгдэл.

Есдүгээр үзэгдэл.

Хубилай Хааны санаа

Нэгдүгээр үзэгдэл.

Хоёрдугаар үзэгдэл.

Гуравдугаар үзэгдэл.

Дөрөвдүгээр үзэгдэл.

Тавдугаар үзэгдэл.

Зургаадугаар үзэгдэл.

Долдугаар үзэгдэл.

Наймдугаар үзэгдэл.

Есдүгээр үзэгдэл.

Түүхэн сурвалжийн он дараалалын хураангуй товчоон